# “ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦООГ ХАНГАХ, ИРГЭД, БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТИЙН САНАЛ АВАХ ПРАКТИКИЙН СУДАЛГАА”

MDS and KhanLex LLP

**Захиалагч:** “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл MON\13\102
УИХ-ын Тамгын газар, ХЗЯ

**Гэрээ байгуулсан огноо:** 2014.10.22

**Гэрээний дугаар:** Б\14-007

**Эцсийн тайлан гаргасан огноо:** 2014.12.17

***МЭДЭГДЭЛ***

Энэхүү тайланг бэлтгэхэд ишлэл болгосон бүх цахим мэдээлэл, хэвлэмэл бүтээл, төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн мэдээлэл үнэн зөв, бодит байдалд нийцсэн гэж үзэж, тайланд ашигласан болно. Мөн энэхүү тайланд шаардлагатай мэдээллийг бүрэн олж цуглуулсан гэсэн баталгааг судалгааны баг өгөөгүй болно. Тайланд тусгагдсан харьцуулалт, үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж санал нь тус "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийн зөвлөх үйлчилгээний багийн санал бөгөөд судалгааны ажлыг санхүүжүүлсэн НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Улсын Их Хурлын Тамгын газрын хэрэгжүүлж байгаа "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төсөл, Хууль зүйн яамны албан ёсны байр суурь, үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

***ТАЛАРХАЛ***

Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийг судлах Зөвлөх үйлчилгээний энэхүү сонирхолтой ажлыг гүйцэтгэх боломж олгож, дэмжин ажиллаж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн захирал Д.Болдбаатар, Төслийн зохицуулагч Г.Золжаргал, Төслийн зөвлөх Н.Лувсанжав, ХЗЯ-ны газрын дарга Т.Бат-Өлзий нарт гүн талархал илэрхийлж байна.

**1. Үндэслэл:**

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болох”-оор заасан. Энэ хүрээнд “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн зүгээс 2013 онд хуулийн төсөл боловсруулахад тавигдах хууль зүйн техникийн болон агуулгын шаардлага, олон улсын туршлага, стандарт, хуулийн төслийн үр нөлөөний шинжилгээ хийх аргачлал зэргийг судлан, тайлан гаргаж Хууль зүйн яамны “Хуулийн тухай” хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт өгсөн байна. Тус яамны Ажлын хэсэг хуулийн төслийг “Хууль тогтоомжийн тухай” хуулийн төсөл болгон боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа юм байна. Энэхүү хуулийн төсөлд туссан зарим асуудлыг гүнзгийрүүлэн судалж, төслийг улам боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх үүднээс хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авахтай холбоотой харилцааг хэрхэн зохицуулах тухайд нэмэлт судалгаа хийж санал зөвлөмж гаргах, тодорхой хуулийн төслийг боловсруулах явцад туршиж үзэх шаардлагатай байна гэж төслийн зүгээс үзсэн. Уг зорилгоор судлаачдын баг шалгаруулахаар сонгон шалгаруулалтыг НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын их хурлын Тамгын газар дээр хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслөөс зарласан.

Уг сонгон шалгаруулалтад тус “ЭмДиЭс энд ХаанЛекс” ХХН шалгарч, 2014.10.22-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд өнөөдөр графикийн дагуу энэхүү ажлын эцсийн тайланг Та бүхэнд толилуулж байна.

**2. Зорилго**

“Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийг боловсронгуй болгох зорилгоор шинэ хуулийн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авахтай холбоотой зохицуулалт, түүний хэрэгжилтийг судалж, санал зөвлөмж боловсруулахад зөвлөх үйлчилгээний зорилго оршино.

**3. Хамрах хүрээ, хийгдэх ажил:**

3.1. Энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгаа, гадаад орнуудын хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ижил

төстэй хууль, эрх зүйн акт, олон нийтийн оролцоог хангах, холбогдох талуудаас санал авах асуудлыг хэрхэн зохицуулсныг дэлгэрүүлэн судлах.

3.1.1. Хуулийн төсөл боловсруулахад оролцоог хангаж, санал авч буй одоогийн үйл явц ба Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд тусгагдсан үйл явцыг харуулсан зураглал хийх

3.1.2. ХЗЯ, УИХ-ын Тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр сүүлийн үед батлагдсан 2-3 хууль, түүнчлэн боловсруулах шатандаа буй 2-3 хуулийн төслийг сонгон авч, тэдгээрийг боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах, санал авах ажиллагаа хэрхэн явагдсан, явагдаж байгаа, тухайн харилцааг хэрхэн зохицуулахаар тусгаж байгаа талаар дэлгэрэнгүй дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж, эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах, энэ талаар тайлан бэлтгэх.

3.2. Судалгаа, дүгнэлт хийж, санал боловсруулахдаа олон улсын сайн практик болон Монгол улсын хууль тогтоох тогтолцооны онцлогийг харгалзан үзэх

3.3. Холбогдох уулзалт, семинарт оролцож хийсэн судалгааны үр дүнгийн талаар танилцуулга хийх эдгээр болно.

Манай багт багийн ахлагч Д.Дүгэржав, багийн гишүүн Д.Мөнхгэрэл, Ц.Одмаа, А.Мөнхзул, М.Золзаяа, Б. Одзаяа нар ажиллав.

### 3. Арга зүй, аргачлал

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд дараахь арга, арга зүйг ашигласан болно.

***Бичиг баримтын судалгаа шинжилгээ.*** Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхдээ хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авахтай холбоотойгоор өмнө хийгдсэн судалгаа, гадаад орнуудын хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ижил төстэй хууль, эрх зүйн акт, олон нийтийн оролцоог хангах, холбогдох талуудаас санал авах асуудлыг хэрхэн зохицуулж, хэрэгжүүлдэг талаар холбогдох мэдээллийг цуглуулж, шаардлагатай орчуулга, харьцуулалт хийж, нэгтгэн манай орны нөхцөлд тохиромжтой зохицуулалтын хувилбарыг тодорхойлох.

***Харьцуулсан судалгаа.*** Хөгжингүй болон хөгжиж байгаа улс, нэгдсэн болон холбооны улс, газарзүйн байрлал, оролцооны ардчиллыг хөгжүүлэх талаар зохих туршлага бүхий гэж тооцогддог байдлыг харгалзан тодорхой улсыг сонгон мэдээлэл цуглуулж, Монгол Улсад хуулийн төсөл боловсруулахад оролцоог хангаж буй байдалтай харьцуулан судлах

***Анкет, асуулга.*** Нэг талаас төрийн байгууллага-хууль санаачлагч, хуулийн төсөл боловсруулагчид, нөгөө талаас хуулийн төсөлд саналаа тусгахад олон нийтийн оролцоо хэрхэн хангаж буйг тандах зорилгоор Иргэд, ТББ-аас асуулга явуулах замаар оролцоог хэрхэн хангаж байгаа болох, хэрхэн оролцож байгаа талаар тэдний байр суурийг тодорхойлж харьцуулан дүгнэх

***Ажиглалт, зорилтот бүлгийн уулзалт ярилцлага хийх.*** Хуулийн төсөл боловсруулах шатанд байгаа болон батлагдсан хуулиудаас сонгож,

боловсруулалтын шатанд иргэдийн оролцоог хангасан, хангаж байгаа байдлыг бичиг баримтын болон ярилцлагын аргаар тодорхойлох. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг бодит байдал дээр нь ажиглах, хуулийн эх баригчидтай уулзалт ярилцлага хийх замаар оролцоог хэрхэн хангаж байгаа, түүний үр дүн, ололт, бэрхшээлийг хэрхэн үзэж буйг тодорхойлох

***Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгох талаар саналаа томьёолох***. Хууль, Улсын их хурлын шийдвэрийн төсөл, боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон бусад хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд оролцоог хангах талаар тусгасан зохицуулалтыг харьцуулан судлах, мөн сонгож судалсан гадаад орнуудын сайн туршлага, хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах талаарх төрийн байгууллагын асуулга, иргэд, ТББ-ын асуулгын судалгаанаас хийсэн дүгнэлт зэрэгт үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд иргэд, олон нийтийн оролцоог хангахтай холбоотой харилцааг хэрхэн тусгах талаар саналаа томъёолон зөвлөмж болгох

***Тайлан, зөвлөмж боловсруулах.*** Дээрх бүх судалгааны үр дүнд хуулийн төсөл боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах, саналыг нь авч тусгах ажиллагаа хэрхэн явагдсан, явагдаж байгаа, тухайн харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд хэрхэн зохицуулах болон зохион байгуулалт, арга зүйн хувьд цаашид анхаарах асуудлын талаар дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж, эрх зүйн зохицуулалтын талаарх саналын үндэслэлээ тодорхойлох

***Хэлэлцүүлэг хийх, гарсан саналыг тусгах.*** Боловсруулсан санал, зөвлөмжөө төслийн зүгээс тдорхойлсон холбогдох байгууллага, хүмүүсээр хэлэлцүүлж гарсан саналыг тусгав.

**АГУУЛГА**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ....................................................... 8**

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА....11**

**2.1. ӨМНӨД АФРИК...........................................................................................11**

2.1.1. Эрх зүйн орчин...........................................................................................12

2.1.2. Олон нийтийн оролцооны арга, талууд....................................................17

2.1.3. Тулгамдаж буй асуудал.............................................................................20

**2.2. КАНАД УЛС...............................................................................................22**

2.2.1. Эрх зүйн орчин...........................................................................................22

2.2.2. Олон нийтийн оролцооны арга, талууд....................................................25

2.2.3. Тулгамдаж буй асуудал.............................................................................28

**2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС........................................................30**

2.3.1. Эрх зүйн орчин...........................................................................................30

2.3.2. Олон нийтийн оролцооны арга, талууд....................................................36

**2.4. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС................................................................38**

2.4.1. Эрх зүйн орчин...........................................................................................38

2.4.2. Олон нийтийн оролцооны арга, талууд....................................................42

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО: МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА.........................................................................................44**

3.1. Эрх зүйн орчин...............................................................................................44

3.2. Олон нийтийн оролцооны арга, талууд........................................................50

3.3. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар тусгасан зохицуулалтын харьцуулалт...............................................................................................................53

**3.4.Зөвлөмж.......................................................................................................63**

**3.5. Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаар сонгосон жишээн дээр хийсэн судалгаа.............................64**

3.5.1. Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн төсөл.........................64

3.5.2. Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл..68

3.5.3. Гэр бүлийн тухай хуулийн төсөл...............................................................71

3.5.4. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль /2014.06.13-нд батлагдсан/....................................................................................................72

3.5.5. Тамхины хяналтын тухай хууль /2012.10.24-нд батлагдсан/......................74

3.6. Иргэний оролцооны тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хийсэн ажиглалт....................................................................................................76

3.7. Хууль санаачлагчдаас авсан асуулгын дүн..................................................77

3.8. Төрийн бус байгууллагаас авсан анкетын судалгаа.....................................81

3.9. Иргэдээс авсан анкетын судалгаа.................................................................84

3.10. Тулгамдаж буй асуудал...............................................................................86

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.................................................92**

4.1. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж.............................................................................92

4.2. Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмж....................................................................................................95

4.3. Хууль боловсруулахад олон нийтийн оролцоог хангах чиглэлээр “Хууль тогтоомжийн тухай” хуулийн төсөлд тусгах санал.............................................103

**ХАВСРАЛТУУД**

**ХАВСРАЛТ 1** / Хууль санаачлагчдаас авсан анкетийн судалгаа/......................108

**ХАВСРАЛТ 2** / Төрийн бус байгууллагуудаас авсан анкетийн судалгаа/..........124

**ХАВСРАЛТ 3** / Хуулийн төсөл боловсруулахад иргэдийн оролцоог хэрхэн хангаж буй талаар иргэдээс авсан анкетийн судалгаа/.....................................131

**ХАВСРАЛТ 4** / Хууль санаачлагчдын цахим хуудсанд хийсэн ажиглалт/.........149

**ХАВСРАЛТ 5** /ОУПХ-оос гаргасан парламентын цахим хуудасны сайн практикийн талаарх зөвлөмжийг монгол улсын парламентын цахим хуудастай харьцуулах нь/...............................................................................................161

**ХАВСРАЛТ 6** /Ашигласан материалын жагсаалт/.............................................165

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Төрт ёсны түүхэн хугацаанд дэлхий дахинаа ардчиллын тухай хэд хэдэн төрлийн онолын үндэслэл бүхий ойлголтууд хөгжиж, хэрэгжсээр ирсэн. Монгол Улс 1990-д оноос хойш төлөөллийн ардчиллыг идэвхтэй баримталж байна.

Төлөөллийн, зөвлөлдөх /deliberation/, итгэмжлэлийн /delegative/, шууд гэх мэт ардчиллын олон төрөл хэлбэрүүд байх ба улс үндэстнүүд эдгээр ардчиллын төрөл хэлбэрүүдийн зөвхөн аль нэгийг нь сонгон авч идэвхтэй баримтлах бус төрийн тогтолцоо, үйл ажиллагааны үе шат бүрт аль тохирохыг нь хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Жишээ нь, хууль тогтоох байгууллага нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх гол байгууллага болох боловч зарим төрлийн шийдвэр эсхүл хуулийг батлан гаргахаас өмнөх шатанд шууд ардчиллын аргуудыг хэрэглэх тохиолдол элбэг байна. Энэхүү судалгааны явцад зөвлөлдөх ардчиллын хэлбэрүүд болох хэлэлцүүлэг, цахим хэлэлцүүлэх, иргэдтэйгээ зөвлөлдөх талаар тодруулж авч үзнэ. Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалын байгууллагад тодорхой хэм хэмжээ тогтоох эрхээ хуульд заан доош шилжүүлдэг (Delegative power) бол иргэд хуулийн төсөл боловсруулах явцад өөрсдийн эвлэлдэн нэгдсэн төрийн бус байгууллагаараа дамжуулан/ итгэмжлэн өөрсдийн эрхийг хамгаалах буюу саналаа тусгуулдаг итгэмжлэлийн ардчилал (Delegative democracy) нь дээшээ чиглэснээрээ ялгаатай ойлголт юм.

Судалгаанаас харахад нийтийн албаны зардал, татвар өндөр орнуудад төлөөллийн ардчилал илүү хөгжсөн байх бол харин шууд ардчилал хөгжсөн улс орнуудад энэхүү үзүүлэлт бууралттай байдаг байна.[1]

Шууд ардчиллын үр дүнд ард нийт нь төрийнхөө үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байх, чинээлэг цөөнхийн гэхээсээ илүү олон нийтийн эрх ашигт нийцсэн хууль батлагдах гэх мэт олон давуу тал байх боловч төрийн тогтвортой бодлого баримтлах чадвар алдагдах, шийдвэр гаргах зардал өсөх, популист удирдагчдын үйл ажиллагаа идэвхижсэний үндсэн дээр санал өгөгч иргэд төөрөгдөлд автах гэх мэт сул талууд үүсдэг.

Хуулийн төсөлд олон нийтээс санал авах нь эцсийн шийдвэрийг батлах эрх биш хэдий ч шууд ардчиллын шинж чанарыг агуулж байгаа үйл ажиллагаа мөн билээ.

Шууд ардчиллын олон аргууд байдаг. Үүн дотроос дурдаж болох онцлог арга бол орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан олон нийтийн оролцоог хангах арга юм. Хамтарсан цахим ардчилал[2] нь оролцогч иргэн бүр шууд, эсхүл шууд бусаар прокси төлөөллийг ашиглан өөр өөр бодлогын салбарын тодорхой асуудалд санал өгөх замаар оролцох боломж юм. Энэ аргыг анх 2009 онд судлаач Петрик Клаус танилцуулсан юм.[3] Иргэн бүр данстай байх ба түүгээрээ дамжуулан шууд саналаа илэрхийлэх эсхүл, тухайн асуудлаар илүү мэдлэгтэй, идэвхтэй этгээдэд өөрийнхөө өмнөөс санал өгөх эрхийг олгож болох юм. Манай улс шиг уудам газар нутагтай, иргэд нь тархан суурьшсан бөгөөд асуудал бүрийг судлан, идэвхтэйгээр санал өгөх нөхцөл бага тохиолдолд хөдөө орон

[1] Manfred G.Schmidt, “Political performance and types of democracy: Findings from comparative studies”, 2002, European Journal of Political Research, 1566-р тал.
[2] http://en.wikipedia.org/wiki/Collaborative_e-democracy
[3] http://en.wikipedia.org/wiki/Collaborative_e-democracy.

нутгийн багийн гишүүд асуудал бүрээр өөрийн багийн идэвхтэй, илүү мэдлэгтэй нэгнээ томилж санал өгүүлэх гэх мэт арга хэрэглэж болох юм. Мөн энэ технологи нь иргэд хоорондоо идэвхтэй хэлэлцэх, мэтгэлцэх боломжийг олгох бөгөөд нэг иргэний гаргасан санааг олон тооны[4] хүн дэмжсэн бол түүнийг хууль санаачлагчдад хүргүүлж хуулийн төсөл болгох хүртэл эрх зүйн зохицуулалт оруулах боломжтой.

Мөн Ann Seidman болон Robert B. Seidman нар[5] батлагдан гарсан хуулиуд олон нийтийн эрх ашигт бүрэн нийцсэн байж чадахгүй байгаагийн учир шалтгааныг судлан үзэж, дараах дүгнэлтийг хийжээ:

"..."ардчилал" гэдэг нэр томьёог дан ганц өрсөлдөөнтэй сонгууль гэж тодорхойлох нь хангалтгүй. ... Хүмүүс төвтэй хөгжлийн талаарх популист мөрөөдлийн бүтэлгүйтлийг тайлбарлахын тулд хууль тогтоох процессыг судлаад зогсохгүй, ихэвчлэн хүнд сурталтай, нууцлалын ард явагддаг хуулийн төсөл боловсруулах үйл явцыг судлах шаардлагатай гэж үзсэн байдаг.

Пост-колони, пост-апартейд, пост-коммунист улсад аль алинд нь ардчилсан үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд хуучин, авторитар дэглэмийн тогтолцоог өөрчлөхөд чиглэсэн хууль батлах шаардлагатай. 20 дугаар зууны төгсгөлд гарч ирсэн шинэ, популист засгийн газрууд нь эдгээр дэглэм, тогтолцоог өөрчлөхөд амжилт олоогүй. Өрсөлдөөнтэй сонгууль нь хууль тогтоох эрх мэдлийн гүйцэтгэгч монопол байдлыг арилгаж чадаагүй ба дэглэм, тогтолцооны өөрчлөлт хийх чадваргүй болох нь нотлогдсон. Эдгээр өөрчлөлт нь зөвхөн хүмүүсийн хандлагын өөрчлөлтийг бодитойгоор бий болгоход чиглэсэн нарийн боловсруулсан хуулиудын үр дүнд бий болно.

Хэдий тийм болович хуулийн төсөл боловсруулах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэгч, тоглогчдын асуудал бүхий хандлагын шалтгаан нь тэдгээрийн хувь хүний зан чанараас хамаараагүй. Харин хуулийн төсөл боловсруулах тогтолцоонд уг шалтгаан нь оршдог. Үүнд:

1. Хуулийн төслийг боловсруулахад наад захын танин мэдэхүйн судалгаа болон туршлага дээр үндэслэх шаардлага тавьсан зохицуулалт байдаггүй,

2. Дэглэм, тогтолцооны өөрчлөлт хийх хүмүүсийн хандлагыг өөрчлөхөд хууль тогтоомжийг ашиглаж болно гэдгийг үгүйсгэдэг улс төрчид, төрийн албан хаагчид (ашиг сонирхлын бүлгүүдийн нөлөөг онцолсон хууль тогтоох онолыг үгүйсгэх) болон тодорхой улсын нөхцөл байдлыг судлахад шаардлагатай, нийгмийн шинжлэх ухааны судалгааны ур чадвар хангалтгүй,

3. Популист арга хэмжээг эсэргүүцсэн нийтлэг үзэл бодол,

4. Албаны нууцын тухай хуулиудаар хаалттай байдлыг тогтоож, хууль батлах үйл явцад олон нийтийн хяналтыг үгүйсгэдэг,

5. Эрх мэдэл, давуу эрхтэй хэсгийн оролцоо, эргэх холбоог дэмжиж, ядуу цөөнхийн оролцоо, эргэх холбоог үгүйсгэдэг,

[4] Чухам хэдий хэр хүний дэмжлэгийг авах вэ гэсэн босгыг хуулиар тогтоож өгөх нь зүйтэй.
[5] Ann Seidman,Robert B. Seidman "Beyond Contested Elections: The Processes Of Bill Creation And The Fulfill-Ment Of Democracy's Promises To The Third World", 1997 President and Fellows of Harvard College Harvard Journal on Legislation, 1997.

6. Сонгогдсон эрх баригчид нь үнэн хэрэгтээ хуучин тогтолцооны дээд шатны, авторитар байгууллагуудын нөлөөнд байдаг.

Баримтаас харахад хуулийн төсөл боловсруулах үйл явц нь тогтолцоог олонхийн эрх ашигт нийцүүлэн шинэчлэх боломжтой хуулийн төсөл бий болгож чадаагүй гэдэгт гурван шалтгаан байна. 1. Төрийн албан хаагчид шинэчлэл хийхүйц хуулийн төсөл боловсруулах чадваргүй, цөөнхөд үйлчлэх үзэл санааг баримталдаг, 2. Элит байгууллагууд нь төрийн албанд тулгуурлахаас өөр аргагүй албан тушаалтнуудаар удирдуулдаг. 3. Өөрчлөлтийг эрэлхийлсэн иргэний нийгмийн бүлгүүдийн саналыг хуулийн төсөл боловсруулах явцад сонсохгүй байгаа нь тэдний урмыг хугалдаг. Эдгээр хүндрэлүүдийг даван гарахад хуулийн төсөл боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах болон төрийн албан хаагчид, сонгогдсон албан тушаалтнуудыг хууль тогтоомжийг туршлага дээр үндэслэн бий болгох, үнэлэхэд чиглүүлж өгөх хууль тогтоох үзэл баримтлалыг бий болгох шаардлагатай...Хууль тогтоох үзэл баримтлал нь ...хандлагын өөрчлөлтийг тусгах л боломжтой. Харин нээлттэй, хариуцлагатай хуулийн төсөл боловсруулах үйл явц дахь холбогдох баримт, учир шалтгааныг гарган тавих зорилго бүхий олон нийтийн идэвхитэй оролцоо л аливаа байгууллагын өөрчлөлт олон нийтэд ашигтай байх нөхцөлийг хангана." гэж үзээд хуулийн төслийг ул суурьтай хийсэн судалгаан дээр үндэслэх, нийгмийн чиглэлээр судалгаа хийх чадвартай төрийн албан хаагчдыг ажиллуулах, нууцлалын талаарх хууль тогтоомжийг дахин хянаж, олон нийтийн санал авах боломжтой хуулийн тоог нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ авахыг судлаачид зөвлөжээ. Мөн шийдвэр гаргах эрх бүхий этгээд /байгууллага/-ийг шинээр сонгон гаргасны дараа тухайн этгээд хүнд суртал бүхий, чадвар муутай тогтолцоог өөрчлөх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхгүй бол уг тогтолцоо нь шинээр гарч ирсэн этгээд /байгууллага/-ийг өөрийг нь өөрчилчихдөг болохыг сануулсан байна.[6]

Тохиромжтой хууль тогтоох онолын дагуу судалгааны тайланг хуулийн төслийн хамт гаргахыг шаардсан дүрэм журам баталснаар хоёр үр дагавар үүснэ. Нэгдүгээрт, хуулийн төсөл нь түүнийг бэхжүүлэх судалгааны чанар дээр суурилж байгаа тул хуулийн төслийн чанар сайжрах магадлалтай. Судалгааны тайлангийн агуулгыг тодорхой болгосноор эрх баригчид хуулийн төсөл боловсруулагч нь хуулийн төсөл нь 1. Шийдвэрлэхээр зорьж буй асуудал бүхий хандлагын шалтгааныг хангалттай тусгасан, 2. Эдгээр шалтгаануудыг даван гарах хувилбар бүхий шийдлүүдийг санал болгосон, 3. Санал болгож буй шийдлүүдээс зардал болон үр ашгийг харьцуулсны үндсэн дээр сонголт хийсэн байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хийгдэх шаардлагатай судалгааг нарийвчлан тодорхойлж чадна. Эрх зүйн актын төсөл боловсруулснаар хуулийн төсөл боловсруулагчид хуулийн төслөө туршлага дээр суурилан боловсруулах илүү магадлалтай болно. Уг судалгааны тайлан нь хуулийн төслийн гол чанарын хяналтыг бий болгоно.

Хоёрдугаарт, хуулийн төслийг ямар ч сайд, кабинет, парламентын гишүүн өнгөн талаас нь үнэлэх боломжгүй. (Төв банкны тухай хуулийг зөвхөн өнгөн талаас нь дүгнэх нь боломжгүй) Хангалттай судалгааны тайлангүйгээр үүрэг бүхий улс төрийн эрх мэдэлтнүүд нь нэг бол хууль боловсруулах эрх мэдлээ

[6] Ann Seidman,Robert B. Seidman "Beyond Contested Elections: The Processes Of Bill Creation And The Fulfill-Ment Of Democracy's Promises To The Third World", 1997 President and Fellows of Harvard College Harvard Journal on Legislation, 1997.

мэргэжилтнүүдэд шилжүүлнэ, эсвэл туршлага дээр суурилсан үндэслэл байхгүй хуулийн төслийг батална.

Хамгийн гол нь тогтолцооны шинэчлэлийг бий болгох боломжтой хуулийг боловсруулах, хэрэгжүүлэхэд хууль боловсруулах үйл явцад оролцоог хангах шинэ дүрэм журмууд шаардлагатай. Зөвхөн олон нийтийн оролцоог хангахад чиглэгдсэн дүрэм журмаар л шинэчлэл хийх шинж чанар бүхий хууль тогтоомжийг нийтлэхэд олон албан тушаалтны гаргадаг чирэгдэлд орших хоёр харилцан хамаарал бүхий шалтгааныг даван гарах боломжтой: 1. Төрийн албан хаагчдын авторитар үзэл санаа, 2. Одоогийн төлөв байдлыг үргэлжлүүлэх сонгогдсон албан тушаалтнуудын ашиг сонирхол, үзэл санааны тогтсон хандлага. Эдгээр шалтгаанууд нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж байх ба шийдвэр гаргах тогтолцоонд хийсэн анализийн дүнгээс харвал төрийн албан хаагчид, улс төрчид олон нийтийн саналыг авахгүйгээр хууль тогтоох ажиллагааны үр дүн нь популист зарчмаас илүүтэйгээр эрх мэдэл, эрх ямбыг нэмэгдүүлнэ гэж судлаачид онцолж байна.

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны талаарх бусад улсын зохицуулалтыг шууд хуулбарлан авах нь тухайн нэг оронд шууд тохирох боломжгүй. Харин, өөрийн орны онцлог, ард иргэдийн асуудалд хандах чиг хандлага, төрийн байгуулалтын тогтолцоо гэх мэт нөхцөл байдлыг сайтар судлан үзсэний үндсэн дээр тохирох зохицуулалтыг бий болгох шаардлагатай.[7]

Жишээ нь, хоёр Герман улс нэгдэхээс өмнө Ардчилсан бүгд найрамдах герман улсад хууль санаачлагч санаачилсан хуулийнхаа үзэл баримтлалыг тухайн хуулийг боловсруулах шатанд хэрхэн олон нийтийн оролцоог хангах, уулзалт, хэлэлцүүлгийн хувиарыг тодорхой бичиж хүргүүлдэг байсан нь маш үр дүнтэй байсан гэж судлаачид дүгнэдэг.[8]

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Бид энэхүү судалгааны явцад хуулийн төсөл боловсруулах явцад иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар бусад улс орнууд эрх зүйн ямар зохицуулалт хийдэг, оролцоог практикт хэрхэн хангадаг талаар зарим орны жишээн дээр судалсан юм. Хуулийн төсөл боловсруулахад оролцоог манай улсад хэрхэн хангаж байгаатай харьцуулах, Хуулийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгоход өгөх саналаа тодорхойлох зорилгоор хөгжингүй болон хөгжиж байгаа улс, нэгдсэн болон холбооны улс,  газарзүйн байрлал, оролцооны ардчиллыг хөгжүүлэх талаар зохих туршлага бүхий гэж тооцогддог байдлыг харгалзан тодорхой улсыг сонгон мэдээлэл цуглуулж зохих анализ хийлээ. Үүнд ӨАБНУ, Канад, Өмнөд солонгос, Польш зэрэг улсуудын жишээг авч үзлээ.

### 2.1. ӨМНӨД АФРИК

[7] Ann Seidman, Robert B. Seidman “Beyond Contested Elections: The Processes Of Bill Creation And The Fulfill-Ment Of Democracy's Promises To The Third World”, 1997 President and Fellows of Harvard College Harvard Journal on Legislation, 1997.
[8] Ann Seidman , Robert B. Seidman “Beyond Contested Elections: The Processes Of Bill Creation And The Fulfill-Ment Of Democracy's Promises To The Third World”, 1997 President and Fellows of Harvard College Harvard Journal on Legislation, 1997.

### 2.1.1. Эрх зүйн орчин

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ) нь төлөөллийн ардчилал бүхий[9], парламентын бүгд найрамдах улс бөгөөд 54 сая хүн амтай[10], эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд 34 дүгээр байранд[11] ордог. ӨАБНУ нь хэд хэдэн эрх зүйн тогтолцооны нийлбэрээс үүссэн холимог эрх зүйн тогтолцоотой.[12] 1993 оны Завсрын Үндсэн хуулиараа ардчилсан тогтолцоонд шилжсэн ба улс төрийн намуудын зөвшилцлийн үндсэн дээр 1994 онд анхны арьс өнгөөр ялгаварлаагүй сонгуулийг явуулсан.[13]

***Хууль тогтоох процесс.*** ӨАБНУ-ын Үндсэн хуулийн 73 дугаар хэсэгт зааснаар Гүйцэтгэх эрх мэдлийн гишүүн болон тухайн Парламентын танхимын гишүүн, хороо хуулийн төслийг Парламентад танилцуулах эрхтэй. Үүнээс гадна Үндсэн хуулийн 55, 68 дахь хэсгүүдэд зааснаар Парламентын аль аль танхим нь хууль санаачлах эрхтэй байна. Хууль тогтоох ажиллагааны эхний үе шатанд хуулийн төслийг санаачлах, боловсруулах нь албан ёсны гүйцэтгэх эрх мэдлийн зөвшөөрлөөс хамаардаг.[14] Үүний дараагаар хуулийн төслийг зарчмын хувьд батлуулахаар засгийн газрын Кабинетэд өгдөг. Хуулийн төслийг Кабинетээр баталсны дараа тухайн хуулийн төслийн зорилгыг тайлбарласан илтгэх хуудсын хамтаар хуулийн төслийг Парламентэд явуулна.[15] Хуулийн төсөл нь Кабинетээр батлагдсаны дараагаар Ерөнхий Төрийн Хуулийн Зөвлөх (Chief State Law Adviser)-ийн газарт хүргүүлдэг ба энэ газраас баталгаажсан эсэхээс үл хамааран Парламентын хуулийн төслийн газар руу хүргүүлдэг. Парламентын танхимуудын дүрэмд зааснаар хуулийн төслийг парламентад танилцуулахаас 30 хоногийн өмнө хуулийн төслийн танилцуулгыг, хуулийн төсөлд олон нийтийн санал өгөх урилгын хамтаар Засгийн газрын албан ёсны хэвлэлд нийтэлнэ.[16]

Хуулийн төслийн Парламентын танилцуулга нь тухайн танхимын дүрмийн дагуу явагдах ба үүний дараа хорооны үе шатаар дамжина. Энэ үе шатанд мөн олон нийтийн оролцоог хангах ажиллагаа хийгддэг. Ингэснээр хуулийн төслийг тухайн танхимаар шийдвэрлүүлэхээр Дараалын Хуудас (Order Paper)-т байрлуулах ба тухайн танхимаар батлагдсан тохиолдолд нөгөө танхим руу явуулдаг ба хоёр дахь танхимд мөн хороогоор дамжин, хуралдааны үе шат буюу Дараалын хуудаст байрлуулдаг. Дараагийн шатанд хуулийн төслийг Ерөнхийлөгчид уламжилж, Ерөнхийлөгч гарын үсэг зурснаар хуулийг нийтэлж, Парламентын хууль болдог.

---

[9] Politics of South Africa, http://en.wikipedia.org/wiki/Politics_of_South_Africa , 2014.11.27.
[10] Mid-year population estimates 2014, http://beta2.statssa.gov.za/publications/P0302/P03022014.pdf, 2014.11.7.
[11] South Africa, http://en.wikipedia.org/wiki/South_Africa#Politics, 2014.11.7.
[12] http://en.wikipedia.org/wiki/Law_of_South_Africa 2014.11.27.
[13] South Africa - 20 Years of Democracy, http://www.sahistory.org.za/article/south-africa-20-years-democracy , 2014.11.27.
[14] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 2-р тал.
[15] Мөн тэнд.
[16] Rules of the National Assembly, South Africa, 241-р дүрэм, Rules of the National Council of Provinces, South Africa, 186-р дүрэм.

## ӨАБНУ-ЫН ХУУЛЬ ТОГТООХ ПРОЦЕСС

Хуулийн төслийг Үндэсний Асамблей болон Үндэсний бүс нутгуудын зөвлөл (парламентын танхимууд)-д танилцуулна.

↓

Холбогдох хороо руу шилжих ба олон нийтийн саналыг авахаар засгийн газрын албан ёсны хэвлэлд нийтэлнэ.

↓

Хороогоор хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулна.

↓

Санал хураахаас өмнө дахин хэлэлцүүлэхээр аль нэг танхимын хуралд шилжинэ.

↓

Нөгөө танхимаар мөн адил процессыг дамжина.

↓

Баталгаажуулахаар ерөнхийлөгчид шилжинэ

↓

Хуулийг батлах

***Үндсэн хууль.*** ӨАБНУ-ын Үндсэн хуулийг (Үндсэн хууль) тус улсын анхны ардчилсан сонгуулиас сонгогдсон Парламент 1996 онд боловсруулсан. Үндсэн хууль нь шинж чанараараа оролцоог хангасан ардчилсан нийгмийг бий болгохоор зорьсон. [17] Үндсэн хуулийн 1 дэх хэсэгт зааснаар ӨАБНУ-ын үндсэн зарчим нь хариуцлагатай, уриалгахан, нээлттэй байдлыг хангах ардчилсан төрийн систем юм. Энэ нь Үндсэн хуулинд хууль тогтоогч нь төлөөллийн, оролцоог хангасан ардчилал болон олон нийтийн оролцоог хангах талаарх шаардлагуудаар илэрхийлэгдсэн.[18]

ӨАБНУ-ын хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулиндаа зааснаар үндэсний хэмжээнд Үндэсний Асамблей болон Үндэсний Консулаас бүрдэх Парламент болон бүс нутгуудийн хэмжээнд бүс нутгийн хууль тогтоох байгууллага болон Бүс нутгийн Консулууд хэрэгжүүлдэг. [19] Үндэсний Асамблей нь ард түмнийг төлөөлж, Үндсэн хуулийн дагуу ард түмний засгийн газрыг баталгаажуулахаар сонгогддог[20] бол Үндэсний Бүс нутгуудын консул нь үндэсний засгийн газрын хэмжээнд бүс нутгийн ашиг сонирхлыг харгалзан үзэж байгааг хангахад бүс нутгаа төлөөлдөг.[21]

Үндсэн хуулинд хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоог зохицуулсан хэд хэдэн зохицуулалт байдаг. ӨАБНУ-ын Үндсэн Хуулийн 59(1)(а), 72(1)(а),

---

[17] Deliberations of the International Conference on Public Particpation, The People Shall Govern: Public Participation Beyond Slogans Hosted by the Gauteng Provincial Legislature Johannesburg, 2012, 175-р тал.

[18] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010,26-р тал.

[19] Constitution of South Africa, South Africa, 1996, 43-р зүйл.

[20] Constitution of South Africa, South Africa, 1996, 42.3 дахь хэсэг.

[21] Constitution of South Africa, South Africa, 1996, 42.4 дахь хэсэг.

118(1)(a)-д хууль тогтоогч нь өөрийн болон түүний хороодын хууль тогтоох болон бусад ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих үүрэгтэй байхаар заасан. Мөн дээрх зүйлүүдэд зааснаар хууль тогтоогч нь үйл ажиллагаагаа нээлттэй явуулж, өөрийн болон өөрийн хороодын хурлыг нийтэд нээлттэй явуулна.[22]Хууль тогтоогчид нээлттэй, ардчилсан нийгэмд үндэслэлтэй, зүй ёсны гэж тооцогдохоос бусад тохиолдолд хороодын хуралд олон нийт болон мэдээллийн хэрэгслийг оруулахгүй байж болохгүй.[23]

Үндсэн хуулинд дээрх байдлаар хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах ерөнхий шаардлагыг заасан боловч олон нийтийн оролцоог хангах дэлгэрэнгүй зааварчилгааг өгөөгүй ба эдгээр нь олон нийтийн оролцооны тусгайлсан бодлого, стратегиар илрэн гарах ёстой.[24] Харин Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлд Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах дэлгэрэнгүй процессийг заасан байна. Үндсэн хуулийн 73(2)-т заасны дагуу Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг танилцуулахаас хамгийн багадаа 30 хоногийн өмнө төслийг танилцуулах гэж буй хүн эсвэл хороо нь Засгийн газрын албан ёсны хэвлэлд хэвлэж, Үндэсний Асамблейн дүрэм, тогтоолын дагуу олон нийтээс тайлбар авахаар төслийн дэлгэрэнгүйг хэвлэх үүрэгтэй байна. [25] Төслийг танилцуулах үед танилцуулж буй хүн эсвэл хороо нь олон нийт болон бүс нутгийн хууль тогтоох байгууллагаас бичгээр авсан саналыг гаргах ёстой.[26]

Мөн Үндсэн хуулийн 56, 69, 115 дугаар зүйлд Үндэсний Асамблей, Үндэсний Консул, бус нутгийн хууль тогтоох байгууллага, тэдгээрийн хороод нь:

*(a) тангараг, баталгааны нотлох баримт өгүүлэх, бичиг баримт гаргуулахаар аливаа хүнийг дуудах,*
*(b) аливаа хүн, байгууллагыг өөрт нь тайлагнахыг шаардах,*
*(c) а, б хэсгийн дагуух дуудлага, шаардлагыг биелүүлэхийг үндэсний хууль тогтоомж, дүрэм, тогтоолын дагуу албадах,*
*(d) аливаа сонирхсон хүн, байгууллагаас хүсэлт, төлөөлөл, мэдүүлгийг хүлээн авч* болохоор зохицуулсан байна.

Мөн Үндсэн хуулийн 195(1)(e)-д нийтийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ ард түмний хэрэгцээ шаардлагад хариулт өгөх ёстой ба олон нийт бодлого боловсруулахад оролцохыг дэмжих ёстой гэж заасан. Дээрх зохицуулалтуудаас харахад ӨАБНУ-ын Үндсэн хуулинд хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангах зохицуулалт оруулсан байгаа нь энэ үйл явц дахь олон нийтийн оролцоог баталгаажуулах чухал алхам бөгөөд олон нийтийн оролцоог хангахыг зорьж буй бусад улсуудад туршлага болохуйц онцлог зохицуулалт байна.

ӨАБНУ-ын Парламентын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах нь тус улсын Парламентын онцлог шинж юм. ӨАБНУ-ын Үндсэн хуулиас гадна бүс нутгийн хууль тогтоох байгууллагууд өөрийн Үндсэн хуулийг батлан гаргах боломжтой байдаг. Жишээ нь, Вэстэрн Кэйп мужийн Үндсэн хууль[27]-ийн 28.3

[22] Constitution of South Africa, South Africa, 1996, 59(1)(b), 72(1)(b), 118(1)(b) дахь хэсэг.
[23] Constitution of South Africa, South Africa, 1996, 59(2), 72(2), 118(2) дахь хэсэг.
[24] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 69-р тал.
[25] Constitution of South Africa, South Africa, 1996, 74(5)(a) дахь хэсэг.
[26] Constitution of South Africa, South Africa, 1996, 74(6) дахь хэсэг.
[27] Constitution of the Western Cape, Western Cape, South Africa, 1998.

дахь хэсэгт Бүс нутгийн парламент нь өөрийн болон хороодын үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангах ёстой хэмээн заасан.

***Олон улсын болон бүс нутгийн үүрэг.*** Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19, 25 дугаар зүйлүүдэд олон нийтийн асуудалд оролцох ерөнхий эрх болон сонгох, сонгогдох эрхийг тусгасан. ӨАБНУ-ын Үндсэн хуулийн шүүх энэхүү пакт нь иргэддээ улс төрийн оролцоог хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулахээрэг арга хэмжээг авах үүргийг бий болгож байна гэж үзсэн.[28]

Дээрхээс гадна Африкийн хүний эрхийн дүрмийн 13-р зүйлд шууд болон чөлөөтэй сонгогдсон төлөөллөөр дамжуулан засгийн газарт оролцох эрхийг заасан. Мөн энэхүү дүрмийн 25-р зүйлд энэхүү дүрэмд заасан эрх, эрх чөлөөг сургалт, боловсрол, нийтлэлээр дамжуулан сурталчлах, баталгаажуулах үүргийг заасан. Шүүх энэхүү үүрэг нь дээр дурдсан пактад зааснаас илүү тодорхой байдлаар гишүүн орнуудын иргэдийн улс төрийн эрхийн талаар мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан гэж үзсэн.[29] Хэдий тийм боловч дээрх олон улсын баримт бичгүүдэд шууд хууль тогтоох процесст иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар зохицуулалт байхгүй. Харин дээрх заалтуудын дагуу ӨАБНУ зөвхөн хууль тогтоох процесст бус, улс төрийн оролцоог хангах зохицуулалтыг дотоодын хууль тогтоомждоо тусган, иргэн, олон нийтийн оролцоог хангах алхамыг хийх шаардлага тавигдаж байна гэж үзэх боломжтой.

***Бусад хууль.*** Нутгийн захиргааны түвшинд, Нутгийн захиргааны зохион байгуулалтын хууль[30] болон Нутгийн захиргааны тогтолцооны хуулиар[31] орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоог хангах шаардлагыг заасан. Эдгээр хуулиудад эрх зүйн дэд акт гаргах зэрэг орон нутгийн засгийн газрын асуудалд олон нийтийн оролцоог хангах талаар заасан.[32] Нутгийн захиргааны тогтолцооны хуулийн 4-р бүлэгт нутгийн захиргаан дахь нийгмийн оролцооны талаар зохицуулсан ба энэ бүлгийн 16-р хэсэгт нутгийн захиргаа нь оролцоог хангасан удирдлагын систем бүхий албан ёсны төлөөллийн засгийн газрыг бий болгосон нутгийн захиргааны удирдлагын соёлыг хөгжүүлэх ёстой гэж заасан байна. Мөн энэ хэсэгт нутгийн захиргааны үйл хэрэг дэх нийгмийн оролцооны арга, хэлбэрийн талаар зохицуулсан. Харин Үндсэн хуулиас гадна хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоог шууд зохицуулсан бусад хууль тогтоомж ӨАБНУ-д байхгүй ба хууль тогтоох байгууллагуудын дүрэм зэрэг бусад эрх зүйн актуудаар зохицуулсан байна.

***Бусад эрх зүйн акт.*** Үндэсний Асамблейн дүрэм (Rules of the National Assembly), Үндэсний Бүс нутгийн консулын дүрэм (Rules of the National Council of Provinces), Парламентын нэгдсэн дүрэм (Joint Rules of Parliament)-ээр Үндсэн хуулийн олон нийтийн оролцоог хангах заалтыг баталгаажуулж, үндэсний болон бүс нутгийн түвшинд хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах үйл явцын талаар зохицуулсан.

Үндэсний Асамблейн дүрэм болон Үндэсний бүс нутгийн консулын дүрэмд зааснаар энгийн хуулийн төсөл (мөнгөний (Money Bill) болон үндсэн хуулийн

[28] Legislative Sector South Africa, Public Participation Framework for the South African Legislative Sector, 2013, 7-р тал.
[29] Мөн тэнд.
[30] Municipal Structures Act, South Africa, 1998.
[31] Municipal Systems Act, South Africa, 2000.
[32] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 10-р тал.

төслөөс бусад бүх хуулийн төсөл)-ийг Үндэсний Асамблей болон Үндэсний бүс нутгийн консулд танилцуулахаас өмнө Засгийн газрын албан ёсны хэвлэлд хуулийн төслийн урьдчилсан мэдэгдлийг нийтлэх ба үүнд олон нийтийн зүгээс санал өгөх урилгыг багтаасан байна.[33] Үүний дараагаар холбогдох хууль тогтоох хороонууд нь мэдэгдэл, аман мэдэгдэл, нийтийн сонсголыг зарлаж эсхүл нэмэлт олон нийтийн оролцооны арга хэмжээг эхлүүлнэ.[34] Олон нийт хууль тогтоох процесс болон хорооны хуралдаанд оролцох, эдгээр ажиллагаануудын мэдээллийг олж авах эрхтэй.[35]

Мөн бүс нутгийн хэмжээнд, хууль тогтоох байгууллагууд өөрсдийн гэсэн нийтийн оролцооны журам, үйл явцтай байдаг ба эдгээр нь хоорондоо ялгаатай байдаг. ӨАБНУ-ын арван хууль тогтоох байгууллагын (парламент болон 9 мужийн хууль тогтоох байгууллага) 5 нь олон нийтийн оролцоог хангах бодлоготой.[36] Жишээ нь: ӨАБНУ-ын Ийстэрн Кэйп Бүс нутгийн хууль тогтоох байгууллагын тогтоол (Eastern Cape Provincial Legislature's Standing Orders)-ын 32 дугаар дүрэмд олон нийтийн оролцоог хангах дараах зохицуулалтыг оруулсан байна.

> *32.1. Хууль тогтоогч болон түүний хороод нь түүний хууль тогтоох болон бусад процесст дараах зүйлсийг хэрэгжүүлэх замаар олон нийтийн оролцоог хангах үүрэгтэй:.*
>
> > *32.1.2. Мөнгөний болон техникийн хуулийн төслүүдээс бусад төслүүд дээр нийтийн сонсгол явуулах*
> > *32.1.3. Үндэсний чухал хуулийн төслүүдэд нийтийн сонсгол зохион байгуулах*
> > *32.1.4. Олон нийтээс хүсэлт хүлээн авах*
> > *32.1.5. Өөрсдийн Хууль тогтоогчийн үүргийн дагуу олон нийтэд боловсрол олгох*
>
> *32.2. Хууль тогтоогч болон түүний хороод нь олон нийтээс ирсэн бүхий л санал, хүсэлтийг анхаарч үзэх ёстой.*

***Шүүхийн тайлбар.*** ӨАБНУ-ийн Үндсэн Хуулинд заасан хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах үүрэг нь зөвхөн тунхаг шинжтэй биш гэдгийг ӨАБНУ-ын Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцооны талаар гурван тохиолдол дээр харуулсан (Мататиэлийн хэрэг, Үндэсний Асамблейн дарга болон Үндэсний Бүс нутгуудын зөвлөлийн даргын эсрэг Амьдралын төлөөх эмч нарын хэрэг [Doctors for Life case]; ӨАБНУ-ын Ерөнхийлөгчийн эсрэг Мерафонг хил тогтоох форумын хэрэг [Merafong case]). Үндсэн хуулийн шүүх хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоо нь тухайн хууль тогтоомжид нөлөөлөх магадлалтай хүмүүс саналаа амаар болон бичгээр гаргах боломж юм гэж тайлбарласан.[37] Парламент дахь хууль тогтоох процессийн талаар 2010 оны Нэгдсэн Даалгаврын Багийн бэлтгэсэн Парламентын хууль тогтоох үйл явцын талаархи тайланд[38] дээрх хэргүүд дээрх

[33] Rules of the National Assembly, South Africa, 241-р дүрэм, Rules of the National Council of Provinces, 186-р дүрэм.
[34] Joint Rules of the Parliament, South Africa, 32-р дүрэм, Rules of the National Assembly, South Africa, 138-р дүрэм, Rules of the National Council of Provinces, 103-р дүрэм
[35] Constitution of South Africa, South Africa, 1996, 59,72-р хэсэг, Joint Rules of the Parliament, South Africa, 6, 52--р дүрэм, Rules of the National Assembly, South Africa, 157-р дүрэм, Rules of the National Assembly Rules of the National Council of Provinces, South Africa, 114-р дүрэм.
[36] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 63-р тал.
[37] The People Shall Govern: Public Participation Beyond Slogans Hosted by the Gauteng Provincial Legislature Johannesburg 2012, 175-р тал.
[38] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010.

шүүхийн шийдвэрүүдээс гаргасан дүгнэлтийг дараах байдлаар хураангуйлсан байна:

- Олон нийтийн оролцоог хангах нь хууль тогтоох процессийн чухал хэсэг юм.
- Олон нийтийн оролцооны гол элементүүд нь хууль тогтоомжийн талаар мэдээллийг тараах, хууль тогтоох процесст оролцох болон хууль тогтоомжийн төслийн талаар зөвлөлдөх урилга юм.
- Хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангаагүй нь тухайн хууль тогтоомжийг хууль бус болгох үр дагавартай. Олон нийтийн оролцоог хангах цар хүрээ нь тохиолдлоосоо хамаарч өөр өөр байна. Үүнд олон нийт, сонирхсон талууд тухайн асуудлын талаар мэдээлэл авах, үг хэлэх хангалттай боломж олгогдсон байх нь чухал юм.
- Парламентын олон нийтийн оролцоог хангах талаархи эхний үүрэг нь олон нийт болон бүхий л сонирхогч талуудад хууль тогтоох процесст үр дүнтэй оролцох боломжийг бий болгох явдал бол хоёр дахь үүрэг нь олон нийт олгогдсон боломжийнхоо ашиг тусыг хүртэх боломжийг бий болгох арга хэмжээг авах явдал юм.
- Шүүх Парламентын зүгээс ямар этгээдийн оролцоог хангах вэ гэдэг асуудалд төдийлөн хөндлөнгөөс оролцохгүй.

Шүүх хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах талаарх Үндсэн хуулийн заалтууд нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангах эрх, үүргийг бий болгож байна гэж үзсэн ба хэрэв хууль тогтоогч энэхүү үүргээ зөрчсөн бол тухайн хууль хүчин төгөлдөр бус байхаар шийдвэрлэсэн. Үүний үр дүнд Үндсэн хуулийн шүүх нь хэд хэдэн хуулийг олон нийтийн оролцоог хангаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон.

Үндсэн хуулийн шүүх Мерафонгийн хэрэг дээр шийдвэрлэхдээ хууль тогтоогч нь хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах үүрэгтэй боловч энэ нь олон нийтийн саналыг хууль тогтоомжид заавал тусгахыг үүрэг болгоогүй хэмээн шийдвэрлэжээ. Хэдийгээр тийм боловч Парламент олон нийтийн санаа бодлыг харгалзан үзэх шаардлагатайг дурдсан байна. Үндсэн хуулийн шүүхийн дээрх хэргүүдийн шийдвэрүүд нь бүхий л хууль тогтоомжид нэгэн адил хамаарахгүй ч, Үндсэн хуульд заасан олон нийтийн оролцоог хангах шаардлагыг хангаагүй тохиолдолд Үндсэн хуулийн шүүх тухайн хуулийг хүчин төгөлдөр бус болгох боломжтойг харуулсан.[39] "Амьдралын төлөөх эмч нарын хэрэг" дээр шүүгч олон нийтийн оролцоог тодорхойлохдоо хууль тогтоомжиийг сонирхсон бүхий л талууд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангагдсан гэж мэдрэх ёстой гэж шийдвэртээ заасан.

ӨАБНУ нь хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах шаардлагыг Үндсэн хуулиараа зохицуулсан бөгөөд Үндсэн хуулийн шүүх нь хэд хэдэн хуулийг иргэдийн оролцоог хангаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгож байсан нь онцлог юм.

[39] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 29-р тал

## 2.1.2. Олон нийтийн оролцооны арга, талууд

ӨАБНУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тайлбарласнаар хууль тогтоогч нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангах хэлбэрийг шийдэх өргөн хүрээний эрх мэдэлтэй байх ба олон нийтийн оролцоог хангах хэлбэр нь тухайн тохиолдлоос хамаарч тохиромжтой байх шаардлагатай.[40]

***Бичгээр санал өгөх.*** Хууль тогтоох байгууллагын дүрмүүдээр хууль нь Засгийн газрын албан ёсны хэвлэлд танилцуулга хэлбэрээр нийтлэгдсэн байх шаардлагыг тавьдаг. Энэхүү танилцуулгад бичгээр санал өгөх урилга мөн хамт байдаг. Зарим тохиолдолд биечлэн амаар саналаа өгөх нь мөн нээлттэй байдаг байна.[41] Нэгдсэн даалгаврын багийн тайланд бичсэнээр ихэнх тохиолдолд бичгийн хэлбэрээр санал өгөх нь хангалттай ба дараахь тохиолдлуудад амаар мэдэгдэл гаргах нь зүйтэй гэсэн саналыг гаргажээ. Үүнд:

- *Бичгээр өгсөн мэдэгдэл нь ойлгомжгүй,*
- *Ямар нэгэн шалтгаанаар бичгээр мэдэгдэл гаргах боломжгүй бүлгийг оролцуулах,*
- *Бүгд найрамдах улсын тодорхой хэсэг газрын хүмүүст тухайн хууль тогтоомж нөлөөлөх бол.*[42]

Мөн Үндсэн хууль болон бусад холбогдох дүрэм журмаар хууль тогтоогч болон түүний хороонууд нь хувь хүмүүс болон байгууллагуудаас нотлох баримт, мэдэгдэл авах эрхийг олгосон .[43]

***Хүсэлт гаргах.*** Хууль тогтоох процесст тусгайлан заасан бичгээр мэдэгдэл гаргахаас гадна Үндсэн хуулийн 56(d), 69(d) хэсэгт зааснаар Үндэсний Асамблей болон Үндэсний бүс нутгуудийн зөвлөл нь аливаа сонирхсон хүн, байгууллагаас хүсэлт хүлээн авах эрхтэй. Мөн ӨАБНУ-ын арван хууль тогтоох байгууллагын долоо нь хүсэлт гаргах талаар эрх зүйн зохицуулалттай.[44] Бүх хууль тогтоох байгууллагууд нийтийн сонсгол, олон нийтийн боловсролын ажлын хэсгүүд дээр олон нийт хүсэлт гаргах нь нээлттэй байдаг гэж тэмдэглэжээ.[45] ӨАБНУ-ын Хууль тогтоох салбараас гаргасан "Хууль тогтоох эрх мэдлийн олон нийтийн оролцооны суурь" (Public Participation Framework, 2013)-д хүсэлт гаргах нь үндэсний болон бүс нутгийн түвшинд шууд ардчиллыг хангах хүчтэй хэлбэр хэвээр байна гэжээ.[46] Хэдий тийм боловч эдгээр байгууллагад хүсэлт гаргах стандартчилагдсан формат байхгүй байгаа гэдийг дээрх судалгаанд мөн дурдсан байна.

***Нийтийн сонсгол.*** Хууль тогтоох байгууллагууд болон түүний хороод нь нийтийн сонсгол явуулах боломжтой. Тухайн хуулийн төсөл нь онцгой ашиг сонирхолтой, эсхүл тодорхой хэсэг бүлгийн ашиг сонирхолд нөлөөлөхөөр тохиолдолд л Парламентаас гадуур зохион байгуулна.[47] Бусад тохиолдолд нийтийн сонсголыг үндэсний хэмжээнд Парламент дээр явуулна. Дээрх

---

[40] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 13-р тал.
[41] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 13-р тал.
[42] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 30-31-р тал
[43] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 14-р тал.
[44] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 87-р тал.
[45] Мөн тэнд
[46] Legislative Sector South Africa, Public Participation Framework for the South African Legislative Sector, 2013, 36-р тал.
[47] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 31-р тал.

тохиолдлуудад Парламентаас гадуур явуулах нь тодорхой ашиг сонирхол нь хөндөгдөх хэсэг бүлэгт хүрч нийтийн сонсголыг явуулах сонирхолтой холбоотой.

Үндсэн хуулийн шүүх "нийтийн сонсголыг бүх хуулийн төсөл дээр заавал явуулах үүрэггүй, тухайн тохиолдлоос хамаарч, бичгэн мэдэгдэл хангалттай байх боломжтой" гэж үзжээ. Үндэсний Асамблейн дүрмийн 138(c) хэсэг болон Үндэсний Бүс нутгийн консулын дүрмийн 103(1)(c)-д зааснаар эдгээр хууль тогтоох байгууллагын хороод нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн сонсгол явуулж болохоор заасан. Хууль тогтоох байгууллага нь нийтийн сонсгол явуулах боломжтой боловч ихэнх тохиолдолд нийтийн сонсголын урилгыг богино хугацааны өмнө зарладаг тул олон нийтэд сонсголд бэлдэхэд хангалттай хугацаа байдаггүй байна.[48]

**Бусад олон нийтийн оролцоог хангах арга хэрэгслүүд.** Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрлэснээр Парламент нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ ямар аргаар хэрэгжүүлэхийг шийдэх эрхтэй. Ингэхдээ тухайн тохиолдолд олон нийтийн оролцооны ямар арга тохиромжтойг тодорхойлох эрхтэй байна. Тухайн тохиолдолд ямар хэлбэрээр олон нийтийн оролцоог хангах нь тухайн хууль тогтоомжийн онцлог, ач холбогдол, хууль тогтоомжийн олон нийт, эсхүл тодорхой хэсэг бүлэгт үзүүлэх нөлөө зэргийг харгалзана.[49] "Мерафонгийн хэрэг" дээр Үндсэн хуулийн шүүх олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний зүй зохистой байдал гэдэгт цаг, зардал зэргийг шаардах талаар тодорхойлсон ба хэдий тийм боловч цаг, мөнгийг хэмнэсэн нь олон нийтийн оролцоог хангах боломжоор хангаагүй гэх үндэслэл болохгүй талаар заасан.

Мөн Шүүх "Амьдралын төлөөх эмч нарын хэрэг" дээр Парламентын хууль тогтоох ажиллагаанд олон нийтийн оролцоог хангалттай хангасан эсэхийг тогтоохдоо тухайн хууль тогтоомжийн агуулга, ач холбогдол, зайлшгүй шаардлагыг харгалзан олон нийтийн оролцоог хангасан эсэхийг харгалзан үзнэ гэж шийдвэртээ тусгажээ. 2011 оны байдлаар дараах нэмэлт арга хэлбэрээр хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангаж байна. Үүнд:

- *Үндэсний болон Бүс нутгийн хууль тогтоох байгууллагуудын олон нийтийн оролцооны газрууд*
- *Сонгогчдын оффис*
- *Парламентын гишүүнтэй зөвлөлдөх*
- *Парламент орон нутагт ажиллах, уулзалт зохион байгуулах*[50]

***Мэдээлэл авах арга хэрэгсэл.*** Хуулийн төслийн талаар танилцуулга болон санал өгөх урилга нь Засгийн газрын албан ёсны хэвлэлд нийтлэгдэхээс гадна сонин, радио, телевиз, интернэтээр түгээгддэг.[51] Мөн Үндсэн хуулинд зааснаар тодорхой хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд хууль тогтоох бүхий л үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй явагддаг. Мэдээллийг олж авах, сурталчлах тухай хуульд зааснаар иргэд, төрийн бус байгууллагууд мэдээлэл авах хүсэлт гаргах боломжтой.[52]

---

[48] Legislative Sector South Africa, Public Participation Framework for the South African Legislative Sector, 2013, 36-р тал.
[49] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 27-р тал.
[50] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 14-р тал.
[51] Мөн тэнд.
[52] Мөн тэнд.

Хууль тогтоогчийн өөрийн болон хороодын үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангах Үндсэн хуулинд заасан үүрэг нь зөвхөн оролцох эрхийг олгодог боловч тодорхой асуудлаар санал бодлоо илэрхийлэхээр хороодоос уригдаагүй тохиолдолд, процесст нь оролцох эрхийг олгодоггүй. Үүний үр дүнд Үндсэн хуулийн дээрх оролцооны зохицуулалт нь олон нийтийн оролцоог хангах гэхээсээ илүүтэй, мэдээлэл түгээх шинжтэй байдаг.

**Оролцооны талууд**

***Олон нийт.*** Хуульд зааснаар олон нийт нь хууль тогтоох процесст оролцох эрхтэй ба зарим тохиолдолд тухайн хууль тогтоомжийн онцлогоос хамаарч тодорхой бүлгийн оролцоог илүү хангах явдал бий.[53]

***Төрийн бус байгууллагууд.*** Хууль, эрх зүйн актуудад хууль тогтоох явцад олон нийтийн оролцоог хангахдаа төрийн бус байгууллагын оролцооны талаар тусгайлан зохицуулаагүй боловч хууль тогтоогчийн зүгээс олон нийтийн оролцоог хангах арга хэлбэрийг сонгох эрх мэдлийн хүрээнд болон Үндсэн хуулийн шүүх шийдвэртээ тодорхойлсон тухайн хуулийн онцлогоос хамаарч олон нийтийн оролцооны зүй зохистой байдлаас хамаарч мэргэжилтэнгүүд, төрийн бус байгууллагын саналд онцгой ач холбогдол өгөх боломжтой.[54] Төрийн бус байгууллагууд, бизнес, улс төрийн намууд, мэргэжилтэнгүүд, энгийн иргэд хороодын үйл ажиллагаанд оролцох, бичгээр мэдэгдэл гаргах эрхтэй байдаг ба "ихэнх төрийн бус байгууллагууд эдгээр ажиллагаанд оролцох цаг гаргадаг байна."[55]

***Үндсэн хуулийн байгууллагууд.*** Үндсэн хуулийн байгууллагууд гэдэг нь ӨАБНУ-ын Үндсэн хуулийн 9-р бүлэгт заасан үндсэн хуулийн ардчиллыг хүчирхэгжүүлэх үүрэг бүхий байгууллагууд юм. Үүнд Хүний эрхийн Комисс, Жендерийн тэгш эрхийн комисс зэрэг байгууллагууд хамаарна. Эдгээр байгууллагууд нь тус тусийн хуулиар тодорхойлсон өөрийн чиг үүргийн хүрээний асуудлууд дээр хяналт тавьж, судалгаа хийх, боловсрол олгох, лоббидох, зөвлөгөө өгөх эрхтэй.[56] Үүнд хамааралтай хууль тогтоомжийн төслийн талаар мэдэгдэл өгөх эрх мөн хамаарна.[57] Энэ нь хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоог хангах Үндсэн хуулийн онцлог зохицуулалт юм.[58] Дээр дурдсан хоёр байгууллага нь олон нийтийн зөвлөлдөөн, Парламентад хэлэлцэж буй хуулинд санал гаргах үйл ажиллагаа явуулдаг парламентын оффистой байдаг.[59]

### 2.1.3. Тулгамдаж буй асуудал

ӨАБНУ-ын Хууль тогтоох эрх мэдлээс гаргасан "Олон нийтийн оролцооны суурь" судалгаанд дурдсанаар тус улсын Үндсэн хуулинд олон нийтийн шууд оролцоог бус, хөндлөнгийн байр суурьнаас оролцохоор зохицуулсан байгаа нь олон

[53] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 16-р тал.
[54] Мөн тэнд.
[55] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 91-р тал
[56] Human Rights Commission Act, South Africa, 1994, 7-р хэсэг, Commission on Gender Equality Act, 1996, 11(1)(c) хэсэг.
[57] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 17-р тал.
[58] Karen Syma Czapanskiy, Rashida Manjoo, The Right Of Public Participation In The Law-Making Process And The Role Of Legislature In The Promotion Of This Right, 2008, 6-р тал.
[59] Мөн тэнд

нийтийн оролцоог хангахад хүндрэл учруулж буй ажээ.[60] Оксфордын Их сургуулиас гаргасан “Хууль тогтоох үйл явц дахь олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны харьцуулсан судалгаа[61]”-нд тодорхойлсноор улс төрийн хүсэл зориг, хүчин чадлын хязгаарлалт болон хүртээмж нь хууль тогтоох явц дахь олон нийтийн оролцоог хангахад хүндрэл учруулдаг байна.[62] Энэхүү судалгаанд дурдсанаар хууль тогтоох явц дахь олон нийтийн эсэргүүцлийг тусгадаггүй, харгалзан үздэггүй гэх ойлголт өргөн тархсан байдаг байна. ӨАБНУ-ын 10 хууль тогтоох байгууллага нь бүгд олон нийтийн оролцооны төлөвлөгөөг хангах, олон нийтийн оролцоог хангах асуудлаар хороонуудад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон нийтийн оролцооны нэгжүүдтэй[63] боловч эдгээр нэгжүүд нь хангалттай хүн хүчтэй байдаггүй байна. 2009 оны байдлаар Парламентын олон нийтийн оролцоог хангах нэгж нь 36 хүний бүрэлдэхүүнтэй, Гаутэнг мужийн нэгж нь 12 хүний бүрэлдэхүүнтэй ба бусад мужуудийн энэхүү нэгж нь 10-аас бага тооны ажилчидтай байсан байна.[64]

Олон нийтийн оролцоог хангах санхүүгийн эх үүсвэрийн хувьд бүхий л хууль тогтоох байгууллага нь олон нийтийн оролцоог хангахад зориулагдсан төсөвтэй байдаг байна. Энэхүү төсөв нь нэмэгдэх хандлагатай байгаа боловч ӨАБНУ-ын хүн амд хүрч оролцоог хангахад хангалтгүй юм.[65] Үүнээс гадна хууль тогтоох процесс нь ихэнх хүмүүсийн хувьд хүртээмжтэй биш байдаг байна.

Мөн Парламентын Хууль тогтоох үйл явцын Нэгдсэн даалгаврын багийн тайлан[66]д хуулийн төслийu танилцуулахаас өмнөх үе шатуудад, ялангуяа Парламентын танхимуудын дүрэмд заасан төслийг танилцуулахаас өмнө олон нийтээс санал авах урилгын хамт Засгийн газрын албан ёсны хэвлэлд гаргах заалтуудын хувьд Парламент болон Гүйцэтгэх эрх мэдлийн хооронд бодит холбоо хамаарал байх шаардлагатай байгаа талаар санал гаргасан байна.[67] Дээр дурдсан ӨАБНУ-ын хууль тогтоох салбараас гаргасан “Хууль тогтоох эрх мэдлийн Олон нийтийн оролцооны суурь” судалгаанд олон нийтийн оролцоог хангахад учирдаг хүртээмжтэй байдлын саад бэрхшээлүүдийг дараах байдлаар тодорхойлсон:

- Нийтийн сонсгол явуулах газар нь ядуу хүмүүс болон орон нутгийн хүмүүст оролцоход хүндрэл учруулдаг.
- Боловсруулагдаж буй хууль тогтоомжийн талаар мэдээлэл хязгаарлагдмал
- Үндэсний бодлого, хууль тогтоох процессийн талаар мэдлэг бага учир олон нийт хууль тогтоох явцад оролцох боломжийг үл тоодог.
- ӨАБНУ-нь 11 албан ёсны хэлтэй боловч англи хэл гол хэл нь юм. Энэ нь хэлний тодорхой бүлгийг олон нийтийн оролцоонд хамруулахгүй байх үр дагавартай.

---

[60] Legislative Sector South Africa, Public Participation Framework for the South African Legislative Sector, 2013, 84-р тал.
[61] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011.
[62] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 17-р тал.
[63] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 66-р тал.
[64] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 74-р тал.
[65] Renee Scott, An analysis of the public participation in the South African legislative sector, Stellenbosch University, 2009, 77-р тал.
[66] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010.
[67] Joint Task Team on the Legislative Process, Reviewing the Legislative Process in Parliament, 2010, 5-р тал.

- Олон нийтийн ярилцлага, олон нийтийн байгууллага гэх мэт олон нийтийн оролцоог үр дүнтэй болгоход шаардлагатай чадварууд нь харилцан адилгүй тархсан, хангалтгүй хөгжсөн байдаг.

Мөн Гаутэнг мужийн хууль тогтоох байгууллагаас гаргасан Олон нийтийн оролцооны Олон улсын зөвлөгөөн (Deliberation of the International Conference on the public participation)-ий эмхэтгэлд ӨАБНУ дахь хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоо нь ямар нэгэн бодит үр дүнгүй байдаг ба ӨАБНУ нь ард түмний хүсэл зориг дээр суурилсан нээлттэй нийгэм гэж тодорхойлогддог боловч ард түмний хүсэл зориг хууль тогтоох үе шатанд давамгайлдаггүй гэж бичсэн байна.

“ӨАБНУ-ын Хууль тогтоох салбарын Олон нийтийн оролцооны суурь” илтгэлд бичсэнээр дээрх хүндрэлүүдийг даван гарах алхамуудыг Парламент болон бүс нутгийн хууль тогтоогчид авч байна. Жишээ нь ядуу, алслагдсан бүсүүдэд нийтийн сонсголын хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл гаргах, оролцож буй талууд нь үр дүнтэй оролцох боломжийг хангах үүднээс сонсголын өмнө товч танилцуулга гаргах зэрэг юм. Мөн дээрх судалгаанд бичсэнээр хууль тогтоох эрх мэдэлд олон нийтийн оролцоог хэрхэн хангах ёстой болон бодит байдал, практик дээр олон нийтийн оролцоог хангаж буйн хооронд ихээхэн зөрүү байна гэж дүгнэсэн.

ӨАБНУ-ын хууль тогтоох салбар нь 2006 оноос олон нийтийн оролцооны нийтлэг ойлголт, хандлагыг хөгжүүлэхэд чиглэн ажиллаж эхэлсэн.[68] Энэхүү ажил нь Бирквүүдийн Олон нийтийн Оролцооны зөвлөгөөнөөр эхэлсэн ба хууль тогтоогчид энэ зөвлөгөөнөөс гарсан саналын дагуу олон нийтийн оролцоонд хандаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл ӨАБНУ-ын хууль тогтоох эрх мэдэл нь олон нийтийн оролцоог хангах түвшинг сайжруулж, гарч буй хүндрэлүүдийг даван туулах алхмуудыг хийсээр байна.

***Товч дүгнэлт.*** ӨАБНУ нь хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг Үндсэн хуулиндаа оруулсан нь онцлог байна. Үндсэн хуулийн энэхүү  зохицуулалт нь олон нийтийн оролцоо хангагдах чухал алхам болсон байна. Мөн бусад эрх зүйн актуудад хууль тогтоох явц дахь олон нийтийн оролцоог зохицуулсан ба хэд хэдэн төрлийн оролцооны хэлбэрийг тодорхойлсноос гадна хууль тогтоогч тухайн хууль тогтоомжийн онцлогоос хамаарч олон нийтийн оролцооны хэлбэрийг сонгох эрхтэй байна. Тус улсын Үндсэн хуулийн шүүх нь хэд хэдэн шийдвэртээ хууль тогтоох процесс дахь олон нийтийн оролцоог хангах талаар тусгаж, хэд хэдэн хуулийг олон нийтийн оролцоог хангах шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон нь ӨАБНУ-ын хууль тогтоомж дахь дээрх зохицуулалт нь заавал биелэгдэх шинжтэй, чухал зохицуулалтууд гэдгийг харуулсан байна.

Бидний үзсэн хэд хэдэн материалуудад дурдсанаар дээрх оролцоог хангах ажлыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлүүд гардаг боловч ӨАБНУ-ын хууль тогтоох байгууллагууд дээрх саад бэрхшээлүүдийг даван гарах алхмуудыг хийсээр байгаа нь харагдаж байна. ӨАБНУ нь хууль тогтоох процесст олон нийтийн оролцоог хангахыг чухалчлан үздэг ба энэ талаархи эрх зүйн

[68] Legislative Sector South Africa, Public Participation Framework for the South African Legislative Sector, 2013, 77-р тал.

зохицуулалтыг практикт бодитоор хэрэгжүүлэх эрмэлзэлтэй улс гэж дүгнэж болохоор байна.

## 2.2. КАНАД УЛС

### 2.2.1. Эрх зүйн орчин

Канад улс нь холбооны парламентын бүгд найрамдах улс юм.[69] Парламент нь Канад улсын улс төрийн тогтолцооны дээд байгууллагад тооцогддог, засгийн газрын хууль батлах салбар ба Хатан хаан, Нийтийн танхим, Сенатаас бүрддэг. Канад улс нь холимог эрх зүйн тогтолцоотой ба нийтийн болон хувийн эрх зүйн хууль тогтоомжийн үүрэг хариуцлагуудыг Парламент болон мужууд тус тус хэрэгжүүлдэг.[70]

Засгийн газрын бодлого нь гурван үе шатыг дамжин хууль болдог[71]:

(a) Кабинетийн үе шат

(b) Улсын Их Хурал

(c) Хүчин төгөлдөр болох үе шат

Эхний шатанд, холбогдох яамдын хэлтсийн мэргэжилтэнгүүдийн боловсруулсан мэдээлэл дээр үндэслэн хуулийн төсөл боловсруулах шийдвэрийг Кабинет гаргадаг.[72] Энэхүү мэдээллийг цуглуулахдаа дээрх хэлтсүүд нь тухайн шийдвэр нөлөөлж болох бусад хэлтэс зэргийг оролцуулсан тухайн асуудалд ашиг сонирхолтой этгээдүүдтэй зөвлөлддөг.

**Зөвлөлдөх зөвшөөрөл**

Канад улс Үндсэн хуульдаа олон нийтийн оролцоог хангах үүргийг хуульчлаагүй ба хуулийн төслөөс хамааран олон нийттэй зөвлөлдөх зөвшөөрлийг Кабинет эсвэл Ерөнхий сайд олгоно.

Хууль тогтоох ажиллагааны Кабинетийн удирдамжид[73] зааснаар Кабинет хуулийн төсөл санаачлахаар шийдвэрлэсний дараа хариуцсан хэлтэс нь аль болох боломжтой хугацаанд Кабинетын санамж бичгийг гаргах ажлыг зохион байгуулна. Хэрэв төслийг санхүүжүүлж буй яам нь хууль боловсруулах төслийн хүрээнд зөвлөхөөр оролцох буюу эсхүл оролцох сонирхолтой/магадлалтай үед Санамж бичигт олон нийтийн хэлэлцүүлгийн төрлийг тодорхойлно. Уламжлал ёсоор хуулийн төслийг Парламентад өргөн

---

[69] Canada, http://en.wikipedia.org/wiki/Canada, 2014.12.05.
[70] Law of Canada, http://en.wikipedia.org/wiki/Law_of_Canada, 2010.12.05.
[71] The Legislative Process: From Policy to Proclamation, http://www.parl.gc.ca/Content/LOP/ResearchPublications/prb0864-e.htm, 2014.12.05.
[72] Мөн тэнд.
[73] Government of Canada Privy Council Office, Guide to Making Federal Acts and Regulations, 2001.

барихаас өмнө нууцлалтайгаар боловсруулдаг. Хэдий тийм боловч Засгийн газрын ил тод байдал, хэлэлцүүлэг хийх үүрэг хариуцлагатай уялдуулан санхүүжүүлэгч яам хуулийн төсөл дээр зөвлөлдөхөөр шийдвэрлэж болно. Энэхүү зөвлөгөөний зорилго нь хуулийн төсөлд холбогдох этгээдүүдийн үзэл бодлыг тусгахад орших боловч энэ нь Парламентын хууль батлах үүргийг өөрчлөх үндэслэл болохгүй ба аливаа этгээдэд эдийн засгийн шударга бус давуу тал бий болгох ёсгүй. Тиймээс хуулийн төслийг Парламентад өргөн барихаас өмнө олон нийтээр хэлэлцүүлэх тохиолдолд Санамж бичигт үүнийг тодорхойлон, Кабинетийн зөвшөөрлийг авна.

Хуулийн төсөл нь засгийн газрын аппаратын өөрчлөлттэй холбогдож байгаа тохиолдолд, зөвлөлдөх зөвшөөрлийг санхүүжүүлж буй сайд Ерөнхий сайдаас бичгээр хүсдаг.[74]

## Хууль

Холбооны улсын хэмжээнд 1985 оны Канадын Парламентын Тухай Хуулийн 10-13 зүйлд аливаа этгээдийг Сенат болон Нийтийн танхим мэдээлэл өгүүлэхээр дуудах эрхтэй байхаар зохицуулсан боловч энэ хэсэг нь зөвхөн хууль тогтоох процесст хамаарахгүй ба заавал аливаа этгээдийг дуудаж мэдээлэл авахыг үүрэг болгоогүй байна.

Холбооны хууль тогтоомжоос гадна мужууд өөрсдийн хууль тогтоох байгууллагуудын дүрмээр иргэдээс мэдээлэл авах тухай зохицуулсан байдаг.

## Бусад эрх зүйн актууд

Нийтийн танхимын хуулиар зохицуулсан дуудаж мэдээлэл авах эрхийг журмуудаар дэлгэрэнгүй зохицуулсан байдаг. Дуудаж мэдээлэл авсны дараа хороо нь хуулийн төслийг зүйл тус бүрээр нь авч хэлэлцдэг.[75] Мөн мужуудад хорооны ажиллагаа нь тэдгээрийн тус тусын эрх зүйн актуудаар зохицуулагдсан байдаг. Жишээлбэл, Канад улсын Манитоба мужийн Хууль тогтоох Асамблей нь нийтийн сонсгол явуулах зохицуулалттайгаараа бусад мужуудаас ялгаатай.

## Бодлого / Удирдамж

Олон нийтийн оролцоог хангах бодлого нь Хууль зүйн хэлтэсийн Олон нийтийн оролцооны Бодлогын баримт бичиг, удирдамжад тусгагдсан байдаг.[76] Энэхүү бодлогын баримт бичиг нь Хууль Зүйн хэлтэсийн ажилтнуудад олон

---

[74] Мөн тэнд.

[75] University of Oxford, A Comparative Survey of Procedures for Public Participation in the Lawmaking Process, 2011, 21-р тал.

[76] Policy Statement and Guidelines for Public Participation Department of Justice, http://justice.gc.ca/eng/cons/pol.html, 2014.12.15.

нийтийн оролцооны ажиллагааг зохион байгуулах боломж олгодог. Мөн Канадын иргэдэд ил тод, хүртээмжтэй, хариуцлагатай, үнэн зөв мэдээллээр хангах ба Канадын олон салбарыг хамарсан хууль, бодлого, хөтөлбөр, үйлчилгээг зохион байгуулах ажиллагааны илрэл болдог.

Нээлттэй, үр дүнтэй, цаг үеэ олсон, дэлгэрэнгүй мэдээллээр хангагдсан бодлого боловсруулах үйл явцын нэг хэсэг нь олон нийтийн оролцоо байх ёстой ба үүнийг хэлтэс хариуцах ёстой. Холбогдох хэлтсийн эрх бүхий этгээд үүрэг хариуцлагынхаа хүрээнд олон нийтийн оролцооны бүрэлдэхүүний аль хэсэг нь бодлогод хамаарахыг тодорхойлно. Хэлтэс нь бодлого боловсруулах үйл явцыг цаг тухайд нь олон нийтэд мэдээлэх, олон нийтийн үзэл бодол, санал нь шийдвэр гаргах үйл явцад хэрхэн тусгагдсан талаарх мэдээллийг ил тод байлгах ёстой.

Мөн удирдамжад олон нийтийн хэлэлцүүлгийн үйл явцыг дэмжих зарим гол чиг үүргийг тодорхойлно:

a) **Хууль зүйн яам болон Ерөнхий Өмгөөлөгч (Attorney-General):** Олон нийтийн оролцооны үйл явцын үр дүнг ашиглан хууль зүйн салбарт нөлөөлөх бодлого болон хууль эрх зүйн чиглэлд шийдвэр гаргана.

b) **Дэд сайд:** Олон нийтийн оролцоо нь төрийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээний шийдэл болон эдгээрийг дамжуулах, үнэлэхэд салшгүй нэгэн хэсэг болохыг хангах ёстой. Мөн хэлтсийн олон нийтийн оролцооны үр дүн нь шийдвэр гаргах үйл явцад тусгагдах ба энэ үйл явц нь үнэлэлт хийгдсэн байхыг хариуцах ёстой.

c) **Салбар, Хэлтэс болон Салбарын тэргүүн:** Ямар асуудалд олон нийтийн оролцоо шаардлагатайг тодорхойлно. Гэхдээ олон нийтийн оролцоог төлөвлөх, хэрэгжүүлэх болон үнэлэх асуудалд хамаарахгүй. Салбар дотроо болон шаардлагатай бол Засгийн газар, агентлаг болон засгийн газрын бусад түвшний байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.

d) **Зөвлөх Хэсэг, Засгийн газар хоорондын болон Гадаад харилцааны хэсэг**: Эдгээр нэгжүүд нь зөвлөгөө өгөх төлөвлөгөө болон стратеги боловсруулахад зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлдэг. Шаардлагатай сургалтыг хэлтсийн албан хаагчдад боломжтой байлгах, эрх зүйн салбарын оролцогчид, харилцагчидын сан үүсгэн хадгалах үүрэгтэй.

e) **Бүс Нутгийн Газрын Дарга** (бүс нутгийн Үндэсний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төвийн оффис хамаарна): Бүс нутагт олон нийтийн оролцоог санаачлах ажиллагааг гүйцэтгэх ажилд туслахаар оролцохоор дуудагдах ба шаардлагатай үед бүс нутаг дахь төрийн бусад байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж болох талаар санал болгож болно.

f) **Харилцаа холбооны салбар:** Энэ хэлтэс нь олон нийтийн оролцооны үйл ажиллагаанд харилцаа холбооны дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

**g)** **Үнэлгээний Хэсэг:** Олон нийтийн оролцооны үйл ажиллагааны

хэлтэст хөндлөнгийн дүн шинжилгээ хийн, зөвлөгөө өгөх ба менежерүүдэд олон нийтийн оролцооны үйл ажиллагаатай холбоотой хувийн үнэлгээ хийх, гүйцэтгэлийн үнэлгээ болон үр дүнгийн тайланд дэмжлэг үзүүлдэг.

**h) Зөвлөхүүдийн Танхим, Төрийн сангийн нарийн бичгийн дарга болон Канадын Удирдлагын хөгжлийн төв.** Эдгээр нэгж нь зөвлөлдөх зарчмыг засгийн газрын хэмжээнд сурталчлах болох дэмжих үүрэг хүлээсэн байдаг.

Бодлогын баримт бичигт бодлого боловсруулах үйл явцад иргэдийг эхэн үе шатанд оролцуулснаар олон нийтийн оролцоо сайн хангагддаг гэж дурджээ. Ингэснээр олон нийт үзэл бодлоо илэрхийлж, мэдээлэл гаргах болон харилцан ярилцах хоёр талт үйл явцын дагуу олон нийтийн оролцоо хангагдах боломжтой болно.

### 2.2.2. Олон нийтийн оролцооны арга, талууд

#### Мэдэгдэл, Санал / Мэдээллийн хүртээмжтэй байдал

Канадын засгийн газрийн албан ёсний хэвлэлийн 2-р хэсэгт батлагдан хэвлэгдэхээс өмнө, Төрийн мэдээллийн 1 дүгээр хэсэгт хууль боловсруулах сүүлийн шатанд сонирхогч бүлэг, хувь хүн болон Канадын иргэдэд боловсруулж буй хуулийг хянан, санал өгөх сүүлийн боломжийг олгодог. Ингэснээр, өмнө нь хэлэлцсэн санал нь сүүлийн хуулийн төсөлд хэрхэн тусгагдсан байгааг харах боломж болдог.[77]

Мэдээлэл нь мөн хууль тогтоомжтой холбоотой нийтлэл болон бусад төрлийн хэвлэл мэдээллээр цацагддаг. Мэдээллийг олон нийтэд түгээхэд мужууд өөрсдийн үйл явцыг ашигладаг.

#### Онлайн зөвлөлдөөн

Канад Улсын Засгийн газрын зөвлөлдөөний мэдээллийг Канад улсын засгийн газрын зөвлөлдөөний нэгдсэн сайт болох *Канадуудтайгаа зөвлөлдөх нь* (http://www.consultingcanadians.gc.ca/) сайтаас авах боломжтой. Энэхүү зөвлөлдөөний нэгдсэн сайт нь хэлтэс бүрийн хэлэлцүүлж буй үйл ажиллагааны жагсаалт болон холбогдох мэдээллээр хангадаг.

Дээрх цахим хуудас нь сонгогдсон засгийн газар болон агентлагуудын явуулж буй зөвлөлдөөний жагсаалтыг нэг дороос авах боломжийг олгодог. Цахим хуудас дээр тавигдсан зөвлөлдөөний жагсаалтыг холбогдох засгийн газрын хэлтэс, агентлаг нь тогтмол шинэчилж байдаг. Энэхүү цахим хуудсанд одоо явагдаж байгаа хэлэлцүүлгүүдээс гадна явж өнгөрсөн хэлэлцүүлгүүд

[77] Consultation, http://gazette.gc.ca/consult/consult-eng.html, 2014.12.15.

байрладаг ба зөвлөлдөөнийг нэр, төрөл, оролцож буй хэлтэс, агентлагаар нь үзэх боломжтой болгосон байдаг нь зөвлөлдөөн олон нийтэд хүртээмжтэй, ил тод байх үндэс болсон байна.

Энэхүү зөвлөлдөөний гол зорилго нь:

a. Засгийн газрын зөвлөлдөөний үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх;
b. Засгийн газар дахь хэлэлцүүлэгт цахим болон цахим бусаар Канадын иргэдэд оролцох боломжоор хангах;
c. Канадын иргэдийн цахим хэлбэрээр оролцогчдын тоог нэмэгдүүлэх, хэлтэс хоорондын хэлэлцүүлгийн менежментийг сайжруулах

Цахим хуудас нь зөвлөлдөөн явуулж буй байгууллагатай шууд холбогдох боломжийг олгодог ба зөвлдөөнийг хэлтэс, агентлагууд явуулж байдаг.

Холбооны улсаас гадна муж улсуудад мөн цахим хэлбэрээр зөвлөлдөөн явагддаг. Жишээ нь, Нью Брунсвикд хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд засгийн газрийн үйл ажиллагааг ил тод байлгах үүднээс олон нийтийн саналыг авдаг.[78] Санал болгож буй хуулийн төслийг хувь хүн болон байгууллагуудад санал өгөх боломжийг олгон цахим хуудсанд нийтэлсэн байдаг. Хуулийн төсөл боловсруулах үед томоохон өөрчлөлт хийх шаардлага гараагүй бол хууль болон батлагдахаасаа өмнө хамгийн сүүлийн хувилбар дахин цахим хуудсанд нийтлэгдэхгүй. Нова Скотиа мужийн Хууль тогтоох байгууллага нь Твиттер зэрэг нийтийн сүлжээг ашиглах, өргөдөл гаргах болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар олон нийтийн оролцоог дэмждэг.[79] Үүний нэгэн адил, Квебек мужид Үндэсний Ассамблей иргэд цахим хэлбэрээр хүлээгдэж байгаа бүх хууль тогтоомжийг хянах, санал өгөх шинэлэг цахим хуудастай. [80] Эдгээр санал нь Үндэсний Ассамблейд хэлэлцүүлэгдэхээр холбогдох гишүүдэд хүргэгддэг.

**Мэдээллийг харгалзан үзэх үүрэг**

Хариу өгөх арга хэмжээ авах үүргийн хувьд, олон нийтийн оролцооноос гарсан үр дүнг оролцогч нарт заавал мэдэгдэх ба эдгээр үр дүнг бодлого боловсруулах үйл явцад хэрхэн авч хэлэлцсэнийг харуулах үүргийг Канадын хууль тогтоох байгууллага хариуцан ажиллахыг Бодлогын баримт бичиг болон удирдамжинд оруулж өгсөн.

**Нийтийн сонсгол**

Засгийн газар болон бүс нутагт оролцогчдыг урин тэдний саналыг аван

[78] New Brunswick, http://www2.gnb.ca/, 2014.12.15.
[79] Get involved, http://nslegislature.ca/index.php/get-involved/, 2014.12.15.
[80] Voice your opinion, http://www.assnat.qc.ca/en/exprimez-votre-opinion/index.html , 2014.12.15.

тэмдэглэх нь хорооны үе шатанд нийтлэг зүйл юм. Хорооны үйл ажиллагаа нь Алберто, Британийн Колумби, Манитоба, Нова Скотиа, Онтарио, Саскачеван зэрэг мужуудад нийтлэг явагддаг бөгөөд гол онцлогуудыг доор дурдав.

Манитобад хууль тогтоомжийн лавлагаа нь Хороонд зайлшгүй шаардлагатай ба бусад мужуудад үүрэг болгоогүй боловч энэ тогтсон практик юм. Парламентын хороонд бичгээр санал өгөх, нийтийн сонсголд оролцох байдлаар олон нийтийн оролцоог хангадаг. Мөн Хороо нь мэргэжилтэнгүүд, нийгмийн бүлэг, бизнесийн болон эрдэм шинжилгээний бүлгүүдтэй зөвлдөлддөг.[81]

Парламентын хорооны хурал олон нийтэд ихэвчлэн нээлттэй байх ба сурталчилгаа сайн явагддаг. Хороонд гаргасан санал болон үйл ажиллагааны бичлэг нь олон нийтэд нээлттэй байдаг.

**Олон Нийт**

Хууль зүйн хэлтсийн Бодлогын баримт бичиг болон удирдамж нь бүх салбарт хамаарах бөгөөд ерөнхийдөө Канадын иргэд, тусгай сонирхолын бүлэг эсхүл сайн дурын холбоонд чиглэсэн эсхээс үл хамааран бүх олон нийтийн оролцооны үйл явцад дагаж мөрдөгдөнө. Мөн Канад улсын хууль тогтоох байгууллага нь иргэдийн оролцоог, тэдний хэл, бүс нутаг, гарал угсаа, нийгэм эдийн засгийн чадавхи болон бие махбодийн онцлогоос үл хамааран, хангах ёстой.

**Тусгай сонирхолын бүлгүүд**

Олон нийтийн бодлогыг боловсруулах үед тусгай сонирхлын бүлгүүдийн оролцооны нэг жишээ нь 2004 оны 10 дугаар сараас 12 дугаар сарын хооронд Канадын Хүний Эрхийн Комиссоос зохион явуулсан хэлэлцүүлгээр үйл ажиллагааг төвлөрүүлэх зорилгоор гаргасан таван зарчим дээр санал авсан. Засгийн газрийн хэлтсүүд, хувийн хэвшлийн байгууллагууд, Өмгөөллийн бүлэг, үйлдвэрчний эвлэл ба ажил олгогчдын төлөөлөгч, нутгийн уугуул иргэдийн эрх ашгийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд болон бие даасан шинжээчидтэй хурал, уулзалт болон албан бичгээр зөвлөлдсөн.

Мөн Канадын хууль тогтоох байгууллага нь олон төрлийн төрийн бус байгууллага, сайн дурын болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран бодлого боловсруулах болон үйл ажиллагаандаа Канадын бүх иргэд болон сонирхолын бүлгийн олон нийтийн оролцоог дэмждэг.

[81] Discover Your Legislature, http://leg.bc.ca/info/2-7.htm#, 2014.12.15.

### 2.2.3. Тулгамдаж буй асуудал

Бодлогын баримт бичиг болон удирдамжид олон нийтийн оролцоог хангахад анхаарах шаардлагатай хэд хэдэн зүйлийг тодорхойлсон байна.[82]

**Зардал**

Бодлогын баримт бичигт хувь хүн болон бүлгийн оролцоог хангах нь зардал гаргаж болохыг онцолсон. Энэхүү зардлыг олон нийтийн оролцооны зорилго, үр дагавартай харьцуулан үзэх шаардлагатай.

**Олон нийтийн оролцоог үр дүнтэй хангахад цаг хугацаа дутмаг байх**
Олон нийтийн оролцоог үр дүнтэй хангахын тулд зөвлөлдөх хангалттай хугацаа байх шаардлагай. Жишээ нь, Манитоба мужид 48 цагийн дотор хороо нь хурлын цагаа товлон хуралдсантай адилаар олон нийт болон сонирхолын бүлгийг ороцуулахад хүндрэлтэй нөхцөл байдлаас зайлсхийх хэрэгтэй.

**Мэдээлэлд хүртээмжийн тэгш бус байдал**

Удирдамжид тодорхойлсоноор мэдээлэл авах тэгш бус байдал болон оролцогчдын мэдлэг нь олон нийтийн оролцооны ажлын үр ашигт сөрөг нөлөө үзүүлдэг.

Хууль зүйн хэлтэс нь дээр дурьдсан асуудлуудыг даван гарах дараах удирдамжийг гаргасан[83]:

**Зөвшөөрөл ба Төлөвлөлт**

Бүх албан ёсны олон нийтийн оролцооны үйл ажиллагаа нь холбогдох хэлтэсийн удирдлагын санал, зөвшөөрлийг авахаар тэдэнд танилцуулсан байх ёстой. Бодлогын төлөвлөгөө болон Засгийн газарт өргөн барих Санамж бичигт ямар олон нийтийн оролцооны ажиллагааг төлөвлөсөн, шаардлагатай бол товч төлөвлөгөөг оруулсан байх ёстой.

**Ерөнхий үйл ажиллагааны зарчим**

a) Ямар олон нийтийн оролцооны ажил явагдаж байгаа, ямар шийдвэр гарсан талаарх мэдээллээр оролцогчдыг хангах. Бусад бодлогын санаачлага, асуудал эсхүл олон нийтийн оролцооны ажилтай холбоотой мэдээллийг оролцогчдод мэдэгдсэн байх.
b) Олон нийтийн оролцооны цар хүрээнд нийцсэн санхүүжилт болон хүний нөөцөөр хангагдсан байх. Нөөцийн хягаарлалттай бол

[82] Policy Statement and Guidelines for Public Participation Department of Justice, http://justice.gc.ca/eng/cons/pol.html, 2014.12.15.
[83] Мөн тэнд.

мэдэгдсэн байх

c) Ажлын явцад хангалттай хүний нөөцтэй байх ба энэ ажилд тодорхой хэмжээгээр бэлтгэгдсэн байх.
d) Оролцогчдын саналыг хүлээн авах боломжит цаг хугацааг тодорхойлсон байх ба энэ хугацааг мэдэгдсэн байх
e) Холбогдох асуудал, хамрагдах бүлэг, хүний нөөц болон нөөцтэй хамааралтай боломжит олон нийтийн оролцооны хэрэгслийг ашигласан байх
f) Оролцогчдод хариу мэдэгдэх нь үе шатлалтай байх ба энэ хариултанд нэмэлт санал өгөх боломж олгох
g) Үнэлгээний ерөнхий бүтцийг боловсруулан, олон нийтийн оролцооны төлөвлөгөөнд багтаасан байх
h) Оролцогчид болон хамаарах бүлгүүдэд бодлого боловсруулах үйл явц болон тэдний санал хэрхэн тусгагдсан талаар мэдэгдэх
i) Эрх, үүрэг нь хөндөгдөж буй Канадын иргэн, салбар, бусад албан тушаалтан, эсхүл бусад оролцогчид болон тэдгээртэй холбоотой хууль, журам, бодлогын хүрээнд олон нийтийн оролцооны ажиллагаа нь явагдсан байх,

**Хамтын ажиллагаа**

Дээрх удирдамжид зааснаар Канадын хууль тогтоох байгууллага нь төрийн салбар болон агентлагуудтай хүчин чармайлт гарган хамтран ажиллах ба бололцооныхоо хирээр мужийн болон орон нутгийн засаг захиргаатай Канадын эрх зүйн системд тулгарч буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлно:

a) Хамааралтай асуудлуудын талаар хамтарсан байдлаар олон нийтийн оролцоог хангах
b) Ашиг сонирхол нь хөндөгдөх хувь хүмүүс, байгууллагуудыг нэг дор хэд хэдэн олон нийтийн оролцоонд хамрагдахыг шаардахгүй байхаар олон нийтийн оролцоог зохион байгуулах
c) Боломжтой бол Канадын хууль тогтоох байгууллагын олон нийтийн оролцооны удирдамж, бодлого нь хамтарсан үйл явцад хамаарч байхаар зохион байгуулах.

## 2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

### 2.3.1. Эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Солонгос улсын хуулийн төсөл боловсруулах явц дахь олон нийтийн оролцоог шууд болон шууд бус байдлаар зохицуулдаг дараахь хуулиудыг нэрлэж болно.

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль /Constitution of the Republic of Korea/ 1948-07-17
- Бүгд найрамдах Солонгос улсын Үндэсний Асамблейн тухай хууль /National Assembly Act/ 1990-06-29
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын тухай хууль /Government organization act/
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Захиргааны үйл ажиллагааны тухай хууль /Administrative procedures act/ 1996-12-31
- Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль болон дүрэм журам зарлах тухай хууль /Act on the Promulgation of Acts and Subordinate Statutes/ 1963-12-16

***Ерөнхий мэдээлэл.*** Солонгос орон (Хойд болон Өмнөд Солонгос хамтдаа) эртний иргэншилт нутаг бөгөөд НТӨ 2333 онд анхны төрт улс үүссэн гэж үздэг. Шилла улс нь 668 онд Пэкчэ ба Кугурё хоёр улсаа нэгтгэн Нэгдсэн Шилла улсыг байгуулсан байна. Улмаар Курё ба Чусонь улс байгуулагдан, 1910 онд Солонгосын эзэнт улс мөхөх хүртэл нэгдсэн улс болон оршин тогтнож байв. 1910-1945 онд Японы хаант улсын эзэмшилд орж, 1945 онд Дэлхийн 2-р дайн дууссаны дараа Солонгос үндэстэн нь ЗСБНХУ, АНУ улсуудад захирагдаж хойд болон өмнөд хэсгээр хоёр хуваагдсан тул 1948 онд Бүгд Найрамдах Солонгос Улс болон тусгаар тогтносон байна.[84] Одоогийн Бүгд Найрамдах Солонгос улсын хүн ам 48,850,000 орчим байна.[85]

***Үндсэн хууль.*** Солонгос улс нь үндсэн хуульт орон бөгөөд одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль нь 1948-07-17-нд батлагдсан, өнөөг хүртэл 9 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан.[86] Эрх зүйн үндсэн эх сурвалж нь үндсэн хууль болон бусад төрөлжсөн хууль тогтоомжууд болж байгаа нь эх газрын эрх зүйн системтэй улс гэдгийн нэг нотолгоо болно.[87]

Улс төрийн засаглалын хувьд Үндсэн хуулинд заасны дагуу 1948 онд Парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улсыг байгуулжээ. Тус Үндсэн хуулиар, Үндэсний ассамблейн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил бөгөөд Ерөнхийлөгч тэргүүтэй хүчирхэг гүйцэтгэх засаглалыг бүрдүүлсэн байдаг. Харин 1960 онд Өмнөд Солонгос улс Парламентын засаглалыг бүрдүүлж, Үндэсний чуулганы өмнө хариуцлага хүлээх Гүйцэтгэх засаглалыг Ерөнхий сайд тэргүүлэх болжээ. Үндсэн хуулийн 6 дахь өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийг 1 удаа 5 жилийн хугацаатай сонгогдох эрхтэй Улсын тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрчээ. Ерөнхийлөгчийн оролцоотойгоор Төрийн зөвлөл байгуулагддаг. Төрийн зөвлөлд Ерөнхийлөгч болон Үндэсний ассамблейн гишүүдээр дэмжигдсэн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийнхээ хамт, мөн 4 жилийн хугацаатай шууд сонгуулиар сонгогддог Үндэсний ассамблейн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ багтдаг. Сонгуулийн тогтолцоо нь мажоритар болон пропарциональ системээр явагддаг.[88]

Өмнөд Солонгос нь хагас ерөнхийлөгчийн засаглалтай, ардчилсан улс юм.[89] Хууль тогтоох төрийн дээд байгууллага нь Үндэсний ассамблей. Үндэсний

---

[84] "Өмнөд Солонгос".https://mn.wikipedia.org. 2014.11.27
[85] "Өмнөд Солонгос".https://mn.wikipedia.org. 2014.11.27
[86] Constitution of the Republic of Korea, Korea, 1948
[87] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 42-р тал
[88] "Солонгосын улс төрийн тогтолцоо". http://vip76.mn/content/6795. 2011.11.27
[89] "Өмнөд Солонгос".https://mn.wikipedia.org. 2014.11.27

ассамблей нь нэг танхимтай, бүх нийтийн шууд сонгуулиар дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогддог ба гишүүдийн тоог үндсэн хуулиар тогтоодог бөгөөд 200-аас доошгүй байна гэж заасан байдаг. Харин одоогийн парламент нь 299 гишүүнтэй.[90] Үндэсний ассамблей нь 16 байнгын хороотой.[91]

Хууль санаачилж хуулийн төсөл боловсруулах эрх бүхий этгээд:

Хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх эрх бүхий субьектийн хувьд "Үндэсний ассамблейн гишүүн болон засгийн газрын холбогдох яамд хуулийн төслийг өргөн барина" [92] хэмээн заасан байдаг.

***Үйл ажиллагааг зохицуулах хууль.***Үндэсний ассамблейн үйл ажиллагааг Бүгд найрамдах Солонгос улсын Үндэсний Ассамблейн тухай хууль /National Assembly Act 1990-06-29-нд батлагдсан/-аар зохицуулдаг ба Засгийн газрын үйл ажиллагааг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын тухай хууль /Government organization act / болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Захиргааны үйл ажиллагааны тухай хууль /Administrative procedures act/-аар зохицуулдаг.

***Хууль тогтоохоод дагаж мөрдөх бусад хууль дүрэм журам***. Бүгд Найрамдах Солонгос улсад хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг зохицуулсан нэгдсэн хууль байхгүй, ерөнхий байдлаар Үндсэн хууль, Үндэсний ассамблейн тухай хуулиар зохицуулсан байдаг.[93] Үндсэн хуулинд хууль тогтоох эрх мэдлийг 40-р зүйлд, хууль санаачлах эрхийг 52-р зүйлд болон хууль нь үндэсний ассамблейн хурлаар орж батлагдсаны дараа Ерөнхийлөгч түүнд хориг тавьж болох бөгөөд хуулийг олон нийтэд зарлах хугацааг 53-р зүйлд тус тус заасан байна. Дээрх зохицуулалтаас гадна Засгийн газрын хууль тогтоох байгууллагаас /Ministry of Government Legislation/ хуулийн төсөл, түүний хяналт шалгалтад хэрэгждэг энгийн стандартыг нэгтгэн эмхэтгэсэн гарын авлагыг 2012 онд гаргасан байна. Гарын авлага дээрхи стандартыг Үндэсний ассамблей /УИХ/, Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Засаг захиргааны төв байгууллагуудын саналыг авч нэгтгэх замаар тогтоожээ. Засгийн газар нь хууль тогтоох, хянан магадлах тохиолдолд энэхүү стандартыг баримталдаг.[94]

[90] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын иалаар олон улсын туршлага практик, 2013, 43-р тал
[91] National assembly act, Korea, 1990,37-р зүйл
[92] Constitution of the Republic of Korea, Korea, 1948, 52-р зүйл
[93] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 43-р тал
[94] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 44-р тал

***Хуулийн төсөл батлах үе шат:*** [95]

1. Хуулийн төсөл боловсруулах
2. Холбогдох яамдуудтай зөвлөлдөх
3. Засгийн газар болон эрх баригч намын зөвлөлгөөн
4. Хуулийн төслийг урьдчилан зарлах
5. Магадлан шалгах
6. Хууль зүйн яамны хяналт
7. Дэд сайдын хурал
8. Төрийн зөвлөлийн хурал
9. Ерөнхий сайд гарын үсэг зурах
10. Хуулийн төслийг үндэсний ассамблейд танилцуулах
11. Холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлэх
12. Хууль тогтоох болон шүүх хороогоор хэлэлцүүлэх
13. Хуулийн төслийг үндэсний ассамблейн чуулганаар хэлэлцэх
14. Хуулийн төслийг засгийн газарт буцаах
15. Төрийн зөвлөлөөр хэлэлцүүлж ерөнхийлөгч гарын үсэг зурах
16. Хуулийг нийтэд зарлах

[95] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 170-р тал

Хуулийн төсөл нь дээрх шат дамжлагыг дамжин хууль болон батлагддаг. Гэхдээ хуулийн төсөл өргөн барьсан субьектээсээ хамааран дээрхи 16 шат дамжлагыг хаанаас эхлэн дамжих нь тодорхойлогдоно. Засгийн газар хуулийн төслийг өргөн барьсан бол 1-16 хүртэлх шат дамжлагаар явах ёстой ба хэрвээ хуулийн төслийг Үндэсний ассамблейн гишүүн өргөн барьсан бол 10-16 дахь шат дамжлагыг дамжих ёстой. [96] Мөн Солонгосын хуулийн төслийг Үндэсний ассамблейн хуралд хэлэлцүүлэх явц дахь нэг онцлог зохицуулалт нь Үндэсний ассамблейн гишүүн хуулийн төслийг боловсруулах эрх бүхий этгээдийн хувьд хуулийн төслийг боловсруулах ба тухайн хуулийн төслийг Үндэсний ассамблейн 10-аас дээш тооны гишүүд хэлэлцүүлэхийг дэмжсэн санал гаргасан тохиолдолд түүнийг ассамблейн хурлаар хэлэлцэнэ.[97] Хуулийн төсөл батлагдах хүртэлх дээрх 16 шат дамжлагын 4 дэхь буюу хуулийн төслийг урьдчилан зарлах шатанд иргэдийн оролцоог хангадаг байна. Тэгэхээр Засгийн газрын холбогдох яам хуулийн төслийг санаачлан, өргөн барих тохиолдолд иргэдийн оролцоо байдаг бол Үндэсний ассамблейн гишүүн хуулийн төсөл санаачлахад 10-р шатаас эхлэж байгаа тул иргэдийн оролцоог тэр бүр хангадаггүй байна. Гэхдээ үндэсний ассамблейн гишүүн хуулийн төсөл санаачлахдаа иргэд, олон нийтийн байгууллага парламентад өөрийн хуулийн төслийг дангаараа шууд өргөн барих эрхгүй ч дараах арга замаар асуудлаа шийдвэрлэж болдог.[98] Үүнд:

- Хэрэгцээтэй хуулийн талаар парламентад хүсэлт тавих
- Парлментын гишүүнээр дамжуулан хууль санаачлах
- Аль эсвэл өөрийн харьяа намд хуулийн төслийн талаар санал гаргах боломжтой байдаг.

***Хуулийн төсөл боловсруулах.*** Засгийн газраас хуулийн төсөл боловсруулахад хуулийн төслийг холбогдох яамны хуулийн хэлтсээс боловсруулдаг. Хэрвээ хуулийн төслийн агуулга 2 ба түүнээс дээш яамны эрхэлдэг асуудлыг хамарч байвал хуулийн төслөө хамтран боловсруулна.[99]

Үндэсний ассамблейн гишүүн хуулийн төслийг боловсруулахдаа Үндэсний ассамблейн гишүүн өөрөө санал дэвшүүлэх эсвэл хувиараа хуулийн мэргэжлийн хүнтэй санал солилцох, мөн өөрийн харьяа намын хуулийн төсөл боловсруудаг хэлтэс, төсөл боловсруулах эрдэм шинжилгээний хүрээлэн, дэмжигчдийнхээ саналыг авч боловсруулдаг. Хуулийн төслийг Үндэсний ассамблейн дэргэдэх Судалгаа шинжилгээний байгууллага /National assembly research office/ боловсруулдаг. Энэхүү байгууллага нь ассамблейн гишүүний санал болгосноор хуулийн төсөл бэлтгэх, хуулийн төсөлтэй холбоотой судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа явуулна.[100]

***Холбогдох яамдтай зөвшилцөх.*** Засгийн газраас хуулийн төслийг боловсруулж байгаа тохиолдолд хуулийн төслийг боловсруулсны дараа хуулийн төслөө холбогдох яамдтай зөвлөлдөнө. Хууль зүйн яамтай зөвлөлдөн яаралтай эсвэл онцгой нөхцөл байдал хэмээн үзэн хугацааг богиносгохоос бусад тохиолдолд холбогдох яамдтай зөвлөлдөн санал авах хугацаа 10

---

[96] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 170-р тал
[97] National assembly act, Korea, 1990, 79-р зүйл
[98] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 50-р тал
[99] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 164-р тал
[100] National assembly act, Korea, 1990, 22-р зүйл

хоногоос багагүй байх ба санал авах хугацааг төсөл боловсруулагч мэдэгдэх ёстой.[101]

***Засгийн газар болон эрх баригч намын зөвлөгөөн.*** Хуулийн төсөл нь төрийн бодлого болон иргэдийн амьдралд нөлөөтэй байх тохиолдолд тухайн хуулийн төсөлд сөрөг хүчний намын дэмжлэг хүсэх болон Засгийн газар Эрх баригч намтай зөвлөгөөн хийдэг. Энэ шат нь заавал дамжих шат биш хэдий ч практикт хэрэгждэг шат юм.[102]

**Хуулийн төслийг урьдчилан зарлах.** Энэ шат нь хуулийн төсөлд олон хүний саналыг тусгах, хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Гэхдээ яаралтай батлах шаардлагатай, урьдчилан зарлах шаардлагагүй гэж үзсэн хуулийн төслийн хувьд урьдчилан зарлахгүй байж болно. Урьдчилан зарлах хугацаа нь 20-оос доошгүй хоног байна. Яаралтай шийдвэрлэх хуулийн төслийн хувьд 20 хоногоос багаар тогтоож болно. Тухайн хугацаанд хүлээн авсан саналуудаас аль үндэслэлтэй гэснийг нь засгийн газар хүлээн авч хэлэлцэнэ.[103] Сонирхогч этгээд болон шинжээчдээс санал авах, нийтийн сонсгол болон хуулийн төслийг урьдчилан зарлах үйл ажиллагаа нь "Захиргааны зохицуулалтын суурь хууль"(Framework act on administrative regulation)-д нийцсэн байна. [104] Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 4-р бүлэгт "хуулийг урьдчилан зарлах" тухай хуульчилсан байна.[105]

***Магадлан шалгах.*** Энэ шатанд яамнаас боловсруулсан хуулийн төслийг захиргааны байгууллага хэрэгжүүлэхэд ард иргэдийн эрхийг ямар нэг хэмжээгээр хязгаарлаж байгаа эсэхийг хянаж, энэ талаар яам, төрийн захиргааны бүх байгууллагуудаас санал авдаг. [106]

***Хууль зүйн яамны хяналт.*** магадлан шалгалт хийсний дараа хуулийн төсөл боловсруулагч яам нь Хууль зүйн яаманд хүргүүлнэ. Хууль зүйн яам хуулийн төсөлд хуулийн хэллэг, бүтцээс гадна хуулийн төслийн агуулга төрийн зорилтод хэр нийцэж байгаа, үндсэн хууль болон бусад хуультай зөрчилдөж байгаа эсэхийг хянадаг.[107]

***Дэд сайд болон төрийн зөвлөлийн хурал.*** Дэд сайдын хуралдаан нь Төрийн зөвлөлийн хуралдаанаар зөвлөлдөх чухал асуудлыг урьдчилан хянаж, хэлэлцэх үүрэгтэй. Төрийн зөвлөлийн хуралдаанд хуулийн төслийн товч тайлбарыг танилцуулж хэлэлцүүлэх ба яаралтай асуудлын хувьд дэд сайдын хуралдааныг алгасан шууд төрийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж болно.[108]

***Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд гарын үсэг зурах.*** Төрийн зөвлөл Ерөнхийлөгчийг нэгдүгээр гарын үсэг зуруулах, Ерөнхий сайд эсхүл холбогдох яамдын сайдыг хоёрдугаар гарын үсэг зуруулахаар санал өгсөн бол бүгд гарын үсэг зурна. Ингэхдээ төрийн зөвлөл хуулийн төслийг санал нэгтэй дэмжсэн

[101] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 165-р тал
[102] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 166-р тал
[103] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 166-р тал
[104] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 167-р тал
[105] Administrative procedures act , Korea, 1996, 4-р бүлэг
[106] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 167-р тал
[107] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 167-р тал
[108] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 168-р тал

тохиолдолд Ерөнхий сайд болон холбогдох яамдын сайд гарын үсэг зурах ба үүний дараа Хууль зүйн яам Ерөнхийлөгчид хүргүүлж гарын үсэг зуруулна.[109]

***Хуулийн төслийг үндэсний ассамблейд танилцуулж, холбогдох байнгын хороо хэлэлцэх.*** Хуулийн төслийг /уг төслийг дагалдан хуулийн төсөлтэй холбогдох зардлын тооцооны хамт байна/ ассамблейн дарга холбогдох байнгын хороонд хүргүүлдэг. Холбогдох байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хянахдаа эхлээд илтгэсэн хүнээс хуулийн төслийн зорилго, тайлбар, танилцуулгыг сонсоно. Дараа нь мэргэжлийн дүгнэлт, тайлан судалгааг сонсох бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь хэлэлцдэг. Хуулийн төслийг байнгын хороогоор хэлэлцэх хугацаа нь 20 хоног байдаг. Хэлэлцүүлэг дуусахад Хорооны дарга эцсийн шийдвэрийг зарлан Үндэсний ассамблейд хэлэлцүүлэх санал хураалтыг явуулдаг. Хуулийн төслийг байнгын хороогоор хэлэлцээд дэмжлэг аваагүй тохиолдолд тухайн хуулийн төслийн хэлэлцүүлгийг зогсоох бөгөөд тийнхүү шийдвэр гарснаас 7 хоногийн дотор 30 буюу түүнээс дээш тооны ассамблейн гишүүн чуулганд хэлэлцэх хүсэлт гаргавал ээлжит чуулганаар хуулийн төслийг авч хэлэлцэж болно.[110]

***Хууль тогтоох болон шүүх хорооны хяналт.*** Холбогдох байнгын хороо хэлэлцэж дууссаны дараа дэмжигдсэн хуулийн төслийг байнгын хорооны дарга Хууль тогтоох болон шүүх хороонд хүргүүлнэ. Хууль тогтоох болон шүүх байнгын хороо нь хуулийн төслийг хүлээж аваад хуулийн төслийн бүтэц, хэлбэр, агуулга талаас нь хяналт хийнэ. Хяналт шалгалтын үеэр хуулийн төсөлд хууль тогтоох болон шүүх хорооны дарга засвар хийж болдог ба нийт хугацаа 5 хоног байна.[111]

***Хуулийн төслийг үндэсний ассамблейн чуулганаар хэлэлцэх, засгийн газарт шилжүүлэх.*** Байнгын хороодын хяналт дууссаны дараа хуулийн төслийг ээлжит чуулганаар хэлэлцэх бөгөөд хяналт хийсэн холбогдох байнгын хороон дарга хуулийн төслийн тухай шалгалтын дүн, цөөнхийн санал зэргийг чуулганд танилцуулдаг. Үүний дараагаар хуулийн төслийн талаар асууж хэлэлцээд санал хураалт явуулна. Үндэсний ассамблейн чуулганд оролцож байгаа гишүүдийн 2/3 болон түүнээс дээш гишүүн хуулийн төслийг өөрчлөх талаар санал гаргавал хуулийн төслийг Засгийн газарт шилжүүлэх бөгөөд Засгийн газар хуулийн төслийн өөрчлөлтийг заавал хийх ёстой. Үндэсний ассамблейн ½-ээс дээш гишүүн хуулийн төслийг дэмжээгүй тохиолдолд хуулийн төслийг хүчингүй болгох /хэлэлцүлгийг зогсоох/ бөгөөд дараагийн чуулганаар дахин санал болгож танилцуулах эрхгүй болдог. Санал хураалт явагдсаны дараа хуулийн төслийг Засгийн газарт /хууль зүйн яаманд/ шилжүүлдэг.[112]

***Төрийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Ерөнхийлөгч гарын үсэг зурж, нийтэд зарлах.*** Засгийн газарт шилжүүлсэн хуулийн төслийг Ерөнхийлөгч 15 хоногийн дотор нийтэд зарлана.[113] Ерөнхийлөгч хэрвээ хуулийн төсөлд эргэлзээ байвал 15 хоногийн дотор тайлбараа үндэсний ассамблейд хүргүүлэн дахин хэлэлцэхийг хүснэ. Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу үндэсний ассамблейн хурлаар дахин хэлэлцэх ёстой. Хуралдаанд нийт гишүүдийн талаас дээш хувь нь оролцсон байх ба оролцсон гишүүдийн 2/3-оос дээш гишүүд хэвээр

---

[109] Ministry of Government Legislation, Laws on Government Organization, 2008, 168-р тал
[110] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 47-р тал
[111] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 48-р тал
[112] Боналекс ХХК, Хууль боловсруулах стандарт, журмын талаар олон улсын туршлага практик, 2013, 48-р тал
[113] Constitution of the Republic of Korea, Korea, 1948, 53-р зүйл

батлахаар дэмжсэн бол тухайн хуулийг батлагдсанд тооцно. [114] Хэрвээ ерөнхийлөгч 15 хоногийн дотор батлагдсан хуулийг нийтэд зарлаагүй тохиолдолд Үндэсний ассамблейн дарга түүнийг нийтэд зарлана. Хуульд өөрөөр заагаагүй бол батлагдсан хууль нь нийтэд зарлагдсанаас хойш 20 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.[115]

### 2.3.2. Олон нийтийн оролцооны арга, талууд

Үндэсний ассамблейн тухай хуулийн 58/6/-д хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд шинэ хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийтийн сонсгол явуулах эсвэл хуралдаан зохион байгуулна гэж зааж өгснөөр нийтийн оролцоог хангаж өгсөн.

Захиргааны зохицуулалтын суурь хуулийн 9-р зүйлд “Захиргааны төв байгууллага шинэ журам батлах болон одоогийн дүрэм журмаа боловсронгүй болгохдоо захиргааны байгууллага, нийгмийн тодорхой бүлгүүд, холбогдох талууд, судалгааны хүрээлэн, шинжээчдийн саналыг нийтийн сонсгол хийх болон хуулийг урьдчилан зарлах гэх мэт арга хэрэгслийг ашиглан сонсоно” хэмээн заасан байна. Иймд үүгээрэээ хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог хангаж байна гэж үзэж байна. Үүгээр зогсохгүй Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 4-р бүлэг буюу “хуулийн төслийг урьдчилан зарлах тухай” гэсэн бүлэг урьдчилан зарлах хуулийн төслүүд, урьдчилан зарлах этгээд, хугацаа, саналаа өгөх түүнийг боловсруулах, нийтийн сонсгол явуулах тухай хуульчилсан байна.

***Захиргааны үйл ажиллагааны тухай хууль***. Уг хууль нь нийт 8 бүлэгтэй. 3-р бүлэгт холбогдох талуудын болон нийтийн сонсголын тухай, 4-р бүлэгт хуулийн төслийг урьдчилан зарлахтай холбоотой зохицуулалтыг хуульчилсан байна. 4-р бүлэг 41-р зүйлд урьдчилан зарлахгүй байх тохиолдлуудыг, 42-р зүйлд урьдчилан зарлах арга хэрэгслийн тухай, 43-р зүйлд урьдчилан зарлах хугацаа, 44-р зүйлд үзэл бодлоо танилцуулах болон 45-р зүйлд нээлттэй сонсгол явуулах тухай хуульчилсан байна. Захиргааны байгууллага хууль болон эрх зүйн актыг шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгоход дараахь тохиолдолд урьдчилан зарлахгүй. Үүнд:

- Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс яаралтай батлах шаардлагатай хуулийн төсөл эсхүл урьдчилан тооцоолоогүй гэнэтийн нөхцөл байдал үүссэн.
- Суурь хуульд хуулийн төслийг урьдчилан зарлахгүйгээр заасан
- Хуулийн төсөл нь нийтийн эрх, үүрэг болон өдөр тутмын амьдралтай холбоогүй
- Хуулийн төслийг урьдчилан зарлах шаардлагагүй гэж үзсэн
- Урьдчилан зарлах нь нийтийн аюулгүй байдлыг дордуулахаар бол [116] гэж заагаад ийм нөхцөлд хуулийн төслийг урьдчилан зарлахгүй байхаар заасан байна.

---

[114] Constitution of the Republic of Korea, Korea, 1948, 53-р зүйл
[115] Constitution of the Republic of Korea, Korea, 1948, 53/7/-р зүйл
[116] Administrative procedures act , Korea, 1996, 42-р зүйл

Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 42(1)-д төслийг урьдчилан зарлахдаа хуулийн төслийн зорилго, түүний гол санаа болон хуулийн төслийн бүрэн эхийг захиргааны байгууллага нь дараах хэрэгслээр дамжуулан **нийтэд** мэдэгдэнэ. Үүнд:

- Засгийн газрын албан ёсны сонин
- Албан ёсны тогтмол хэвлэл
- Интернэт
- Сонин хэвлэл
- Телевизээр нэвтрүүлэх зэрэг гэж заажээ.[117]

Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 42(4)-д захиргааны байгууллага урьдчилан зарлагдсан хуулийн төсөлд олон нийтийн саналыг авахдаа дээр дурдсан 42(1)-г мөрдөх ба мөн **цахим нийтийн сонсгол**ыг явуулна гэж заажээ. Иймд хуулийн төслийг нийтэд Засгийн газрын албан ёсны сонин, Албан ёсны тогтмол хэвлэл, Интернэт, Сонин хэвлэл, Телевизээр нэвтрүүлэх зэргээс гадна цахим нийтийн сонсгол явуулдаг ажээ.

Нийтийн сонсгол нь танхимд явагдаж болно. Мөн цахим нийтийн сонсголыг интернет сүлжээгээр хийх ба зарчмын хувьд танхимд явагдах нийтийн сонсголтой адилхан.[118] Захиргааны байгууллага цахим нийтийн сонсгол явуулахад оролцогч нь цахим системээр хэлэлцүүлэгт оролцох болон үзэл бодлоо илэрхийлэх ба энэ нь хуулийн төслийн талаар санал цуглуулах болон солилцох ажиллагаа юм[119] хэмээн тодорхойлжээ.

Хугацааны хувьд 40-с доошгүй хоног байх ба зарим дүрэм, журмын хувьд 20 хоног байж болохоор заажээ. [120] Мөн нийтийн сонсгол явуулж буй захиргааны байгууллага нь санал хүлээн авах байгууллага, санал авах хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг өгдөг. Урьдчилан зарласан хуулийн төсөлд өгсөн саналыг холбогдох байгууллага саналыг нэгтгэн боловсруулж хэлэлцэнэ. Үүний дараагаар холбогдох байгууллага ирсэн саналуудын боловсруулалтын үр дүнг санал гаргагчид мэдэгдэнэ. [121]

***Оролцооны талууд.*** Дээр дурдсан Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 38-р зүйлд нийтийн сонсголын тухай заасан байх бөгөөд нийтийн сонсгол явуулах захиргааны байгууллага нь нийтийн сонсгол явуулах өдрөөс 14 хоногийн өмнө **холбогдох талуудад** дараах мэдээллийг Засгийн газрын албан ёсны сонин, Албан ёсны тогтмол хэвлэл, Интернэт, Сонин хэвлэл болон Телевизээр нэвтрүүлэх зэргээр хүргэнэ. Үүнд:[122]

- Гарчиг
- Хугацаа болон хэлэлцүүлэг хийх газрын байршил
- Гол асуудал
- Хуулийн төсөл танилцуулагчийн мэдээлэл
- Танилцуулгад оролцох тухай хүсэлт гаргах хэлбэр, хүсэлтийн маягт
- Нийтийн сонсгол явуулахтай холбоотой бусад мэдээллийг заавал мэдэгдсэн байна гэжээ.

[117] Administrative procedures act , Korea, 1996, 42-р зүйл
[118] Administrative procedures act , Korea, 1996, 38-р зүйл
[119] Administrative procedures act , Korea, 1996, 38-2-р зүйл
[120] Administrative procedures act , Korea, 1996, 43-р зүйл
[121] Administrative procedures act , Korea, 1996, 44-р зүйл
[122] Administrative procedures act , Korea, 1996, 38-р зүйл

Нийтийн сонсгол явуулах тухай холбогдох талуудад мэдэгдэнэ гэж Захиргааны журмын тухай хуулийн 38-д зааснаар иргэдийн оролцооны талууд нь холбогдох талууд болно. Холбогдох талууд гэдгийг уг хуулийн 2-р зүйлд тодорхойлохдоо "захиргааны байгууллагаас явуулж буй үйл ажиллагаанд шууд холбогдон оролцогч талууд болон захиргааны байгууллагын хүсэлтээр захиргааны үйл ажиллагаанд оролцохоор заагдсан сонирхлын бүлгүүд болон хүсэлт гаргагчид" хэмээн тодорхойлжээ. Мөн уг хуулийн 9-р зүйлд:

> "Захиргааны үйл ажиллагаанд дараах этгээдүүдийг холбогдох талууд болно. Үүнд:
>
> - Хувь хүн
> - Хуулийн этгээд, холбоо, сан зэрэг хуулийн этгээд бус этгээдүүд
> - Бусад хууль болон эрх зүйн актын дагуу аливаа эрх, үүрэг хүлээгч этгээд" гэж заажээ.

***Дүгнэлт.*** Өмнөд Солонгосын хувьд парламентын гишүүн нь 10-аас доошгүй гишүүний дэмжлэг авч хууль санаачилдаг, хуулийн төсөл боловсруулах талаар өөрийн харьяа намдаа ханддаг, зарим чухал асуудлаар сөрөг хүчний намын дэмжлэг хүсэх болон Засгийн газар Эрх баригч намтай зөвлөгөөн хийдэг, Захиргааны үйл ажиллагааны тухай хуулиар хуулийн төслийг урьдчилан зарлаж, олон нийтийн оролцоог хангах талаар тодорхой зохицуулдаг, хуулийн төслийн талаар парламентын өмнөх шатанд Дэд сайд нар зөвлөлддөг, нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс яаралтай батлах шаардлагатай хуулийн төсөл, эсхүл урьдчилан тооцоолоогүй гэнэтийн нөхцөл байдал үүссэн, суурь хуульд хуулийн төслийг урьдчилан зарлахгүйгээр заасан, хуулийн төсөл нь нийтийн эрх, үүрэг болон өдөр тутмын амьдралтай холбоогүй, урьчилан зарлах нь нийтийн аюулгүй байдлыг дордуулахаар бол гэх зэрэг нөхцөлд хуулийн төслийг урьдчилан зарлахгүй байхаар зохицуулсан зэрэг онцлогууд бидний анхаарлыг татсан юм. Өмнөд Солонгосын хувьд хуулийн төслийг олон нийтэд нээлттэй зарлах ба телевиз, сонин, интернэт зэргийг ашиглаж байгаа нь хүн бүхэн орж харах боломжтой байгаа ба сонирхсон этгээд нь өөрийн саналыг холбогдох захиргааны байгууллагад хүргэж болдог байна. Үүнээс гадна хуулийн төслийн ийнхүү өргөн сүлжээгээр олон нийтэд танилцуулж байгаа нь олон нийтийн саналыг авах нэгэн чухал ач холбогдолтой алхам бөгөөд ийнхүү хуульчилснаар олон нийтийн санал авах, оролцоог хангах ажиллагааг дэмжсэн байна.

## 2.4. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС

### 2.4.1. Эрх зүйн орчин

Бүгд найрамдах Польш улс нь Төв Европт оршдог хойд талаараа Балтын тэнгисээр хүрээлэгдэж, зүүн талаараа Орос (Калининград муж), Литва, Беларусь, Украйн, урд талаараа Словак, Чех, баруун талаараа Герман гэх долоон улстай газраар хиллэдэг 16 мужаас бүрдсэн Холбооны Улс юм. [123]

[123] Википедиа, Польш, https://mn.wikipedia.org/wiki/%D0%9F%D0%BE%D0%BB%D1%8C%D1%88

Тус улсын хууль тогтоох дээд байгууллага нь Сейм болон Сенат юм. Хуулийн төслийг санхүүгийн үр нөлөөллийн тооцоо болон санхүүгийн эх үүсвэрийн тайлбар дагалддаг ба хуулийн төсөл нь Европын холбооны хуультай нийцсэн байх ёстой байдаг.[124]

Хуулийн төсөл боловсруулах журам нь хууль санаачлагчаас Маршалд ирснээр Сеймийн хуралдаанаас эхэлдэг. Сейм хуулийн төслийг гурван удаагийн уншлагаар хэлэлцүүлдэг ба Анхны уншлагаар хуулийн төслийн талаар санал солилцож, ерөнхий ойлголт аван хэлэлцүүлж хуулийн төслийн ажлыг илүү үр дүнтэйгээр боловсруулахын тулд мэргэжлийн шинжээч, Европын холбооны хуульд нийцсэн эсэхийг дүгнэх мэргэжлийн шинжээч болон Засгийн газрын төлөөллүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж болно. Энэ шатны уншлагаар хуулийн төслийг илүү боловсронгуй болгох талаар нэмэлт санал, тайлан бичдэг, эсхүл хуулийн төслийг мөн түдгэлзүүлэх тохиолдол байдаг. Европын холбооны хуульд нийцэж байгаа эсэх талаар тайлбарыг мэргэжлийн шинжээч гарган, хоёр дугаар уншлагын үеэр хуулийн төсөлд хавсаргана.[125]

Хуулийн төслийг хэлэлцүүлэх гурван удаагийн уншлагаас анхны уншлагын үеэр л мэргэжлийн шинжээчийг ажлын хэсэгт оролцуулж байгаа нь олон нийтийн оролцоог хангаж байгаа нэг арга юм.

Хуулийн төслийн хоёр дахь уншлагаар Хороодын оруулсан нэмэлт саналыг хэлэлцдэг. Энэ шатны уншлагаар хууль санаачлагч нь хуулийн төслөө буцаан татах эрхтэй, Маршал Хороодын нэмэлт саналыг хүлээж авахгүй байх мөн хуулийн төслийг түдгэлзүүлэх эрхтэй байдаг. Хоёр дугаар шатны уншлагын явцад олон нийтийн оролцооны талаар дурдагдаагүй байна.

Гуравдугаар шатны уншлагаар хоёр дугаар шатны уншлагаас гарсан саналуудыг тусгасан талаар хэлэлцэж, санал хураалт явуулан талаас илүү Депутат зөвшөөрсөн тохиолдолд Маршал хуулийн төслийг Сенатад хүргүүлдэг байна.

[124] Бүгд Найрамдах Польш улсын Сеймийн албан ёсны цахим хуудас http://www.sejm.gov.pl/english/prace/prace.html
[125] Бүгд Найрамдах Польш улсын Сеймийн албан ёсны цахим хуудас http://www.sejm.gov.pl/english/prace/prace.html

Хуулийн төсөл боловсруулах үйл явцын товч схемыг дор харууллаа.






Хууль санаачлах болон хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах талаар дараахь хуулиудаар зохицуулсан байдаг.

- Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль /1997/
- Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хууль /2005/
- Бүгд найрамдах Польш Улсын Сеймийн дүрэм /1992/

***Үндсэн Хууль.*** Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль нь 1997 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан бөгөөд 13 бүлэг, 243 зүйлтэй хууль юм. Тус хуулийн 95.1-д Сейм болон Сенат нь хууль тогтоох дээд байгууллага болохыг заасан ба мөн хуулийн 118-д зааснаар 15 Депутат бүрдсэн бүлэг, Сенат, Холбооны Ерөнхийлөгч болон Сайд нарын зөвлөл, доод тал нь 100 мянган хүний дэмжлэг авсан ард иргэд хуулийн төслийг өргөн барих эрхтэй болохыг заасан байдаг.

Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар санал асуулга болон олон нийтийн санаачилга гэсэн хоёр үндсэн замаар хууль тогтоох үйл явцад шууд оролцох боломжийг Польш иргэдэд олгосон байна. [126] Бүх нийтийн санал асуулгыг Үндсэн хуулийн холбогдолтой хууль тогтоомжийн дагуу улс орны амин чухал асуудлуудаар зохион байгуулж болдог ба ийм санал асуулгаар шийдсэн асуудал иргэдийн 50-иас дээш хувь нь оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болдог. Санал асуулга явуулах шийдвэрийг Парламентын тогтоолоор, эсхүл Польшийн Ерөнхийлөгчийн шийдвэрээр гаргана. Өнөөг хүртэл Польшид бүх нийтийн санал асуулгыг гурван удаа зохион байгуулсан байна. Үүнд, нийтийн франчайзын асуудлаар 1996.02.16-нд, Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудлаар 1997.05.25-нд, Польш улс Европын холбоонд нэгдэх асуудлаар 2003.06.08-нд тус тус болжээ.[127]

[126] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо”, 2007, 39-р тал.
[127] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо”, 2007, 39-р тал.

Олон нийтийн санаачлагын хувьд Үндсэн хуулийн 118.2-д доод тал нь 100 мянган хүний дэмжлэг авсан хуулийн төслийг иргэд Сеймд өргөн барих эрхтэй болохыг заасны дагуу цөөн тооны нөхцөл байдлыг эс тооцвол, иргэдийн өргөн барьсан хуулийн төсөл нь Засгийн газрын болон Парламентын гишүүдийн хуулийн төсөлтэй ижил статусаар хэлэлцэгдэх ёстой. Ийм механизм ашиглаж байгаа иргэд Төсвийн тухай хуулийн хүрээнд нөлөөлж болохгүй, Үндсэн хуулийг өөрчлөхийг оролдож болохгүй. Иргэдийн өргөн барьсан хуулийн төсөл нь парламентын ажлын хүрээнд ямар нэгэн эрх ямба эдлэхгүй. [128]

Иргэдийн санаачлах эрхтэй хуулийн төслийн талаар тусгайлсан хуулиар зохицуулна гэж заасны дагуу бид судалгааны явцад тухайн хуулийг хайсан боловч олдоогүй болно.

Хэдийгээр иргэдийн санаачилсан хуулийн төсөл нь тэр бүр дэмжигдээд байдаггүй, бүх нийтийн санал асуулгыг олон удаа явуулж байгаагүй гэсэн судалгаа байдаг боловч Үндсэн хуулиараа ард иргэддээ хууль тогтоох үйл явцад дээрх хоёр аргаар шууд оролцох боломжийг олгосон нь онцлог байна.

***Бусад хууль, дүрэм.*** Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дүрэм нь 1992 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан 5 бүлэг 132 зүйлтэй дүрэм юм. Энэхүү дүрэмд хуулийн төсөл боловсруулах талаар, Сейм хэрхэн оролцох талаар заасан байдаг. Энэхүү дүрмийн 39.1-д Сеймийн хороо, дэд хороо болон Депутатаар хэлэлцэгдэх явцад уригдаж ирсэн шинжээчдийн саналыг сонсохоор заасан нь мөн нэг талаараа олон нийтийн оролцоог хангаж байгаа явдал юм. Дээр дурдсан шинжээчид нь мэргэжлийн лоббист байх талтай байна.

БНПУлсад 2005 онд боловсруулсан Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хуулийг 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдөр баталсан бөгөөд тус хууль 6 бүлэг 24 бүлэгтэй. Энэхүү хуулиар ил тод засаглал, лоббигийн зохицуулалт, мэргэжлийн лобби, лобби хэрэгжүүлэлтийн хяналт, мэргэжлийн лоббист болон Лобби фирмийн бүртгэлийн талаар зохицуулсан.

Энэхүү хуулийн ачаар иргэдэд хууль тогтоох ажилд нөлөө үзүүлэх нэг шинэ институц болох нийтийн сонсгол бий болсон.[129]

Хууль тогтоох ажиллагаанд нөлөө үзүүлж болохуйц бүхий л үйл явдлыг хамарч байгаа ерөнхий лобби үйл ажиллагаа болон мэргэжлийн лобби үйл ажиллагаа хоёрыг дээрх хууль ялгаж тодорхойлсон. Хуульд зааснаар мэргэжлийн лобби үйл ажиллагаа гэдэг нь хэрэв хууль тогтоох үйл явцад нөлөөлөл, тэндээсээ ашиг олох эрмэлзэлтэй бол тэр иргэн /эсхүл хуулийн этгээд/ “мэргэжлийн лоббист” гэж бүртгүүлсэн байхыг хэлнэ.

Мэргэжлийн лоббист нь бүртгүүлснийхээ дараа Парламентад нэвтрэх тусгай үнэмлэх авах бөгөөд Яамд руу саадгүй нэвтрэх эрхтэй байна. Яамд болон Парламент бүхий л чухал мэдээллийг гарган өгч, холбогдох шаардлагатай дотоод журмаа өөрсдөө хариуцах үүрэг хүлээсэн. Лоббист нь дээрхээс өөр тусгай эрх ямба эдлэхгүй. [130]

---

[128] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо”, 2007, 40-р тал.
[129] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо”, 2007, 41-р тал.
[130] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо”, 2007, 42-р тал.

Дээрх хуульд төрийн эрх бүхий байгууллага нийтийн сонсголыг явуулах боломжтой ба нийтийн сонсголыг төвөггүй явагдах байдлыг хангаж, хүрэлцэн ирсэн иргэдэд чөлөөтэй ярих боломжийг олгох гол чиг үүрэгтэй болохыг заасан. [131] Гэвч тухайн нийтийн сонсголыг явуулах процедур, зохион байгуулалтын талаар ямар нэгэн заалт байхгүй, зөвхөн оролцох боломжтой талуудыг бүртгэх талаар л тусгасан.

Нийтийн сонсголыг эрх зүйн орчноо сайжруулах гэсэн иргэдийн гар дээрх үр ашигтай зэвсэг болгох явдлыг хангаж чадах тийм зохицуулалт Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хуульд ороогүй байна.

### 2.4.2. Олон нийтийн оролцооны арга, талууд

***Иргэдийн хууль санаачлах эрх.*** БНПУ-д дээрх байдаар 100 мянган иргэн хууль санаачилдаг боловч уншлагын явцад түдгэлздэг, ийнхүү санаачилсан хуулийн төсөл нь батлагдсан тохиолдол тун бага байдаг гэсэн мэдээлэл байдаг. Энэхүү аргаар хууль санаачилж байгаа иргэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Төсвийн тухай хуульд нөлөөлөхийг хориглосон байдаг юм байна. [132]
100 мянган иргэд хууль санаачлах арга нь дараах байдлаар явагдана:

- Эхний шатанд 15 иргэн хууль санаачилж байгаа талаараа өргөдөл бичин, гарын үсэг зуржˑ Хууль санаачлах хороонд хандана
- Хоёр дах шатанд бүртгэгдсэн хуулийн төсөл санаачлахыг дэмжигчдээс 1000 хүний гарын үсэг цуглуулан, Хороо хууль санаачилж байгаа талаар болон цуглуулсан гарын үсгүүдийг Сеймийн Маршалд танилцуулж, Маршал үүнийг зөвшөөрөн баталгаажуулна.
- Хороо улсын өдөр тутмын сонинд хуулийн төсөлтэй танилцах, гарын үсгээ зурж болох байршлын талаар нийтэлнэ.[133]

Ийнхүү дээрх байдлаар 100000 иргэдийн гарын үсгийг цуглуулан хуулийн төслийг Сеймийн Маршалд өргөн барьдаг байна.

***Лобби.*** Мэргэжлийн лоббистийн бүртгэлийн талаар албан ёсны хэвлэлд түүний байршлын талаарх мэдээллийг заавал нийтэлдэг байна. Мөн жил бүрийн хоёрдугаар сард мэргэжлийн лоббист болон Лобби фирмийн тухайн жилд хийсэн ажлыг талаар нийтлэх шаардлагыг хуульд заасан байна.[134] Лобби үйл ажиллагаа нь олон оронд хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог хангаж байгаа шинэ арга юм. Лобби нь олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн идэвхтэй арга байж болох талтай. Гэхдээ лобби үйл ажиллагааны явцад авилгад автах сул талтай тул энэ талаар нарийвчлан судалж, гажуудал гаргахгүй байх нь чухал юм.

***Нийтийн сонсгол.*** Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хуульд хуулийн төслийг Сеймд өргөн барьж, хэлэлцүүлэхээс өмнө нийтийн сонсгол явуулахаар заасан. Нийтийн сонсгол явуулах өдрөөс долоо хоногийн өмнө

---

[131] Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хууль, БНПУ, 2005, 9.5 дах заалт
[132] Нээлттэй нийгэм форум, УИХ-ын Тамгын газар, "Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь Иргэдийн оролцоо", 2007, 40-р тал.
[133] Anna Rytel, The Popular Initiative in Poland, https://democracy-international.org/sites/democracy-international.org/files/PDF/Publications/2006-05-08_polandpopularinitiative.pdf , 2006.
[134] Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хууль, БНПУ, 2005, 10, 18 дугаар заалт

албан ёсны хэвлэлээр нийтийн сонсгол явуулах огноо болон цагийг зарлах ба нийтийн сонсголыг ямар нэгэн саадгүйгээр явуулна.

***Албан ёсны хэвлэл.*** Аливаа хуулийн болон зохицуулалтын саналыг Сайд нарын зөвлөлийн гишүүдийн саналыг авсны дараа албан ёсны хэвлэл дээр нийтлэх мөн бусад лоббитой холбоотой мэдээллүүдийг мөн дээрх хэвлэлд нийтлэхээр заасан[135] байна.

Хуулийн төсөлд төрийн байгууллагуудын саналыг авч тусгасны дараа батлагдахаас өмнө олон нийтэд хүргэх албан ёсны хэвлэл, албан ёсны цахим хуудсанд нийтлэх талаар хуульд тусгаж өгвөл иргэд хуулийн талаар илүү мэдээлэлтэй болж, саналаа өгч тусгах нь хуулийн хэрэгжилтэд чухал ач холбогдолтой.

***Шинжээчийг оролцуулах.*** Хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийн дараа Сеймийн хороо, дэд хороо болон Депутатаар хэлэлцэгдэх явцад шинжээчдийн саналыг сонсохоор заасан, мөн БНПУ-ын хууль нь Европын холбооны хуульд нийцсэн байх ёстой байдаг тул тухайн хуулийн төслийг боловсруулах явцад Европын холбооны шинжээчийг оролцуулан, дүгнэлт гаргуулдаг байна.[136]

***Дүгнэлт.*** Пост коммунист орны төлөөлөл болгож бид Польшийг сонгосон. 100000 иргэний дэмжлэг авах замаар иргэд шууд ардчиллын зарчмаар хууль тогтоогч болох боломжийг хуульчилсан нь бидний сонирхлыг татсан юм. Түүнчлэн лоббийн үйл ажиллагааг хуульчилсан нь онцлог байсан бөгөөд эрх зүйн зохицуулалтын хувьд бүрэн хэмжээний мэдээлэл авах боломж хомс, лоббийн үйл ажиллагааны шилдэг жишээ туршлага болохоор сэтгэгдэл төрүүлсэнгүй. Бид энэ бүлгийн хүрээнд Польшоос гадна Азербайджан, Киргиз, Вьетнамын Хуулийн тухай хуультай төсөөтэй хуулиудыг судалсан. Иргэдийн оролцооны гол арга болох нийтийн сонсгол, хэвлэн нийтэлж санал авах, сонирхлын бүлэг, мэргэжилтэн шинжээчдээр хэлэлцүүлэх буюу дүгнэлт гаргуулах гэсэн үндсэн асуудлууд төсөөтэй байдлаар тусгасан цөөн зүйл, заалттай байдгийг ажигласан.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО: МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

## 3.1. Эрх зүйн орчин

Монгол Улс шинэ ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд баталж засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж, хүний эрх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан нь оролцооны үндсэн эрхүүд хэрэгжих эхлэл болсон юм. Монгол улсын иргэд шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах эрхтэй болж, үзэл бодлоо янз бүрийн түвшинд илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаанд оролцох, гэр бүл нийгмийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш оролцох зэрэг эрхүүд хууль тогтоомжуудад тусгагдсан билээ. Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. Мөн зүйлд “Иргэд, бусад

[135] Хууль тогтоох болон Лобби зохицуулалтын тухай хууль БНПУ, 2005, 5, 10 дугаар заалт
[136] Бүгд Найрамдах Польш улсын Сеймийн албан ёсны цахим хуудас http://www.sejm.gov.pl/english/prace/prace.html

байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна" гэж заасан нь хууль боловсруулах, санаачлах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангахтай холбоотой Үндсэн хуульд тодорхойлогдсон суурь зарчим юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг шинэ Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах эрх зүйн томоохон шинэтгэлийн ажлыг 1992-1996, 1996-2000 оны Улсын Их Хурал хэрэгжүүлсэн байдаг. Мөн Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгон тогтвортой хөгжүүлэх асуудлын хүрээнд 1998 онд "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг тодорхой хугацаатайгаар төлөвлөн зохион байгуулах үүднээс "Үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2001 оны 44, 2005 оны 26, 2009 оны 38 дугаар тогтоолыг тус тус батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байсан болно. Дээрх асуудлын хүрээнд хууль санаачлагч холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хуулийг Монгол Улсын Их Хурал 1997 онд баталж, 2001 онд шинэчлэн баталсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулиар зохицуулж ирсэн. Уг хуульд хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг тодорхойлсон байдаг. Үүнд:

***Хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх шатанд***

Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно \3.2\

***Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх шатанд***

Үндсэн чиглэлийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагын саналыг авч нэгтгэн судалсны үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна \4.2\. Үндсэн чиглэлийн төсөлд санал өгч байгаа хууль санаачлагч нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах болон дагаж мөрдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг тодорхой заасан байна \4.3\ гэж заасан. Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх шатанд иргэд, олон нийтийн оролцоог энд шууд заагаагүй боловч олон нийтийн зүгээс нийгмийн тодорхой харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, шинээр хууль гаргах болон дагаж мөрдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх саналаа хууль санаачлагчид өгөх боломж нээлттэй байдаг. Үүнтэй уялдаж, хууль санаачлагчийн бүрэн эрхийг тодорхойлсон уг хуулийн 6 дугаар зүйлд "иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах" \6.1.6\ гэж заасан байдаг. Энд дурдсан

хууль санаачлагчийн бүрэн эрх нь иргэд, олон нийтээс санаачлага гарсантай холбоотойгоор тодорхойлогдож байгаа тул дараалын хувьд иргэд олон нийтийн оролцоог эхэлж тодорхойлох нь зүйтэй байсан болов уу.

***Хууль санаачлагчийн бүрэн эрхийн хүрээнд***

Уг хуульд зааснаар иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог дайчлах, хангах чиглэлээр хууль санаачлагч нь дараах бүрэн эрхтэй байна:

- хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдгээрийн саналыг авах \6.1.4\;
- хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх \6.1.5\. Энэ заалтыг 2009 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж оруулсан.
- иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах \6.1.6\.

***Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр***

Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна \7.1\:

- хуулийн төслийг өөрөө боловсруулах;
- холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэж хуульд заасан.

Энд "холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах" гэж заасан. Практик дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүний нилээдгүй хувийг төрийн холбогдох байгууллагын төлөөлөл эзэлдэг. Мөн "мэргэжлийн" гэдэг утгаараа төрийн бус байгууллагын төлөөлөл оролцох нь түгээмэл байдаг. Энэ нь ч зүйн хэрэг. Харин ажлын хэсэгт төрийн байгууллагын төлөөлөл оролцдог гэдгийг хуулийн энэ хэсэгт нэмж оруулах шаардлагатай. Ийнхүү шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хуулийн төсөл боловсруулах нь нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангаж буй нэг арга мөн.

***Хуулийн төсөлд санал авах***

Хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана \18.3\. Өмнөх бүлэгт Канад, Өмнөд Солонгос зэрэг улсад эхлээд хуулийн төслөө боловсруулж, төрийн байгууллагуудаасаа санал авсны дараа олон нийтэд танилцуулах, санал авах ажиллагааг явуулдаг тухай дурдсан. Манай хуулийн энэ заалтаар төрийн байгууллага, иргэд, хуулийн этгээдээс саналыг нь авах ажлын дараалал нь тодорхойгүй, зэрэгцүүлээд уг ажиллагааг явуулсан ч болох мэт ойлгогдож байгаа нь анхаарвал зохих асуудал юм. Энэ хуульд заасанчлан хуульд өөрөөр

заагаагүй бол хууль санаачлагч хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээс санал авах ажиллагааг дараахь хэлбэрээр зохион байгуулна\18.4\:

- хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах;
- хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно

Хууль санаачлагч нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулахдаа хуулийн төслийг бүрэн эхээр нь байрлуулахаас гадна зохих ёсоор батлагдсан уг хуулийн үзэл баримтлал, танилцуулга, уг хууль батлагдахтай холбогдуулан бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг мөн олон нийтэд танилцуулах нь зүйтэй. Ингэснээр олон нийт Яагаад? гэсэн олон асуултдаа хариулт авч, тухайн хуулийн төслийн талаар иж бүрэн төсөөлөл, мэдээлэлтэй болж, саналаа өгөх нөхцөл бүрдэнэ. Ийнхүү олон нийтэд танилцуулсан мэдээллийг санал авах хугацаа дуусмагц тухайн цахим хуудсанд наад тал нь 3-5 жил, түүнээс ч урт хугацаанд архивлан хадгалдаг байх нь иргэд олон нийтийн мэдээллийн, эрх зүйн боловсролын, судалгааны, хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгч, шүүхийн практик үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, тэдгээрт олон нийтээс ирүүлсэн санал, түүнийг хуулийн төсөлд тусгасан байдал, тусгаагүй бол энэ тухай тайлбар зэрэг мэдээллийг мөн тухайн цахим хуудсанд байрлуулдаг байх нь төр, олон нийтийн эргэх холбоог сайжруулахын зэрэгцээ хуулийг нэг мөр ойлгох, тайлбарлах, хэрэглээний соёлыг бий болгоход чухал ач холбогдолтой.

***Олон нийтийн оролцоог төлөвлөж, мэдээлэх шаардлагатай байна***

Жирийн иргэн, байгууллагын хувьд ямар байгууллагын, аль цахим хуудсанд, ямар хуулийн төслийн талаарх мэдээлэл хэдийд тавих нь тодорхойгүй байгаа нь иргэд, олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна. Ийм мэдээлэл урьдчилсан байдлаар байхгүй тохиолдолд цахим хуудсанд байрлуулах хугацааг 1 сар, 6 сараар тавьсан ч үр дүн гарахгүй. Иймд энэ талаарх төлөвлөгөөг хагас жил, улирал, болдог бол жилийн өмнөөс тодорхой болгон баталж, олон нийтэд мэдээлдэг тогтолцоог хуульчлах нь зүйтэй. Түүнчлэн “Монголчуудтайгаа зөвлөлдөх нь” гэсэн нэгдсэн цахим хуудас бүтээж, энэхүү төлөвлөгөө болон олон нийтээр хэлэлцүүлж байгаа хуулийн төсөл, архивт орсон төслүүдийг хариуцан боловсруулж буй байгууллага буюу хууль санаачлагчийн цахим хуудас руу орох линктэйгээр байрлуулж хэвшвэл цахим хэлэлцүүлгийг 10-15 хоногт багтаахаар хуульчилсан ч хэрэгжих боломжтой байх боломжтой. Үүнээс урт хугацаагаар цахим хуудсанд байрлуулахаар хуульчлах нь хууль тогтоох үйл ажиллагааг сунжруулах сул талтай.

Уг хуулийн 18 дугаар зүйлд хуулийн төслийг хууль санаачлагч буюу хуулийн төсөл боловсруулсан тухайн харилцааны асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зүгээс төрийн бусад байгууллагын саналыг авч тусгах, зарим асуудлаар хууль зүйн болон төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлийг авах журмыг тодорхойлсон байдаг. Мөн хуулийн 18.15-д: “Хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана” гэж заасан нь хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн

хангасан талаарх эцсийн товч тайлан гэж үзэж болно. Хуулийн төслийн аль шатанд хэний, ямар байгууллагын ямар санал дэмжигдэж хуулийн төсөлд тусгагдсаныг олон нийт мэдэх боломжтой болгоно гэдэг нь эргээд тухайн санал гаргагчийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хууль бол ард түмний бүтээл гэдгийг жинхэнэ утгаар илэрхийлнэ. Тийм ч учраас хэн нэг албан тушаалтан хуулийн төслийг дураараа засах боломж хаагдаж, хууль тогтоох ажиллагааны ил тод байдал хангагдаж, оролцооны механизм хэрэгжинэ.

***Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх***

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулж болно гэж заагаад Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж шийдвэрлэх журам, ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэх талаар шийдвэр гаргасан байхаар заасан байна.
Хуулийн төслийг нийт ард түмнээр; нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хэлэлцүүлж болох бөгөөд уг ажлын зохион байгуулалт, дүнг нэгтгэн Улсын Их Хуралд танилцуулах зэрэг харилцааг зохицуулсан хэдий ч уг зохицуулалтыг практикт хэрэглээгүй байна.

***Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль***

Уг хуулийн “Үйл ажиллагааны ил тод байдал” гэсэн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах” гэж заасан. *Нэгдүгээрт,* Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд хуулийн төслийг 10 хоног байрлуулахаар заасантай хугацааны хувьд зөрчилтэй байна. *Хоёрдугаарт,* зөвхөн үндэслэлтэй бол саналыг төсөлд тусгаад үндэслэлгүй бол яагаад үндэслэлгүй гэж үзсэн тухай мэдээлэл олон нийтэд хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Ер нь хуулийн төслийг хэлэлцүүлнэ гэдэг нь олон нийтийн саналыг авах гол зорилготойгоос гадна тухайн хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг цогцоор нь олон нийтэд ойлгуулах зорилго агуулах ёстой гэж үзэж байна. Хууль бол нийгмийн харилцааг зохицуулахдаа шударга, товч байх учиртай. Тухайн хуулийн төсөл нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хөндөх буюу тэдний зан үйлийн хэм хэмжээг тогтоож, зарим тохиолдолд орлогыг нь бууруулах, нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээний зохицуулалтыг хамардаг. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгийн санал бүрийг хуулийн төсөлд тусгах шаадлагагүй байж болно. Иймд гарсан саналыг яагаад төсөлд тусгаагүйг ямар нэг хэлбэрээр мэдээлэх нь иргэдийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, хуулиар дамжин илрэх төрийн бодлогыг ойлгуулах илүү өргөн зорилго, ач холбогдолтой.

Бид хуулийн төсөл хэлэлцүүлэх, хэлэлцүүлэг хийх гэж ярьж хэвшсэн байна. Ихэнх орнууд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёо хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Хэлэлцүүлэг зохион байгуулах гэдэг үг төрийн идэвхтэй санаачилгаар буюу нэг тал-төр давамгайлсан утгыг агуулж байгаа юм бишүү гэх санаа төрж байна. Тийм ч учраас хэлэлцүүлгээс гарсан “үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах” гэж хуульчлаад үндэслэлгүй гэж үзсэн шалтгааныг хэлэлгүй орхиод байна уу? Харин “иргэдтэйгээ зөвлөлдөх” гэдэг нь тэгш харилцаа, харилцан ойлголцлыг агуулж байна. Иймд шинээр боловсруулж байгаа хуульд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёог хэрэглэхийг зөвлөж байна.

Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"-д “ЗӨВЛӨЛДӨХ”- аливаа тогтоох төлөвлөх үйл хэргийг олноороо хамтран хуралдаж хянан шүүмжилж хэлэлцэх; зөвлөлдөн хэлэлцэх; “ХЭЛЭЛЦЭХ”-хэлэхийн үйлдэлцэх хэв, харилцан ярилцах; 2. олноор буюу бусдын хамт хэлэх; шүүмжлэн хэлэлцэх; хурал дээр зөвлөн хэлэлцэв; хэлэлцэх хэрэг (хурал зөвлөлгөөнөөр ярилцах хэргийн товьёг жагсаалт); хэлэлцэх асуудал (ярилцвал зохих хэрэг)[137] гэж тайлбарласнаас үзвэл зөвлөлдөх гэдэг нь өргөн агуулгатай, хэлэлцэх гэсэн утгыг дотроо багтаасан ойлголт болох нь харагдаж байна.

Хуулийн төсөл өргөн мэдүүлсний дараа олон нийтийн оролцоог хангах талаар тодорхой зохицуулалтуудыг өөр хуулиар тогтоосон байдаг.

### *Хуулийн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэх*

Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах” гэсэн 21 дүгээр зүйлд Төр, нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн төслийг нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг дараахь журмаар холбогдох Байнгын хороо зохион байгуулж болно:

- төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ санал ирүүлэх хугацаа, түүнийг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байх;
- олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төсөлд санал өгсөн иргэн буюу хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн саналынх нь талаар асуулт асуух.

Хуулийн төслийг хэвлэлд нийтлүүлж санал авах, түүнийг нэгтгэн судлах үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын хороо, Тамгын газар хариуцна хэмээн заасан байдаг.

Мөн хуулийн 54 дүээр зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах, ашиглах журмыг тодорхойлсон бөгөөд хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд, ажлын хэсэг, бусад Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгээс холбогдох Байнгын хороонд бичгээр ирүүлсэн саналын томъёолол, тэдгээрийн үндэслэл, тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг зэрэг хуулийн хувийн хэрэгт оруулах материалыг жагсаасан. Хуралдааны бичвэр, соронзон болон

[137] http://tsevel.toli.query.mn/, 2014.12.08

дуу, дүрс бичлэгийн тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтнууд шууд, бусад байгууллагын ажилтан, албан тушаалтан Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр танилцаж болно. Уг тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтан 7 хоног хүртэл хугацаагаар танилцаж болох бөгөөд зөвшөөрөлгүйгээр олшруулах, хувилахыг хориглоно. Бусад байгууллагын ажилтан тэрхүү тэмдэглэлтэй Тамгын газрын архивт танилцана гэж хуульчилсан нь УИХ дээр хуулийг хэрхэн хэлэлцэж, ямар санал гарч байсан тухай мэдээллийг мэдэх боломж олгосон байна. Харин энэхүү мэдэх эрхийг хувь хүнд олгоогүй, аль нэг байгууллагын ажилтанд л олгосныг  анхаарах нь зүйтэй юм.

***Хуулийн төслийг хэдийд нээлттэй болгох вэ?***

Зарим улсын хуульд, тухайлбал Канад улсад хуулийн төслийг Парламентын хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулах хүртэл "нууцад хамааруулдаг" заншил тогтсон байдгийг  анхаарч судлах нь зүйтэй. Хэдийгээр бидний судалгааны зорилго олон нийтийн оролцоог дэмжих зорилготой боловч дараа нь гарч болох нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл нь ил тод байдлыг хангаснаас бий болох давуу талаас илүү байж болох тохиолдлыг ялгавартай авч үзэхийг санал болгож байна.  Тухайлбал, татвар, шимтгэл, нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, бууруулах, өршөөл үзүүлэх зэрэг эдийн засагт шууд нөлөөлөх зарим харилцааг зохицуулж байгаа хуулийн төслийг тодорхой шатанд хүртэл нууцлах, эсхүл олон нийттэй санал солилцох ажиллагааг явцуу хүрээгээр нарийвчлан тодорхойлох шаардлага байж болох юм гэж үзэж байна.  Энэ нь төрийн албан хаагчийн ёс зүйтэй ч холбогдох асуудал мөн. 1990-ээд оны эхэнд Засгийн газрын 20 дугаар тогтоол гарч барааны үнэ болон банкны хадгаламжид байгаа төгрөгийг хоёр дахин нэмэх шийдвэр гаргахын урьд өдөр мэдээлэлд ойр байсан хэсэг хүмүүс тэдгээрийн ард гэр, найз нөхөд нь банк дахь хадгаламжаа арав арван мянгаар нь салгаж хийх, байгаа мөнгөөрөө дэлгүүрийн барааг бөөнөөр нь худалдан авах зэрэг үйлдэл хот, хөдөөд хийгдэж, ашиг олсон, мэдээллийн нууц задруулсан гэх асуудал шуугиан тарьж, хуулийн байгууллагаар шалгагдаж байсан гашуун туршлага бий. Мэдээж, тэр үед хуулийн тодорхой зохицуулалт байхгүй байсан.  Тэр хэрэг тэгсгээд намжсан. Мөн зарим Их хурлын гишүүн, хууль санаачлагч УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтанд ороогүй, зарим тохиолдолд хуулийн төсөл боловсруулж эхлээгүй байхдаа нийгмийн сонирхлыг ихээхэн татсан асуудлаар тийм ийм хуулийн төсөл санаачлан боловсруулж байгаа гэж сурталчилж байгаа нь анзаарагддаг. Сонгуулийн мөнгөний амлалтууд ч үүнд хамаарна гэж үзэж байна. Энэ нь нийгмийн сэтгэлзүйг үймүүлэх, урьдаас хүлээлт үүсгэх, эсхүл тухайн мэдээлэл дээр үндэслэн нийгмийн зарим оролцогч өөрт ашигтай хувилбараар "зохиомлоор шийдвэр" гаргахад түлхэх сул талтай. Энэ нь зарим хууль санаачлагчийн зүгээс  "Хүлээлт үүсгэж" байгаад шийдвэр гаргагчдыг нийгмийн тодорхой бүлгийн хамт шахалтанд оруулж хуулиа батлуулах тактик ч байж болох талтай. Ийм төрлийн хуулиуд нь ихэвчлэн мөнгө, ашиг  амласан, сонгуульд бэлтгэж улс төржсөн маягтай байдаг нь ажиглагддаг. Энэ бол анхаарч судлан зохистойгоор зохицуулах асуудлын нэг гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хэдийг хүртэл хуулийн төсөл нууцад хамаарах вэ гэдэг асуудал юм.

### 3.2. Олон нийтийн оролцооны арга, талууд

***Нээлттэй сонсгол***

2007.10.11-ны өдөр батлагдсан Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт оруулж, Байнгын, дэд хороо тодорхой асуудлын талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор нээлттэй сонсгол /цаашид "сонсгол" гэх/ зохион байгуулах журмыг дор дурдсанаар \7[1] дүгээр зүйл\ тодорхойлсон:

- Байнгын, дэд хорооны дарга сонсголын сэдэв, өдөр, цагийг 14-өөс доошгүй хоногийн өмнө товлох бөгөөд энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээгээр нийтэд мэдээлэх;
- тодорхой асуудлын талаар санал хэлэх, мэдээлэл хийх иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, холбогдох бусад хүмүүс /цаашид "сонсголд оролцогч" гэх/ уг сонсгол болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө холбогдох Байнгын, дэд хороонд мэдэгдэж бүртгүүлэх, илтгэл, санал, мэдээллээ өгөх;
- сонсголд оролцогч санал хэлэх, мэдээлэл хийх дарааллыг сонсгол даргалагч тогтоох;
- сонсголд оролцогч нь 10 минутаас илүүгүй хугацаанд санал, мэдээллээ танилцуулах;
- гишүүн сонсгол даргалагчийн тогтоосон хугацаанд санал, мэдээлэлтэй нь холбогдуулж асуулт асуух;
- сонсголд оролцогч нь гишүүдээс асуулт асуухгүй бөгөөд сонсгол даргалагчийн зөвшөөрснөөр 2 минутаас илүүгүй хугацаанд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх;
- Байнгын, дэд хороо сонсголын явцад гарсан саналыг нэгтгэн тухайн асуудлыг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт өгөх.

Дээр дурдсан тухайн тодорхой асуудлын талаар Байнгын, дэд хорооны сонсголыг нэгдсэн болон Байнгын, дэд хорооны хуралдаантай давхардуулахгүйгээр зохион байгуулах бөгөөд сонсголыг чуулганы чөлөөт цагт зохион байгуулж болно. Сонсголын үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын, дэд хороо, Тамгын газар хариуцан зохион байгуулна хэмээн хуульчилсан.

Оролцоог бид Засгийн газраас эсхүл Парламентаас удирдан явуулдаг үйл явц гэж ойлгодог. Энэ нь тийм биш. Учир нь төрийн бус байгууллага, энгийн иргэд бусад сонирхсон бүлгүүд ямарваа асуудлыг шийдэх талаар өөрсдийн саналаа төсөл хэлбэрээр боловсруулж болдог. Иргэд хамтран шаардлагатай мэдлэг туршлага, нөөц бололцоогоо нэгтгээд амьдралд хэрэгжихүйц санал боловсруулдаг.[138] Иргэд, олон нийтийн нийтлэг хүсэл зоригийг хуулийн төсөл боловсруулагчид, хууль тогтоогчид төрөл бүрийн арга замаар авч, сайтар

[138] [138] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах нь: Европын зарчмууд ба практик асуудлууд, Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 15-р тал

судалж, хуулийн төсөлд тусгаснаар хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг өндөржүүлж, хууль зорилгодоо хүрэх нөхцөл бүрдэнэ.

Дурдалгүй өнгөрч болохгүй өөр нэгэн зүйл бол Европын хэд хэдэн Засгийн газрууд олон нийттэй зөвлөлдөх болон оролцооны үйл явц ямар байдлаар явагдах ёстой талаар тусгай журам баталсан байдаг. Хууль боловсруулж эхлэхээс өмнө оролцооны үйл явцын төлөвлөгөөг гарган, хуулийн төслийг хариуцах албан тушаалтан, төсөл боловсруулах багийн бүрэлдэхүүн, оролцоог хангах арга хэмжээ болох цаг хугацааг тодорхойлсон төлөвлөгөө гэх мэт бүтцийг тодорхой болгосон байдаг. Эдгээр зүйлс нээлттэй байхад тэр хуулийн төслийн талаар хэнд, хэзээ хандах асуудал өөрөө шийдэгддэг.[139] Манай орны хувьд бодлого боловсруулах, хууль тогтоох үйл явцад иргэд, төрийн бус байгууллагууд оролцох арга зам нь захидал бичих, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, цөөн тооны төрийн бус байгууллага, хувь хүмүүс хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох зэргээр хязгаарлагдаж байна.

***Захидал бичих***. Судалгаанд оролцсон 359 иргэний 9% буюу 32 иргэн захидлаар хуулийн төсөлд саналаа өгсөн байна.

***Уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах.*** Судалгаанд оролцогч 359 иргэдийн 68% буюу 245 нь үгүй, 9% буюу 31 нь 1 удаа, 2% буюу 9 нь 2 удаа, 3% буюу 11 нь 3 болон түүнээс дээш удаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан бол 18% буюу 63 нь санал асуулгад хариулаагүй байна.

***Төрийн бус байгууллага, хувь хүмүүс хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох***. Судалгаанд хамрагдсан 11 төрийн бус байгууллуудын 8 байгууллагын төлөөлөл төрийн аль нэг байгууллагын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан байна.

***Нээлттэй сонсгол***

Иргэдийн байнгын, бодит оролцоог хангах анхны дорвитой санал санаачлагыг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргаж, Иргэний танхим ажиллуулан нээлттэй хэлэлцүүлэг хийж байхаар болсон[140]. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журам”-ыг баталсан. 2012 онд Улсын их хурлын Хүний эрхийн дэд хороо “7 дугаар сарын 1-ний хэрэг” гэх асуудлаар нээлттэй сонсгол зохион байгуулж, орон даяар телевизээр шууд дамжуулж байсан. Дараа нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд “Нээлттэй сонсгол” гэсэн нэртэй зүйл нэмж оруулсан. Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явц дахь нээлттэй сонсгол гэдэг нэр томъёо олон хүний хувьд шинэ содон санагдаж магадгүй. Хамгийн энгийнээр тайлбарлавал сонсгол гэсний учир нь ИРГЭН төрийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын хэлэлцэх гэж буй тодорхой хууль, шийдвэрийн төслийн талаар байр сууриа илэрхийлж, шийдвэр гаргагч СОНСОНО гэсэн санааг агуулж буй юм. Нээлттэй сонсголын үндсэн зорилго нь тухайн шийдвэрлэх гэж буй бодлогын асуудлаар иргэд, байгууллагуудаас санал шүүмжлэл, зөвлөмж хүлээн авч, тэдгээрийг нэгтгэн хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн бодлогын

[139] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах нь: Европын зарчмууд ба практик асуудлууд, Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 20-р тал

[140] Нээлттэй нийгэм форум, ”Нээлттэй сонсгол.Бодлого боловсруулах үйл явцад оролцох иргэдийн гарын авлага”, 2009, 5-р тал

асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах явдал юм. Нээлттэй сонсгол нь нэрэндээ дурдсанчлан олон нийтэд нээлттэй үйл явц бөгөөд хүссэн хүн бүр түүнд оролцож байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл санал, тайлбар, нотлох баримтаа бичгээр ирүүлэх боломжийг олгодог. Нээлттэй сонсгол нь энгийн хэлэлцүүлгээс ихээхэн ялгаатай. Хамгийн гол ялгаа нь сонсголын явцад аль болох олон хүнд байр сууриа илэрхийлэх боломж олгох үүднээс энгийн хэлэлцүүлгийн үеийнх шиг талууд мэтгэлцэх, харилцан ярилцах, санал бодлоо солилцох боломж байдаггүй. Сонсголд оролцогчид тодорхой журам, дэгийн дагуу, ихэвчлэн хурал даргалагчийн зүгээс оролцох хүмүүсийн тоог харгалзаж тогтоосон хугацаанд багтаан эрэмбэ дараалал, эмх цэгцтэйгээр байр сууриа илэрхийлэх хэлбэрээр явагддаг. Нээлттэй сонсгол нь хууль санаачлах, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын байнгын хороо, комисс, Засгийн газар, Ерөнхийлөгчийн томилсон ажлын хэсгээс зохион байгуулдаг нээлттэй хурал, хэлэлцүүлэг бөгөөд хууль тогтоомж, бодлогын асуудлуудаар санал шүүмжлэл гаргаж, зөвлөмж өгөх боломжийг олон нийт, мэргэжилтнүүд, улсын ба хувийн хэвшлийн холбогдох байгууллагын төлөөлөгчдөд олгодог. Хуулийн төслийг хэлэлцэх нээлттэй сонсголыг гол төлөв хууль тогтоох үйл явцын эхэнд, эсхүл дундуур зохион байгуулдаг нь эндээс цуглуулж авсан мэдээллийг ашиглан төслийг батлагдахаас нь өмнө сайжруулж өөрчлөлт оруулдагтай холбоотой. Ингэснээр тухайн хууль тогтоомж, шийдвэр нь нөлөөлж байгаа төрийн байгууллага, салбар, иргэдийн хэрэгцээ шаардлагыг илүү сайн тусгах нөхцөл бүрддэг. Одоо хүчин төгөлдөр хуульд зааснаар нээлттэй сонсголыг зөвхөн УИХ дээр анхны хэлэлцүүлэг хийхийн өмнө явуулж болохоор заасан хэдий ч практик дээр хуулийн төсөл бүрэн гараас гараагүй байх шатанд ч нээлттэй сонсгол зохион байгуулж байгаа нь ажиглагдах боллоо.

***Лобби***

Энэ уг нь монголчуудад танил болоод олон жил болж байна. Лобби гэдэг нь хууль боловсруулах, тогтоох үйл явцад нөлөөлөх, хууль тогтоох боловсруулах үйл явцыг өөрчлөх үйл ажиллагаа юм. Мэдээж ашиг сонирхлоо хөөх асуудал лоббигийн хувьд байдгийг үгүйсгэхгүй ч хамгийн чухал нь хууль боловсруулах үйл явцад нөлөөлөх арга хэлбэр гэдгийг цохон тэмдэглэе.[141]

Словакийн туршлагаас үзвэл Лоббийн тухай хуулийн нарийвчилсан заалт байхгүй ч хуулиар хориглоогүй тул лоббийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд идэвхтэй явуулдаг байна. Үүнд мэргэжлийн лобби агентлаг бүр ажлаа гүйцэтгэхдээ хуримтлуулсан холбоо барих сантай байдаг байна. Парламентын түвшинд хэд хэдэн хэлбэрээр лоббигийн үйл ажилллагаа явуулж болдог.

- Парламентын гишүүдтэй уулзах,
- Байнгын хороодын хуралдаанд байлцах.
- Парламентын хуралдааны үеэр үг хэлэх эрхгүйгээр ажиглагчаар байлцах /лоббигийн үйл ажиллагаа явуулж байгаа хүний хувьд энэ нь хамгийн эцсийн үр дүнгүй шат/.[142]

***Нөлөөлөл*** гэдэг нь олон нийтийн ашиг сонирхол дээр голлодог бол лобби хувийн ашиг сонирхол дээр голлодог. Гэвч зааг ялгаа нь бас л бүдэг. Энэ тухай 2007 онд Монголд болсон “Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь

---

[141] Виктория Млинарчикова, Парламент дахь лоббигийн зохицуулалт, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 92-р тал
[142]

иргэдийн оролцоо” олон улсын семинарын үеэр Словакийн төлөөлөгч өгүүлсэн байдаг. Тэрээр нэг жишээг өөрийн туршлагаас сонирхуулсан . Би лоббичноор ажиллаж байхдаа ширхэгийн худалдаа эрхэлсэн дэлгүүрийн сүлжээний нээгдэх хаагдах цагийн хуваарийн талаар лоббийн үйл ажиллагаа явуулж байсан. Тэр үед бид судалгаа хийгээд Словак иргэдийн наян хувь нь супермаркетуудыг орой болтол ажиллаж, ням гарагт нээлттэй байлгах хүсэлтэйгээ илэрхийлсэн байсан. Гэвч энэ асуудал хувийн ашиг сонирхлын асуудал байсан уу, олон нийтийнх байсан уу? Бид дэлгүүрийн сүлжээг хариуцаж байсан тул хувийн ашиг сонирхлын төлөө ажиллаж байсан мэт харагдах боловч нөгөөтэйгүүр хүн амын наян хувийн ашиг сонирхлын асуудал байсан учир олон нийтийн асуудал байсан. Хувийн ба олон нийтийн гэдэг ойлголтын дундах ялгаа их бүдэг гэж үздэг. Энэ талаар хэлэлцэж, маргалдаж болно. Зарим тохиолдолд ялт ч үгүй аль нэг ашиг сонирхол нь давамгайлсан байдаг. Хууль эрх зүйн зохицуулалт байхгүй ч Словакт явагдсаар байгаа маргаан Монголд ч хэлэлцэх ёстой асуудлын нэг юм.

### 3.3. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар тусгасан зохицуулалтын харьцуулалт

Бид судалгааныхаа эхэнд хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцооны талаар хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хууль, улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль \цаашид “Одоогийн хууль” гэх\ болон манай судалгааны багт Хууль зүйн яамнаас 2014.10.04-нд ирүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл \цаашид “Төсөл” гэх\-д тусгагдсан зохицуулалтыг харьцуулан харуулсан болно.

Судалгааны дараагийн шатанд энэхүү санал, зөвлөмжөө олон улсын шилдэг туршлагаар илүү баяжуулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд өгөх саналдаа тусган энэхүү тайлангийн дүгнэлтийн хэсэгт оруулсан болно. Ажлын даалгаварт зааснаар өмнө нь хийгдсэн судалгаа, гадаад орнуудын хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ижил төстэй хууль, эрх зүйн акт, олон нийтийн оролцоог хангах, холбогдох талуудаас санал авах асуудлыг хэрхэн зохицуулсныг дэлгэрүүлэн судалж зөвлөмж өгөх асуудал туссан. Хуулийн төсөл боловсруулахад оролцоог хангаж, санал авч буй одоогийн үйл явц ба Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд тусгагдсан үйл явцыг харуулсан зураглалыг гаргасан бөгөөд уг зураглал-харьцуулсан судалгаанаас хийж болох гол дүгнэлт, санал, зөвлөмжийг дор сийрүүлж байна.

***Хуулийн зорилгыг тодорхойлох***

| **Одоогийн хууль** | **Төсөл** | **Харьцуулалт** |
|---|---|---|
| Энэ хуулийн зорилт нь хууль санаачлагч | Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад | 1.Төсөлд ... харилцааг зохицуулна гэж бичиж ирсэн хэвшмэл “зорилт”-ыг бус, хууль баталснаар хүрэх “зорилго”-ыг |

| | | |
|---|---|---|
| хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | шийдвэрийн төсөл санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино | тодорхойлсон нь цоо шинэ хандлага болж байна. Үүнтэй холбоотойгоор хууль санаачлагч, хуулийн төсөл боловсруулагч нар ***хуулийн зорилгыг хэрхэн тодорхойлох талаар Төсөлд илүү нарийвчилж оруулах***ыг зөвлөж байна<br>2.Төсөлд “олон нийтийн оролцоог хангах” зорилгыг хуулийн 1 дүгээр зүйлд заасан нь ардчиллын хөгжилд чухал алхам болно гэж үзэж байна<br>3.Төслийн 60 дугаар зүйлд шинээр оруулж байгаа хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийхэд уг зорилгод хүрсэн эсэхийг үнэлэх байдлаар хуулийн доторх уялдааг хангажээ. |

***Нийтлэг зарчим***

Одоогийн хуульд хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхэд баримтлах зарчмыг тусгайлан зүйл заалт болгон зохицуулаагүй бол Төсөлд энэ хуулийг дагаж мөрдөхөд хууль ёсны байх; ***ил тод, нээлттэй байх; олон нийтийн оролцоог хангах;*** ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална хэмээн заасан нь дэвшилттэй болсон байна. Харин төслийг бүхэлд нь авч үзвэл ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим хэрхэн хангагдаж байгаа нь төдийлөн тодорхой тусгагдаагүй байгааг цаашид төслийг боловсронгуй болгох явцад анхааралдаа авах нь зүйтэй.

***Хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх шатанд***

Одоогийн хуульд “Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно” \3.2\ хэмээн Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд “Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна” гэж заасныг хэрэгжүүлэх хэлбэр, боломжийг нарийвчлан тодорхойлсон зохицуулалтыг Төслөөс хассан байх тул энэхүү одоо байгаа зохицуулалтыг Төсөлд нэмж тусгахыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх үе шатанд иргэд, хуулийн этгээдийн оролцоог тодорхойлохгүй байх нь төсөлд тусгагдсан зорилго, зарчмаасаа ухарсан хэрэг болно.

***Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх шатанд***

| Одоогийн хууль | Төсөл | Харьцуулалт |
|---|---|---|
| Үндсэн чиглэлийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн | Үндсэн чиглэлийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв | 1. Үндсэн чиглэлийг боловсруулахдаа Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичигт нийцүүлэх талаар нэмж оруулсан. |

| | | |
|---|---|---|
| захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагын саналыг авч нэгтгэн судалсны үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна \4.2\ Үндсэн чиглэлийн төсөлд санал өгч байгаа хууль санаачлагч нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах болон дагаж мөрдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг тодорхой заасан байна \4.3\ Хууль санаачлагчийн бүрэн эрхийг тодорхойлсон уг хуулийн 6 дугаар зүйлд "иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах" \6.1.6\ | байгууллага, холбогдох бусад байгууллагын саналыг авч нэгтгэн судалсны үндсэн дээр Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна\7.3\ Үндсэн чиглэлийн төсөлд санал өгч байгаа байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхой заана \7.6\. | 2. Хууль санаачлагчийн бүрэн эрхийг тодорхойлсон одоогийн хуулийн 6 дугаар зүйлийг Төсөлд бие даасан зүйл болгож тусгаагүй.<br>3. Одоогийн хуулийн 6.1.6-д заасан "иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах" хууль санаачлагчийн бүрэн эрхийг Төсөлд тусгаагүй нь Үндсэн чиглэл батлах буюу хууль тогтоомж боловсруулах ажлыг төлөвлөх шатанд иргэд, олон нийтийн оролцоог хассан ухралт болохоор байна.<br>4.Төслийн 7 дугаар зүйлд "Иргэн, хуулийн этгээд эдийн засаг, нийгмийн амьдралд шинээр бий болсон харилцааг зохицуулах болон тодорхой харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах хэрэгцээ шаардлага, шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаарх үндэслэл бүхий саналаа Үндсэн чиглэлд тусгуулахаар санал өгч байгаа, саналыг нэгтгэж байгаа байгууллагаар дамжуулан, эсхүл хууль санаачлагчид шууд бичгээр уламжилж болох тухай болон тухайн этгээд иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи уг саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах арга хэмжээ авдаг байх, тийнхүү тусгах боломжгүй бол үндэслэл бүхий хариу өгдөг байхаар төсөлд тусгаж, хууль боловсруулах ажлын төлөвлөлтийн шатанд олон нийтийн оролцоог хангах нь зүйтэй байна. |

***Хууль санаачлагчийн бүрэн эрхийн хүрээнд***

Одоогийн хуульд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог дайчлах, хангах чиглэлээр хууль санаачлагч нь дараах бүрэн эрхтэй байхаар заасан:

- хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдгээрийн саналыг авах \6.1.4\;
- хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх \6.1.5\.
- иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах \6.1.6\.

Төсөлд хууль санаачлагчийн бүрэн эрхийг бие даасан зүйл болгож тусгаагүй. Агуулгаараа хуулийн төсөлд туссан гэж үзэв.

***Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр***

Одоогийн хуульд хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна \7.1\:

- хуулийн төслийг өөрөө боловсруулах;
- холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэж заасан.

Энд “холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах” гэж заасан. Практик дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүний нилээдгүй хувийг төрийн холбогдох байгууллагын төлөөлөл эзэлдэг. Мөн “мэргэжлийн” гэдэг утгаараа төрийн бус байгууллагын төлөөлөл оролцох нь түгээмэл байдаг. Энэ нь ч зүйн хэрэг. Харин ажлын хэсэгт төрийн байгууллагын төлөөлөл оролцдог гэдгийг энэ хэсэгт заагаагүй. Ийнхүү шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хуулийн төсөл боловсруулах нь нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангаж буй нэг арга юм.

Төслийн гуравдугаар бүлэг нь “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах” гэсэн нэртэй бөгөөд энэ бүлэгт ажлын үе шат, тодорхой аргачлалын дагуу хийх төрөл бүрийн тандан судалгаа, үнэлгээ, тооцоолол, магадлан шалгалт, дүгнэлт, төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Харин хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэрийг Төсөлд тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах; хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэсэн явцуу ч гэсэн төрийн бус оролцоог тодорхойлсон зохицуулалт хасагдаж байна. Иймд Төслийн 9 дүгээр зүйлд энэ талаар одоогийн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгон оруулах санал байна.

***Хуулийн төсөлд санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах***

Одоогийн хуульд хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана \18.3\. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээс санал авах ажиллагааг дараах хэлбэрээр зохион байгуулна\18.4\:

- хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах;
- хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр заан хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно хэмээн зохицуулсан байна.

Төслийн "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат" гэсэн 8 дугаар зүйлд хууль санаачлагчийн зохион байгуулах үйл ажиллагааны дараалдлыг тодорхойлж, хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон мэргэжлийн бусад байгууллагын саналыг авах \8.1.5\, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлж, санал авах \8.1.6\ гэж заасан. Харин үзэл баримтлалыг батлах тухай Төслийн 13 дугаар зүйлд олон нийтийн оролцоог хангах талаар зохицуулалт тусгагдаагүй байна. Зөвхөн хуулийн төсөл төдийгүй түүний үзэл баримтлалд санал авах, тэдгээрийг хэлэлцүүлэх ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах талаар төслийг боловсронгуй болгох шаардлагатай.

"Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах" нэртэй Төслийн 36 дугаар зүйлд: Төсөл нь үр нөлөөний үнэлгээ, үзэл баримтлалын хамт санаачлагчийн албан ёсны цахим хуудсанд /эсвэл www.legalinfo.mn/ байршуулж өдөр тутмын хэвлэлд мэдээлснээр олон нийтийн хэлэлцүүлэг эхлэх бөгөөд санал зөвлөмж авах сүүлийн хугацааг хамтад нь зарлана. Төслийг нийтэлснээс хойш 30-90 хоногийн /хуулийн ач холбогдлоор нь ангилбал түүнтэй холбож болох/ дотор байгууллага, хувь хүн саналаа ирүүлэх бөгөөд төслийг сайжруулах талаар тодорхой саналаа тусгана. Саналыг бичгээр холбогдох этгээдийн гарын үсгийн хамт ирүүлнэ гэж заасан байна.

***Нэгдүгээрт***, Олон нийтийн оролцоог ***төлөвлөж, мэдээлэх зохицуулалт нэмэх шаардлагатай байна.*** Жирийн иргэн, байгууллагын хувьд ямар байгууллагын, аль цахим хуудсанд, ямар хуулийн төслийн талаарх мэдээлэл хэдийд тавих нь тодорхойгүй байгаа нь иргэд, олон нийтийн оролцоог тэгш хангах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна. Ийм мэдээлэл урьдчилсан байдлаар байхгүй тохиолдолд цахим хуудсанд байрлуулах хугацааг 1 сар, 6 сараар тавьсан ч үр дүн гарахгүй гэж үзэж байна. Иймд энэ талаарх төлөвлөгөөг хагас жил, улирал, болдог бол жилийн өмнөөс холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага\ ЗГХЭГ ч байж болох талтай\ нэгтгэн тодорхойлж, олон нийтэд мэдээлдэг тогтолцоог хуульчлах нь зүйтэй. ***Хоёрдугаарт***, "Монголчуудтайгаа зөвлөлдөх нь" гэсэн ***нэгдсэн цахим хуудас*** \эсхүл www.legalinfo.mn дээр байсан ч болно\ бүтээж, энэхүү төлөвлөгөө болон олон нийтээр хэлэлцүүлж байгаа хуулийн төсөл, архивт орсон төслүүдийг хариуцан боловсруулж буй байгууллага буюу хууль санаачлагчийн цахим хуудас руу орох линктэйгээр байрлуулж хэвшвэл цахим хэлэлцүүлгийг 10 хоногт багтаахаар хуульчилсан одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх нь илүү хүнд сурталгүй бөгөөд хууль тогтоох үйл ажиллагаа

сунжруулахгүй байх нөхцөл бүрдэнэ. ***Гуравдугаарт,*** Хууль санаачлагч нь уг нэгдсэн цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулахдаа хуулийн төслийг бүрэн эхээр нь байрлуулахаас гадна зохих ёсоор батлагдсан уг хуулийн үзэл баримтлал, танилцуулга, уг хууль батлагдахтай холбогдуулан бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг мөн олон нийтэд танилцуулах нь зүйтэй. Ингэснээр олон нийт Яагаад? гэсэн олон асуултдаа хариулт авч, тухайн хуулийн төслийг бусад хуулиудтай уялдаатайгаар иж бүрэн төсөөлөхүйц мэдээлэлтэй болж, саналаа өгөх нөхцөл бүрдэнэ. ***Дөрөвдүгээрт,*** Цахим хэлэлцүүлгийн явцад ирсэн саналыг бүртгэх, төсөлд тусгах, эргэж мэдээлэх зэрэг хууль санаачлагчийн үйл ажиллагааг Төсөлд тодорхой тусгах нь зүйтэй***. Тавдугаарт,*** Ийнхүү олон нийтэд танилцуулсан мэдээлэл, ирсэн санал, түүнийг тусгасан байдал, тусгаагүй бол түүний шалтгаан зэрэг мэдээллийг санал авах хугацаа дуусмагц тухайн цахим хуудсанд наанадаж 3-5 жил, түүнээс ч урт хугацаанд архивлан хадгалдаг байх нь хуулийн төслийг УИХ дээр хэлэлцэх үед болон иргэд олон нийтийн мэдээллийн, эрх зүйн боловсролын, судалгааны, хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгч, шүүхийн практикт чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, тэдгээрт олон нийтээс ирүүлсэн санал, түүнийг хуулийн төсөлд тусгасан байдал, тусгаагүй бол энэ тухай тайлбар зэрэг мэдээллийг мөн тухайн цахим хуудсанд байрлуулдаг байх нь оролцоог дэмжих хоёр талын хүсэл эрмэлзлэлийг дэмжих, эргэх холбоог сайжруулахын зэрэгцээ хуулийг нэг мөр ойлгох, тайлбарлах, хэрэглээний соёлыг бий болгох, шууд ардчиллыг хөгжүүлэх, үнэлэхэд чухал ач холбогдолтой.

Одоогийн хуулийн 18.15-д: "Хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана" гэж заасан нь хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаарх эцсийн товч тайлан гэж үзэж болно. Төслийн 32 дугаар зүйл \Хуулийн төслийн танилцуулга\-д дээрх санааг илүү дэлгэрүүлж, "хуулийн төслийг боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар авсан арга хэмжээ, тэднээс гаргасан саналыг хуулийн төсөлд тусгасан байдал, тусгаагүй бол түүний шалтгаан" гэсэн заалт нэмж оруулах нь зүйтэй.

Хуулийн төслийн аль шатанд хэний, ямар байгууллагын ямар санал дэмжигдэж хуулийн төсөлд тусгагдсаныг олон нийт мэдэх боломжтой болгоно гэдэг нь эргээд тухайн санал гаргагчийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хууль бол ард түмний бүтээл, тэдний хүсэл зоригийн илэрхийлэл гэдгийг жинхэнэ утгаар илэрхийлнэ. Ингэснээр хэн нэг албан тушаалтан хуулийн төслийг дураараа засах боломж хаагдаж, хууль тогтоох ажиллагааны ил тод байдал хангагдаж, оролцооны механизм хэрэгжинэ.

"Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах" гэсэн Төслийн тавдугаар бүлэг нь 2 зүйлтэй байх бөгөөд Эрх бүхий байгууллага, албан тушаалтаас санал авах гэсэн 37 дугаар зүйл нь уг бүлгийнхээ агуулгад нийцэхгүй байна. Иймд уг зүйлийг 22 дугаар зүйлийн орчимд шилжүүлэх нь зохимжтой байна \Төслийн 22.6 дээр зохицуулалтыг нь бичээгүй буйг харна уу\. Харин энэхүү "Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах" гэсэн бүлэгт дээр санал болгосон олон нийтийн оролцоог төлөвлөх, мэдээлэх, "Монголчуудтайгаа зөвлөлдөх" нэгдсэн цахим хуудас, түүнд тавигдах

мэдээллийн агуулга, мэдээллийг архивлан хадгалах, эргэх холбоо зэрэг асуудлыг тусгахаас гадна олон нийтийн оролцоог хангах арга хэлбэр, үе шат, оролцооны хүрээг тодорхойлох зэрэг харилцааг тусган уг бүлгийг иж бүрэн томъёолохыг зөвлөж байна.

Бид хуулийн төсөл хэлэлцүүлэх, хэлэлцүүлэг хийх гэж ярьж хэвшсэн байна. Ихэнх орнууд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёо хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Хэлэлцүүлэг зохион байгуулах гэдэг үг төрийн идэвхтэй санаачилгаар буюу нэг тал-төр давамгайлсан утгыг агуулж байгаа юм бишүү гэх санаа төрж байна. Тийм ч учраас Одоогийн хуульд хэлэлцүүлгээс гарсан "үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах" гэж хуульчлаад үндэслэлгүй гэж үзсэн шалтгааныг эргэж мэдээлэхгүй орхиод байна уу? Харин "иргэдтэйгээ зөвлөлдөх" гэдэг нь тэгш харилцаа, харилцан ойлголцлыг агуулж байна. Иймд шинээр боловсруулж байгаа хуульд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёог хэрэглэхийг зөвлөж байна.

Судлаачдын бичиж байгаагаар олон нийтийн оролцооны гол асуудал нь: (а) нэг талаас, оролцоог хангах гэсэн хууль санаачлагч буюу төрийн байгууллага, ажилтны, нөгөө талаас, оролцогч иргэн, олон нийтийн аль аль талын хүсэл эрмэлзэл сайн байвал үр дүн өгдөг; (b) оролцоог хангахын тулд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх явдал чухал. Оролцоог төлөвлөх, төлөвлөгөөг мэдээлэх, саналаа бэлтгэх боломж олгох зэрэг дээр дурдсан асуудал үүнд хамаарна; (с) Хамгийн гол үр дүн нь эргэх холбоо буюу саналыг тусгасан эсэх, яагаад тусгаагүй вэ гэдгийг эргэж мэдээлдэг байх явдал байдаг байна. Оролцоог хангах аргыг:

1. мэдээлэх- цахим хуудас, өдөр тутмын хэвлэлд нийтлэх, хуулийн төслийг цахим болон ердийн шуудангаар хүргүүлэх гм
2. зөвлөлдөх- уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нийтийн сонсгол зохион байгуулах, цахим хэлэлцүүлэг гм
3. идэвхтэй оролцоо- ажлын хэсэгт ажиллах, мэргэжлийн шинжээчээр оролцох, хууль боловсруулах ажлыг төлөвлөхөөс эхлээд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх, батлах нийтлэх хүртэл бүх шатанд иргэн, байгууллага хувь нэмрээ оруулах, бүх шатанд асуудлаа танилцуулах боломж
4. мониторинг буюу тухайн хуулийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах бүх үе шатанд олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буйг хөндлөнгөөс хянах гэх зэргээр тодорхойлсон байна. Үүнээс эхний 3 арга манайд зохих хэмжээгээр хуульд тусcан буюу практик дээр хэрэгжиж байна. Харин 4 дэх аргын тухайд хуульд тусгагдаагүй, практик дээр эхлэлийн төдий байгаа гэж үзэж байна.

Зөвлөлдөх гэдэг нь 1.нийтийн сонсгол 2.хэлэлцүүлэг 3.вэб буюу онлайнаар зөвлөлдөх 4. Өдөр тутмын сонинд хэвлүүлэх 5. Санал асуулга явуулах 6. Парламентыг хороод дээр гэрчийг сонсох гм замаар санал авах, тусгах, зөвлөлдөх ажиллагааг голчлон ойлгодог байна. Иймд энэхүү тавдугаар бүлгийг боловсруулахад дээрхээс санаа авч, оролцооны тохиромжтой арга хэлбэрийг тухайн зохицуулах харилцааны онцлогтой уялдуулан бүх үе шатанд нээлттэй байхаар тодорхойлох нь зүйтэй. Жишээ нь, одоогийн хуулийн орчинд нийтийн

сонсголыг зөвхөн УИХ-ын байнгын хороо, дэд хорооны шийдвэрээр явуулахаар шийдвэрлэсэн хуулийн төслийн хувьд хэрэглэж болохоор заасныг өргөжүүлж, хуулийн төсөл боловсруулж эхлэхээс өмнө, эсхүл хуулийн төсөл боловсруулсны дараа, өргөн барихын өмнө нийтийн сонсгол зохион байгуулж болохоор зохицуулахад буруудах зүйлгүй байна.

***Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх***

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулж болно гэж заагаад Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж шийдвэрлэх журам, ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэх талаар шийдвэр гаргасан байхаар заасан байна. Хуулийн төслийг нийт ард түмнээр; нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд; тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хэлэлцүүлж болох бөгөөд уг ажлын зохион байгуулалт, дүнг нэгтгэн Улсын Их Хурлын танилцуулах зэрэг харилцааг зохицуулсан хэдий ч уг зохицуулалтыг практикт хэрэглээгүй байх бөгөөд Төсөлд энэ агуулга хэвээр тусгагдсан байна.

***Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль***

Уг хуулийн "Үйл ажиллагааны ил тод байдал" гэсэн 7 дугаар зүйлийн 7.1.5-д "шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах" гэж заасан. ***Нэгдүгээрт***, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд хуулийн төслийг 10 хоног байрлуулахаар заасантай хугацааны хувьд зөрчилтэй байна. ***Хоёрдугаарт,*** зөвхөн үндэслэлтэй бол саналыг төсөлд тусгаад үндэслэлгүй бол яагаад үндэслэлгүй гэж үзсэн тухай мэдээлэл олон нийтэд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

Хуулийн төслийг хэлэлцүүлнэ гэдэг нь олон нийтийн саналыг авч төсөлд тусгах гол зорилготойгоос гадна тухайн хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг цогцоор нь олон нийтэд ойлгуулах зорилго агуулах ёстой гэж үзэж байна. Хууль бол нийгмийн харилцааг зохицуулахдаа шударга, товч байх учиртай. Тухайн хуулийн төсөл нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хөндөх буюу тэдний зан үйлийн хэм хэмжээг тогтоож, зарим тохиолдолд орлогыг нь бууруулах, нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээний зохицуулалтыг хамардаг. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгийн санал бүрийг хуулийн төсөлд тусгах шаардлагагүй бөгөөд боломжгүй. Иймд гарсан саналыг яагаад төсөлд тусгаагүйг ямар нэг хэлбэрээр мэдээлэх нь иргэдийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, хуулиар дамжин илрэх төрийн бодлогыг ойлгуулах илүү өргөн зорилготой. Иймд энэ төслийг дагалдуулан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, зөрчил, давхардлыг арилгахыг санал болгож байна.

Хуулийн төсөл өргөн мэдүүлсний дараа олон нийтийн оролцоог хангах талаар тодорхой зохицуулалтуудыг тогтоосон байдаг.

***Хуулийн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэх***

Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн "Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах" гэсэн 21 дүгээр зүйлд Төр, нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн төслийг нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг дараах журмаар холбогдох Байнгын хороо зохион байгуулж болно:

- төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ санал ирүүлэх хугацаа, түүнийг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байх;
- олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төсөлд санал өгсөн иргэн буюу хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн саналынх нь талаар асуулт асуух.

Хуулийн төслийг хэвлэлд нийтлүүлж санал авах, түүнийг нэгтгэн судлах үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын хороо, Тамгын газар хариуцна хэмээн заасан байдаг.

Мөн хуулийн 54 дүгээр зүйлд Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах, ашиглах журмыг тодорхойлсон бөгөөд хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд, ажлын хэсэг, бусад Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгээс холбогдох Байнгын хороонд бичгээр ирүүлсэн саналын томъёолол, тэдгээрийн үндэслэл, тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг зэрэг хуулийн хувийн хэрэгт оруулах материалыг жагсаасан. Хуралдааны бичвэр, соронзон болон дуу, дүрс бичлэгийн тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтнууд шууд, бусад байгууллагын ажилтан, албан тушаалтан Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр танилцаж болно. Уг тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтан 7 хоног хүртэл хугацаагаар танилцаж болох бөгөөд зөвшөөрөлгүйгээр олшруулах, хувилахыг хориглоно. Бусад байгууллагын ажилтан тэрхүү тэмдэглэлтэй Тамгын газрын архивт танилцана гэж хуульчилсан нь УИХ дээр хуулийг хэрхэн хэлэлцэж, ямар санал гарч байсан тухай мэдээллийг мэдэх боломж олгосон байна. Харин энэхүү мэдэх эрхийг хувь хүнд олгоогүй, аль нэг байгууллагын ажилтанд л олгосныг анхаарч, Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгож байна.

Төслийн "Хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагаанд тавих ерөнхий шаардлага" гэсэн долдугаар бүлэгт шинээр орж буй зохицуулалтад олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн нэлээд олон заалт, зохицуулалт тусгагдсан нь сайшаалтай байна. Тухайлбал, 40.1. Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагааг дараах үндсэн хэлбэрээр зохион байгуулна: хуулийн төсөлд дүгнэлт гаргах ***ажлын хэсэг*** томилж ажиллуулах \40.1.1\; хуулийн төслийн талаар Байнгын болон дэд хороонд ***нээлттэй сонсгол*** зохион байгуулах \40.1.2\; 41.1. Төслийн зохицуулах харилцааны ач холбогдол, хамрах хүрээг харгалзан Улсын Их Хурлын дарга, Байнгын хороо

төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, ***мэргэжилтнүүдийн оролцоотойгоор*** байгуулж болно, шаардлагатай гэж үзвэл хэлэлцэж байгаа асуудлаар ***нарийн мэргэшсэн шинжээчдийг ажлын хэсэгт туслах дэд ажлын хэсэг***тэй хамтран ажиллах \41.2.2\ гэх мэт. Харин энэ бүлгээр зохицуулах харилцаа нь Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдах харилцаа юу, энэ хуульд тусгах нь зөв үү гэдгийг дахин магадлах нь зүйтэй санагдсан болно.

***Хуулийн төслийг хэдийд нээлттэй болгох вэ?***

Зарим улсын хуульд, тухайлбал Канад улсад хуулийн төслийг Парламентын хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулах хүртэл “нууцад хамааруулдаг” заншил тогтсон байдгийг  анхаарч судлах нь зүйтэй. Хэдийгээр бидний судалгааны зорилго олон нийтийн оролцоог дэмжих зорилготой боловч дараа нь гарч болох нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл нь ил тод байдлыг хангаснаас бий болох давуу талаас илүү байж болох тохиолдлыг ялгавартай авч үзэхийг санал болгож байна.  Тухайлбал, татвар, шимтгэл, нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, бууруулах, өршөөл үзүүлэх зэрэг эдийн засагт шууд нөлөөлөх зарим харилцааг зохицуулж байгаа хуулийн төслийг тодорхой шатанд хүртэл нууцлах, эсхүл олон нийттэй санал солилцох ажиллагааг явцуу хүрээгээр нарийвчлан тодорхойлох шаардлага байж болох юм гэж үзэж байна.  Энэ нь төрийн албан хаагчийн ёс зүйтэй ч холбогдох асуудал мөн. 1990-ээд оны эхэнд Засгийн газрын алдарт “20 дугаар тогтоол” гарч барааны үнэ болон банкны хадгаламжид байгаа төгрөгийг хоёр дахин нэмэх шийдвэр гаргахын урьд өдөр мэдээлэлд ойр байсан хэсэг хүмүүс тэдгээрийн ард гэр, найз нөхөд нь банк дахь хадгаламжаа салгаж хийх, байгаа мөнгөөрөө дэлгүүрийн барааг бөөнөөр нь худалдан авах зэрэг үйлдэл хот, хөдөөд хийгдэж, ашиг олсон, мэдээллийн нууц задруулсан гэх асуудал шуугиан тарьж, хуулийн байгууллагаар шалгагдаж байсан гашуун туршлага бий. Мэдээж, тэр үед хуулийн тодорхой зохицуулалт байхгүй байсан.  Тэр хэрэг тэгсгээд намжсан. Мөн зарим Их хурлын гишүүн, хууль санаачлагч УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтанд ороогүй, зарим тохиолдолд хуулийн төсөл боловсруулж эхлээгүй байхдаа нийгмийн сонирхлыг ихээхэн татсан асуудлаар тийм ийм хуулийн төсөл санаачлан боловсруулж байгаа гэж сурталчлах буюу зарим тохиолдолд тодорхой байгууллага дээр дарагдчихсан мэтээр мэдээлж байгаа нь анзаарагддаг. Энэ нь нийгмийн сэтгэлзүйд нөлөөлөх, урьдаас хүлээлт үүсгэх, эсхүл тухайн мэдээлэл дээр үндэслэн нийгмийн зарим оролцогч өөрт ашигтай хувилбараар “зохиомлоор шийдвэр” гаргахад түлхэх сул талтай. “Хүлээлт үүсгэж” байгаад шийдвэр гаргагчдыг нийгмийн тодорхой бүлгийн хамт шахалтанд оруулж хуулиа батлуулах тактик ч байж болох талтай. Ийм төрлийн хуулиуд нь ихэвчлэн мөнгө, ашиг  амласан, сонгуульд бэлтгэж улстөржсөн маягтай байдаг нь ажиглагддаг. Энэ бол анхаарч судлан зохистойгоор зохицуулах асуудлын нэг гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хэдийг хүртэл, ямар харилцааг зохицуулж байгаа хуулийн төсөл нууцад хамаарах вэ гэдэг асуудал юм.

Хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх, мэдээлэх, хүргэх, олон нийтэд таниулахтай холбогдсон харилцааг бүлэг болгон нарийвчлан зохицуулахаар Төсөлд тусгасан нь олон нийтийг мэдээллээр хангах чухал ач холбогдолтой зохицуулалт болно гэж үзэж байна.

Төсөлд энэхүү хуулийн хэрэгжилтийн шатанд мэргэжлийн байгууллагын оролцоог хэд хэдэн газар тодорхойлсон байна. Тухайлбал, “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг өөрөө буюу хөндлөнгийн бие даасан хараат бус байгууллага, мэргэжлийн хүмүүсээр гэрээний үндсэн дээр хийлгэж болно” \15.4\. Мөн “Хяналт, шинжилгээ, үнэлгээ”-тэй холбоотой зохицуулалтыг Төслийн 10 дугаар бүлэгт тусгасан бөгөөд “Улсын Их Хурлаас хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээг Улсын Их Хурлын Байнгын хороод, Улсын Их Хурлын Тамгын газар /Хяналт шинжилгээний алба, Судалгааны алба/ хамтран хэрэгжүүлнэ. Хяналт шинжилгээг хийхэд төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулж болно” \59.5\, “Хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ хийлгэж болно” \59.7” гэж заасан нь мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог хангах чухал арга мөн. Харин хуулийн төсөл боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах; хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх аргыг Төсөлд тусгаагүй байгааг нэмж тусгах саналыг дээр дурдсан.

Хууль санаачлагч өөрөө хуулиа бичээд байх боломж тэр бүр хомс. Бодит байдал дээр хуулийн төсөл боловсруулах ажлыг төрийн бус байгууллага, мэргэжлийн хүмүүсээр \тэр дундаа гадаадын экспертээр\ хийлгэж, санхүүжилтын асуудлыг аль нэг хөгжлийн байгууллагаас гаргуулах хандлага давамгайлж байгаа нь нууц биш. Энэ нь төрийн бодлогыг төрийн жинхэнэ албан хаагч нар тодорхойлж байна уу гэдэг асуулт тавигдахад хүргэдэг. Үүнтэй холбоотойгоор хуулийн төсөлд тусгаад байгаа дээр дурдсан ажлуудыг ТББ, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлэх санхүүжилтын асуудал тодорхой байх нь чухал. Батлагдсан хуулиас түрүүлж, зах зээлд цоо шинэ харилцаа нэвтэрч, эрх зүйн зохицуулалтыг цаг алдахгүй шийдвэрлэх шаардлагатай болдог. Мэдээлэл, мэдлэг, туршлага хаа хаанаа дутагддаг шилжилтийн үед бид эксперт урихаас өөр боломж ховор байсан. Харин одоо мэргэжилтнүүдийн мэдээлэл нэмэгдэж, хэлний бэрхшээл арилж байгаа энэ цаг үед төрийн мэргэшсэн албаны үүрэг, чадавхийг дайчлах бодлого барих нь зүйтэй байж болох юм. Нөгөө талаар мэргэжлийн байгууллага, ТББ, мэргэжилтэн дайчлах тохиолдолд ажлын хөлсийг санхүүжүүлэх асуудлыг зохистой шийдвэрлэх талаар анхаарах нь зүйтэй. Энэ бол цэвэр төрийн үүрэг байх учиртай тул төсвөөс санхүүждэг байх нь зохистой.

### 3.4. Зөвлөмж

Хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буй талаар хийсэн анализ дээр үндэслэн дээр дурдсан болон нэгтгэсэн байдлаар дараах зөвлөмж өгч байна:

1. Иргэдтэйгээ зөвлөлдөх нэгдсэн цахим хуудастай болох
2. Иргэдтэй зөвлөлдөх ажиллагааны төлөвлөгөөг хамгийн багадаа 3 сарын өмнө бүх төрийн байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлан уг цахим хуудсанд байрлуулан, уг цаг хугацааг мөрдөж ажиллах

3. Дээрх хоёр зохицуулалт нь иргэн бүр мэдээллийг тэгш, нээлттэй авах боломж олгоно
4. Үндсэн чиглэл боловсруулахаас өмнөөс эхлээд хууль батлагдаж, нийтлэгдэж, хүчин төгөлдөр болох бүхий л хугацааны аль үе шатанд нийгмийн ямар бүлгийг хамруулж оролцоог ямар аргаар хангах вэ гэдгийг сайтар боловсруулах.
5. Дээрхтэй холбоотойгоор тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагаврыг тооцсоны үндсэн дээр боловсруулагдаж байгаа хуулийн төслийн агуулгыг тодорхой үе шатыг хүртэл төрийн буюу байгууллагын нууцад хамааруулах эсэх асуудлыг хуульчлах уу гэдэг асуудал байна. Бүх хуулийн төслийг тодорхой үе шатанд хүрсний дараа иргэдтэйгээ зөвлөнө. Энэ бол зарчим. Харин тэр үе шат хүртэл онцлог харилцааны тухайд ямар онцлог байх вэ? гэдгийг ярилцах шаардлагатай.
6. Магадгүй тухайн зохицуулах харилцааны онцлогийг харгалзан нийгмийн ямар бүлгийг хамруулж, ямар аргаар хуулийн төсөлд санал авах вэ гэдгийг тодорхой үе шатанд аль нэг төрийн байгууллага шийдвэрвэрлэдэг байх зохицуулалт байж болох талтай. Тус байгууллага нь иргэдтэй зөвлөлдөх ажиллагаанд оролцох хүрээ \мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн бүлэг, тодорхой салбарын бизнесийн байгууллага, тодорхой бүс нутгаас санал асуух гм\, зөвлөлдөх арга \хуулийн төсөл багц материалыг цаасаар болон цахим хэлбэрээр хүргүүлэх, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах, тодорхой шинэ зохицуулалтын талаар санал асуулга явуулах гм\ зэрэг заавал хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж шийдвэр гаргадаг байхаас гадна зөвлөлдөх ажиллагааны үр дүнг нэгтгэх буюу гарсан саналыг төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол шалтгааныг эргэж мэдээлэх зэрэг асуудлыг зохицуулах
7. Эцэст нь дээрх болон цаашид гарч болох бүх асуудлыг заавал хуульд тусгахгүйгээр хуулиар эрх олгосон байгууллага эрх зүйн актаар зохицуулж болно гэж үзэж байна.

### 3.5. Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаар сонгосон жишээн дээр хийсэн судалгаа

Судалгааны явцад УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн яамтай зөвшилцсөний үндсэн дээр батлагдсан болон боловсруулалтын шатанд буй хэд хэдэн хуулийг сонгож уг хуулийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаар нарийвчлан танилцаж судалсан. Энэ талаар тус бүрт нь авч үзье.

#### 3.5.1. Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн төсөл

***Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг.*** Гэмт хэргийн болон Зөрчлийн хуулийн тухай төслүүдэд иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авч, оролцоог хангасан байдлыг судлахдаа Хууль Зүйн Яамнаас энэ талаар анкетын

судалгаа авсан. Мөн 2014 оны 11 сарын 21-ний өдөр Хууль Зүйн Яам (ХЗЯ)-ны Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Оюунболдтой уулзаж, дэлгэрэнгүй ярилцлага хийж, тус хуулийн төслүүд дээр ирсэн саналуудыг авч танилцсан. Мөн иргэдээс авсан анкетын судалгаанд дээрх хуулийн төслүүдэд саналаа өгч байсан эсэх, өгсөн бол ямар хэлбэрээр өгсөн эсэх талаар асуулт оруулж дүгнэсэн. Дээрх хоёр хуулийн төсөл дээр иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авч, оролцоог хангах ажиллагаа нь хамтдаа явагдаж байсан ба энэхүү хуулийн төслүүд дээр Хууль зүйн Яамнаас авсан анкетын ихэнх хэсэг нь адил мэдээлэлтэй байсан тул санал авч, оролцоог хангасан байдлыг уг хоёр хуулийн хувьд нэгтгэн дүгнэв.

Гэмт хэргийн болон Зөрчлийн тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн байгаа (2014 оны 11-р сарын 14-ний байдлаар). Боловсруулалтын болон хэлэлцүүлгийн шатанд Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд нийт 25 удаа, Зөрчлийн тухай хуулийн төсөлд нийт 13 удаа холбогдох байгууллагатай хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Үүнд Хууль Зүйн Яамны салбар, нэгж дээр явуулсан хэлэлцүүлгийг багтаагаагүй ба хуулийн төслийн онцлогоос хамаарч олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна. Дээр дурдсан уулзалт, хэлэлцүүлэгт нийт 800 орчим оролцогч оролцсон байна. Эдгээр уулзалт, хэлэлцүүлгийн хэлбэр, ямар хүрээнд явагдахаас шалтгаалж, и-мэйл, ХЗЯ-ны вэбсайт болон тараах материал зэргийг ашиглажээ.

Гэмт хэргийн тухай хуулийн төслийг 2013.05.28, 2014.01.14-ний өдөр, Зөрчлийн тухай хуулийн төслийг 2014.01.14-ний өдөр тус тус санал авахаар нийт 131 байгууллага, судлаачдад тараасан ба эдгээр хуулийн төслүүд нь үзэл баримтлал, танилцуулгын хамт тараагдсан өдрөөс эхлэн тус яамны вэб хуудсанд одоог хүртэл тавигдсан байна.

Хэлэлцүүлгүүдийг зохион байгуулахад ХЗҮХ, ШШГЕГ, ХСИС туслалцаа үзүүлсэн байна. Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд нэг удаа Ерөнхийлөгчийн Тамгын Газартай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Хэлэлцүүлэг, уулзалтын зардлыг ХЗЯ өөрийн санхүүжилтээг гаргасан, тодорхой зардлын хэмжээг ажлын хэсгийнхэн мэдэхгүй, тус яамны санхүү мэднэ гэсэн тайлбар өгсөн.

Дээрх хуулийн төслүүдийн уулзалт, хэлэлцүүлэгт нийт 800 орчим хүн оролцсон ба Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд давхардсан тоогоор нийт 150 орчим байгууллага, иргэдийн 1000 орчим санал, Зөрчлийн тухай хуулийн төсөлд давхардсан тоогоор нийт 85 орчим байгууллага, иргэдийн 1500 орчим санал ирсэн ба эдгээр санал тус бүрийг хэлэлцэж, нийт ирүүлсэн саналын 90 орчим хувийг тусгасан байна. Санал гаргасан иргэд, байгууллагад саналыг тусгасан эсэх талаар хариу мэдэгдэж байсан. Хэлэлцүүлэг, уулзалтууд дээр нарийн бичиг хамт явж, дуу хураагч ашиглан, гарч буй саналыг баримтжуулж байсан байна. Мөн саналын товьёогийг тухай бүр боловсруулж, дэд ажлын хэсгийн гишүүдэд цахим шуудангаар тарааж, хурлаар хэлэлцэж, шийдвэрлэж байсан байна.

Хуулийн төсөл боловсруулах шатанд хийгдсэн холбогдох байгууллагын төлөөлөлтэй хамтарсан анхны уулзалтууд нь ихэвчлэн мэдээллийн шинжтэй, цаашид хэрхэн хуулийн төсөл боловсруулахад хамтран ажиллах асуудлуудыг шийдвэрлэсэн нь  энэ чиглэлээр хийгдэх ажлыг оновчтой төлөвлөхөд ач

холбогдолтой байсан. Санал авахаар хуулийн төслүүдийг байгууллага, судлаачдад хүргүүлж, ирүүлсэн саналын 60 орчим хувьд саналын үндэслэлийг огт дурдаагүй байсан нь хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийнхэнд уг саналыг хэлэлцэхэд нилээд хүндрэлтэй байсан талаар анкетын судалгаанд дурдсан байна. Мөн Гэмт хэргийн тухай хуулийн төслийг бүх нийтийн хэлэлцүүлэхээр хуулийн төслийг тараасан боловч уг төсөлд иргэд тодорхой санал гаргахаас илүүтэй тодруулга, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх хүсэлтүүд илүү гарч байсныг дурджээ. Яамны ахлах мэргэжилтэн ярилцлагын үеэр энэхүү шалтгаанаар дээрх хуулийн төслүүдэд бүх нийтийн хэлэлцүүлэг явуулах нь үр дүнгүй байсан гэж тайлбарласан.

***Цахим хэлэлцүүлэг.*** Гэмт хэргийн тухай хуулийн төслийг 2013.05.28-ны өдөр, Зөрчлийн тухай хуулийн төслийг 2014.01.14-ний өдөр Хууль Зүйн яамны www.moj.gov.mn вэб хуудсанд байршуулсан ба дээрх хуулийн төслүүд нь үзэл баримтлал, танилцуулгын хамт одоог хүртэл олон нийтэд нээлттэй байна. Хуулийн төслүүдийг санал авахаар тараагдсан үеэс эхлэн УИХ-аар батлагдах хүртэл яамны вэб хуудсанд байрлуулдаг ба батлагдсаны дараа www.legalinfo.mn вэб хуудсанд тавигддаг. Эдгээр хуулийн төслүүдэд вэб хуудсаар дамжуулан санал бараг ирээгүй байна.

Цахим шуудангаар санал авахад техникийн шинжтэй (фонт зөрсөн, цахим шуудانг буруу бичих зэрэг) асуудлууд гарч байсан. Мөн цахим шуудангаар санал илгээхдээ дээрх хоёр хуулийн төслийн саналыг нийлүүлж явуулах асуудал гарч байсан тул эдгээрийг ялгах нь ажиллагаа ихтэй байсныг ажлын хэсгийн гишүүн хэлсэн.

***Бусад асуудал.*** Дээрх хоёр хуулийн төслийг бүх аймгийн ЗДТГ, ЦЕГ, УЕПГ, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хуулийн төсөл тараасныг тус байгууллагууд өөрсдийн дотоод сүлжээгээр бүх аймгуудад тарааж ирүүлсэн саналыг нэгтгэн ирүүлсэн. Мөн бүх аймгаар явж, хуулийн төслүүдийг сурталчилж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Хуулийн төсөл боловсруулах явцад докторын зэрэгтэй 9 хүнээс зөвлөх үйлчилгээ авсан. Энэхүү үйлчилгээ нь байнгын шинжтэй биш байсан, хүн бүрт 1 сая төгрөгийн буюу нийт 9 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээнд зарцуулсан байна. Эдгээр зөвлөхүүд нь хуулийн төслүүд дээр ажил хэрэгч шинжтэй санал өгснийг төсөлд тусгасан байна. Мөн ажлын хэсэгт Улсын Дээд шүүхийн эрүүгийн танхим, Улсын Ерөнхий Прокурорын газар, Өмгөөлөгчдийн холбоо, хувь судлаачид зэрэг байгууллага, хувь хүмүүсээс орж ажилллаcан.

Хуулийн төслийн ажлын хэсэгт МУИС-ийн эрдэмтэн багш нар, судалгаа хийдэг төрийн байгууллагын төлөөллүүдээс оролцсон. Хуулийн төслийг санал авахаар тараахдаа бүх хуулийн их дээд сургуулиуд руу явуулж хариу авахад ирсэн саналууд дотор дээрх хуулийн сургуулиудын багш нараас ирсэн саналууд давамгайлж байсан. Мөн хүний эрхийг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудад хуулийн төслийг тарааж, санал авсан байна.

Яамны ахлах мэргэжилтний үзэж байгаагаар хуулийн төслийг иргэдээр хэлэлцүүлэхэд үр дүнтэй биш байдаг гэээд хууль тогтоогч нь иргэдийг төлөөлж хууль баталдаг тул иргэдээс санал авах шаардлагагүй гэсэн санал хэлсэн.

Энэхүү байр суурийг онолын үүднээс судалсан судлаачид дор дурдсанаар авч үзсэн байна. Баримтаас харахад хуулийн төсөл боловсруулах үйл явц нь тогтолцоог олонхийн эрх ашигт нийцүүлэн шинэчлэх боломжтой хуулийн төсөл бий болгож чадаагүй гэдэгт гурван шалтгаан байна. 1. Төрийн албан хаагчид шинэчлэл хийхүйц хуулийн төсөл боловсруулах чадваргүй, цөөнхөд үйлчлэх үзэл санааг баримталдаг, 2. Элит байгууллагууд нь төрийн албанд тулгуурлахаас өөр аргагүй албан тушаалтнуудаар удирдуулдаг. 3. Өөрчлөлтийг эрэлхийлсэн иргэний нийгмийн бүлгүүдийн саналыг хуулийн төсөл боловсруулах явцад сонсохгүй байгаа нь тэдний урмыг хугалдаг. Эдгээр хүндрэлүүдийг даван гарахад хуулийн төсөл боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах болон төрийн албан хаагчид, сонгогдсон албан тушаалтнуудыг хууль тогтоомжийг туршлага дээр үндэслэн бий болгох, үнэлэхэд чиглүүлж өгөх хууль тогтоох үзэл баримтлалыг бий болгох шаардлагатай...Хууль тогтоох үзэл баримтлал нь ...хандлагын өөрчлөлтийг тусгах л боломжтой. Харин нээлттэй, хариуцлагатай хуулийн төсөл боловсруулах үйл явц дахь холбогдох баримт, учир шалтгааныг гарган тавих зорилго бүхий олон нийтийн идэвхитэй оролцоо л аливаа байгууллагын өөрчлөлт олон нийтэд ашигтай байх нөхцөлийг хангана." гэж үзээд хуулийн төслийг ул суурьтай хийсэн судалгаан дээр үндэслэх, нийгмийн чиглэлээр судалгаа хийх чадвартай төрийн албан хаагчдыг ажиллуулах, нууцлалын талаарх хууль тогтоомжийг дахин хянаж, олон нийтийн санал авах боломжтой хуулийн тоог нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ авахыг судлаачид зөвлөжээ. Мөн шийдвэр гаргах эрх бүхий этгээд /байгууллага/-ийг шинээр сонгон гаргасны дараа тухайн этгээд хүнд суртал бүхий, чадвар муутай тогтолцоог өөрчлөх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхгүй бол уг тогтолцоо нь шинээр гарч ирсэн этгээд /байгууллага/-ийг өөрийг нь өөрчилчихдөг болохыг сануулсан байна.[143]

Тэгэхээр иргэдийн хуулийн төслийн боловсруулалтын шатанд оролцох идэвх сул байсан гээд энэ ажлыг алгасах уу гэдгийг бодож үзэх ёстой байна. Мэргэжилтэн маань цаашид ярилцлагаа үргэлжлүүлэхдээ "Харин тодорхой нийтийн ашиг сонирхол хөндөгдөх асуудал дээр олон нийтээс санал авах нь зүйтэй. Мөн зорилтот бүлгээр хуулийн төслийг хэлэлцүүлэх нь үр дүнтэй" гэсэн саналаа илэрхийлсэн байна.

***Анкетын судалгаа***. Иргэдээс авсан анкетын судалгаанд нийт 359 иргэн оролцсоноос 36 иргэн буюу нийт оролцогчдын 10% нь Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд саналаа өгсөн гэж хариулсан ба эдгээр 36 иргэнээс 7 нь буюу 19% нь хэлэлцүүлэгт оролцсон, 3 нь буюу 8% нь биечлэн очиж уулзсан, 5 нь буюу 14% нь захидлаар, 7 нь буюу 19% нь утсаар, 4 нь буюу 11% нь и-мэйлээр, 4 нь буюу 11% нь мессэжээр санал өгч байсан гэж хариулсан бол 6 нь буюу 17% нь хариулаагүй байна. Уг хуулийн төслийн хэлэлцүүлэг иргэдийн дунд ихэвчлэн онлайнаар хүрсэн. Судалгаанд оролцсон иргэдийн 10 хувь нь уг хэлэлцүүлэгт тодорхой хэмжээгээр оролцсон, гэсний дотор и-мэйл, мессеж, утсаар 39 хувь нь саналаа өгсөн гэж хариулж байгаа нь иргэдийн оролцоо муугүй, тэхдээ бүр зардал багатай хувилбараар саналаа өгөх хандлага сайн гэж үзэхээр байна. Гэмт хэргийн тухай хуульд саналаа өгсөн гэж хариулсан 36 иргэнээс 2 нь буюу 5% нь санал нь хуулийн төсөлд тусгагдаагүй, 14 нь буюу 39% нь зарим санал нь

[143] Ann Seidman ба Robert B. Seidman "Beyond Contested Elections: The Processes Of Bill Creation And The Fulfill-Ment Of Democracy's Promises To The Third World", 1997 President and Fellows of Harvard College Harvard Journal on Legislation, 1997.

тусгагдсан, 2 нь буюу 5% нь хангалттай тусгагдсан, 13 нь буюу 36% нь мэдэхгүй гэж хариулсан ба 5 нь буюу 14% нь хариулаагүй байна. Санал өгсөн иргэдийн 44 хувь нь санал нь хангалттай буюу зарим санал тусгагдсан гэж хариулсан байна. Иргэдийн энэхүү хариулт нь ХЗЯ-ны мэргэжилтний "хуулийн төслийг иргэдээр хэлэлцүүлэхэд үр дүнтэй биш байдаг" гэсэн хариултыг үгүйсгэв. Бидний зүгээс энэ байдал нь олон нийтийн оролцооны талаарх төрийн албан хаагчид, улс төрчдийн байр суурийг тайлбарласан дээр дурдсан судлаачдын дүгнэлтийг нотолсон гэж үзэж байна.

Харин нийт судалгаанд оролцсон 359 иргэнээс 24 нь буюу 7% нь Зөрчлийн тухай хуулийн төсөлд саналаа өгсөн гэж хариулсан ба эдгээр 24 иргэнээс 2 нь буюу 8% нь хэлэлцүүлэгт оролцсон, 2 нь буюу 8% нь биечлэн очиж уулзсан, 3 нь буюу 4% нь утсаар санал өгсөн гэж хариулсан ба үлдсэн 17 нь буюу 70% нь энэ асуултад хариулаагүй байна. Саналаа өгсөн гэж хариулсан 24 иргэнээс 1 нь буюу 4% нь санал нь хуулийн төсөлд тусгагдаагүй, 6 нь буюу 25% нь саналыг зарим нь тусгагдсан, 8 нь буюу 33% нь хангалттай тусгагдсан, 2 нь буюу 8% нь мэдэхгүй гэж хариулсан ба үлдсэн 7 нь буюу 30% нь энэ асуултанд хариулаагүй байна.

***Дүгнэлт.*** Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн төсөлд олон нийтийн санал авах ажиллагааг ХЗЯ-ны зүгээс ихээхэн анхаарч ажилласан болох нь иргэдийн дунд хийсэн судалгаагаар нотлогдож байна. Гэмт хэрэг, Зөрчлийн хуулийн төслүүд дээр Хууль зүйн Яамны зүгээс холбогдох байгууллагуудтай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналын ихэнх хувийг тусгасан байна. Хуулийн төслүүдийн онцлогоос хамаарч, бүх нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах нь үр дүнгүй тул холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлсэн нь уг хуулиудын онцлогт нийцсэн үр дүнтэй алхам болсон байж болох юм. Мөн хуулийн төслүүдийг ном хэлбэрээр тараасан ба Хууль Зүйн Яамны цахим хуудсанд байрлуулж, дээрх хэлбэрүүдээр хуулийн төсөлтэй танилцсан иргэн, байгууллага ажлын хэсэгтэй холбогдон, хуулийн төслийн саналаа илэрхийлэх боломжийг олгож байсан байна. Энэ нь сонирхсон иргэн, хуулийн этгээд өөрийн саналыг илэрхийлэх нээлттэй боломжийг олгосон байна. Мөн нийт ирсэн санал тус бүрийг авч хэлэлцэн, тусгах эсэхийг шийдвэрлэж байсан нь оролцоог үр дүнтэй хангах талаар зохих ёсоор ахнаарсан гэж үзэж болохоор байна. Үүнээс гадна, ирсэн саналуудыг дуу хураагч ашиглан болон бичгээр баталгаажуулж байсан нь саналыг баталгаажуулах үр дүнтэй алхам болж чадсан байна.

Мөн хуулийн төслүүдэд санал авахаар бүх аймгуудын ЗДТГ болон их дээд сургуулиуд, Төрийн бус байгууллагуудын саналыг авсан нь дээрх хуулийн төслүүдийн онцлогоос хамаарч үр дүнтэй санал тусгагдах боломжийг бүрдүүлсэн байна. Иймд хуулийн төслийн онцлогоос хамаарч үр дүнтэй оролцооны арга, хэлбэр болон оролцооны хүрээг тодорхойлох зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна. Харин иргэдийн оролцоог үнэлэх үнэлэмж төрийн албан хаагчийн зүгээс ядмаг, тэр тусмаа УИХ-ын гишүүн нь иргэдийг төлөөлөн хүсэл зоригийг нь баталж буй хуульд тусгадаг гэдгээр орлуулж ойлгож илэрхийлж байгаа нь оролцооны талаархи орчин үеийн дүгнэлт, пост коммунист орны хувьд хөгжилд учирч буй бэрхшээл, хандлагын талаар төрийн албан хаагчдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

### 3.5.2. Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл

УИХ-ын Тамгын газар болон Хууль зүйн яамнаас сонгосон хуулиудаас Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг боловсруулах явц дахь олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаар Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, Эмэгтэйчүүдийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Нарантуяатай 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр уулзаж, баримт бичигтэй танилцлаа.

***Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг.*** Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиуд нь багц хууль бөгөөд бүх шатанд хамт боловсруулагдаж, хамт хэлэлцэгдэж явсан. Тус хоёр хуулийн төслийн Үзэл баримтлал нь 2014 оны 9-р сарын 5-ны өдөр батлагдаж, одоогийн байдлаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа.
Хуулийн төслүүдийг Иргэний танхим, шүүгч, өмгөөлөгчдөөр, хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллагуудаар, энэхүү чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгч нар, судалгаа хийдэг судлаачид, цагдаагийн байгууллага болон хүний эрхийн байгууллагын төлөөлөл мөн ажлын хэсэг зэрэг олон хүрээнд нийт 7-8 удаа хэлэлцүүлсэн  нь хуулийг хэрэгжүүлэх этгээдийг бүрэн хамарч, тэдний саналуудыг тусгаж ажилласан  байна. Мөн хуулийн төслийн ажлыг хэсэг 1 удаа ваакумжин хуулийн төсөл дээр ажилласан бөгөөд ажлын хэсэг ХАХНХЯ, ХТҮГ, Нийслэлийн ХГБХХ дээр олон удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн төслөө хэлэлцэж, саналыг тусган ажилласан.

Яамнаас Үндэсний хэмжээнд 4 удаа Чуулган зохион байгуулсан  ба үүнд “Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого зорилт” сэдэвт үндэсний чуулган, “Бид оролцъё, хөгжье” сэдэвт хүүхдийн үндэсний чуулган, “Хүүхдийн эрх, хамгааллалд үүрэг хүлээгчдийн хариуцлага”, “Гэр бүлийн үнэ цэнэ-хөгжил, шинэчлэл” сэдэвт үндэсний чуулганыг зохион байгуулж Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхдийн хамгааллын тухай хуулийн төслөө танилцуулж, олон нийтийн саналыг сонсож байсан ба иргэд, албан байгууллагууд санал өгөх гэхээсээ илүүтэйгээр өөрсдөд тулгарсан асуудал, өөрийн бодлоо илэрхийлж байсан. Үндэсний чуулган тус бүрт аймаг орон нутгаас 600-800 төлөөлөгч оролцсон байна.

Хэлэлцүүлэх гэж буй хуулийн төслийг оролцогчдод цахим шуудангаар болон утсаар  өмнө нь мэдэгддэг байсан ба хэлэлцүүлгийг Хүүхэд, Гэр бүлийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулж байсан. Хэлэлцүүлэг, уулзалтын санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сан, бусад хөгжлийн байгууллагуудын тусламж болон төсвөөр шийдвэрлэсэн байдаг. Гэвч хэдэн удаагийн хэлэлцүүлэгт хичнээн төгрөгийн зардал гарсныг тодруулах боломжгүй гэсэн тайлбарыг бидэнд өгсөн юм.

Хуулийн төслүүдэд өгсөн саналын хувьд Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд 15 яамнаас 70 санал ирүүлснээс 66 саналыг тусган, 4 саналыг тусгах боломжгүй талаар тайлбар оруулсан, мөн төрийн бус байгууллага, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Хүүхдийн төлөө үндэсний газар, судлаачид, шүүгчид, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр өмгөөлөл хийдэг өмгөөлөгчид болон

Хүүхдийн эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагуудаас бичгээр 110 санал гарсан байдаг, үүнд хэлэлцүүлгийн явц дахь амаар хэлсэн саналууд ороогүй болно.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөлд 15 яамнаас 65 санал ирүүлсэн бөгөөд 51 саналыг тусган, 14 саналыг тусгах боломжгүй талаар тайлбар оруулсан, мөн төрийн бус байгууллага, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Хүүхдийн төлөө үндэсний газар, судлаачид, шүүгчид, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр өмгөөлөл хийдэг өмгөөлөгчид болон Хүүхдийн эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагуудаас бичгээр 23 санал гарсан байдаг, үүнд хэлэлцүүлгийн явц дахь амаар хэлсэн саналууд мөн ороогүй болно.

Хуулийн төслүүдийг шүүгч, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр өмгөөлөл хийдэг өмгөөлөгчид, тус салбарын төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлэхэд маш үнэтэй саналууд гарч байсан ба ийнхүү өгсөн саналуудын дийлэнх хувийг хуулийн төсөлд тусгасан.

Хоёр хуулийн төсөлд 15 яамдаас ирсэн 135 саналаас Хүүхэд хамгааллын тухай хуулйн төсөлд 94.3%-ийг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөлд 78.5%-ийг тусгасан.

Ажлын хэсгээс гарсан саналуудыг тусгасан талаарх мэдээллийг ажлын хэсгийн дараагийн уулзалтаар танилцуулдаг боловч яг санал өгсөн этгээдүүдэд тусгайлан танилцуулж, хариу өгч байгаагүй байна. Иргэдээс Яамны 1111 дугаарт ирсэн саналуудын хувьд иргэд хуулийн төсөлд тусгахаар тоймтой санал гаргадаггүй тул төсөлд тусгах боломжгүй байдаг байна.

Хуулийн төсөлд олон нийтийн саналыг тусгасан байгаа нь эргээд хэрэгжилтийн механизмд хүндрэл бага учирдаг ололттой талтай гэж Яамны мэргэжилтэн дурьдаж байлаа. Мөн хэлэлцүүлэгт оролцогчид хуулийн төсөлтэй сайн танилцаж амжаагүйгээс болоод хэлэлцүүлгийн үед хуулийн төсөлд туссан байгаа зүйлсийг тусгах талаар ярих, мөн зөвхөн ганц, хоёр хэсэг дээр удаан ярилцаж, өөр хуулиар зохицуулах харилцааг тус хуулийн төслүүдэд оруулахыг шаардах зэргээр хэлэлцүүлгийг үр дүнгүй асуудлаар удаашруулах, зарим тохиолдолд хэлэлцүүлэг төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх тохиолдол ч байсан гэв.

***Цахим хэлэлцүүлэг.*** Цахим хэлэлцүүлгийн хувьд хуулийн үзэл баримтлал, төслийг цахим хуудсанд байрлуулж иргэдээс санал авсан гэж анкетийн судалгааг бөглөсөн байсан боловч бодит байдал дээр үзэл баримтлал, хуулийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй байна. Энэ нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 18.4.1-т заасан шаардлагыг хангахгүй байна гэсэн үг. Хуулийн төслүүдийг цахим хуудсандаа байршуулаагүй байгаа тул цахим хэлэлцүүлгийн бусад асуултанд хариулсныг илэрхий буруу хариулт гэж үзэв.
Яамны зүгээс хуулийн төслийг цахим хуудсаар иргэдээс санал авахаас илүүтэйгээр мэргэжилтнүүдийг цуглуулан хэлэлцүүлж, тэднээс санал авах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн санал өгсөн юм.

***Бусад асуудал.*** Хуулийн төслийн ажлын хэсэгт салбарын судлаачид, эрдэмтэд, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон Төрийн бус байгууллагууд, хуулийг хэрэгжүүлэх этгээд болон хуульчдыг оролцлуулсан нь

хуулийн төслийг боловсронгуй болгоход маш үр дүнтэй ажил болсон гэж үзэж байгаа.
Мөн хуулийн төслийг Хүүхдийн эрхийн тухай Конвенц, Дэлхийн 68 орны 130 хуулийг судалж шилдэг туршлагыг нэгтгэн боловсруулсан олон улсын Хүүхэд хамгааллын загвар хуулийг загвар болгон боловсруулснаараа олон улсын жишигт нийцсэн гэж үзэж буйгаа мэргэжилтэн онцлов.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны хувьд Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг хариуцаж байсан мэргэжилтэн нь ажлаасаа гарсан бөгөөд одоо хариуцаж байгаа ажилтан нь нарийн мэдээллүүдийг мэдэхгүй байсан тул зарим мэдээллүүдэд хариулт авч чадаагүй болохыг анхаарна уу.

***Анкетын судалгаа.*** Судалгаанд 359 иргэн оролцсоноос "Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд санал өгч байсан уу?" гэсэн асуултанд 40 иргэн буюу 11% нь дээрх хуулийн төслүүдэд санал өгч байсан гэж хариулсан ба тэдгээрийн 5 буюу 12.5% нь ямар аргаар санал өгсөн талаар хариулаагүй, 4 буюу 10% нь хэлэлцүүлэгт оролцсон, 6 буюу 15% нь биечлэн уулзсан, 4 буюу 10% нь захидлаар, 7 буюу 17.5% нь утсаар, 5 буюу 12.5% нь и-мейлээр, 9 буюу 22.5% нь мессежээр тус тус санал өгснөөс 7 иргэн миний саналыг огт тусгаагүй, 8 иргэн саналын заримыг хуулийн төсөлд тусгасан, мөн 5 иргэн миний саналыг хангалттай тусгасан гэж хариулсан бөгөөд 11 иргэн энэ талаар мэдэхгүй байна гэж хариулсан байна. Энэхүү асуулгад 319 иргэн буюу 88.8% нь хариулаагүй нь эдгээр хүмүүс уг хуулийн төсөлд санал өгөх ажилд оролцоогүй байх талтай гэж үзэв.
Төрийн бус байгууллагын анкетын судалгаанд 11 Төрийн бус байгууллага оролцсоноос "Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд санал өгч байсан уу?" гэсэн асуултад 3 ТББ буюу 27% нь дээрх хуулийн төсөлд санал өгч байсан гэж хариулсан, 1 ТББ буюу 9% хуулийн төслийн ажлын хэсэгт ажилласан, 2 ТББ буюу 18% нь хэлэлцүүлэгт оролцсон гэж хариулжээ. 1 ТББ-ын саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх гэсэн асуултад хариулаагүй, 1 ТББ саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байна гэжээ.

### 3.5.3. Гэр бүлийн тухай хуулийн төсөл

***Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг.*** Гэр бүлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал нь 2014 оны намар батлагдаж, одоогийн байдлаар Улсын Их Хурлын анхны хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд байна.
Хуулийн төслийг Иргэний танхим, шүүгчид, өмгөөлөгчид, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажилтан, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, судлаачид, Монгол Улсын Иргэний эрх зүйн тэнхимийн багш зэрэг олон хүрээнд нийт 5-6 удаа хэлэлцүүлсэн. Хуулийн төслийг боловсруулах явцад ажлын хэсэг олон удаагийн уулзалт зохион байгуулж хэлэлцүүлсэн.

Яамнаас Үндэсний хэмжээнд 4 удаа Чуулган зохион байгуулсан байдаг ба үүнд "Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого зорилт" сэдэвт үндэсний чуулган, "Бид оролцоё, хөгжье" сэдэвт хүүхдийн үндэсний чуулган, "Хүүхдийн эрх, хамгаалалд үүрэг хүлээгчдийн хариуцлага", "Гэр бүлийн үнэ цэнэ-хөгжил, шинэчлэл" сэдэвт үндэсний чуулганыг зохион байгуулж Хүүхдийн эрхийн тухай

болон Хүүхдийн хамгааллын тухай хуулийн төсөлтэй хамт Гэр бүлийн тухай хуулийн төслөө мөн танилцуулж, олон нийтийн саналыг сонсож байсан ба иргэд, албан байгууллагууд санал өгөх гэхээсээ илүүтэйгээр өөрсдөд тулгарсан асуудал, өөрийн бодлоо илэрхийлж байсан. Үндэсний чуулган тус бүрд аймаг орон нутгаас 600-800 төлөөлөгч оролцсон байна.

Үндэсний хэмжээнд хэлэлцүүлсэнээс гадна бусад хүрээнд хуулийн төслийг 200-300 төлөөлөгчдийг оролцуулан хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэх гэж буй хуулийн төслийг оролцогчдод цахим шуудангаар болон утсаар өмнө нь мэдэгддэг байсан.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг Хүүхэд, Гэр бүлийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Нийслэлийн шүүх, Хуульч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран зохион байгуулж байсан. Хэлэлцүүлэг, уулзалтын санхүүжилтийг Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн байдаг. Гэвч хэдэн удаагийн хэлэлцүүлэгт хичнээн төгрөгийн зардал гарсныг тодруулах боломжгүй гэсэн тайлбарыг бидэнд өгсөн юм.

Хуулийн төслийг анх Хууль зүйн яам боловсруулж байсан тухайн үед ирж байсан санал, сүүлд Хүүхдийн төлөө үндэсний газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Иргэний танхимын шүүгч, өмгөөлөгчид, эрдэмтэн, судлаачдаас хэлэлцүүлгий үеэр, цахим шуудангаар болон бичгээр нийт 200-аад санал ирсэн.

Иргэний танхимын шүүгч, өмгөөлөгчид нь яг практик дээр гэр бүлийн чиглэлээрх асуудлуудыг шийдвэрлэж, эрх зүйн туслалцаа үзүүлж байдаг тул Гэр бүлийн тухай хуульд маш үнэтэй саналуудыг өгч байсан ба энэхүү саналуудыг 100% хуулийн төсөлд тусгасан. Зарим байгууллагуудаас ирүүлсэн саналуудын зарим нь өөр хуулиар зохицуулагдах, хуулийн төсөлд нэгэнт тусагдсан байгаа зэрэг шалтгаанаар тал хувийг нь төсөлд тусгаагүй байна.

Санал гаргасан этгээдэд хуулийн төсөлд түүний саналыг тусгасан талаар ямар нэгэн мэдэгдэл хийгээгүй, харин ажлын хэсгээс гарсан саналуудыг тусгасан талаар тухай бүрд нь цахим шуудангаар явуулан, ажлын хэсгийн дараачийн уулзалтаар хариу хэлж байсан.

***Цахим хэлэлцүүлэг.*** Гэр бүлийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсан дээр байршуулж олон нийтийг санал өгөх бололцоогоор хангасан.
Тухайн хуулийн төслийг архивладаг эсэх асуудлын хувьд өнөөдөр буюу 2014 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар цахим хуудсанд хуулийн төсөл байсаар байгаагаас үзвэл архивладаг юм байна.

Яамны зүгээс хуулийн төслийг цахим хуудсаар иргэдээс санал авахаас илүүтэйгээр мэргэжилтнүүдийг цуглуулан хэлэлцүүлж, тэднээс санал авах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн санал өгсөн.

***Бусад асуудал.*** Хуулийн төслийн ажлын хэсэгт салбарын судлаачид, эрдэмтэд, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон Төрийн бус байгууллагууд, хуулийг хэрэгжүүлэх этгээд болон хуульчдыг оролцлуулан ажилласан.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны хувьд Гэр бүлийн тухай хуулийн төслийг хариуцаж байсан мэргэжилтэн нь ажлаасаа гарсан бөгөөд одоо хариуцаж байгаа ажилтан нь нарийн мэдээллүүдийг мэдэхгүй байсан тул зарим мэдээллүүдэд хариулт авч чадаагүй болохыг анхаарна уу.

***Анкетын судалгаа.*** Иргэдийн анкет, судалгаанд 359 иргэн оролцсоноос "Гэр бүлийн тухай хуулийн төсөлд санал өгч байсан уу?" гэсэн асуултанд 33 иргэн буюу 9% нь дээрх хуулийн төсөлд санал өгч байсан гэж хариулсан ба тэдгээрийн 9 буюу 27% нь ямар аргаар санал өгсөн талаар хариулаагүй, 5 буюу 15% нь хэлэлцүүлэгт оролцсон, 3 буюу 9% нь биечлэн очиж уулзсан, 2 буюу 6% нь захидлаар, 5 буюу 15% нь утсаар, 8 буюу 24% нь и-мейлээр, 2 буюу 6% нь мессежээр тус тус санал өгснөөс 12 иргэний саналын заримыг хуулийн төсөлд тусгаагүй, мөн 3 иргэний саналыг хангалттай тусгаж, 4 иргэн энэ талаар мэдэхгүй байна гэж, 5 иргэн хариулаагүй байна. Уг асуултанд 326 иргэн буюу 90% нь хариулаагүй нь уг хуулийн төсөлд санал өгөөгүй байх талтай.
Төрийн бус байгууллагын анкетын судалгаанд 11 Төрийн бус байгууллага оролцсоноос "Гэр бүлийн тухай хуулийн төсөлд санал өгч байсан уу?" гэсэн асуултад 3 ТББ буюу 27% нь дээрх хуулийн төсөлд санал өгч байсан гэж хариулсан, 2 ТББ буюу 18% нь хэлэлцүүлэгт оролцсон гэжээ. 1 ТББ саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар бөглөөгүй, 1 ТББ саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байна гэж хариулжээ.

### 3.5.4. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль /2014.06.13-нд батлагдсан/

2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Малын индексжүүлсэн даатгалын төслийн чадавхийг бэхжүүлэх эрх зүйн асуудал хариуцсан зохицуулагч Б.Сувд-Эрдэнэ болон тус байгууллагын Болдоо гэх ажилтантай "Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль"-ийг боловсруулах явц дах иргэдийн оролцооны талаар ярилцахаар уулзалт хийсэн. Гэвч дээрх ажилтнууд зарим мэдээлэл, баримт бичгүүдээ бидэнд танилцуулж, үзүүлэхээс татгалзсан боловч тэдний бөглөсөн анкет зэргээс зарим нэгэн асуултыг тодрууллаа.

***Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг.*** МИДТХууль нь 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Хуулийн төслийн талаар 2013 оны 10 дугаар сард Малын индексжүүлсэн даатгалын төслийн 21 аймаг дахь салбарын зохицуулагч, менежерүүдтэй зөвлөлдөх уулзалт, 2007, 2013 оны 1 дүгээр сард Малын индексжүүлсэн даатгалын зөвлөлдөх уулзалт, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгийн хорооны хуралдаанаас тус тус хэлэлцэгдсэн байна. Холбогдох ажилтнууд энэхүү төслийг анх 2005 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн талаар дурдсан ба хуультай байх шаардлагатай эсэх талаар 2007 оноос эхлэн хэлэлцэж эхэлсэн байна. Хэлэлцүүлгийг цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр, хуулийг хэрэгжүүлэх байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Даатгагчдын холбоо, даатгалын компаниудаар, эрх ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд болох Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Хэнтий, Увс зэрэг аймгуудын зарим малчдын төлөөллүүдээр, ажил мэргэжлийн хүрээнд Малын индексжүүлсэн даатгалын төслийн 21 аймаг дахь салбарын зохицуулагч, менежерүүдээр тус тус хэлэлцүүлсэн байна. Хөдөө орон нутгаар маш олон удаа

хэлэлцүүлсэн боловч протокол, гарсан санал, түүнийг хуулийн төсөлд тусгасан байдал зэргийг үзүүлэх боломжгүй гэсэн болно.
Хэлэлцүүлэх гэж буй хуулийн төслийг оролцогчдод цахим хуудас, и-мейл, шуудангаар болон хэлэлцүүлэгт хүрэлцэн ирснийх нь дараа танилцуулсан байдаг. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг УИХ-ын 6 гишүүн, Монгол Улсын Сангийн сайд болон дэд сайд, ТУХ-ны дарга, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн суурин төлөөлөгч, төсөлд оролцогч даатгалын компанийн төлөөлөл, төслийн дотоодын зөвлөхүүд, 56 сумын Засаг дарга, ЗДО, 283 багийн Засаг дарга нар, Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж байсан.

Хуулийн төслийн санхүүжилт нь төслөөс санхүүжигдсэн бөгөөд төсөл нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа юм байна. Хэдэн удаагийн хэлэлцүүлэгт хичнээн төгрөгийн зардал гаргасан талаарх мэдээллийг өгөх боломжгүй гэж тайлбарласан.

Гарсан саналыг баримтжуулан саналын нэгтгэл гарган дүн шинжилгээ хийж саналын 70-80 хувийг хуулийн төсөлд тусгасан талаар дурдаж холбогдох материалуудыг танилцуулсан юм. Санал гаргасан этгээдэд хуулийн төсөлд саналыг тусгасан талаар цахим шуудангаар, Яам, Агентлаг, холбогдох байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн товъёог гаргасан. Хуулийн төслийг хэлэлцүүлэг хийх замаар уулзалт зохион байгуулахад оролцогчдод урьдчилсан байдлаар тараасан хэдий ч хэлэлцүүлгийн үеэр хуулийн төсөлтэй танилцаагүй, саналаа богино хугацаанд өгөх хангалттай цаг байхгүй байх зэрэг хүндэрлүүд учирч байсан байна. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хувьд Олон улсын байгууллагын хөрөнгөөр орон даяар олон удаагийн хэлэлцүүлэг хийсэн нь сайн талтай ч тухайн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээг нууцлсан нь зохимжгүй гэж бид үзэж байна. Зарим төслийн хувьд ийнхүү санхүүжилтийн боломж өргөн байхад ихэнх тохиолдолд олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний зардал байдаггүй, хангалтгүй гэдгийг хууль санаачлагчид, төрийн байгууллагууд онцолж байсан.

***Цахим хэлэлцүүлэг.*** Цахим хэлэлцүүлгийн хувьд Улсын Их Хурлын цахим хуудас, Сангийн яамны цахим хуудас, төслийн цахим хуудсанд жилийн хугацаатайгаар байршуулж, иргэдийг санал өгөх боломжоор хангасан байна. Гэвч цахимаар иргэдээс ямар нэгэн тоймтой санал огт ирдэггүй тул энэ нь их үр дүнгүй арга гэж төслийн ажилтнууд үзэж байна.
Хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээ авсан бөгөөд Малын индексжүүлсэн даатгалынхан зөвлөх үйлчилгээ нь маш нь давуу талтай байдаг, зөвхөн нэг талыг барьж хазайдаггүй ба хөндлөнгийн нүдээр харж хийдэг учраас маш үр дүнтэй байсан гэдгийг онцлон тэмдэглэж байсан.

***Бусад асуудал.*** Төслийн удирдах хорооны гишүүд нь эрдэмтэн, судлаачид байдаг учраас хуулийн төслийг боловсронгуй болгох замаар тэдний саналыг байнга авч, төсөлд өөрчлөлт орох бүрт тэдэнд хуулийн төслөө хүргүүлж ажилласан байна.
Малын индексжүүлсэн даатгалын төслийн ажилтан Б.Сувд-Эрдэнэ ярихдаа бид хуулийн төслийг хуулийг хэрэгжүүлэх этгээд, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдээс хангалттай санал авч ажилласан, орон нутгийн малчдын төлөөллүүдийг Улаанбаатар хотод урин хуулийн төслөө заалт бүрээр нь үр дүнтэйгээр хэлэлцүүлсэн гэв.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийг олон удаа, маш үр дүнтэйгээр хэлэлцүүлж байгаа талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олонтаа харж байсан тул тус хуулийг сонгосон билээ. Гэвч холбогдох ажилтнууд нь баримт бичигтэй танилцуулахаас татгалзсан нь уулзалтын үр дүнг бууруулсан.

***Анкетын судалгаа.*** Иргэдийн анкет, судалгаанд 359 иргэн оролцсоноос "Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд санал өгч байсан уу?" гэсэн асуултанд 26 иргэн буюу 7% нь дээрх хуулийн төсөлд санал өгч байсан гэж хариулсан ба тэдгээрийн 9 буюу 34% нь ямар аргаар санал өгсөн талаар хариулаагүй, 5 буюу 19% нь хэлэлцүүлэгт оролцсон, 7 буюу 26% нь биечлэн очиж уулзсан, 1 буюу 3% нь утсаар, 1 буюу 3% нь и-мейлээр, 3 буюу 11% нь мессежээр тус тус санал өгснөөс 9 иргэний саналын заримыг хуулийн төсөлд тусгаагүй, мөн 2 иргэний саналыг хангалттай тусгаж, 1 иргэн энэ талаар мэдэхгүй байна гэж хариулсан бол, 14 иргэн энэ асуултанд хариулаагүй байна. Энэ хуулийн тухай асуултанд 333 иргэн буюу 92% нь хариулаагүй нь огт оролцоогүй байж болох талтай байна.
Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийн талаар судалгаанд оролцсон 11 төрийн бус байгууллага ямар нэгэн байдлаар хариулт өгөөгүй нь тэдгээр нь уг хуульд санал өгөх ажиллгаанд оролцоогүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

### 3.5.5. Тамхины хяналтын тухай хууль /2012.10.24-нд батлагдсан/

2014 оны 11-р сарын 24-ны өдөр Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн Байгалийн санал болгосноор Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөх Цэцэгдарьтай очиж уулзлаа. Тэрээр тухайн үед төслийн эх баригч байсан. Тамхины хяналтын тухай хууль нь 2012 оны 10 сард батлагдсан.

***Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг.*** Хуулийн төслийн хэлэлцүүлэг хэдэн удаа, ямар хүрээнд, хэрхэн хэлэлцүүлсэн тухай мэдээлэл яамны архивд байгаа ба тэрээр тодорхой тоо баримттай санахгүй байна гэсэн ба хуулийн төслийг танилцуулах, болон санал авах ажиллагааг маш өргөн хүрээнд хийсэн. Жишээ нь С1, ТВ9 зэрэг телевизүүдээр тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Г.Баярсайхан нартай нэвтрүүлэгт оролцож хуулийн төслийг танилцуулж иргэдээс нээлттэй утсаар санал авсан ба, гэр бүлийн FM-ээр шууд нэвтрүүлэг хийсэн, хуулийн төслийг сонинд хэвлэн нийтлэх зэргээр танилцуулга хийсэн ба үүнээс гадна хуулийн төсөлтэй холбоотой мөн хуулийн хэрэгжилттэй холбоотой ярилцлагуудыг сонинд хэвлүүлсэн. Мөн орон нутгийн хүрээнд бүсчилсэн танилцуулгыг Архангай аймаг, Дархан хотод очиж хийсэн хэмээн мэдэгдсэн.

***Цахим хэлэлцүүлэг.*** Хуулийн төслийг өргөн барихаас 1 сарын өмнө вэбд байрлуулсан бөгөөд, яамдуудад албан тоотоор хандан зарлаж, ажлын хэсгийн гишүүд зөвлөхүүдэд урилга явуулах болон и-мэйл илгээх зэргээр хуулийн төслийг хүргүүлэн санал авсан. Хэлэлцүүлгийг иргэний танхимтай хамтран зохион байгуулж байжээ. Ирсэн саналуудын хувьд яам агентлагаас албан тоотоор ирүүлсэн саналуудыг саналыг авсан эсэх талаар саналын товчоон үүсгэсэн байдаг ба 70-80%-ийн саналыг тусгасан хэмээн мэдэгдсэн ба холбогдох материал нь яамны архивд хадгалагддаг, иймд биднийг өөрсдөө

холбогдоод очиж үзэж болно гэсний дагуу бид холдогдсон хэдий ч архивтай танилцаж чадаагүй.

Албан тоотоос бусад хэлбэрээр ирсэн саналыг нь авсан эсэх талаар тайлбарыг нэвтрүүлгийн үеэр шууд хариу тайлбар өгөх хэлбэрээр хийсэн ба хуулийн төсөлд цахим хэлбэрээр санал бараг ирээгүй, ирсэн нь дандаа асуулгын шинжтэй байсан гэв.

Хуулийн төслийг боловсруулахдаа яам өөрөө боловсруулсан ба зөвлөх үйлчилгээ аваагүй. Ажлын хэсгийн гишүүдийн хувьд бүх төлөөллөөс оролцуулахыг хичээн үйлдвэрлэгч, импортлогч болон иргэдийн төлөөлөл, мэргэжлийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг хамруулсан байна. Хуулийн төслийг боловсронгуй болгоход эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн судлаачдаас санал аваагүй ба гэхдээ тэдний хийсэн судалгаан дээр үндэслэн хуулийн төслийг боловсруулсан болохоор оролцуулаагүй гэж хэлэхээргүй гэж үзэж байна гэв.

Санхүүжилтийн хувьд төсөл боловсруулах болон хэлэлцүүлгийн үеэр ойролцоогоор арван сая төгрөгийн зардал гарсан ба санхүүжилт нь Эрүүл мэндийг дэмжих сангаас гарсан байна.

**Бусад асуудал.** Эцэст нь нэмэлт санал хэсэгт тэрээр аливаа хуулийн төслийг мэргэжлийн баг боловсруулж, дараа нь мэргэжлийн багт ороогүй хүмүүсээс санал авах нь зүйтэй. Мөн хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхдээ сонин хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглавал бас үр дүнтэй гэсэн саналуудыг өглөө. Ийнхүү нээлттэй ярилцлага хийн, хуулийн төслийн явцын мэдээллийг өгсөн Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөх Цэцэгдарь таньд талархал илэрхийлж байна.

**Анкетын судалгаа**. Иргэдээс авсан анкет асуулгад Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн үү? Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 12% буюу 44 иргэн тийм, 88% буюу 315 иргэн үгүй гэж хариулсан байна. Хуулийн төсөлд санал өгсөн бол оролцсон арга хэлбэр гэсэн асуултанд 44 иргэнээс 18% буюу 8 иргэн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн, 9% буюу нь 4 иргэн биечлэн очиж уулзсан, 11% буюу 5 иргэн захидлаар, 16% буюу 7 иргэн утсаар, 11% буюу 5 иргэн и-мэйлээр, 13% буюу 6 иргэн мессежээр гэж хариулсан ба 20% буюу 9 иргэн хариулаагүй байна. Таны санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх гэсэн асуултанд нийт санал өгсөн 44 иргэнээс 4,5% буюу 2 иргэн тусгагдаагүй, 25% буюу 11 иргэн зарим нь тусгагдсан, 32% буюу 14 иргэн хангалттай, 18% буюу 8 иргэн мэдэхгүй, 20% буюу 9 иргэн нь хариулаагүй байна.

Төрийн бус байгууллагаас авсан анкет асуулгад нийт 11 төрийн бус байгууллага хариу ирүүлснээс Тамхины хяналтын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 18% буюу 2 ТББ-ын төлөөлөл санал гэж хариулсан байна. Хуулийн төсөлд саналаа өгсөн бол ямар хэлбэрээр гэсэн асуултанд нийт саналаа өгсөн хоёр ТББ-ын нэг нь хэлэлцүүлэгт оролцсон мөн амаар болон бичгээр саналаа өгч, нэг ТББ-ын төлөөлөл нь ганцхан хэлэлцүүлэгт оролцсон байна. Мөн таны санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх асуултанд 2 ТББ-ын 50% буюу 1 ТББ нь өгсөн зарим саналыг тусгасан ба 50% буюу 1 ТББ-ын төлөөлөл нь саналыг хангалттай тусгасан гэж үзсэн байна.

### 3.6. Иргэний оролцооны тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хийсэн ажиглалт

Хууль боловсруулах үе шатанд иргэдийн оролцоо хэрхэн хангагдаж байгааг тодорхойлох зорилгоор 2014.11.04-нд Ерөнхийлөгчийн тамгын газар, Нийслэлийн иргэний танхимтай хамтран зохион байгуулсан Иргэний оролцооны тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт оролцож, ажиглалт хийсэн. Төслийг Ерөнхийлөгчийн тамгын газар, Нийслэлийн иргэдийн оролцооны хэлтэс зэрэг байгууллагуудаас оролцсон ажлын хэсэг боловсруулж байгаа юм.

Энэхүү хэлэлцүүлэгт 70 орчим оролцогчид оролцсон ба оролцогчдын дийлэнх хэсгийг дүүрэг, хороодын иргэний танхимын ажилчид болон хэсгийн төлөөлөгчид эзэлж байсан ба оролцогчид хэлэлцүүлгийн талаархи мэдээллийг дүүрэг, хороодын иргэдтэй харилцах хэлтсээр дамжуулж авсан буюу дийлэнх оролцогчид ажлын журмаар ирсэн байсан. Оролцогчид хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байсан ба 6 хүн санал хэлж, 1 хүн асуулт асуусан. Хэлэлцүүлгийн явцад видео бичлэг хийгдсэн.

Уг хэлэлцүүлэг нь 2 цаг үргэлжилсэн ба хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг байсан тул хуулийн төслийн товч танилцуулгыг хийж, ажлын хэсгийн гишүүд хэлэлцүүлгийн ихэнх цагт танилцуулга хийсэн ба хэлэлцүүлгийн цагт оролцогчид санал хэлж, асуулт тавих хангалттай цаг байгаагүй. Хэлэлцүүлэг зохион байгуулагчид дахин хэлэлцүүлэг явагдах тул саналаа хэлж амжаагүй оролцогчид дараагийн хэлэлцүүлгүүд дээр саналаа хэлэх боломжтойгоос гадна холбогдож, саналаа хэлэх цахим шууданг оролцогчдод танилцуулсан. Мөн хуулийн төсөл бүрэн гүйцэд бэлэн болоогүй, цаашид хэлэлцүүлэг явагдана гэсэн шалтгаанаар хуулийн төслийг оролцогчдод хэлэлцүүлгийн өмнө болон хэлэлцүүлгийн үеэр тараагаагүй.

Хэлэлцүүлгийн явцаас дүгнэвэл, уг хэлэлцүүлэг нь хуулийн төслийн гол үзэл санааг иргэдэд танилцуулахад чиглэгдсэн үр дүнтэй ажил болсон гэж үзэж болохоор байна. Хуулийн төслийн хэлэлцүүлэг дахин явагдах бөгөөд оролцогчид саналаа цахим шуудангаар илэрхийлэх боломжтой тул хуулийн төслийг оролцогчдод танилцуулаагүй, бүх саналыг сонсоогүй нь төдийлөн оролцоог хязгаарласан гэж үзэх үндэслэл болохгүй байна. Хэдий тийм боловч хуулийн төслийн хэлэлцүүлгийн зар нь олон нийтэд нээлттэй тавигдаагүй байгаа болон оролцогчдын ихэнх хэсгийг дүүрэг, хорооны ажилтнууд эзэлж байснаас харахад иргэдэд нээлттэй оролцох боломжийг хязгаарласан гэж үзэхээр байна. Мөн хэлэлцүүлгийн явцаас ажиглахад хэлэлцүүлгийн үеэр оролцогчид хуулийн төсөлд төдийлөн ач холбогдолгүй санал гаргах явдал гарч байсан. Санал гаргахыг хүссэн оролцогч бүр саналаа хэлвэл хэлэлцүүлэг удаан үргэлжлэх шинжтэй байсан. Үүнээс харахад хэлэлцүүлгийн хэлбэрээр иргэдийн оролцоог хангах нь цаг хугацаа их шаардахаас гадна үр дүн багатай байх магадлалтай тул зарим тохиолдолд иргэдийн саналыг шуудан, цахим шуудангаар авах нь илүү үр дүнтэй байж болох талтай.

### 3.7. Хууль санаачлагчдаас авсан асуулгын дүн

НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газарт хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд

манай байгууллага “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийг судалж” байгаатай холбогдуулан хууль санаачлах эрхтэй \хуулийн төсөл боловсруулдаг\ Ерөнхийлөгчийн Тамгын газар ,Улсын Их Хурлын 76 гишүүн, 13 Яамд \нийт 91 этгээд\ руу анкетийн судалгааг УИХ-ын Тамгын газрын даргын гарын үсэг бүхий албан бичиг хүргүүлснээс  Улсын Их Хурлын 13 гишүүн, 9 Яамдаас хариу ирсэн юм.

Судалгаанд оролцсон 22 хууль санаачлагчдын 1 /Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам/-ний санаачилж буй хуулийн төсөл нь боловсруулалтын анхан шатандаа яваа тул ямар нэгэн хэлэлцүүлгийн ажил зохион байгуулж эхлээгүй байгаа. Бусад 21 хууль санаачлагч \хуулийн төсөл боловсруулагч\-даас 78 \69 нь хуулийн төсөл, 9 нь батлагдсан хууль\ хуулийн төслийн талаарх мэдээлэл ирүүлсэн бөгөөд үүнээс 9 хууль батлагдсан, 25 хуулийн төсөл нь боловсруулалтын шатанд байгаа, 42 хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн, хэлэлцүүлэх шатанд байгаа, 2 хуулийн төсөл нь аль шатанд байгаа нь тодорхойгүй байлаа.

Судалгаанд хамрагдсан хуулийн төслөөс  33 төслийг 1-10 удаа, 9  төслийг 10-20 удаа, 4 төслийг 20-оос дээш удаа хэлэлцүүлж, уулзалт зохион байгуулсан бол 12 төслийг олон нийтээр хэлэлцүүлээгүй бөгөөд 7 хуулийг хэлэлцүүлсэн эсэх нь хариултаас тодорхойгүй байна. Уулзалт, хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн хувьд шүүгч, өмгөөлөгч, хуульч, эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүд, ажил мэргэжил, салбарын хүрээнд хэлэлцүүлсэн байдаг бол Яамдын санаачилсан хуулийн төслийг эрх ашиг нь хөндөгдөх болон тухайн хуулийг хэрэгжүүлэх этгээдүүд, ажил мэргэжлийн хүрээнд, төрийн бус байгууллага, тухайн иргэний хөдөлгөөний төлөөлөл болон орон даяар хэлэлцүүлжээ. Судалгаанаас үзвэл Яамдын санаачилсан хуулийн төслүүдийн олонхийг орон даяар хэлэлцүүлсэн байгаа нь харьяа байгууллага, зохион байгуулалтын бүтцийн давуу талыг харуулж байна.  Улсын Их Хурлын гишүүд нь орон нутагт ажиллах үеэрээ санаачилж буй хуулийн төслөө хэлэлцүүлж, танилцуулдгаас гадна Н.Энхболд \Хоршооны тухай, МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай CHF Канадын хоршоодын холбоо, УИХ гишүүний зардлаар, 1636 хүн\, Н.Батбаяр \Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төслийг НҮБ-ийн санхүүжилтээр 100 000 хүн\, Ж.Батсуурь \Газрын тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг тойрогт ажиллах явцдаа 3240 хүн\ нар нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан болон, малчдаар хэлэлцүүлсэн байна.

19 хуулийн төслийн хэлэлцүүлэгт 1-100 иргэн, албан байгууллага, 14 хуулийн төсөлд 100-500 иргэн, байгууллага, 6 хуулийн төсөлд 500-1000 иргэн байгууллага, 15 хуулийн төслийн хэлэлцүүлэгт 1000-аас дээш иргэн байгууллага оролцсон байх бөгөөд 8 хуулийн төсөлд хэдэн хүн оролцсон нь тодорхойгүй, 2 хуулийн төсөл хэлэлцүүлгээ хараахан зохион байгуулаагүй байгаа, харин Сангийн яам Улсын төсөвтэй холбоотой  8 хуулийн төслийг нийт хүн амаар хэлэлцүүлсэн  гэж хариулжээ.

Давхардсан тоогоор 29 хуулийн төслийг цахим хуудсан дээр байрлуулан, 15 хуулийн төслийг цахим шуудангаар, 11 хуулийн төслийг албан бичгээр хүргүүлэн танилцуулснаас зөвхөн 4 хуулийн төслийг хэлэлцүүлэг болохоос 3-10 хоногийн өмнө хүргүүлсэн талаар дурдаж, бусад хуулийн төслийг хэдий

хугацааны өмнө хүргүүлсэн талаар хариулт өгөөгүй байгаа нь оролцогчид саналаа урьчдилан бэлтгэх боломж хангалттай биш байдаг гэсэн дүгнэлтэд хүргэхээр байна.

Хууль санаачлагчид хуулийн төслийн хэлэлцүүлгээ олон төрлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдгаас 9 хууль санаачлагч Төрийн байгууллагуудтай, 7 хууль санаачлагч орон нутгийн ЗДТГ болон орон нутгийн бусад байгууллагуудтай, 6 хууль санаачлагч олон улсын байгууллагатай, 1 хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүний ажлын албаараа, 7 хууль санаачлагч төрийн бус байгууллагатай, 4 хууль санаачлагч Иргэний танхим, Нээлттэй нийгэм форумтай, 1 хууль санаачлагч салбарын байгууллага, 3 хууль санаачлагч төслийн багтай хамтран ажилласан бөгөөд, 1 хууль санаачлагч өөрөө хэлэлцүүлгээ зохион байгуулсан байна.

Улсын Их Хурлын гишүүдийн хувьд хэлэлцүүлэг зохион байгуулахад хөрөнгө санхүүгийн асуудал маш хүнд байдаг талаар дурдсан ба судалгаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдээс 6 гишүүн хувиасаа болон гишүүний батлагдсан төсвөөс, 5 гишүүн олон улсын байгууллагын санхүүжилтээр, 1 гишүүн тойрогт ажиллах боломжоо ашигласан бол 2 гишүүн ямар нэгэн зардал гаргалгүйгээр хэлэлцүүлжээ. Яамдын хувьд 5 Яам НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн сан, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, USAID, Германы ОУХАН зэрэг олон улсын байгууллагаас санхүүжсэн байдаг бол Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Хууль зүйн яам төсвөөс санхүүжиж, Батлан хамгаалах яам хөрөнгө төсөвлөөгүй байна.

Судалгаанд хамрагдсан нийт 78 хуулийн төслийн 28 хуулийн төсөлд 2868 иргэн, албан байгууллагаас 4539 санал иржээ. 9 хуулийн төсөлд 10695 санал ирсэн гэж хариулсан боловч хэдэн иргэн, албан байгууллагаас ирсэн нь тодорхойгүй, 3 хуулийн төсөлд 2409 иргэн, албан байгууллага санал өгсөн гэж хариулсан боловч хэдэн санал ирсэн нь мөн тодорхойгүй байсан бөгөөд 34 хуулийн төсөлд хэдэн иргэн, албан байгууллагаас хэдэн санал ирсэн талаар хариулаагүй байлаа.

Олон нийтээс гарсан саналын 0%-50%-ийг 10 хуулийн төсөлд, саналын 50-100%-ийг 16 хуулийн төсөлд тус тус тусгасан гэж хариулсан бол бусад хуулийн төслийн хувьд саналын хэдэн хувийг хуулийн төсөлд тусгасан талаар хариулаагүй болно.

Хууль санаачлагчид хуулийн төсөлд санал гаргасан хүнд тухайн саналыг тусгасан эсэх талаарх хариу өгсөн эсэх гэсэн асуултанд 15 төслийн хувьд хууль санаачлагч хэлэлцүүлгийн үеэр шууд хариу өгсөн, 9 төслийн хувьд хууль санаачлагч цахим шуудангаар хариу өгсөн, 3 төслийн хувьд хууль санаачлагч албан бичгээр хариу тайлбар явуулсан, 3 төслийн хувьд хууль санаачлагч /Л.Эрдэнэчимэг, Н.Батбаяр, С.Бямбацогт гишүүн/ хариу өгөөгүй байна.

Судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдын санаачилсан хуулийн төслүүдийн хувьд 40 хуулийн төслийг цахим хуудсан дээр байршуулсан гэж хариулсан бол 33 хуулийн төслийг байршуулаагүй гэж хариулсан байна. Мөн 3 хуулийн төсөл боловсруулагдаж байгаа бөгөөд цахим хуудсанд хараахан байршуулаагүй байгаа, 1 хууль санаачлагч "хуулийн төслийг УИХ ТГ цахим хуудастай холбоотой асуудлыг хариуцдаг тул хариулах боломжгүй" гэсэн хариу

өгсөн бол, 1 Улсын Их Хурлын гишүүн өөрийн твиттер хуудсанд байршуулсан байна. Иргэдийн дунд явуулсан анкетын асуулгаар тэд цахим хуудсаар мэдээлэл авч, санал өгөхийг дэмжсэн \57хувь\ байхад судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдын зүгээс боловсруулсан хуулийн төслийнхөө 72 хувийг цахим хуудсандаа байршуулсан гэж хариулсан боловч 2014 оны 12-р сарын 3-ны өдрийн цахим хуудсанд хийсэн ажиглалтаар 8 хувь нь л цахим хуудсандаа байршуулсан байгаа нь хангалтгүй мэт харагдаж байна. Дээрх ажиглалтаар нийт 76 гишүүдийн 46 буюу 60,5 хувь нь хуулийн төсөл болон түүний талаарх мэдээллийг байршуулаагүй байсан. Улсын их хурлын гишүүдээс зөвхөн С.Ганбаатар гишүүн буюу 1,3 хувь нь хуулийн төслөө цахим хуудсандаа байршуулсан байсан ба 29 буюу 38,2 хувь нь зөвхөн хуулийн төслийг санаачилсан талаарх мэдээллийг байршуулсан байлаа. 13 Яамдаас 6 буюу 46,1 хувь нь хуулийн төслөө цахим хуудсандаа байршуулаагүй байна. Цахим хуудсанд хуулийн төсөл, үзэл баримтлал, бусад хуульд оруулах өөрчлөлт, судалгааны дүнг байршуулах нь олон нийтийг мэдээллээр бүрэн, тэгш хангах хамгийн зардал багатай арга болохыг хууль санаачлагчид анхаарах нь зүйтэй юм.

Цахим хэлэлцүүлэгт зориулж тавигдсан мэдээллүүдийг тухайн веб дээр архивлан хадгалдаг уу гэсэн асуултанд 19 хуулийн төслийг архивласан, 50 хуулийн төслийг архивлаагүй, 7 хуулийн төслийг архивласан эсэх талаар хариулаагүй байна. Тухайн хуулийн төсөлд санал өгсөн иргэн, хуулийн этгээд уг санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх, тусгагдаагүй бол яагаад гэсэн хариулт авч байх нь хуулийн төсөл боловсруулах, батлах явцад иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тухайн харилцааг хууль зүйн үүднээс зөв ойлгож, дүгнэх боломж олгохоос гадна тухайн хууль батлагдсаны дараа хуулийг тайлбарлах, хэрэглэх, нэг мөр ойлгох практик болон судалгааны ач холбогдолтой тул хуулийн төсөл, түүнд олон нийтээс өгсөн санал, саналыг тусгасан эсэх, тусгаагүй шалтгаан зэрэг мэдээллийг харьцангуй удаан хугацаагаар архивлан тухайн цахим хуудсанд хадгалах зөвлөмжийг манай багийн зүгээс өгч байна.

Цахим хэлэлцүүлгийн үеэр 16 хуулийн төсөлд иргэд, албан байгууллагуудаас 191 санал ирсэн, 41 хуулийн төсөлд санал ирээгүй бөгөөд үүнд цахим хуудсанд байршуулаагүйгээс уг асуултанд хариулаагүй байж болох талтай байна. 13 хуулийн төсөлд санал өгсөн эсэх нь тодорхойгүй байна. Ирүүлсэн саналд 6 хууль санаачлагч товъёог боловсруулсан, 9 хууль санаачлагч товъёог болосвруулж, дүн шинжилгээ хийгээгүй байна. Санал гаргасан этгээдэд 5 хууль санаачлагч хариу мэдэгдсэн бол 11 хууль санаачлагч хариу мэдэгдээгүй байна. Ирүүлсэн саналд товъёог боловсруулах, санал гаргасан этгээдэд хариу мэдэгдсэн эхэс гэсэн асуултад 7 хууль санаачлагч илэрхий буруу хариулсан байна. Жишээ нь, цахим хэлбэрээр санал ирээгүй гэж хариулсан боловч, саналын товъёог боловсруулж, санал өгсөн этгээдэд хариу мэдэгдсэн гм илтэд буруу хариулсан.

38 хуулийн төслөөр Орон нутагт санал авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд бусад хуулийн төслөөр орон нутагт санал авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Хэдийгээр хүн амын тал шахам хувь нь Улаанбаатарт амьдардаг тул хэлэлцүүлэг, хуулийн төсөлд санал авах ажиллагааг нийслэлд зохион байгуулснаар хүн амын төдийчинээ хувийг төлөөлнө гэж тооцож болох боловч ихэнх хуулийн зохицуулалт төв суурин

газарт тохиромжтой байдлаар бичигддэг, эсхүл суурин иргэншилтэй улс орны хуулиудыг жишиг болгон хуулийн төсөл боловсруулдаг гэх шүүмжлэл дагуулсаар байгааг энэхүү судалгаа зарим талаар харуулж байна. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, нүүдлийн соёл иргэншилтэй манай орны хувьд тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлогоос шалтгаалан ямар хүрээг хамруулан иргэд, олон нийтийн оролцоог хангах вэ, аль хуулийн төслийг заавал хөдөө орон нутгийн иргэдийн оролцоог хангах вэ гэдгийг шийдвэрлэх уян хатан зохицуулалт хэрэгтэй байна гэж манай судалгааны баг үзсэн болно.

Хуулийн төслийг боловсронгуй болгоход эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг 49 хуулийн төсөлд оролцуулж, санал авсан ба 24 хуулийн төсөлд эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг оролцуулж тэдний саналыг сонсоогүй байна.

Судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдаас хуулийн төслийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад гардаг хүндрэл, бэрхшээл, ололттой талуудыг дурдахыг хүсэхэд хөрөнгө санхүү дутагдалтай, хэлэлцүүлэгт оролцогчдод хуулийн төслийг олон хоногийн өмнө хүргүүлдэг боловч хуулийн төсөлтэй сайн танилцаагүй байдаг, санал гэхээсээ илүү өөрсдийн асуудлыг ярьдаг, санал авахаар хүргүүлсэн хариуг удаадаг, шинэ нэр томъёо, шинэ зохицуулалтыг хүлээж авахдаа удаан байдаг зэрэг бэрхшээлийг нэрлэсэн байна. Энэ нь иргэдийн эрх зүйн боловсрол хангалтгүй, хуулийн төсөлд санал өгч тусгуулах нь өөрт тохиолддог асуудлыг шийдвэрлэх, зохицуулах чухал арга зам гэдгийг бүрэн ухамсарлахгүй байгаа, өөрөөр хэлбэл иргэдийн оролцооны соёл, ардчиллын ойлголт хангалттай төлөвшөөгүй байгааг харуулж байна. Ихэнх иргэд энэ бол төрийн л ажил гэх хандлагатай байгаа нь оролцооны ардчиллын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, оролцож байж үр дүнг нь мэдэрдэг практикруу иргэдийг түлхэх явдал чухал болохыг харуулж байна. Нөгөөтэйгүүр иргэдийн оролцоог бүрэн утгаар нь хэрэгжүүлэх нь хууль санаачлагчид, төр засгийн өндөр албан тушаалтнууд иргэд, олон нийтийн санаа бодлыг судлахгүйгээр өөрсдийн хүссэн хуулиа баталдаг, олигарх бүлгээ дэмжсэн хууль гаргадаг гэсэн шүүмжлэлээс салах арга зам юм.

Хууль санаачлагчдаас цахим хэлэлцүүлгээс бусад хэлбэрээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, ялангуяа хөдөө орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулахад зардал, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр үр дүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авахад бэрхшээлтэй байдаг ба тухайн хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор олон улсын эсхүл гадаад улсын хөгжлийн байгууллагын дэмжлэг байхгүй тохиолдолд хэлэлцүүлгийн зардал, хөрөнгийг төсөвт тусгадаг байх шаардлагатай байна, мөн хуулийн төслийг боловсруулж түүнд олон нийтийн саналыг бүх түвшинд тусгаж байхын тулд нэг төсөлд шаардагдах жишиг зардлыг гаргаж хэрэгжилтэд хяналт тавих зэрэг хөрөнгө, санхүүтэй холбоотой саналуудыг өгсөн байлаа.

### 3.8. Төрийн бус байгууллагаас авсан анкетын судалгаа

НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газарт хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд манай байгууллага “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд,

байгууллага, олон нийтийн санал авах практикийг судалж” байгаатай холбогдуулан цахим шуудангаар уул уурхай, нийгмийн хамгаалал, бизнес, байгаль орчин, авто зам, хүний эрх зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 67 төрийн бус байгууллагатай утсаар холбогдсоноос судалгаанд хамрагдахаар зөвшөөрсөн 30-аад Төрийн бус байгууллагад товч судалгааны анкетыг хүргүүлсэн юм. Товч судалгааны анкетыг хүргүүлсэн Төрийн бус байгууллагуудаас өнөөдрийн буюу 2014 оны 12-р сарын 1-ний өдрийн байдлаар нийтдээ 11 Төрийн бус байгууллагаас хариу ирлээ.

Бид Монголын өмгөөлөгчдийн холбооны бүх өмгөөлөгч нарт мэдээлэл хүргэдэг мэйл лист болон Ардчиллын боловсрол төвийн бүх төрийн бус байгууллагад мэдээлэл хүргэдэг цахим сүлжээгээр тус бүр 2 удаа ТББ-аас авах асуулгыг илгээсэн хэдий ч асуулгад туйлын хангалтгүй оролцсон болно. Зүй нь иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, тодорхой бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах, тухайн чиглэлээрээ төрийн бодлогод нөлөөлөх гол зорилго, чиг үүрэгтэй ТББ-ууд хуулийн төсөл боловсруулахад хэрхэн оролцож буй талаараа 10-хан минутын асуулгад хариулахгүй байгаа нь бидний гайхшралыг төрүүлсэн. ТББ үүсэж хөгжсөн эхний үе шатанд аль нэг хөгжлийн байгууллгын санхүүжилтээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байсан үе ард хоцорч, Монгол хүний дундаж орлого нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүн өсч байгаатай холбогдон хөгжлийн зээл тусламж авах явдал буурсныг даган ТББ-ууд идэвхгүй байдалд орсон уу гэсэн асуулт тавигдахад хүргэж байна. Олон нийтийн оролцоог хамгийн хүчтэй төлөөлж чадах ТББ-ууд  хуулийн төсөл боловсруулахад  оролцохгүй болох нь ардчиллыг бэхжүүлэх, олон нийтийн хүсэл зориг шингэсэн хуулиуд батлагдах үйл явцад тулгарах том бэрхшээл болно. Гэвч бидний сонгож судалсан хуулийн төслүүдэд төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцож, саналаа өгч, ажлын хэсэгт ажилладаг болох нь нотлогдсон. Иймд нэг хэсэг бороothe дараах мөөг шиг олширсон төрийн бус байгууллагуудаас хөгжлийн явцад шалгарч, амьдрах чадвартайгаа нотолсон хүчирхэг ТББ-ууд бэхжиж байгааг харуулах үзүүлэлт ч байж болох талтай. Ямартай ч ТББ-ын оролцоогүйгээр хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж, тэдний хүсэл зориг шингэсэн хууль батлагдах боломж бага гэдгийг хэн ч  үгүйсгэхгүй.

Дээрх 11 ТББ-ууд нь хууль зүйн, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгаалал, авто зам, хүний эрх болон банк, бизнесийн салбарт 1-24 жил үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байсан юм.

Анкет бөглөсөн ТББ-ын 8 байгууллагын төлөөлөл төрийн аль нэг байгууллагын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан байна.

Нийт 9 ТББ-ын 3 болон түүнээс дээш удаа хуулийн төсөлд санал өгч байсан болон 1 нь үгүй гэж хариулан, нөгөө 1 ТББ нь хариулаагүй байна.

Тухайн хуулийн төсөлд санал авч бус тухай мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор 9 байгууллагын төлөөлөл утас болон бусад аргаар хүсэлт ирүүлснээр, 1 байгууллага Иргэний нийгэм форумаас, 1 байгууллага ДЕМО, МБОИЗ, “ТАН” эвсэл, Нээлттэй нийгэм форумаас, дээр дурдсан утас болон бусад аргаар хүсэлт ирүүлснээр мэдээллийг авсан 1 ТББ-ын төлөөлөл мөн өөр бусад цахим хуудаснаас мэдээлэл авч байжээ.

Хуулийн төсөлд ямар хэлбэрээр саналаа өгсөн бэ гэсэн асуултанд 9 ТББ хэлэлцүүлэгт оролцон саналаа өгч, давхардсан тоогоор 5 нь бичгээр, 2 нь амаар, 3 нь и-мейлээр өгч байсан байна.

Сүүлийн 1 жилийн хугацаанд танай байгууллагын төлөөлөл аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон уу гэсэн асуултанд 9 ТББ 3 болон түүнээс дээш удаа, 1 нь 2 удаа аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан /1 ТББ хэдэн удаа хэлэлцүүлэгт оролцож байснаа тэмдэглээгүй болно/ гэж хариулсан.

Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна гэсэн асуултанд 6 ТББ тухайн хэлэлцүүлгийг боломжийн үр дүнтэй болсон гэж үзсэн бол 5 нь уг хэлэлцүүлгийг хангалтгүй болсон гэж үзжээ. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг хангалтгүй гэж үзсэн ТББ-ын дурдсан шалтгаануудын хувьд 1 ТББ-ын саналыг сонсоогүй, 4 ТББ-ын саналыг төвөгшөөн, ойшоодоггүй бөгөөд хэлэлцүүлэг гэж зүгээр л нэр хааж, ээлж өнгөрөөсөн арга хэмжээ болсон гэж хариулсан.

Танай байгууллагын өгсөн санал хуулийн төсөлд хир тусгагдсан бэ гэсэн асуултанд 1 ТББ-ын хувьд хангалттай, 6 ТББ-ын хувьд зарим нь тусгагдсан гэж үзсэн байдаг бол, 1 ТББ-ын саналыг тусгаагүй, 3 ТББ-ын төлөөллийн хувьд энэ талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй гэж хариулсан байна.

Тухайн өгсөн санал нь хуулийн төсөлд тусгагдсан эсэх талаар 9 байгууллагад хариу өгөөгүй, 1 ТББ-д и-мейлээр хариу өгсөн бөгөөд 1 ТББ-ын энэ асуултыг дугуйлаагүй байна.

Санал өгсөн иргэн, байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал дэмжих үү, энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ гэсэн асуултанд 7 төрийн бус байгууллагын төлөөлөл цахим хуудсандаа тавих болон цахим хаягаар илгээх аргыг дэмжсэн бол 2 нь албан бичгээр хариу өгөх нь зүйтэй байна гэж хариулан 2 нь асуултанд хариулаагүй юм.

Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах ямар арга хэлбэр илүү тохиромжтой гэж буй талаар саналыг асуухад 1 ТББ төрөл бүрийн аргаар, 2 ТББ хэвлэл мэдээллийн аргаар, 3 ТББ цахим хуудсаар, 2 ТББ тухайн хуулиар зохицуулагдаж байгаа харилцаанд эрх, ашиг, оролцоо нь хөндөгдөж байгаа байгууллагаас заавал санал авдаг байх, салбар, мэргэжлийн хүмүүсийн дунд хэлэлцүүлэг хийх аргаар иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах, 1 ТББ хуулийн төслийг маш давчуу хугацаанд боловсруулдаг гэж үзсэн бол өөр 1 ТББ хуулийн төсөл боловсруулахдаа мэргэжлийн бүлгүүдийн хэлэлцүүлэг, эрдэмтдийн бүлгийн хэлэлцүүлэгт гол ач холбогдлоо өгөх, мөн судалгааг нарийвчлан хийж, үндэслэлийг гаргаж тайлбарласан тайлбараа олон нийтэд хүртээж болох бүх хэлбэрээр хүртээх, тухайн хууль нь ямар харилцааг зохицуулах талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулах замаар зохион байгуулах, 1 ТББ хуулийн хэлэлцүүлэгт оролцож байсан Иргэний нийгмийн байгууллагуудаар санал авахуулж тусгах зэргээр хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах нь тохиромжтой гэж үзжээ.

Хуулийн төслийг вебд тавьж олон нийтээс санал авах хугацаа хэд хоног байвал зохимжтой талаар асуухад 1 төрийн бус байгууллага 10 хоног, 5 нь 30 хоног, 3 нь 60 хоног, 1 нь 90 хоног цахим хуудсанд тавьж олон нийтээс санал авах нь зохимжтой гэж үзсэн байна. 1 ТББ дээрх асуултад хариулаагүй байсан юм.

Бидний хийж байгаа судалгааны нэг хэсэг болох сонгогдсон хуулийн төсөл, хуулиудыг боловсруулах явцад хэрхэн олон нийтийн оролцоог хангасанг судлах ажил байлаа. Энэхүү хэсгийн хүрээнд бид сонгогдсон дараах хууль, хуулийн төслүүдэд судалгаанд оролцсон төрийн бус байгууллагууд саналаа өгч, хэлэлцүүлэгт оролцсон эсэх талаар асуулга явуулсан юм:

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд 3 төрийн бус байгууллагын төлөөлөл саналаа өгч байсан ба 1 ТББ саналаа бичгээр өгөн, түүний өгсөн саналын зарим нь хуулийн төсөлд тусгагдсан байна. 1 ТББ хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон байсан ба түүний санал хуулийн төсөлд тусгагдсан талаар ямар нэгэн мэдээлэлгүй байгаа бол 1 ТББ дээрх хуулийн төсөлд саналаа өгч байсан боловч ямар байдлаар гэдгээ дурдаагүй байсан юм.
- Зөрчлийн тухай хуулийн төсөлд 2 ТББ саналаа өгч байснаас 1 ТББ хэлэлцүүлэгт оролцон амаар саналаа өгсөн ба түүний саналыг одоогоор хэлэлцэгдэж байгаа юм байна. 1 ТББ дээрх хуулийн төсөлд саналаа өгч байсан боловч ямар байдлаар гэдгээ дурдаагүй байсан юм.
- Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд 3 ТББ саналаа өгөн, 1 ТББ хуулийн төслийн ажлын хэсэгт ажилласан ба 2 ТББ хэлэлцүүлэгт оролцсон боловч 1 ТББ-ын саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар бөглөөгүй байсан бол нөгөө 1 ТББ-ын саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байгаа.
- Гэр бүлийн тухай хуулийн төсөлд 3 ТББ саналаа өгснөөс 2 ТББ төлөөлөл хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон боловч 1 ТББ-ын саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар бөглөөгүй байсан бол нөгөө 1 ТББ-ын саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байна
- Тамхины хяналтын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 2 ТББ саналаа өгснөөс 2 ТББ хэлэлцүүлэгт оролцон, 1 ТББ амаар болон бичгээр саналаа өгч, 1 байгууллагын төлөөллын өгсөн зарим саналыг тусган, нөгөө байгууллагын төлөөллийн саналыг хангалттай тусгасан байна
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд судалгаанд оролцсон төрийн бус байгууллагуудаас ямар нэгэн байдлаар санал өгөөгүй байна.

Дээрх судалгаанаас үзэхэд хуулийн төслийг боловсруулж байгаа талаар төрийн бус байгууллагуудад утас болон бусад аргаар хүсэлт ирүүлдэг байна. Үүнээс үзэхэд олон нийт гэхээсээ илүү зөвхөн тухайн хүрээний эсхүл байнга харилцдаг төрийн бус байгууллагуудад хуулийн төсөл боловсруулагдаж байгаа мэдээлэл хүрдэг, нөгөөтэйгүүр тухайн байгууллагууд хэвлэл, мэдээлэл, цахим хаягаар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа талаарх мэдээлллийг авдаггүй болох нь харагдаж байгаа юм. Хуулийн төслийг боловсруулсан байгууллага

санал өгсөн төрийн бус байгууллагуудад тэдний саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн хариу ирүүлдэггүй талаар дурджээ. Төрийн бус байгууллагуудын хувьд хуулийн төсөл боловсруулах явцад тухайн салбарын мэргэжилтэн, үйл ажиллагаа явуулж буй олон албан байгууллагуудыг маш дутмаг оролцуулдаг, мөн хуулийн сурталчилгаа муу байдаг талаар нэмэлт саналын хэсэгт бичсэн байсан. Энэ нь хуулийн төслийн сурталчилгаа, олон нийтэд хүрэх асуудал дутмаг, иргэд, байгууллага тэр бүр ямар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа талаар мэдээлэлгүй байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа.

Хуулийн төсөлд өгсөн саналыг тусгасан эсэх талаар төрийн бус байгууллагуудад цахим хэлбэрээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгвөл зохистой байна гэж үзсэн нь техник, технологи өндөр хөгжсөн орчин үед иргэн, байгууллага бүр цахим хэлбэрээр хуулийн төсөлтэй танилцаж, санал өгөх нь тэдэнд амар, цаг хэмнэдэг болох нь ажиглагдаж байна. Мөн цахимаар олон нийтээс санал авах хугацааг 30 хоног байх нь зүйтэй байна гэж судалгаанд оролцсон дийлэнх төрийн бус байгууллагууд үзсэн юм.

### 3.9. Иргэдээс авсан анкетын судалгаа

Хуулийн төсөл боловсруулахад иргэд хэрхэн оролцож буй талаар Улаанбаатар хотын төвийн дүүргийн 359 иргэдээс урьдчилан бэлтгэсэн асуулгаар асуулга бөглүүлж, анкетийн судалгаа хийж нэгтгэв. Энэхүү судалгааны мэдээлэл цуглуулахад туслалцаа үзүүлсэн ТИС-ийн оюутан Д.Мяасүрэн, О.Мөнхбат нарт талархал илэрхийлж байна. Ажлын даалгаварт тусгагдаагүй боловч иргэдийн оролцоог өөрсдөөс нь асууж дүгнэх зорилгоор, судалгааны хүрээ өргөн, гүйцэтгэх хугацаа давчуу байсны улмаас орон нутгийг хамруулж чадаагүй бөгөөд зохих хэмжээний төлөөллийг бүрэн хангасан гэх боломжгүй ч тодорхой дүр зураг гаргах боломжтой гэж үзлээ.

Хуулийн төсөл боловсруулахад иргэд хэрхэн оролцож буй талаар Улаанбаатар хотын төвийн дүүргийн 359 иргэдээс урьдчилан бэлтгэсэн асуулгаар асуулга бөглүүлж, анкетийн судалгаа хийж нэгтгэв. Асуулгын анкетыг Хангарьд ордон, Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын нэг цэгийн үйлчилгээг хүртэж буй иргэд, Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэгчид, МУИС-ийн зарим багш нар, Монголын иргэний агаарын тээврийн ерөнхий газрын ажилтнууд зэрэг төрийн үйлчилгээг хүртэж буй, эсхүл тодорхой ажил эрхэлж буй иргэдээр бөглүүлж авсан болно. Судалгаанд бүх насны ангиллын хүмүүс жигд хамрагдсан байна. Мөн ажил эрхлэлтийн янз бүрийн төлөөллийн хүмүүс уг судалгаанд хамрагдсан болно.

Та аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу гэсэн асуултанд хариулт өгсөн 359 иргэний 244 буюу 64% нь үгүй, 60 буюу 16% нь 1 удаа, 25 буюу 7% нь 2 удаа, 22 буюу 6% нь 3 болон түүнээс дээш удаа санал өгсөн бол 8 буюу 2% нь хариулаагүй байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 272 хүн саналаа өгсөн хуулийн нэрийг бичээгүй нь тэдгээр хүмүүс хуулийн төсөлд санал өгч байгаагүй гэж үзэж болох талтай. Харин хуулийн төсөлд саналаа өгч байсан хүмүүс нийтдээ 32 хуулийн төслийг нэрлэж, давхардсан тоогоор 108 хүн санал өгсөн гэж хариулж

байгаа нь судалгааг цаашид үргэлжлүүлж тэдний санал хуулийн төсөлд хэрхэн туссан талаар дүгнэх боломж байна гэсэн итгэл төрүүлсэн юм.

Хуулийн төслийн талаарх мэдээллийг ихэнх тохиолдолд иргэд хэвлэл мэдээллээс авч байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь тухайн хуулийн төслийг боловсруулж байгаа болон бусад байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авч байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас нь мэдээллийг олон нийтэд хүргэх гол суваг болохыг тодотгож байна. Судалгаанд оролцогчдын 20 хувь нь цахим хуудас, интернетээр мэдээлэл авч буйг хангалттай өндөр гэж үзэхгүй байгаа ч хөдөө орон нутгийн иргэдийн цахимаар мэдэээл хүлээн авах техник, технологи /гар утас, PC, интернет/-ийн нөхцөл бүрдээд байгаа орчин үед хууль тогтоомжийн төслийг олон нийтэд танилцуулж, санал авах “Монголчуултайгаа зөвлөлдөх нь” нэгдсэн цахим хуудас ажиллуулах талаар хуулийн төсөлд бидний өгч буй зөвлөмж үндэслэлтэйг давхар харуулж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон болон ямар нэг хэлбэрээр хуулийн төсөлд саналаа өгсөн хүн судалгаанд оролцогчдын гуравны нэг орчмыг эзэлж байгаа нь хуулийн төсөлд санал өгөх иргэдийн идэвх багагүй болохыг нотолж байна. Хуулийн төсөлд саналаа өгөх хэлбэрийн хувьд хэлэлцүүлэгт оролцох хэлбэрийг дэмжиж буй иргэдийн эзлэх хувь өндөр байгаа ч и-мэйл, мессэж зэрэг мэдээллийн технологи ашигласан тохиолдол судалгаанд оролцогчдын 15 хувийг эзэлж байгаа нь монголчууд энэхүү хэлбэрийг ашиглах боломж харьцангуй өргөн, цаашид ирээдүйтэй буйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 14 хувь нь хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон гэж хариулж байгаа нь иргэдийн оролцох эрмэлзлэл, идэвх байна гэдгийг нотолсон бөгөөд чамлахаар үзүүлэлт биш юм. Энэ нь нөгөөтэйгүүр хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах нь зохистой хэлбэрийн нэг гэдгийг нотолсоор байна.

Хэлэлцүүлэг хийсэн нийтдээ 24 хуулийн нэр дурдагдсанаас давхардсан тоогоор 52 иргэн хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон гэж хариулж байгаа нь хэлэлцүүлэгт оролцох иргэдийн идэвх сонирхол муу биш болохыг дахин харуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үр дүнг хангалттай буюу боломжийн гэж оролцогчдын 31 хувь нь үзэж, харин 15 хувь нь хангалтгүй гэж үзэж байна.

Хэлэлцүүлгийн үр дүн яагаад хангалтгүй болдог шалтгааныг тодруулахад санал хэлэх боломж олгоогүй, миний саналыг сонсоогүй гэсэн хариулт давамгайлж, хуулийн төсөл боловсруулагчид өөрсдийн эрх ашгийг боддог, хуулийн төсөлтэй урьдчилан танилцах боломжоор хангадаггүй, иргэдийн оролцоо бага, танхим дүүргэлт муу, цөөхөн хүнтэй хэлэлцүүлэг болдог гэсэн шүүмжлэлийг илэрхийлсэн нь ихэнх улс орнуудад оролцоог хангах чиглэлээр тулгардаг бэрхшээл манай орны хувьд ч мөн асуудал хэвээр байгааг нотолж байна.

Судалгаанд хариулсан иргэдийн 26 хувь нь өгсөн саналын зарим нь тусгагдсан буюу хангалттай тусгагдсан гэж үзэж байгааг санал тусгагдаагүй гэсэн 19 хувийн саналтай харьцуулбал иргэдийн санал тусгагддаг гэсэн хариулт давамгайлж,

иргэдээс санал авах, хэлэлцүүлэг явуулах ажил зохих хэмжээгээр үр дүнгээ өгдөг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Түүнчлэн уг асуулгад хариулсан иргэдийн 55 хувь нь санал тусгагдсан эсэх талаар мэдэхгүй, 88 хувь нь санал тусгагдсан эсэх талаар хариу өгөөгүй гэж хариулж байгаа нь Хууль, Улсын их хурлын шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд аль алинд нь хуулийн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн санал нь уг төсөлд тусгагдсан эсэх талаар санал гаргагчид мэдээлдэг, эргэх холбоотой байх талаар төрийн байгууллага буюу хуулийн төсөл боловсруулагчид үүрэг хүлээлгэсэн ямар ч зохицуулалт байхгүй байгаагийн үр дагавар гэж дүгнэж байна.

Хуулийн төсөлд өгсөн саналыг уг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар хариуг 18 иргэн авсны дотор и-мейл, мессеж, цахим хуудсаар 11 хүн хариу авснаас үзвэл мэдээллийн технологи ашиглан хуулийн төслийн талаар гарсан саналыг эргэн мэдээлэх нь тохиромжтой арга байж болохыг харуулж байна.

Санал өгсөн иргэн байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийн тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал Та дэмжих үү гэсэн асуултанд 91 хүн дэмжинэ гэж хариулжээ. Энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ? гэсэн задгай асуултанд 30 хүн хариулсны дотор бараг тэн хагас нь буюу 14 хүн цахим хэлбэрийг дэмжсэн санал бичсэний дотор “Бүх хуулийн төсөл хэлэлцүүлэг тусдаа нэгдсэн цахим хуудастай байвал дээр”, “нэгтгэж тавьбал сайн” гэх зэргээр хариулж байгаа нь хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах нэгдсэн, иргэдэд ойлгомжтой бөгөөд хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар арга хэрэгсэл буюу бүх хууль тогтоомжийн төслийг нэгдсэн цахим хуудсаар орж саналаа өгдөг байхыг иргэд хүсч байгааг харуулж байна.

Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах илүү тохиромжтой арга хэлбэрүүдээр мэдээллийг хүртээмжтэй түгээх, санал авах, санал асуулга явуулах, хэлэлцүүлэг хийх, Иргэдийн төлөөлөгчид, хороо, дүүргээрээ дамжуулах, иргэдийн амьдрал, ажил, орон нутгийн захиргаанаас гадна иргэн бүрт хөрсөн дээр нь буусан бодит үндэслэлтэй уялдуулсан судалгаанд үндэслэдэг байх, хуулийн төсөл боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, иргэдийг оролцуулдаг байх, хууль иргэдэд ойлгомжтой байх, хуулийн сургалт, сурталчилгаа хийх дагнасан суваг, танхимтай байх зэрэг авууштай саналыг дурдсаны дээр мөн л цахим ертөнцөөр саналаа өгч байх боломжийг олонтаа давтсан байгаа нь анхаарал татаж, хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах явдлыг иргэд ихээхэн дэмжиж, хүлээж байгаа болон бидний судалгаанд иргэдийн санал бодлыг илэрхийлж чадахуйц бүлэг оролцсоныг давхар нотолж байна.

Хуулийн төслийг вэб-д тавьж олон нийтээс санал авах тохиромжтой хугацаа 30 хүртэл хоног байхыг оролцогчдын 57 хувь нь дэмжсэн байна.

## 3.10. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

***Олон нийтийн оролцооны талаар Үндсэн хуульд тусгах уу?*** Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд

байна" гэсэн заалт хууль тогтоох ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангаж байгаа Үндсэн хуулийн зарчим болж чадах уу гэсэн асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Манай зарим хууль тогтоогчид олон нийтийн оролцоог хангах асуудлаар тавьсан илтгэлдээ энэхүү заалтыг дурдсан байдаг[144]. Бидний үзэж байгаагаар энэ нь тунхаглалын шинжтэй заалт юм. Иймд тэгрүүлэх эрдэмтэд

Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд хууль боловсруулахад иргэд олон нийтийн оролцоо бодитойгоор хэрэгжих үндсийг илүү тодорхой оруулж өгөх талаар бид зөвлөмжөө өгөх болно.

Иргэдийн оролцоог дэмжиж идэвхжүүлэх нэг механизм бол тэдний саналыг хэрхэн тусгасан талаарх эргэх холбоог бий болгох явдал мөн. Интернетийн тусламжтайгаар цахим нийтийн сонсгол явуулах илүү хялбар механизм бий болгон сурталчлах, нэгдсэн цахим хуудас ажиллуулах шаадлагатай.

***Олон нийтийн оролцоог бодитойгоор дэмжих хууль санаачлагчийн үүрэг.*** Олон тохиолдолд зөвлөлдөөн,  оролцоо байгаа ч иргэдийн[145] саналаа өгсөн төслийн эцсийн хувилбараас тэс өөр хууль Парламентаар батлагдах нь цөөнгүй. Тиймээс хууль санаачилж буй Засгийн Газар, эсхүл Парламентын гишүүд тэдний санаачилсан хууль нь иргэдийн оролцооны үйл явцыг тусгасан байхыг хангах хариуцлага хүлээх ёстой[146]. Оролцоог хангаагүй бол хуулийн төслийг буцаах үндэслэл болохыг хуульчлах шаардлагатай.

***Олон нийтийн оролцоог ямар тохиолдолд ямар хуулиар зохицуулах вэ?*** Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулах асуудлаар бид судалгаа хийж, зөвлөмжөө боловсруулах явцад иргэдийн оролцоог дэмжихэд чиглэсэн хэд хэдэн хуулийн төслийг янз бүрийн хууль санаачлагч санаачлаад байгааг мөн ажигласан.

Энэхүү судалгааны явцад Монгол Улсын Ерөнхийлөгч ***Иргэдийн оролцооны тухай хуулийн төсөл*** боловсруулж хэлэлцүүлж байгааг бид мэдэж,

---

[144] З.Энхболд, Хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцооны тулгамдсан асуудлууд, Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 9-р тал

[145] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн орлцоог хангах нь: Еюропын зарчмууд ба практик асуудлууд, Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 15-р тал

[2] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн орлцоог хангах нь: Еюропын зарчмууд ба практик асуудлууд, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 16-р тал

[3] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн орлцоог хангах нь: Еюропын зарчмууд ба практик асуудлууд, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 20-р тал

[4] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн орлцоог хангах нь: Еюропын зарчмууд ба практик асуудлууд, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 21-р тал

[5] Виктория Млинарчикова, Парламент дахь лоббигийн зохицуулалт, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 92-р тал

[6] Виктория Млинарчикова, Парламент дахь лоббигийн зохицуулалт, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 93-р тал

[7] Виктория Млинарчикова, Парламент дахь лоббигийн зохицуулалт, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 94-95-р тал

[146] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн орлцоог хангах нь: Еюропын зарчмууд ба практик асуудлууд, Хууль болвсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 21-р тал

хэлэлцүүлэгт нь ажиглагчаар оролцсон. Энэ тухай мэдээллийн www.news.mn цахим хуудсанд тавигдсан мэдээллийг дор сийрүүлэв.

Шууд ардчилал хүрээлэн ТББ нь “Иргэний оролцооны тухай хууль”-ийн төсөл дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Нийслэлийн Иргэдийн Оролцооны хэлтэстэй хамтран ажиллаж байна. Уг хууль нь иргэдийг шийдвэр гаргахад оролцуулах, орон нутгийн асуудлаа зохицуулах, төлөвлөлтийн явцад оролцох, иргэдийн эрх ашгийг хохироохгүй байх, санал бодлыг нь сонсох, иргэдийн санал бодлыг ажил хэрэг болгох үүднээс төр засаг, тухайн орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдах ёсны байгууллага болон иргэд, иргэд хоорондын эрх, үүргийн харилцааг зохицуулах зорилготой. Түүнчлэн орон нутгийн төсөв, хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлууд, томоохон төсөл, хөтөлбөр, орон нутгийн чанартай тогтоол, шийдвэр гаргах, тогтоол шийдвэрийн төслийг хэлэлцүүлэх, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, өмчийн эрх ашгийг хөндсөн шийдвэрийг гаргахаас өмнө орон нутгийн урт ба дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө батлах, орон нутгийн хилийн цэс шинээр тогтоох, бусад засаг захиргааны нэгжтэй нэгтгэх, тараах, шинээр байгуулах, Иргэдийн аудит хийх, аудитын шийдвэрийг авч хэлэлцэх, иргэдэд мэдээлэл өгөлгүй гаргасан аливаа тогтоол, шийдвэр, байгуулсан гэрээг цуцлах, залруулах асуудлаар хурал, хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргах, нийтийн сонсгол явуулах, Нийтийн өмгөөллөөр иргэд болон төрийн асуудлыг шийдвэрлэдэг байх зэрэг олон талын харилцааг зохицуулна.

Үүний үр дүнд иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх бодитой хэрэгжсэнээр хяналтгүй *төр хяналттай болж*, мэдээлэлгүй *иргэд мэдээлэлтэй болж*, улс орны хөгжил,*ардчиллын үйл явцад бодитой ахиц*, *зэрэг өөрчлөлт бий болно* гэж үзэж байна.

Одоогийн байдлаар Иргэний оролцооны тухай хуулийн төсөл боловсруулалтын шатандаа явж байна, нийт 11 бүлэгтэй Үүнд:

- иргэний оролцоо
- нийтийн зар мэдээ
- Иргэдийн Нийтийн Хурал
- орон нутгийн үндсэн дүрэм
- нийтийн сонсгол
- санал асуулга
- санал хураалт
- иргэдийн аудит
- нийтийн өмгөөлөл зэрэг бүлгүүд багтсан.

Энэ хуульд төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж иргэдийн оролцоог хэрхэн хангах, зар мэдээ, мэдээллийг мэдээлэх, хүргэх, зар мэдээний төрөл, хариуцах этгээд, зар мэдээ, мэдээллийн стандарт, санал асуулга, санал хураалтыг явуулах зарчим, иргэдийг санал асуулга, санал хураалтанд ямар хэлбэрээр оролцуулах, *орон нутгийн үндсэн дүрмээр* тухайн орон нутгийн иргэд, иргэд хоорондын, иргэд болон Засаг дарга, Засаг даргын тамгын газар, орон нутгийн хурлын байгууллагууд, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллаагаа явуулж байгаа бүхий л аж ахуйн нэгж, байгууллагуудын харилцааг, иргэдийн аудит нь төрийн байгууллагын төсвийг үр ашигтай зарцуулж, иргэдэд нээлттэй,

ил тод байхад хяналт тавих, төсвийг боловсруулах, хянах, хэрэгжүүлэх, батлах үйл явцад олон нийтийн оролцоог хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, арга зүйн туслампж үзүүлэх зэрэг асуудлуудыг зохицуулахаар тусгаж [147] байгаа юм байна.

Уг хуулийн төсөл нь орон нутагт шийдвэр гаргахад иргэдийн оролцооог хэрхэн хангахтай холбоотой харилцааг зохицуулах онцлог бүхий асуудлыг хөндсөн байна.

Түүнчлэн ***Захиргааны ерөнхий хуулийн*** төслийг Хууль зүйн яамны боловсруулж буй хуулийн төслүүд гэсэн цэсэнд байршуулсан байна [148]. Уг хуулийн төслийн "Захиргааны хэм хэмжээний акт" гэсэн Зургаадугаар бүлэгт Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг хэлнэ (58.1) гэж тодорхойлоод
"Захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авах" гэсэн 61 дүгээр зүйлд :
Төслийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна. Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ѐсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангана. Эрх, хууль ѐсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ. Түүнээс гадна дараах хүрээнд хэлэлцүүлэг хийж болно:

- эрх, хууль ѐсны ашиг сонирхол хөндөгдөх бүлгийн хүрээнд;

[147] http://www.news.mn/content/196670.shtml

[148] http:www.moj.gov.mn

- эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд; тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд; тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:

- уулзалт, ярилцлага;
- өдөр тутмын сонин, хэвлэлд төслийг нийтэлж санал авах;
- цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах;
- бусад.

Хэлэлцүүлгийн явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг актын төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ (уг мэдээллийг юунд зориулж, яах гэж байгаа нь тодорхойгүй бөгөөд гол нь эргэх холбоо байх эсэх нь тодорхойгүй байна). Төслийг нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээллийн хамт өөрийн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр хянуулна. Захиргааны хэм хэмжээний актыг нэн даруй батлах шаардлагатай хойшлуулшгүй тохиолдолд энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан санал авах ажиллагааг хийхийг шаардахгүй гэсэн зохицуулалтыг оруулахаар төсөлдтусгасан байна.

Эдийн засгийн хөгжлийн яам гэж байх үед боловсруулсан бөгөөд 2014 оны 10 дугаар сарын 1-нд УИХ-д өргөн барьсан ***Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай*** хуулийн төсөлд Улсын Их Хурлаас хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах удирдамж, чиглэлийг Засгийн газарт өгсний дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн үзэл баримтлалын төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн оролцоог ханган боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ (16.2) Тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодын оролцоог ханган, төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулна (17.2) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн, бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ (22.4) Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно (23.3) Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна (26.3) гэсэн байдлаар олон нийтийн оролцооны талаар тусгасан байна. Уг хуулийн төслийн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах” гэсэн зургаадугаар бүлгийн “Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах” гэсэн төслийн 36 дугаар зүйлд:

- Бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх явцын талаарх мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй, ил тод байх асуудлыг тухайн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага хариуцна.

- Энэ хуулийн 27-34 дугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
- Бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх явцад иргэд, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулна.
- Хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дараах байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулна:

- олон нийтийн хэлэлцүүлгийг хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд, эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд, төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд тус тус явуулна.
- хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг нэгтгэн, бодлогын баримт бичигт тусган боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх бөгөөд бодлогын баримт бичгийн төслийг нээлттэй, ил тод мэдээлнэ.
- Батлагдсан бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн байгууллага хариуцан зохион байгуулна.

Бид 2011 онд GIZ, Үндэсний хөгжил, шинэтгэлийн Хорооны захиалгаар Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн хэрэгжилт, нэмэлт өөрчлөлт оруулах талаар хийсэн судалгааны үеэр хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулах шатанд иргэдийн оролцоог хангаж, нэгэнт батлагдсан бол аливаа сонгуулийн үр дүнгээр өөрчилдөггүй, өөрчлөх шаардлагатай бол эргээд олон нийтээр хэлэлцүүлж, батлахдаа өндөр хувийн дэмжлэг авч байж өөрчлөлт оруулдаг байдлаар төрийн бодлогын тогтвортой байдлыг хангадаг болохыг судлаачид зөвлөж, зарим орны хуульд тусгасан байдгийг тайландаа дурдаж байсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төсөлд амин чухал гэж бидний үзсэн энэ үзэл санаа төдийлөн бүрэн, ойлгомжтой байдлаар тусгагдаагүй байгааг хэлэлцүүлгийн шатанд авч үзнэ байх гэж найдаж байна.

Мөн УИХ-ын гишүүн Ж.Батзандан ***Иргэний санаачлагын тухай***[149] хуулийн төсөл боловсруулж, www.assa.mn цахим хуудсанд байршуулсныг бид судалгааны явцад авч үзсэн. Уг хуулийн төсөлд: “энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл /цаашид хууль, тогтоол гэх/-ийн тухай саналаа хууль санаачилагчид уламжлах /цаашид “иргэний санаачилга” гэх/ арга, хэлбэр, зарчим, болон түүнийг хэлэлцүүлэх журмын талаарх харилцааг зохицуулахад оршино, “Иргэний санаачилгын эрх” гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгуулийн эрх бүхий нийт иргэдийн 5

[149] http://www.shuud-ardchilal.mn/legislation 2014.12.11

хувь нь тодорхой асуудлаар шинээр хууль, тогтоол гаргах эсхүл дагаж мөрдөж байгаа хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг энэ хуульд заасан хугацаа, нөхцөл, журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагад уламжлахыг ойлгоно гэж заагаад санаачлагын эрхээ хэрэгжүүлэх процессийг зохицуулахад уг төсөл чиглэсэн байна. Хуулийн төсөлд санаачлага гаргах иргэдийг 5 хувь, 10 хувь, 200 иргэн, нутаг дэвсгэрийн тавиас доошгүйг хамарсан байх гэх мэтээр янз бүрээр бичсэн бөгөөд уг санаачлагыг ХЗЯ бүртгэж, олон нийтэд зарлаж санал цуглуулах, хэрэв сонгуулийн эрх бүхий нийт иргэдийн 10 хувийн дэмжлэг авсан бол Засгийн газар уг хуулийн төслийг боловсруулах үүрэгтэй байхаар тусгажээ. Уг хуулийн төсөлд ийнхүү 10 хувийн саналыг цуглуулах арга хэмжээг хэн зохион байгуулах, зардлыг нь хэн хариуцах талаар тодорхойгүй байна. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжлах  эрх болохыг Үндсэн хуулиар олгосон байтал энэхүү хуулиар маш олон хүнээр дэмжүүлэх, хууль зүйн яаманд бүртгүүлэх гэх мэт харин ч Үндсэн хуулиар шууд олгочихоод байгаа эрхээ хэрэгжүүлэхэд олон шаардлага, процедур бий болгохоор байгаа нь иргэдийн оролцоог дэмжих биш, харин хязгаарлах чиглэлд шинэ олон зохицуулалт бий болгохоор тусгасныг Үндсэн хуулиар олгогдсон эрхийг дордуулах вий гэх болгоомжлол төрүүлж байна. Хэрэв хуулийн төслийн талаар тодорхой хэмжээний олон иргэд дэмжсэн санал гаргасан тохиолдолд хууль санаачлагч уг хуулийн төслийг заавал боловсруулж хэлэлцүүлдэг байх үүргийг хуульчлах нь зүйтэй гэж үзвэл уг харилцааг Хууль тогтоомжийн тухай хуульд тусгаж болох бөгөөд иргэд, олон нийтийн оролцоог дэмжих тийм арга зам байдгийг бид дээр Польшийн жишээн дээр авч үзсэн билээ.

Дээр дурдсан хэд хэдэн хуулийн төсөлд хууль, төрийн томоохон чухал шийдвэрийн төсөл боловсруулахад иргэдийн оролцоог хангах талаар олон хууль санаачлагч нар зохих ёсоор анхаарал тавьж, янз бүрийн хуулийн төсөл боловсруулахдаа тусгаж байгааг бид зүй ёсны нааштай хандлага гэж үнэлж байна. Эдгээр хуулийн төсөлд яг аль шатанд ямар хүрээнд, ямар арга хэлбэрээр, ямар үндэслэлээр, хэн, нийгмийн ямар бүлэг оролцох вэ гэдэг асуудал төдийлөн бүрэн, ойлгомжтой тусгагдсан гэхэд учир дутагдалтай байна. Зарим улс, жишээ нь Өмнөд Солонгос, Европын холбоо аль аль түвшинд оролцоог хангахтай холбоотой харилцааг нэг хуулиар зохицуулсан туршлага байна.

Судлаачид бүтээлдээ хэлэлцүүлэгт оролцох сонирхлын бүлэг, төрийн бус байгууллагыг тухайн хуулийн төслийг боловсруулж байгаа төрийн байгууллага буюу албан тушаалтнууд сонгодог тул аль болох мэддэг, дэмждэг хүмүүсээ урих, зар өгөх явдал түгээмэл байдгийг[150] дурдаж,  тулгамдсан асуудлын нэгээр нэрлэсэн байдаг. Иймд цахим хуудсаар урьдчилан төлөвлөгөө, мэдээллээ түгээж санаачлагаараа оролцох оролцоог дэмжих нь зүйтэй юм.

[150] Катерина Хадзи-Мицева, Хууль боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах нь: Европын зарчмууд ба практик асуудлууд, Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /олон улсын семинар/, 2007, 19-р тал

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 4.1. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

Төлөөллийн, зөвлөлдөх /deliberation/, итгэмжлэлийн /delegative/, шууд гэх мэт ардчиллын олон төрөл хэлбэрүүд байх ба улс үндэстнүүд эдгээр ардчиллын төрөл хэлбэрүүдийн зөвхөн аль нэгийг нь сонгон авч идэвхтэй баримтлах бус төрийн тогтолцоо, үйл ажиллагааны үе шат бүрт аль тохирохыг нь хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Жишээ нь, хууль тогтоох байгууллага нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх гол байгууллага болох боловч зарим төрлийн шийдвэр эсхүл хуулийг батлан гаргахаас өмнөх шатанд шууд ардчиллын аргуудыг хэрэглэх тохиолдол элбэг байна.

Судалгаанаас харахад **нийтийн албаны зардал, татвар өндөр орнуудад төлөөллийн ардчилал илүү хөгжсөн байх бол харин шууд ардчилал хөгжсөн улс орнуудад энэхүү үзүүлэлт бууралттай байдаг**. [151] гэдгийг судлаачид онцолжээ.

Шууд ардчиллын үр дүнд ард нийт нь төрийнхөө үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байх, чинээлэг цөөнхийн гэхээсээ илүү олон нийтийн эрх ашигт нийцсэн хууль батлагдах гэх мэт олон давуу тал байх боловч төрийн тогтвортой бодлого баримтлах чадвар алдагдах, шийдвэр гаргах зардал өсөх, популист удирдагчдын үйл ажиллагаа идэвхжсэний үндсэн дээр санал өгөгч иргэд төөрөгдөлд автах гэх мэт сул талууд үүсдэг гэдгийг бид анхаарах ёстой.

Хуулийн төсөлд олон нийтээс санал авах нь эцсийн шийдвэрийг батлах эрх биш хэдий ч шууд ардчиллын шинж чанарыг агуулж байгаа үйл ажиллагаа мөн билээ.

Пост-колони, пост-апартейд, пост-коммунист улсад аль алинд нь ардчилсан үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд хуучин, авторитар дэглэмийн тогтолцоог өөрчлөхөд чиглэсэн хууль батлах шаардлагатайг судлаачид зөвлөжээ. **Тэд 20 дугаар зууны төгсгөлд гарч ирсэн шинэ, популист засгийн газрууд нь эдгээр дэглэм, тогтолцоог өөрчлөхөд амжилт олоогүй гэж дүгнэсэн.** Өрсөлдөөнтэй сонгууль нь хууль тогтоох эрх мэдлийн гүйцэтгэгч монопол байдлыг арилгаж чадаагүй ба дэглэм, тогтолцооны өөрчлөлт хийх чадваргүй болох нь нотлогдсон. Эдгээр өөрчлөлт нь **зөвхөн хүмүүсийн хандлагын өөрчлөлтийг бодитойгоор бий болгоход чиглэсэн нарийн боловсруулсан хуулиудын үр дүнд бий болно** гэж үздэг байна.

Хэдий тийм боловч хуулийн төсөл боловсруулах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэгч, тоглогчдын асуудал бүхий хандлагын шалтгаан нь тэдгээрийн хувь хүний зан чанараас хамаараагүй. Харин **хуулийн төсөл боловсруулах тогтолцоонд уг шалтгаан нь оршдог** байна. Үүнд:

1. Хуулийн төслийг боловсруулахад наад захын танин мэдэхүйн судалгаа болон туршлага дээр үндэслэх шаардлага тавьсан зохицуулалт байдаггүй,

2. Дэглэм, тогтолцооны өөрчлөлт хийх хүмүүсийн хандлагыг өөрчлөхөд хууль тогтоомжийг ашиглаж болно гэдгийг үгүйсгэдэг улс төрчид, төрийн албан хаагчид (ашиг сонирхлын бүлгүүдийн нөлөөг онцолсон хууль тогтоох онолыг

[151] Manfred G.Schmidt, “Political performance and types of democracy: Findings from comparative studies”, 2002, European Journal of Political Research, p 1566

үгүйсгэх) болон тодорхой улсын нөхцөл байдлыг судлахад шаардлагатай, нийгмийн шинжлэх ухааны судалгааны ур чадвар хангалтгүй,

3. Популист арга хэмжээг эсэргүүцсэн нийтлэг үзэл бодол,

4. Албаны нууцын тухай хуулиудаар хаалттай байдлыг тогтоож, хууль батлах үйл явцад олон нийтийн хяналтыг үгүйсгэдэг,

5. Эрх мэдэл, давуу эрхтэй хэсгийн оролцоо, эргэх холбоог дэмжиж, ядуу цөөнхийн оролцоо, эргэх холбоог үгүйсгэдэг,

6. Сонгогдсон эрх баригчид нь үнэн хэрэгтээ хуучин тогтолцооны дээд шатны, авторитар байгууллагуудын нөлөөнд байдаг гэсэн гол дүгнэлтийг судлаачид хийснийг бид харгалзан үзэх нь зүйтэй байна.

Баримтаас харахад хуулийн төсөл боловсруулах үйл явц нь тогтолцоог олонхийн эрх ашигт нийцүүлэн шинэчлэх боломжтой хуулийн төсөл бий болгож чадаагүй гэдэгт гурван шалтгаан байна. 1. **Төрийн албан хаагчид** шинэчлэл хийхүйц хуулийн төсөл боловсруулах чадваргүй, **цөөнхөд үйлчлэх үзэл санааг баримталдаг**, 2. Элит байгууллагууд нь төрийн албанд тулгуурлахаас өөр аргагүй албан тушаалтнуудаар удирдуулдаг. 3. Өөрчлөлтийг эрэлхийлсэн **иргэний нийгмийн бүлгүүдийн саналыг хуулийн төсөл боловсруулах явцад сонсохгүй байгаа нь тэдний урмыг хугалдаг**. Эдгээр хүндрэлүүдийг даван гарахад хуулийн төсөл боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах болон төрийн албан хаагчид, сонгогдсон албан тушаалтнуудыг хууль тогтоомжийг туршлага дээр үндэслэн бий болгох, үнэлэхэд чиглүүлж өгөх хууль тогтоох үзэл баримтлалыг бий болгох шаардлагатай...Хууль тогтоох үзэл баримтлал нь ...хандлагын өөрчлөлтийг тусгах л боломжтой. Харин нээлттэй, хариуцлагатай хуулийн төсөл боловсруулах үйл явц дахь холбогдох баримт, учир шалтгааныг гарган тавих зорилго бүхий олон нийтийн идэвхитэй оролцоо л аливаа байгууллагын өөрчлөлт олон нийтэд ашигтай байх нөхцөлийг хангана." гэж үзээд хуулийн төслийг ул суурьтай хийсэн судалгаан дээр үндэслэх, нийгмийн чиглэлээр судалгаа хийх чадвартай төрийн албан хаагчдыг ажиллуулах, нууцлалын талаарх хууль тогтоомжийг дахин хянаж, олон нийтийн санал авах боломжтой хуулийн тоог нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ авахыг судлаачид зөвлөжээ.

Бидний хийсэн судалгаа, ажиглалтаас үзвэл бидний ярилцлагад оролцсон төрийн албан хаагч "хуулийн төслийг иргэдээр хэлэлцүүлэхэд үр дүнтэй биш байдаг" гэсэн хариултыг хуулийн төсөлд санал өгсөн иргэдийн 44 хувь нь санал нь хангалттай буюу зарим санал тусгагдсан гэж хариулснаараа үгүйсгэв. Бидний зүгээс энэ байдал нь олон нийтийн оролцооны талаарх төрийн албан хаагчид, улс төрчдийн байр суурийг тайлбарласан дээр дурдсан судлаачдын дүгнэлтийг нотолсон гэж үзэж байна.

Ил тод байдал нь ач холбогдол бүхий болон мэдээлэл сайтай олон нийтийн оролцоог хангахад тусалдаг, ба нөгөөтэйгүүр ач холбогдол, мэдээлэл бүхий олон нийтийн оролцоо нь хууль дүрэм бүтээгчийг төлөвшүүлдэг.

Хуулийн төсөл боловсруулахад иргэд олон нийтийн оролцоог бодитойгоор хангахад үндсэн 3 асуудлыг шийдвэрлэснээр үр дүнтэй байж болохыг судлаачид зөвлөж байна. Үүнд:

1. Ил тод байдал
2. Олон нийтийн оролцоо
3. Стратегийн төлөвлөгөө.

**Ил тод байдлыг хангах**: ямар байгууллага ямар мэдээллийг ил тавих вэ гэдэгт анхаарал хандуулах ёстой. Эцсийн үр дүнд олон нийтэд нээлттэй мэдээллийн зорилго нь мэдээллийг цаг тухайд нь гаргах мөн голчлон интернэт ашиглах замаар олон нийтийн ач холбогдол бүхий хандалтыг бий болгоно. Үүнд:

- Интернетэд тавигдах бүхий л мэдээлэл нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тодорхойлогдсон байна.
- Төрийн байгууллагууд хууль бүтээх үйл явцаа өөрийн цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал гэсэн хэсэгт байрлуулахаар хуульчилсан. Бид энэ судалгааны явцад бүх хуулийн төсөл, түүний түүх, архивын нэгдсэн цахим хуудас бий болгохыг зөвлөж байгаа. Хэсэг хугацааны дараа бид хамгийн сайн туршлагыг илрүүлж нэвтрүүлэх тухай ярилцана гэж найдаж байна
- Уг цахим хуудас дахь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд гаргах сахилгыг сайжруулах нь зүйтэй
- зөвлөлдөх /deliberation/, итгэмжлэлийн /delegative/ ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж мэргэшиж буй олон нийтийн ашиг сонирхлын бүлгүүд буюу төрийн бус байгууллагуудыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тогтоосон төлбөрөөс чөлөөлөхөд чиглэсэн зохицуулалтыг бий болгох
- мэдээлэл хүссэн хүсэлтийг шийдвэрлэх төрийн байгууллага, ажилтны процессыг тодорхой болгож, хариуцлагыг өндөржүүлэх

**Олон нийтийн оролцоог хангах.** Сонирхлын бүлгүүд хууль бүтээх процесст аль болох эхний шатнаас оролцдог болоход оролцоход илүү анхаарах нь зүйтэй:

- Төрийн байгууллагууд нь олон нийтийн санал өгөх процессын олон арга, хэлбэр, боломжоос туршилт хийх
- Төрийн байгууллагын гаднах оролцогчдын мэдээлэл харилцааг дэмждэг байгууллагын соёлыг бий болгох
- Шинэ хууль, дүрэм боловсруулахад сонирхлын бүлгийн оролцоог эхний үе шатанд өргөн хүрээгээр хангахад “нээлтэй хаалганы” бодлого эсхүл тууштай алхам хийж дэмжлэг үзүүлэх

**Стратегийн төлөвлөгөө.** Хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах Стратегийн төлөвлөгөөг төрийн байгууллагууд бүхэлдээ, эсхүл тухайн байгууллага өөрсдийн туршлага, ил тод байдал, олон нийтийн оролцооны бодлогыг тасралтгүй сайжруулах, дэвшилтэт аргыг судалж нэвтрүүлэхэд чиглүүлэх

- Төрийн байгууллагууд нь “олон нийтийн оролцооны төлөвлөгөө”-г сайжруулан өөрсдийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн оролцооны процессыг тогтмол сайжруулахыг хичээх
- Шаардлагатай санхүүжилтийг тооцож төлөвлөн бүтэц, зохион байгуулалтын механизмыг бий болгосноор цаашид улам сайжруулж, шинэчлэлийг тэнцвэртэй хөгжүүлэх.
- Төлөвлөлт нь олон нийтэд ил тод байснаар тэдний оролцоог бодитойгоор хангах чухал нөхцөл болгон хөгжүүлэх юм.

Хууль бүтээх процесс дахь ил тод байдал болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь Засгийн газраас гарч буй хууль, дүрмийн чанар болон хууль ёсны байдлыг нэмэгдүүлдэг. Энэхүү зөвлөмж нь хууль бүтээх процесс дахь алдаа дутагдлыг засах урт замыг туулах нь мэдээж юм. Уг зөвлөмж нь тэргүүлэх чиглэлийг тодорхойлж аливаа хууль дүрэм нь шударга, нээлттэй үйл явцаар дамжин гарч, Монголын олон нийтэд үр дүнтэй үйлчлэх явцыг хангана.

## 4.2. Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмж

Төсөлд ... харилцааг зохицуулна гэж бичиж ирсэн хэвшмэл "зорилт"-ыг бус, хууль баталснаар хүрэх "зорилго"-ыг тодорхойлсон нь цоо шинэ хандлага болж байна. Үүнтэй холбоотойгоор хууль санаачлагч, хуулийн төсөл боловсруулагч нар ***хуулийн зорилгыг хэрхэн тодорхойлох талаар Төсөлд илүү нарийвчилж оруулах***ыг зөвлөж байна

Төсөлд "олон нийтийн оролцоог хангах" зорилгыг хуулийн 1 дүгээр зүйлд заасан нь ардчиллын хөгжилд чухал алхам болно гэж үзэж байна. Төслийн 60 дугаар зүйлд шинээр оруулж байгаа хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийхэд уг зорилгод хүрсэн эсэхийг үнэлэх байдлаар хуулийн доторх уялдааг хангажээ.

Одоогийн хуульд хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхэд баримтлах зарчмыг тусгайлан зүйл заалт болгон зохицуулаагүй бол Төсөлд энэ хуулийг дагаж мөрдөхөд хууль ёсны байх; ***ил тод, нээлттэй байх; олон нийтийн оролцоог хангах;*** ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална хэмээн заасан нь дэвшилттэй болсон байна. Харин төслийг бүхэлд нь авч үзвэл ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим хэрхэн хангагдаж байгаа нь төдийлөн тодорхой тусгагдаагүй байгааг цаашид төслийг боловсронгуй болгох явцад анхааралдаа авах нь зүйтэй.

Одоогийн хуульд "Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно" \3.2\ хэмээн Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд "Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна" гэж заасныг хэрэгжүүлэх хэлбэр, боломжийг нарийвчлан тодорхойлсон зохицуулалтыг Төслөөс хассан байх тул энэхүү одоо байгаа зохицуулалтыг Төсөлд нэмж тусгахыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх үе шатанд иргэд, хуулийн этгээдийн оролцоог тодрхойлохгүй байх нь төсөлд тусгагдсан зорилго, зарчмаасаа ухарсан хэрэг болно.
Одоогийн хуулийн 6.1.6-д заасан "иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах" хууль санаачлагчийн бүрэн эрхийг Төсөлд тусгаагүй нь Үндсэн чиглэл батлах буюу хууль тогтоомж боловсруулах ажлыг төлөвлөх шатанд иргэд, олон нийтийн оролцоог хассан ухралт болохоор байна.

Төслийн 7 дугаар зүйлд "Иргэн, хуулийн этгээд эдийн засаг, нийгмийн амьдралд шинээр бий болсон харилцааг зохицуулах болон тодорхой харилцааг зохицуулж

байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах хэрэгцээ шаардлага, шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаарх үндэслэл бүхий саналаа Үндсэн чиглэлд тусгуулахаар санал өгч байгаа, саналыг нэгтгэж байгаа байгууллагаар дамжуулан, эсхүл хууль санаачлагчид шууд бичгээр уламжилж болох тухай болон тухайн этгээд иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи уг саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах арга хэмжээ авдаг байх, тийнхүү тусгах боломжгүй бол үндэслэл бүхий хариу өгдөг байхаар төсөлд тусгаж, хууль боловсруулах ажлын төлөвлөлтийн шатанд олон нийтийн оролцоог хангах нь зүйтэй байна.

Одоогийн хуульд хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна \7.1\:

- хуулийн төслийг өөрөө боловсруулах;
- холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэж заасан.

Энд “холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах” гэж заасан. Практик дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүний нилээдгүй хувийг төрийн холбогдох байгууллагын төлөөлөл эзэлдэг. Мөн “мэргэжлийн” гэдэг утгаараа төрийн бус байгууллагын төлөөлөл оролцох нь түгээмэл байдаг. Энэ нь ч зүйн хэрэг. Харин ажлын хэсэгт төрийн байгууллагын төлөөлөл оролцдог гэдгийг энэ хэсэгт заагаагүй. Ийнхүү шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хуулийн төсөл боловсруулах нь нарийн мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангаж буй нэг арга гэж үзэж байна.

Төслийн гуравдугаар бүлэг нь “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах” гэсэн нэртэй бөгөөд энэ бүлэгт ажлын үе шат, тодорхой аргачлалын дагуу хийх төрөл бүрийн тандан судалгаа, үнэлгээ, тооцоолол, магадлан шалгалт, дүгнэлт, төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Харин хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэрийг Төсөлд тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах; хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх гэсэн явцуу ч гэсэн төрийн бус оролцоог тодорхойлсон зохицуулалт хасагдаж байна. Иймд Төслийн 9 дүгээр зүйлд энэ талаар одоогийн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгон оруулах саналтай байна.

Одоогийн хуульд хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана \18.3\. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээс санал авах ажиллагааг дараахь хэлбэрээр зохион байгуулна\18.4\:

- хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах;

- хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно хэмээн зохицуулсан байна.

Төслийн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат” гэсэн 8 дугаар зүйлд хууль санаачлагчийн зохион байгуулах үйл ажиллагааны дарааллыг тодорхойлж, хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон мэргэжлийн бусад байгууллагын саналыг авах \8.1.5\, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлж, санал авах \8.1.6\ гэж заасан. Харин үзэл баримтлалыг батлах тухай Төслийн 13 дугаар зүйлд олон нийтийн оролцоог хангах талаар зохицуулалт тусгагдаагүй. Зөвхөн хуулийн төсөл төдийгүй түүний үзэл баримтлалд санал авах, тэдгээрийг хэлэлцүүлэх ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах талаар төслийг боловсронгуй болгох шаардлагатай.

“Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах” нэртэй Төслийн 36 дугаар зүйлд: Төсөл нь үр нөлөөний үнэлгээ, үзэл баримтлалын хамт санаачлагчийн албан ёсны цахим хуудсанд /эсхүл www.legalinfo.mn/ байршуулж өдөр тутмын хэвлэлд мэдээлснээр олон нийтийн хэлэлцүүлэг эхлэх бөгөөд санал зөвлөмж авах сүүлийн хугацааг хамтад нь зарлана. Төслийг нийтэлснээс хойш 30-90 хоногийн /хуулийн ач холбогдлоор нь ангилбал түүнтэй холбож болох/ дотор байгууллага, хувь хүн саналаа ирүүлэх бөгөөд төслийг сайжруулах талаар тодорхой саналаа тусгана. Саналыг бичгээр холбогдох этгээдийн гарын үсгийн хамт ирүүлнэ гэж заасан байна.
***Нэгдүгээрт***, Олон нийтийн оролцоог ***төлөвлөж, мэдээлэх зохицуулалт нэмэх шаардлагатай байна.*** Жирийн иргэн, байгууллагын хувьд ямар байгууллагын, аль цахим хуудсанд, ямар хуулийн төслийн талаарх мэдээлэл хэдийд тавих нь тодорхойгүй байгаа нь иргэд, олон нийтийн оролцоог тэгш хангах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна. Ийм мэдээлэл урьдчилсан байдлаар байхгүй тохиолдолд цахим хуудсанд байрлуулах хугацааг 1 сар, 6 сараар тавьсан ч үр дүн гарахгүй гэж үзэж байна. Иймд энэ талаарх төлөвлөгөөг хагас жил, улирал, болдог бол жилийн өмнөөс холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага\ ЗГХЭГ ч байж болох талтай\ нэгтгэн тодорхойлж, олон нийтэд мэдээлдэг тогтолцоог хуульчлах нь зүйтэй. ***Хоёрдугаарт***, “Монголчуудтайгаа зөвлөлдөх нь” гэсэн ***нэгдсэн цахим хуудас*** \эсхүл www.legalinfo.mn дээр байсан ч болно\ бүтээж, энэхүү төлөвлөгөө болон олон нийтээр хэлэлцүүлж байгаа хуулийн төсөл, архивт орсон төслүүдийг хариуцан боловсруулж буй байгууллага буюу хууль санаачлагчийн цахим хуудас руу орох линктэйгээр байрлуулж хэвшвэл цахим хэлэлцүүлгийг 10 хоногт багтаахаар хуульчилсан одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх нь илүү хүнд сурталгүй бөгөөд хууль тогтоох үйл ажиллагааг сунжруулахгүй байх нөхцөл бүрдэнэ. ***Гуравдугаарт,*** Хууль санаачлагч нь уг нэгдсэн цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулахдаа хуулийн төслийг бүрэн эхээр нь байрлуулахаас гадна зохих ёсоор батлагдсан уг хуулийн үзэл баримтлал, танилцуулга, уг хууль батлагдахтай холбогдуулан бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг мөн олон нийтэд танилцуулах нь зүйтэй. Ингэснээр олон нийт Яагаад? гэсэн олон асуултдаа хариулт авч, тухайн хуулийн төслийг бусад хуулиудтай уялдаатайгаар иж бүрэн төсөөлөхүйц мэдээлэлтэй болж, саналаа өгөх нөхцөл бүрдэнэ. ***Дөрөвдүгээрт,*** Цахим хэлэлцүүлгийн явцад ирсэн саналыг бүртгэх,

төсөлд тусгах, эргэж мэдээлэх зэрэг хууль санаачлагчийн үйл ажиллагааг Төсөлд тодорхой тусгах нь зүйтэй***. Тавдугаарт,*** Ийнхүү олон нийтэд танилцуулсан мэдээлэл, ирсэн санал, түүнийг тусгасан байдал, тусгаагүй бол түүний шалтгаан зэрэг мэдээллийг санал авах хугацаа дуусмагц тухайн цахим хуудсанд наанадаж 3-5 жил, түүнээс ч урт хугацаанд архивлан хадгалдаг байх нь хуулийн төслийг УИХ дээр хэлэлцэх үед болон иргэд олон нийтийн мэдээллийн, эрх зүйн боловсролын, судалгааны, хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгч, шүүхийн практикт чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, тэдгээрт олон нийтээс ирүүлсэн санал, түүнийг хуулийн төсөлд тусгасан байдал, тусгаагүй бол энэ тухай тайлбар зэрэг мэдээллийг мөн тухайн цахим хуудсанд байрлуулдаг байх нь оролцоог дэмжих хоёр талын хүсэл эрмэлзлийг дэмжих, эргэх холбоог сайжруулахын зэрэгцээ хуулийг нэг мөр ойлгох, тайлбарлах, хэрэглээний соёлыг бий болгох, шууд ардчиллыг хөгжүүлэх, үнэлэхэд чухал ач холбогдолтой.

Одоогийн хуулийн 18.15-д: “Хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана” гэж заасан нь хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангасан талаарх эцсийн товч тайлан гэж үзэж болно. Төслийн 32 дугаар зүйл \Хуулийн төслийн танилцуулга\-д дээрх санааг илүү дэлгэрүүлж, “хуулийн төслийг боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар авсан арга хэмжээ, тэднээс гаргасан саналыг хуулийн төсөлд тусгасан байдал, тусгаагүй бол түүний шалтгаан” гэсэн заалт нэмж оруулах нь зүйтэй.

Хуулийн төслийн аль шатанд хэний, ямар байгууллагын ямар санал дэмжигдэж хуулийн төсөлд тусгагдсаныг олон нийт мэдэх боломжтой болгоно гэдэг нь эргээд тухайн санал гаргагчийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хууль бол ард түмний бүтээл, тэдний хүсэл зоригийн илэрхийлэл гэдгийг жинхэнэ утгаар илэрхийлнэ. Ингэснээр хэн нэг албан тушаалтан хуулийн төслийг дураараа засах боломж хаагдаж, хууль тогтоох ажиллагааны ил тод байдал хангагдаж, оролцооны механизм хэрэгжинэ.

“Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах” гэсэн Төслийн тавдугаар бүлэг нь 2 зүйлтэй байх бөгөөд Эрх бүхий байгууллага, албан тушаалтаас санал авах гэсэн 37 дугаар зүйл нь уг бүлгийнхээ агуулгад нийцэхгүй байна. Иймд уг зүйлийг 22 дугаар зүйлийн орчимд шилжүүлэх нь зохимжтой байна \Төслийн 22.6 дээр зохицуулалтыг нь бичээгүй буйг харна уу\. Харин энэхүү “Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах” гэсэн бүлэгт дээр санал болгосон олон нийтийн оролцоог төлөвлөх, мэдээлэх, “Монголчуудтайгаа зөвлөлдөх нь” нэгдсэн цахим хуудас, түүнд тавигдах мэдээллийн агуулга, мэдээллийг архивлан хадгалах, эргэх холбоо зэрэг асуудлыг тусгахаас гадна олон нийтийн оролцоог хангах арга хэлбэр, үе шат, оролцооны хүрээг тодорхойлох зэрэг харилцааг тусган уг бүлгийг иж бүрэн томъёолохыг зөвлөж байна.

Бид хуулийн төсөл хэлэлцүүлэх, хэлэлцүүлэг хийх гэж ярьж хэвшсэн байна. Ихэнх орнууд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёо хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Хэлэлцүүлэг зохион байгуулах гэдэг үг төрийн идэвхтэй санаачилгаар буюу нэг тал-төр давамгайлсан утгыг агуулж байгаа юм бишүү гэх

санаа төрж байна. Тийм ч учраас Одоогийн хуульд хэлэлцүүлгээс гарсан "үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах" гэж хуульчлаад үндэслэлгүй гэж үзсэн шалтгааны эргэж мэдээлэхгүй орхиод байна уу? Харин "иргэдтэйгээ зөвлөлдөх" гэдэг нь тэгш харилцаа, харилцан ойлголцлыг агуулж байна. Иймд шинээр боловсруулж байгаа хуульд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёог хэрэглэхийг зөвлөж байна.

***Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай*** хуулийн "Үйл ажиллагааны ил тод байдал" гэсэн 7 дугаар зүйлийн 7.1.5-д "шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах" гэж заасан. ***Нэгдүгээрт***, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд хуулийн төслийг 10 хоног байрлуулахаар заасантай хугацааны хувьд зөрчилтэй байна. ***Хоёрдугаарт,*** зөвхөн үндэслэлтэй бол саналыг төсөлд тусгаад үндэслэлгүй бол яагаад үндэслэлгүй гэж үзсэн тухай мэдээлэл олон нийтэд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

Хуулийн төслийг хэлэлцүүлнэ гэдэг нь олон нийтийн саналыг авч төсөлд тусгах гол зорилготойгоос гадна тухайн хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг цогцоор нь олон нийтэд ойлгуулах зорилго агуулах ёстой гэж үзэж байна. Хууль бол нийгмийн харилцааг зохицуулахдаа шударга, товч байх учиртай. Тухайн хуулийн төсөл нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хөндөх буюу тэдний зан үйлийн хэм хэмжээг тогтоож, зарим тохиолдолд орлогыг нь бууруулах, нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээний зохицуулалтыг хамардаг. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгийн санал бүрийг хуулийн төсөлд тусгах шаадлагагүй бөгөөд боломжгүй. Иймд гарсан саналыг яагаад төсөлд тусгаагүйг ямар нэг хэлбэрээр мэдээлэх нь иргэдийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, хуулиар дамжин илрэх төрийн бодлогыг ойлгуулах илүү өргөн зорилготой. Иймд энэ төслийг дагалдуулан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, зөрчил, давхардлыг арилгахыг санал болгож байна.

Хуулийн төсөл өргөн мэдүүлсний дараа олон нийтийн оролцоог хангах талаар тодорхой зохицуулалтуудыг тогтоосон байдаг.

Хуулийн төслийг **Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай** хуультай хэрхэн уялдуулах талаар авч үзэх асуудал байна. Хуулийн төслийн Хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагаанд тавих ерөнхий шаардлага гэсэн долдугаар бүлгийн 45 дугаар зүйлээс бусад нь дэгийн тухай хуулиар зохицуулах харилцаанд хамаарна гэж үзэж буй тул Дэгийн тухай хуульд нэмэлт оруулах байдлаар шийдвэрлэхийг зөвлөж байна.

Төслийн "Хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагаанд тавих ерөнхий шаардлага" гэсэн долдугаар бүлэгт шинээр орж буй зохицуулалтад олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн нэлээд олон заалт, зохицуулалт тусгагдсан нь сайшаалтай байна. Тухайлбал, 40.1.Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагааг дараах үндсэн хэлбэрээр зохион

байгуулна: хуулийн төсөлд дүгнэлт гаргах ***ажлын хэсэг*** томилж ажиллуулах \40.1.1\; хуулийн төслийн талаар Байнгын болон дэд хороонд ***нээлттэй сонсгол*** зохион байгуулах \40.1.2\; 41.1. Төслийн зохицуулах харилцааны ач холбогдол, хамрах хүрээг харгалзан Улсын Их Хурлын дарга, Байнгын хороо төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, ***мэргэжилтнүүдийн оролцоотойгоор*** байгуулж болно, шаардлагатай гэж үзвэл хэлэлцэж байгаа асуудлаар ***нарийн мэргэшсэн шинжээчдийг ажлын хэсэгт туслах дэд ажлын хэсэг***тэй хамтран ажиллах \41.2.2\ гэх мэт УИХ дээр иргэдийн оролцоог хангахтай холбоотой харилцааг зохицуулахаар байгаа нь сайшаалтай байна.
Хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх, мэдээлэх, хүргэх, олон нийтэд таниулахтай холбогдсон харилцааг бүлэг болгон нарийвчлан зохицуулахаар Төсөлд тусгасан нь олон нийтийг мэдээллээр хангах чухал ач холбогдолтой зохицуулалт болно гэж үзэж байна.

Төсөлд энэхүү хуулийн хэрэгжилтийн шатанд мэргэжлийн байгууллагын оролцоог хэд хэдэн газар тодорхойлсон байна. Тухайлбал, “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг өөрөө буюу хөндлөнгийн бие даасан хараат бус байгууллага, мэргэжлийн хүмүүсээр гэрээний үндсэн дээр хийлгэж болно” \15.4\. Мөн “Хяналт, шинжилгээ, үнэлгээ”-тэй холбоотой зохицуулалтыг Төслийн 10 дугаар бүлэгт тусгасан бөгөөд “Улсын Их Хурлаас хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээг Улсын Их Хурлын Байнгын хороод, Улсын Их Хурлын Тамгын газар /Хяналт шинжилгээний алба, Судалгааны алба/ хамтран хэрэгжүүлнэ. Хяналт шинжилгээг хийхэд төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулж болно” \59.5\, “Хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ хийлгэж болно” \59.7” гэж заасан нь мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог хангах чухал арга мөн. Харин хуулийн төсөл боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах; хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх аргыг Төсөлд тусгаагүй байгааг нэмж тусгах саналыг дээр дурдсан.

Хууль санаачлагч өөрөө хуулиа бичээд байх боломж тэр бүр хомс. Бодит байдал дээр хуулийн төсөл боловсруулах ажлыг төрийн бус байгууллага, мэргэжлийн хүмүүсээр \тэр дундаа гадаадын экспертээр\ хийлгэж, санхүүжилтын асуудлыг аль нэг хөгжлийн байгууллагаас гаргуулах хандлага давамгайлж байгаа нь нууц биш. Энэ нь төрийн бодлогыг төрийн жинхэнэ албан хаагч нар тодорхойлж байна уу гэдэг асуулт тавигдахад хүргэдэг. Үүнтэй холбоотойгоор хуулийн төсөлд тусгаад байгаа дээр дурдсан ажлуудыг ТББ, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлэх санхүүжилтын асуудал тодорхой байх нь чухал. Батлагдсан хуулиас түрүүлж, зах зээлд цоо шинэ харилцаа нэвтэрч, эрх зүйн зохицуулалтыг цаг алдахгүй шийдвэрлэх шаардлагатай болдог. Мэдээлэл, мэдлэг, туршлага хаа хаанаа дутагддаг шилжилтийн үед бид эксперт урихаас өөр боломж ховор байсан. Харин одоо мэргэжилтнүүдийн мэдээлэл нэмэгдэж, хэлний бэрхшээл арилж байгаа энэ цаг үед төрийн мэргэшсэн албаны үүрэг, чадавхийг дайчлах бодлого барих нь зүйтэй байж болох юм. Нөгөө талаар мэргэжлийн байгууллага, ТББ, мэргэжилтэн дайчлах тохиолдолд ажлын хөлсийг санхүүжүүлэх асуудлыг зохистой шийдвэрлэх талаар анхаарах нь зүйтэй. Энэ бол цэвэр төрийн үүрэг байх учиртай тул төсвөөс санхүүждэг байх нь зохистой.

Судалгааны дүн, харьцуулалт, ажиглалт, зөвлөмж дээр үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсронгуй болгох саналаа уг хуулийн төсөлд тусгасан хувилбараар энэхүү тайлангийн Тавдугаар бүлэг буюу хавсралтаар өгч байна.

Иргэдийн оролцооны тухай хуулийн төсөл нь орон нутагт шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хэрхэн хангахтай холбоотой харилцааг зохицуулах онцлог бүхий асуудлыг хөндсөн байна. Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн хувьд оролцоог хангах асуудлыг энэ хуулиар зохицуулж болох боловч эрх зүйн дэд актуудын төсөл боловсруулахад оролцоог хангах асуудлыг ямар хуулиар хэрхэн зохицуулах нь орхигдох магадлалтай байна. Зарим улс, жишээ нь, Өмнөд Солонгос, Европын холбоо аль аль түвшинд оролцоог хангахтай холбоотой харилцааг нэг хуулиар зохицуулсан туршлага байна.

Хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буй талаар хийсэн анализ дээр үндэслэн дээр дурдсан болон нэгтгэсэн байдлаар дараах арга зүй, зохион байгуулалтын шинжтэй зөвлөмж өгч байна:

1. Нэгэнт орон нутагт иргэдийн оролцоог хангах талаар Ерөнхийлөгч хуулийн төсөл санаачлан боловсруулж байгаа бөгөөд агуулгаараа энэ хуульд бүрэн нийцэх боломжгүй байгаа тул бие даасан хууль батлахад буруугүй гэж үзэв
2. Эрх зүйн дэд актуудын төсөл боловсруулахад оролцоог хангах асуудлыг ямар хуулиар хэрхэн зохицуулах нь орхигдох магадлалтай байгааг зохих түвшинд ярилцах шаардлагатай гэж үзлээ.
3. Иргэдтэйгээ зөвлөлдөх нэгдсэн цахим хуудастай болох
4. Иргэдтэй зөвлөлдөх ажиллагааны төлөвлөгөөг хамгийн багадаа 3 сарын өмнө бүх төрийн байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлан уг цахим хуудсанд байрлуулан, уг цаг хугацааг мөрдөж ажиллах
5. Дээрх хоёр зохицуулалт нь иргэн бүр мэдээллийг тэгш, нээлттэй авах боломж олгоно
6. Үндсэн чиглэл боловсруулахаас өмнөөс эхлээд хууль батлагдаж, нийтлэгдэж, хүчин төгөлдөр болох бүхий л хугацааны аль үе шатанд нийгмийн ямар бүлгийг хамруулж оролцоог ямар аргаар хангах вэ гэдгийг сайтар боловсруулах.
7. Дээрхтэй холбоотойгоор тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагаврыг тооцсоны үндсэн дээр боловсруулагдаж байгаа хуулийн төслийн агуулгыг тодорхой үе шатыг хүртэл төрийн буюу байгууллагын нууцад хамааруулах эсэх асуудлыг хуульчлах уу гэдэг асуудал байна. Бүх хуулийн төслийг тодорхой үе шатанд хүрсний дараа иргэдтэйгээ зөвлөнө. Энэ бол зарчим. Харин тэр үе шат хүртэл онцлог харилцааны тухайд ямар онцлог байх вэ? гэдгийг ярилцах шаардлагатай.
8. Магадгүй тухайн зохицуулах харилцааны онцлогийг харгалзан нийгмийн ямар бүлгийг хамруулж, ямар аргаар хуулийн төсөлд санал авах вэ гэдгийг тодорхой үе шатанд аль нэг төрийн байгууллага шийдвэрлэдэг байх зохицуулалт байж болох талтай. Тус байгууллага нь иргэдтэй зөвлөлдөх ажиллагаанд оролцох хүрээ \мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн бүлэг, тодорхой салбарын бизнесийн байгууллага, тодорхой бүс нутгаас санал асуух гм\, зөвлөлдөх арга

\хуулийн төсөл багц материалыг цаасаар болон цахим хэлбэрээр хүргүүлэх, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах, тодорхой шинэ зохицуулалтын талаар санал асуулга явуулах гм\ зэрэг заавал хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж шийдвэр гаргадаг байхаас гадна зөвлөлдөх ажиллагааны үр дүнг нэгтгэх буюу гарсан саналыг төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол шалтгааныг эргэж мэдээлэх зэрэг асуудлыг зохицуулах

9. Эцэст нь дээрх болон цаашид гарч болох бүх асуудлыг заавал хуульд тусгахгүйгээр хуулиар эрх олгосон байгууллага эрх зүйн актаар зохицуулж болно гэж үзэж байна.

Дээрх судалгаа, анализад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд хууль боловсруулахад олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор дараах саналыг томъёолон өгч байна.

### 4.3. Хууль боловсруулахад олон нийтийн оролцоог хангах чиглэлээр “Хууль тогтоомжийн тухай” хуулийн төсөлд тусгах санал

Бид дор дурдсан саналыг Хууль зүйн яамнаас 2014 оны 10 дугаар сарын 4-ны өдрөөр огноолж, Энхмаагийн цахим шуудангаар ирүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл (цаашид “төсөл” гэх) дээр ажиллаж өгч болно.

**НЭГ.** Хуулийн зорилтыг бус зорилгыг тодорхойлохоор энэ хуулийн төсөлд тусгасантай холбоотойгоор Төслийн 26.1.10-ын дараа “26.2. Хуулийн зорилго нь тухайн хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрч болох, хүрэхийг эрмэлзэж буй, хэрэгжилтийг нь үнэлэх боломж бүхий нэг буюу хэд хэдэн үр дүнг тодорхойлсон байна” гэж нэмэх

**ХОЁР.** Төслийн 5 дугаар зүйлд “5.5.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно” гэж нэмэх. Үндсэн хуулийн 26 зүйлд заасан иргэний энэхүү эрхийг хэрэгжүүлэх зорилгоор Ж.Батзандан гишүүн Иргэдийн санаачлагын тухай хуулийн төсөл санаачилсныг бид танилцаж саналаа дээр бичсэн. Тодорхой тооны иргэдийн дэмжсэн саналыг хууль санаачлагч хуулийн төсөл болгон боловсруулж өргөн барих үүрэгтэй байх зохицуулалтыг энэ хэсэгт оруулж болох талтай. Хэрэв үүнийг тусгах бол хэдэн хүний дэмжлэг авах, дэмжлэг авах ажиллагааг хэн, хэрхэн санхүүжүүлэх зэрэг харилцааг хамтад нь зохицуулах шаардлагатай.

**ГУРАВ.** Төслийн 7 дугаар зүйлийн дараа дараах агуулгатай 8 дугаар зүйл шинээр нэмэх:

“**8 дугаар зүйл. Хууль тогтоомж боловсруулах ажлыг төлөвлөхөд иргэдийн оролцоог хангах**

8.1. Иргэн, хуулийн этгээд нь эдийн засаг, нийгмийн амьдралд шинээр бий болсон харилцааг зохицуулах болон тодорхой харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах хэрэгцээ шаардлага, шинээр болон

нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаарх үндэслэл бүхий саналаа Үндсэн чиглэлд тусгуулахаар холбогдох Засгийн газрын байгууллагаар дамжуулан, эсхүл хууль санаачлагчид шууд бичгээр уламжлах эрхтэй.

8.2. Иргэн, хуулийн этгээдээс энэ хуулийн 8.1-д зааснаар ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг хүлээн авсан байгууллага буюу хууль санаачлагч нь тухайн саналыг Үндсэн чиглэлд тусгуулах арга хэмжээ авах, эсхүл түүнд тусгах боломжгүй гэж үзвэл үндэслэл бүхий хариуг санал гаргагчид бичгээр өгнө.

**ДӨРӨВ.** Төслийн 8 дугаар зүйлийн дараа Одоогийн хуулийн 7.1-д заасан агуулгыг сэргээж дараах агуулгаар нэмэх:

**“9 дүгээр зүйл. Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр**

9.1. Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна:

9.1.1.хуулийн төслийг өөрөө боловсруулах;

9.1.2.холбогдох төрийн, эрдэм шинжилгээ, судалгааны, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

9.2.3.хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

9.2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч нь энэ хуулийн 9.1.2, 9.1.3-т заасан нийтийн албаны албан хаагчаас бусад иргэн, хуулийн этгээдийн зардлыг төсвөөсөө санхүүжүүлнэ.”

**ТАВ**.Төслийн Хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах гэсэн гуравдугаар бүлэгт хуулийн төслийг боловсруулж, үнэлгээ, зардлын тооцоо, эрх зүйн магадлан шалгалт хийсний дараа ЗГ-ын хуралдаанаар оруулахаас өмнө төрийн байгууллагуудаас санал авч нэгтгэн, саналыг тусгах буюу тусгаагүй бол түүний шалтгааныг ЗГ-ын хуралдаанд оруулдаг байх дарааллыг баримтлах нь зүйтэй байна. Иймд Төслийн “Хууль тогтоомжийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх” гэсэн 22 дугаар зүйл (8 дугаар хуудас)-ийн өмнө Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас санал авах гэсэн төслийн 37 дугаар зүйлийг зохих найруулга хийж, давхардлыг арилган байрлуулбал эхлээд төрийн зүгээс хуулийн төслөө гараас гаргах боломж бүрдэх юм. Төслийн 22 дугаар зүйлийг боловсронгуй болгоно байх.

**ЗУРГАА.**Төслийн 22 дугаар зүйлд дараах агуулгатай хэсгүүд нэмэх:

“22.11. Хуулийн төслийг хэлэлцүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан Засгийн газрын хуралдаанаас уг хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх хүрээ *(сонирхлыг бүлэг, ТББ, эрх ашиг*

*нь хөндөгдөж байгаа тал, хувийн хэвшлийн тодорхой салбар, түүний хэрэглэгчид, тодорхой бүс нутаг, хуулийг хэрэглэх буюу хэрэгжилтэд оролцох талууд гм)*, арга *(хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах, бичгээр хүргэж санал авах гм)*, хэлбэр *(теле, видео, цахим, танхимд зохион байгуулах)*, хугацаа *(тодорхой тов тогтоох, эхлэх дуусах хугацаа тогтоох гм)*-г тогтооно. (*italic* хэсгийг хасч болно)

22.12. Хуулийн төслийг урьдчилан олон нийтэд зарлах нь түүний хэрэгжилтэд оролцогчдыг зохиомол шийдвэр гаргахад хүргэж, хуулийн зохицуулалтын үр нөлөөг бууруулах сөрөг үр дагаварт хүргэхээс урьдчилан сэргийлж, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, өршөөлийн, үндэсний аюулгүй байдалтай холбоотой зэрэг зарим хуулийн төслийг олон нийттэй зөвлөлдөх шаардлагагүй гэж Засгийн газар шийдвэрлэж болно.

22.13. Энэ хуулийн 22.12-т заасан хуулийн төслийг боловсруулах зэргээр уг мэдээллийг мэдэх болсон төрийн албан хаагч, хууль санаачлагч, хууль тогтоогч хэн боловч уг хууль батлагдах хүртэл мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.”

**ДОЛОО.** “Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд өөрийн санаачилж буй хуулийн төсөлд Засгийн газрын санал дүгнэлтийг авах шатанд олон нийттэй зөвлөлдөх хүрээ, арга, хэлбэр, хугацаа тогтооно. Энэ тохиолдолд Энэ хуулийн 22.12, 22.13 нэгэн адил хамаарна” гэдгийг төслийн 19 дүгээр зүйлд нэмж тусгах. (Бидэнд ирүүлсэн Төсөл дээр 22 дугаар зүйлийн дараа, 20 дугаар зүйлийн өмнө, 9 дүгээр хуудсанд энэхүү 19 дүгээр зүйлийг байрлуулсан байв)

**НАЙМ**. Төслийн “Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах” гэсэн тавдугаар бүлгийн нэрийг **“Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх”** гэж өөрчлөх саналтай байна. Уг бүлэгт дараахь агуулгатай зүйлүүдийг нэмж, төслийн 36 дугаар зүйлийг хасах саналтай байна.(Төслийн 37 дугаар зүйлийг гуравдугаар бүлэгт шилжүүлэх саналаа дээр хэлсэн)

## “ТАВДУГААР БҮЛЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ

### 36 дугаар зүйл. Хуулийн төслийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах

36.1.Засгийн газар нь энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаар батлагдсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдсан хуулийн төслийг, Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн өөрийн санаачлан боловсруулах хуулийн төслийг тус тус олон нийттэй зөвлөлдөх хуваариа зөвлөлдөх ажиллагаа эхлэхээс 3 сараас багагүй хугацааны өмнө www.legalinfo.mn цахим хуудасны “Монгол иргэдтэйгээ зөвлөлдөх нь” цэс болон өөрийн цахим хуудсанд дамжин нэвтрэх боломжтой байдлаар байршуулах арга хэмжээ авна.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасан хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх хуваарьт зөвлөлдөх гэж буй хуулийн нэр, зорилгыг тусгаж, иргэн, хуулийн этгээд уг ажиллагаанд оролцохоор бүртгүүлэх, саналаа өгөх боломжийг хангасан байна.

36.3. Энэ хуулийн 22.12-т зааснаас бусад тохиолдолд хууль санаачлагч нь энэ хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын саналыг авч тусгасны дараа хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл, уг хуулийг дагалдан бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, хууль санаачлагч шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох судалгаа, мэдээлэл, хуулийн төсөлд санал авах ажиллагаа эхлэх, дуусах хугацаа, хэлэлцүүлэг, уулзалт, нийтийн сонсгол зохион байгуулах бол түүний огноо, цаг, газрыг www.legalinfo.mn цахим хуудасны "Монгол иргэдтэйгээ зөвлөлдөх нь" цэс болон өөрийн цахим хуудсанд дамжин нэвтрэх боломжтой байдлаар байршуулах арга хэмжээ авна. *(Жич: хуулийн төслийн танилцуулга нь олон нийттэй зөвлөлдөх ажиллагаа дууссаны дараа түүний үр дүнг тусгасан байдлаар бичигдэнэ гэж ойлгогдож буй тул энд танилцуулгыг оруулаагүй бөгөөд үүнтэй холбоотойгоор доор 38.2-ыг харна уу)*

36.4. Энэ хуулийн 36.3-т заасан www.legalinfo.mn цахим хуудасны "Монгол иргэдтэйгээ зөвлөлдөх нь" цэс болон уг цэснээс дамжин нэвтрэх боломж бүхий тухайн хууль санаачлагчийн цахим хуудсаар иргэн, хуулийн этгээд уг хуулийн төсөлд саналаа өгөх, зарлагдсан хэлэлцүүлэг, уулзалт, нийтийн сонсголд оролцохоор бүртгүүлэх боломжийг хангасан байна.

**37 дугаар зүйл. Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх хугацаа, олон нийтийн оролцоог дэмжих бусад арга хэмжээ**

37.1. Хуулийн төсөлд санал авах хугацаа 10 хоногоос багагүй байна.

37.2. Хууль санаачлагч хуулийн төслийн талаар цахим хэлбэрээр зөвлөлдөхийн зэрэгцээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хуулийн төслийг тайлбарлан таниулах, төсөлд саналаа өгөх боломж, арга замын талаар мэдээлэх, иргэд, олон нийтээс гарч буй саналын талаар мэдээлж, тайлбарлах, шаардлагатай бол тодорхой асуудлаар санал асуулга явуулах арга хэмжээг нэгэн зэрэг зохион байгуулах үүрэгтэй.

**38 дугаар зүйл.Хуулийн төсөлд ирүүлсэн саналыг тусгасан эсэх тухай мэдээллийн ил тод байдал**

38.1. Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх ажиллагаа дуусч, хуулийн төслийг Улсын их хуралд өргөн барихын өмнө хууль санаачлагч уг хуулийн төслийн талаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал бүрийг нэгтгэн саналын товъёог үйлдэж, гарсан саналыг хуулийн төсөлд тусгах арга хэмжээ авна. Саналыг тусгах шаардлагагүй гэж үзсэн бол энэ тухай тайлбарыг саналын товъёогт бичнэ.

38.2. Энэ хуулийн 38.1-д заасан саналын товъёог, энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн төслийн танилцуулгыг хууль санаачлагч энэ хуулийн 36.3-т заасан цахим хуудсанд нэмж байршуулна.

38.3. Энэ хуулийн 36.3, 38.1, 38.2-т зааснаар байршуулсан мэдээллийг www.legalinfo.mn цахим хуудсанд 10 жилийн хугацаагаар *(хугацаа тавих уу, тухайн хууль хүчинтэй байх бүх хугацаанд уу, бүр хугацаагүй хадгалах уу?-ярилцах)* архивлан хадгална.

**39 дүгээр зүйл. Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх ажиллагааны журам**

39.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч энэ хуулийн 22.11-д зааснаар хуулийн төслийн талаар олон нийттэй албан ёсоор зөвлөлдөх ажиллагаа эхлэхээс өмнө өөрийн санаачилж буй хуулийн үзэл баримтлалын болон хуулийн төслийн агуулгын талаар олон нийттэй зөвлөлдөж болно. Ийнхүү урьдчилан зөвлөлдсөн нь энэ хуульд заасан олон нийттэй албан ёсоор зөвлөлдөх ажиллагааг орлохгүй.

39.2. Нийтийн сонсгол явуулах журмыг хуулиар тогтооно.

39.3. Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх тодорхой үйл ажиллагааны журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож болно.

**ЕС.** Төслийн 31.1.9-ийг "энэ хуулийн тавдугаар бүлэгт зааснаар хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдсөн тухай мэдээлэл, баримтууд" гэж өөрчлөх

**АРАВ.** Олон нийтэд хууль тогтоомж бүрэн эхээрээ, мадаггүй зөв хүрэх нөхцөлийг хангаж, хариуцлагажуулах үүднээс Төслийн 50 дугаар зүйлд дараахь агуулгатай 50.5 хэсэг нэмэх.(*Энэ бол ОХУ-ын туршлага*)

"50.5. Эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим сан- www.legalinfo.mn цахим хуудсанд оруулсан хууль, түүний нэмэлт, өөрчлөлтийн бичвэрийн төгсгөлд түүнийг оруулсан операторын овог, нэр, огноо, хянасан хуульчийн овог, нэр, огноог бичнэ."

**АРВАННЭГ.** Төслийн "Хуулийн төслийг хэлэлцэн батлах ажиллагаанд тавих ерөнхий шаардлага" гэсэн долдугаар бүлгийг УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлтээр оруулж, "Хуулийн төслийн талаар олон нийттэй зөвлөлдөх Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн нь тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг төсөл санаачлагчид буцаах үндэслэл болно" гэдгийг нэмэх.

**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААН ЛЕКС" ХХН**

**2014 оны 12 дугаар сарын 15**

**ХАВСРАЛТ 1**

## Санаачилсан буюу боловсруулсан хуулийн төсөлд иргэд, байгууллага, олон нийтийн саналыг авч, оролцоог хангасан байдал

| | | |
|---|---|---|
| 1. | Хуулийн нэр, одоогийн статус: батлагдсан, хэлэлцүүлгийн эсхүл боловсруулалтын аль шатанд байгаа | |
| **А. Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байдал** | | |
| 2. | Хуулийн төслийн аль шатанд хэдэн удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан | |
| 3. | Ямар хүрээнд: орон даяар, нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэр, эрх ашиг сонирхлыг нь хөндсөн этгээд, тухайн хуулийг хэрэгжүүлэх байгууллагын хүрээнд гм. | |
| 4. | Нийт оролцогчдын тоо | |
| 5. | Хэлэлцүүлэх гэж буй хуулийн төслийг оролцогчдод ямар хугацааны өмнө хэрхэн хүргэсэн: вэб дээр тавьсан урьдчилан бичгээр, цахим шуудангаар хүргэсэн, хэлэлцүүлэгт ирэхэд нь тараасан, хуулийн төслийг тараалгүйгээр танилцуулга хийсэн гм: | |
| 6. | Хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан байгууллага \иргэний танхим, төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага гм\: | |
| 7. | Хэлэлцүүлгийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэсэн \Хөгжлийн байгууллага, улс, орон нутгийн төсөв, зардал гаргаагүй бол ямар болмжийг ашигласан гм\: | |
| 8. | Нийт хэдэн хүн, хэдэн санал гаргасан: | |
| 9. | Гарсан саналыг тусгайлан авч хэлэлцэж, дүн шинжилгээ хийсэн эсэх? Хэлэлцүүлгээс гарсан саналын хэдийг\хэдэн хувийг нь хуулийн төсөлд тусгасан: | |
| 10. | Санал гаргасан этгээдэд хуулийн төсөлд тусгасан эсэх талаар мэдэгдсэн үү, тийм бол мэдэгдсэн арга: хэлэлцүүлгийн үеэр тайлбарлаж хариулсан, бичгээр, цахим шуудангаар, мессежээр хариу өгсөн, саналын товъёогийг вэб дээр тавьсан гм: | |
| 11. | Хуулийн төслийг уулзалт, хэлэлцүүлэг хийх замаар санал авахад учирсан бэрхшээл, ололттой тал: | |
| **Б.Цахим хэлэлцүүлэг** | | |
| 12. | Хуулийн үзэл баримтлал, төслийг байрлуулсан Вэб хуудасны нэр, анх | |

| | | |
|---|---|---|
| | тавьсан болон, авсан огноо: | |
| 13. | Цахим хэлэлцүүлэгт зориулж тавигдсан мэдээллийг тухайн вэб дээр нь архивладаг эсэх, тийм бол ямар хугацаанд ашиглах боломжтой: | |
| 14. | Цахим хэлэлцүүлгийн үеэр хэдэн хүнээс, хэдэн санал ирсэн: | |
| 15. | Ирүүлсэн саналын товъёог боловсруулсан, тусгайлан авч хэлэлцэж, дүн шинжилгээ хийсэн эсэх: | |
| 16. | Санал гаргасан этгээдэд өгсөн саналыг нь хуулийн төсөлд тусгасан талаар мэдэгдсэн эсэх; | |
| | **В. Бусад асуудал** | |
| 17. | Орон нутагт санал авах ажиллагаа зохион байгуулж байсан уу? | |
| 18. | Уг хуулийн төслийг боловсронгуй болгоход эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг хэрхэн \хэлэлцүүлэг, ажлын хэсэгт урьсан, төслөө хүргүүлж санал авсан, сайн дураараа саналаа ирүүлсэн гм\ оролцуулсан, түүний үр дүн: | |
| 19. | Нэмэлт саналаа энд бичнэ үү: | |

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ИРҮҮЛСЭН АСУУЛГЫН НЭГТГЭЛ

| № | Асуулга | Б.Чойжилсүрэн | З.Баян-сэлэнгэ | Л.Эрдэ-нэчимэг | О.Баасанхүү | Н.Энх-болд | С.Ган-баатар | Н.Бат-баяр | Л.Ган-төмөр | С.Оюун | С.Эрдэнэ | С.Бямбацогт | Ж.Бат-суурь | Ц.Оюун-гэрэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн нэр, одоогийн статус: батлагдсан, хэлэлцүүлгийн эсхүл боловсруулалтын аль шатанд байгаа | 1 хууль<br><br>Боловсруулалтын шатанд байгаа | 5 хууль<br><br>Тов тогтоолгохоор явуулсан | 1 хууль<br><br>Өргөн мэдүүлсэн | 3 хууль<br><br>Өргөн барих шатанд байгаа | 2 хууль<br><br>1-ыг УИХ-д өргөн барихад бэлдсэн, 1-ыг саналыг нэгтгэж байгаа | 4 хууль<br><br>2 нь боловсруулалтын шат, 1 өргөн мэдүүлсэн, 1 батлагдсан | 1 хууль<br><br>Өргөн мэдүүлсэн | 4 хууль<br><br>Хэлэлцүүлгийн шатанд байгаа | 1 хууль батлагдсан | 3 хууль<br><br>2 хуулийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн 1 хуулийг УИХ-аар дэмжсэн, одоо ажлын хэсэгт байгуулагдаж байгаа | 1 хууль<br><br>боловсруулалтын шатанд байгаа | 2 хууль<br><br>1-өргөн мэдүүлсэн, 1- байнгын хороо хэлэлцэж байгаа | 3 хууль<br><br>1- УИХ-д өргөн баригдсан, 2-боловсруулж дууссан |
| **А. Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байдал** | | | | | | | | | | | | | | |
| 2 | Хуулийн төслийн аль шатанд хэдэн удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан | 4 | Үгүй, иргэдийн гомдлоор | 4 | 1 хуулийг 2 удаа, 1 хуулийг 5 удаа, 1 хуулийг 2 удаа | 1 хуулийг 40 удаа, 1 хуулийг 24 удаа | 1 хуулийг 5 удаа, үлдсэн 3 хууль нь тодорхойгүй | Ойлгомжгүй хариулт | 4 хуулийг 8 удаа | 2 | 1 хуулийг 6 удаа, 2 хуулийг 11 удаа | 2 удаа | Ойлгомжгүй хариулт | 1 хуулийг 10 удаа, 1 хуулийг 8 удаа, 1 хууль тодорхойгүй |
| 3 | Ямар хүрээнд: орон даяар, нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжил, нутаг дэвсгэр, эрх ашиг сонирхлыг нь хөндсөн этгээд, хэрэгжүүлэх байгууллагын хүрээнд гм. | Хуульч, судлаачид | үгүй | Нийслэлийн удирдлага, худалдаа эрхлэгч, цагдаа, эмнэлгийн ажилтнууд | 2 хууль нь эрх ашиг нь хөндсөн этгээдүүдээс авсан.<br>1 хууль нь нийтээр | Орон нутагт болон салбарын хүмүүсийн хүрээнд | Ажил мэргэжлийн хүрээнд | 21 аймаг, 330 сум, УБ хотын иргэдийн дунд санал авсан | Салбарын хүрээнд, Аймаг, нийслэлийн Боловсролын газраар дамжуулан орон нутагт, ТББ | Тухайн асуудал эрхэлсэн төр, ТББ, байгууллагын төлөөлөлцэг, эх | Үндэсний хэмжээнд, тухайн салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, Шүүгч болон өмгөөлөгчд өөр тус тус хэлэлцүүлсэн | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид | Аймаг, сумдын ИТХ, хөдөөгийн малчид | Орон даяар, салбарын байгууллага, мэргэжилтнүүдтэй |
| 4 | Нийт | 40 | Байхгүй | 640 | 9 | 1636 | 72 | 100,000 | 300 | 20-30 | 2600 | 100 | 3240 | 51100 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцогчдын тоо | | Өршөөлийн хууль тул энэ зөв | | | | | | | | | | | |
| 5 | Төслийг оролцогчдод ямар хугацааны өмнө хэрхэн хүргэсэн: вэб, бичгээр, цахим шуудангаар хүргэсэн, хэлэлцүүлэгт ирэхэд нь тараасан, тараалгүй танилцуулсан | Цахим шуудан | Цахим шуудан | Албан бичгээр | Албан бичгээр, цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр | Цахим шуудангаар болон бичгээр | Бичгээр, цахим шуудангаар | Албан бичгээр | Албан бичгээр болон цахим хаягаар | Цахим шуудан | Цахим хаягаар, утсаар | Хэвлэн тараасан | Хуулийн төслийг танилцуулах хэлбэрээр | Хэлэлцүүлэгт ирэхэд нь тараасанцахим шуудан |
| 6 | Хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан байгууллага \иргэний танхим, ТББ, орон нутгийн байгууллага гм\: | Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтарсан | Төрийн, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага | Иргэний танхим, цагдаагийн байгууллага | УИХ-ын гишүүний өөрхийн ажлын албан зохион байгуулсан | Салбарын байгууллага болон төрийн байгууллагатай хамтарсан | Мэргэжлийн хүмүүс болон ТББ | Яамдууд, ЗДТГ, аймаг, сумдын ИТХ | Төслийн багтай | Нээлттэй нийгэм хүрээлэн, ТББ | ТББ, ОУБ, аймаг, дүүргийн ЗДТГ, ХГБХХ-тэй хамтран | Орон нутгийн ЖДҮГ | Орон нутгийн байгуулага | Үгүй |
| 7 | Хэлэлцүүлгийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэсэн | Хувиасаа болон гишүүнийн батлагдсан төсвөөс | ТББ болон ОУБ | Үнэгүй ашигласан | Өөрийн дотоод нөөц болон УИХ-ын гишүүний төсвөөс | CHF Канадын хоршоодын холбоо болон УИХ-ын гишүүний төсвөөс | Уих-ын гишүүний төсвөөс | НҮБ | АХБ-ын санхүүжилт,<br>1 хууль зардал гараагүй | Уих-ын гишүүний төсвөөс | НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад хөгжлийн байгууллагуудаас | Хувиас | Тойрогт ажиллах боломжийг ашигласан | Зардал гараагүй Улс орон нутгийн төсөв |
| 8 | Нийт хэдэн хүн, хэдэн санал гаргасан: | 20 хүн, 30 санал | Байхгүй | 300 | 12 | 163 | 24 хүн 30 санал | 9700 | 23 байгууллагаас 252 | 20-30 хүнээс 30-50 санал | 16 байгууллага болон 15 Яамдаас 468 санал | 40 хүн 80 санал | | |
| 9 | Гарсан санал дүн шинжилгээ хийсэн эсэх? Хэлэлцүүлгээс гарсан саналын хэдэн хувийг нь | 80% | байхгүй | Олонхийн саналаар | Дүн шинжилгээ хийсэн | 60% | 50%, 30%, бүрэн | 70-80% | 30%<br>27% | 10% | 97%<br>78.5% | 20% | 5% | Боломжит саналууд бүгд тусгагдсан |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөлд тусгасан: | | | | | | | | | | | | | |
| 10 | Санал гаргасан этгээдэд хуулийн төсөлд тусгасан эсэх талаар мэдэгдсэн эсэх, мэдэгдсэн арга | Хэлэлцүүлгийн үеэр | Хэлэлцүүлгийн үеэр | Мэдэгдээгүй | Цахим хуудас болон бичгээр хариу өгсөн | Хэлэлцүүлгийн үеэр тайлбарлах болон цахим шуудангаар хариу өгсөн | Цахим шуудангаар, нэгийг мэдэгдээгүй байгаа | Мэдэгдээгүй | Хэлэлцүүлгийн үеэр | Дараагын хэлэлцүүлгийн үеэр, цахим шуудангаар, албан бичгээр | Хэлэлцүүлгийн үеэр | Мэдэгдээгүй | Танилцуулгын үеэр тайлбарласан | Хэлэлцүүлгийн үеэр болон цахим шуудангаар |
| 11 | Хуулийн төслийг хэлэлцүүлхэд бэрхшээл, ололттой тал: | Орчуулга, оноосон хэллэгийн бэрхшээл | Хөрөнгө санхүүгийн бэрхшээл | Иргэдийг дасгах шаардлагатай | Хариуг удаашруулсан | Оролцогчид идэвхитэй байсан нь ололттой байсан | Ажлын байрны бэрхшээл байсан | Монголын бүх аймаг, сумдаар явж санал авсан ололттой | Байхгүй | Зохицуулах шаардлагатай асуудлаар санал солилцох сайн талтай | Саналыг тусгаснаараа хэрэгжилтийн механизмд байга хүндрэл учирдаг | Урьдчилсан мэдээлэл хүргэх дутагдалтай байсан | Хөрөнгө санхүү | Ажлын бус цагаар байнга ажиллах шаардлага гарсан |
| **Б.Цахим хэлэлцүүлэг** | | | | | | | | | | | | | | |
| 12 | Хуулийн үзэл баримтлал, төслийг байрлуулсан Вэбийн нэр, тавьсан авсан огноо: | үгүй | үгүй | www.Erdenechimeg.parliament.mn 2014.06.11 | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өөрийн twitter хуудсанд 2014.09.24 | 2010 болон 2011 оноос хойш www.mongolia.coop; www.namac.mn; www.redcross.mn; | Үгүй | Үгүй | Ямны цахим хуудсан дээр 2014 оны 4 сараас тавигдсан | УИХТГ-ын ажилтан хариуцдаг тул хариулах боломжгүй | www.mpdsp.gpv.mn www.khuukhednac.gov.mn www.nac.gov.mn | www.vip76.mn | Үгүй | Тавигдаагүй |
| 13 | Цахим хэлэлцүүлэгт тавигдсан мэдээллийг тухайн вэб дээр нь архивладаг эсэх, тийм бол ямар хугацаанд ашиглах боломжтой: | үгүй | үгүй | үгүй | Устгаагүй тохиолдолд байж байдаг | 3 дотор ашиглах боломжтой | Үгүй | Үгүй | Хадгалагддаг | | Хуулийн төслийг батлагдаж хүртэл архивладаг | үгүй | Үгүй | |
| 14 | Цахим хэлэлцүүлгийн үеэр хэдэн | үгүй | Үгүй | ирээгүй | 14 | 46 | Үгүй | Үгүй | Онцгойлсон санал ирээгүй | | Сайжруулах чиглэлээр санал ирдэг | 30 хүнээс 20 санал | Үгүй | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүнээс, хэдэн санал ирсэн: | | | | | | | | | | | | | |
| 15 | саналын товъёог хийж, тусгайлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийсэн эсэх: | үгүй | Үгүй | үгүй | Цахим хуудсаар хариулсан | Дүгнэж төсөлд тусгасан | Үгүй | Үгүй | Боломжтой гэж үзсэнийг тусгасан | | Ажлын хэсэгт танилцуулдаг | | Үгүй | Дүн шинжилгээ хийсэн |
| | Саналыг тусгасан эсэх талаар мэдэгдсэн эсэх; | үгүй | Үгүй | үгүй | мэдэгдсэн | Цахим шуудангаар мэдэгдсэн | Үгүй | Үгүй | Хэлэлцүүлгийн үеэр | | Үгүй | Үгүй | Үгүй | Хариу мэдэгдсэн |
| **В. Бусад асуудал** | | | | | | | | | | | | | | |
| | Орон нутагт санал авах ажиллагаа зохион байгуулж байсан уу? | тийм | Өөрөө орон нутагт ажиллахдаа танилцуулсан | Орон нутгийн Засаг дарга нараас авсан | Орон нутагт ажиллахдаа танилцуулсан | Зохион байгуулсан | Үгүй | тийм | Тийм | Орон нутгийн төлөөлөл оролцсон | Тийм | Байсан | Говь-Сүмбэр, Дорноговь аймгийн бүх сумд | Зохион явуулсан |
| | Уг хуулийн төслийг боловсронгуй болгоход, эрдэмтэн судлаачдыг хэрхэн оролцуулсан, түүний үр дүн: | Тийм, бусад орны хуулийг судалсан | Танил эрдэмтэн судлаачдаас авсан | үгүй | Тухайн салбарын хүмүүс болон байгууллага, хувь хүмүүсээс санал авсан | Эрдэмтэн багш нараас авсан | Эрдэмтэн судлаачдаас санал авсан | Ойлгомжгүй хариулт | Багш нараас авсан | Эрдэмтэн, судлаачдад хүргүүлж санал авсан | Ажлын хэсэгт судлаачид ажилласан | Оролцуулсан | ШУА-ын судлаачид | |
| | Нэмэлт саналаа энд бичнэ үү: | байхгүй | байхгүй | байхгүй | байхгүй | Хууль тогтоох байгууллага идэвхи санаачлагатай ажиллах | ЗГ дээр маш удаан хэлэлцдэг, мэргэшсэн хуульч дутагдалтай | Ойлгомжгүй хариулт | Ойлгомжгүй хариулт | байхгүй | байхгүй | Холбогдох этгээдээс санал авах, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, санал авдаг тусгай цахим хуудас, сонин, ТВ-тэй болох | Байхгүй | Байхгүй |

## ЯАМДУУДААС ИРҮҮЛСЭН АСУУЛГЫН НЭГТГЭЛ

| № | Анкетын асуулга | ГХЭЗХАЯ | БХЯ | ҮХААЯ | СЯ | БОНХЯ | ЭМЯ | БШУЯ | ССАЖЯ | ХЗЯ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн нэр, одоогийн статус: батлагдсан, хэлэлцүүлгийн эсхүл боловсруулалтын аль шатанд байгаа | 2 хууль<br><br>Боловсруулах эхний шатанд яваа тул доорх ажлууд эхлээгүй | 3 хууль<br><br>1 бодлогын баримт бичиг, боловсруулан ҮАБЗ, ЕТГ-т хүргүүлээд байна | 3 хууль<br><br>1 нь үзэл баримтлал батлагдсан, 1 нь Яамдаас санал авах, 1 нь ЗГ-т хүргүүлсэн | 15 хууль<br><br>7 хууль батлагдсан, 3-УИХ-аар хэлэлцэж байгаа, 1-УИХ-д өргөн барьсан, 2-ТБХ – оор, 1-эргүүлэн татсан, 1 хууль аль шатанд байгаа нь тодорхойгүй | 3 хууль<br><br>1-СЯ-аас, 1-ЗГ-аас УИХ-д өргөн барих зөвшөөрөл авахаар хүргүүлсэн, 1-үзэл баримтлал батлагдсан, | 4 хууль<br><br>2 хуулийг ЗГ-т хүргүүлэхэд бэлэн болсон, 1-Яамдаас санал авч байгаа, 1-боловсруулалтын шат | 4 хууль<br><br>Хэлэлцүүлгийн шатанд байгаа | 7 хууль,<br><br>1-батлагдсан, 1-ү/б-д санал авч байна, 1-УИХ-д хэлэлцэхээр шийдсэн, 2- ү/б-ын төсөл, 1-санал авах, 1-боловсруулалт | 11 хууль<br><br>3-УИХ-д ө/м., 1-ЗГ-т хүргүүлсэн, 4-санал авч байгаа, 1- хэлэлцүүлгийн шатанд, 1-боловсруулалтын шатанд , 1 хууль ү/б батлагдсан |
| **А. Хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байдал** | | | | | | | | | | |
| 2 | Хуулийн төслийн аль шатанд хэдэн удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан | | Олон нийтээр хэлэлцүүлээгүй | 1 хуулийг 14 удаа, 1 хуулийг 11 удаа, 1 хуулийг 13 удаа, | 1 хуулийг 7 удаа, 1 хуулийг 11 удаа, 2 хуулийг 10 удаа, 1 хуулийг 5 удаа | 1 хуулийг 8 удаа, 1 хуулийг 13 удаа, 1 хуулийг 5 удаа | 1 хуулийг 10 удаа, 1 хуулийг 6 удаа, 1 хуулийг 4 удаа | 4 хуулийг 8 удаа | 1 хуулийг 20 удаа, 1 хуулийг 5 удаа, 1 хуулийг 4 удаа, 1 хууль нь тодорхойгүй | 1 хуулийг 5 удаа, 1 хуулийг 3 удаа, 1 хуулийг 14, 1 хуулийг 1 удаа, 1 хуулийг 1 удаа, 1 хуулийг 3 удаа, 1 хуулийг 1 удаа, 1 хуулийг 25 удаа, 1 хуулийг 13 удаа, 1 хуулийг 1 удаа, |
| 3 | Ямар хүрээнд: орон даяар, нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэр, эрх ашиг сонирхлыг нь хөндсөн этгээд, тухайн хуулийг | | Төрийн захиргааны байгууллага, ЗХЖШ, БХ Эрдэм шинжилгээний хүрээлэн /Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тул тодорхой хүрээнд/ | Орон нутагт болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулсан | Залуу мэргэжилтнүүдийн хөдөлгөөн, Төрийн захиргааны байгууллага, Намын бүлэг, салбарын мэргэжилтнүүд, хуулийг хэрэгжүүлэх байгууллага, эрх, ашиг, сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд, ажил мэргэжлийн хүрээнд, | Тухайн иргэний хөдөлгөөний төлөөлөл, хуулийг хэрэгжүүлэх байгууллага, салбарын төлөөлөл МБОИЗ, ҮХААЯ | Эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүд, хууль хэрэгжүүлэх этгээдүүд | Салбарын хүрээнд, Аймаг, нийслэлийн Боловсролын газраар дамжуулан орон нутагт, ТББ | Орон даяар, нийгмийн тодорхой бүлэг, хуулийг хэрэгжүүлэх байгууллага, ажил мэргэжлийн хүрээнд, эрх ашиг нь хөндсөн этгээд | Орон нутагт, Иргэд, ТББ, Хуульчид, харъяа байгууллага, эрдэмтэн, судлаач, салбарын төрийн болон ТББ, БНСУ, ХБНГУ, Молдав улсын судлаачид |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх байгууллагын хүрээнд гм. | | | | | | | | | |
| 4 | Нийт оролцогчдын тоо | | 30 орчим хүн ажилласан | 4312 | 505 | 1459 | 3050 | 300 | Бүх ажилчид , 6-8 | 9437 |
| 5 | Хэлэлцүүлэх гэж буй хуулийн төслийг оролцогчдод ямар хугацааны өмнө хэрхэн хүргэсэн: вэб дээр тавьсан урьдчилан бичгээр, цахим шуудангаар хүргэсэн, хэлэлцүүлэгт ирэхэд нь тараасан, хуулийн төслийг тараалгүйгээр танилцуулга хийсэн гм: | | 7 хоногийн өмнө хүргүүлсэн | Цахим шуудангаар болон бичгээр хүргүүлсэн | Цахим шуудангаар болон Яамдад бичгээр , урьдчилан бичгээр | Цахим шуудангаар | Албан бичгээр | Албан бичгээр болон цахим хаягаар | Бичгээр, цахим шуудангаар | Цахим хуудсаар, цаасан хувилбараар, хэлэлцүүлгийн үеэр, цахим шуудангаар, |
| | Хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан байгууллага \иргэний танхим, төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага гм\: | | БХЯ, ЗХЖШ, БХИС | ТББ, ОУБ болон салбарын байгууллагуудтай | ЕТГ, ЗГ, МБХ, ММНБИ, Дэлхийн банк, Щвейцарын агентлагын суурин төлөөлөгч, баг, сумдын ЗД, Онцгой байдлын газар, УИХ 6 гишүүн | МХЕГ, Монголын иргэний зөвлөл, ЗБГХТХ-ийн БОЖЭГХТТасаг, НҮБХХ, ХЗ-ууд, ТББ, ҮХААЯ | АХБ, ДЭМБ, МЭАҮЭХ, МӨАУМХ, ТББ | Төслийн багтай | ЮНЕСКО, Номын сангийн консерциум, Дэлхийн АЖБ, харъяа байгууллага, Аймаг нийслэлийн ССАЖГ | ЕСБХБ, ХЗҮХ, ШШГЕГ, ХСИС, ЕТГ, USAID-BPI, ИТ, ННФ, МХЭХ, Ханнс Зайделийн төсөл, ОУСК, УБЕГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Хэлэлцүүлгийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэсэн \Хөгжлийн байгууллага, улс, орон нутгийн төсөв, зардал гаргаагүй бол ямар болмжийг ашигласан гм\: | | Хөрөнгө төсөвлөөгүй | НҮБ, Дэлхийн банк, төсвөөс | ЕТГ, Nextgen club, Яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дэлхийн банк болон ММНБИ, Малын индексжүүлсэн даатгал төслөөс | Яамны дотоод нөөц бололцоо, НҮБХХ, Дэлхийн банк, Германы ОУХАН, БХС | Эрүүл мэндийг дэмжих сан, хэлэлцүүлэгт тусад нь санхүүжилт төлөвлөж гаргаагүй | АХБ-ын санхүүжилт, 1 хууль зардал гараагүй | Улс орон нутгийн төсөв | Яамны санхүүжилт, НҮБ-ын ХС, ОУСК, Азийн сан, USAID-BPI, ЕСБХБ |
| 7 | Нийт хэдэн хүн, хэдэн санал гаргасан: | | Ажлын хэсгийн гишүүдийн санал | 2449 | 3 хууль дээр 420 санал, бусад хууль дээр Төрийн захиргааны байгууллагын уулзалтуудаар | 106 хүн 100 санал | 170 хувь хүн, байгууллага 300 гаруй санал | 23 байгууллагаас 252 | | 330 байгууллагаас 3191 санал |
| 8 | Гарсан саналыг тусгайлан авч хэлэлцэж, дүн шинжилгээ хийсэн эсэх? Хэлэлцүүлгээс гарсан саналын хэдийг\хэдэн хувийг нь хуулийн төсөлд тусгасан: | | Санал тус бүрийг судалсан | 2/3, 56%, 70% | 1 хууль – 50%, бусад хуульд тухай бүрд нь тусгасан<br>1 хууль 70% | 70% | 70% | 30%<br>27% | Боломжит саналууд бүгд туссан | 60%, 30%, 50%, 90%,<br>90% 29 % |
| 9 | Санал гаргасан этгээдэд хуулийн төсөлд тусгасан эсэх талаар | | Амаар болон албан бичгээр | Хэлэлцүүлгийн үеэр болон цахим шуудангаар | Хэлэлцүүлгийн үеэр тайлбарлаж хариулсан. Цахим шуудангаар хариу явуулсан | Хэлэлцүүлгийн үеэр, хуулийн төслийг цахим шуудангаар хүргүүлдэг | Хэлэлцүүлгийн явцад | Хэлэлцүүлгийн үеэр | Хэлэлцүүлгийн үеэр болон цахим шуудангаар | Саналыг тодруулахаар утсаар холбоо барьсан, хэлэлцүүлгийн үеэр хариулсан |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдэгдсэн үү, тийм бол мэдэгдсэн арга: хэлэлцүүлгийн үеэр тайлбарлаж хариулсан, бичгээр, цахим шуудангаар, мессежээр хариу өгсөн, саналын товъёогийг вэб дээр тавьсан гм: | | | | | | | | | |
| 10 | Хуулийн төслийг уулзалт, хэлэлцүүлэг хийх замаар санал авахад учирсан бэрхшээл, ололттой тал: | | Ажлын хэсгийн гишүүдийн ирц хүндрэлтэй байсан | Хөрөнгө, санхүүгийн бэрхшээл байдаг. Туршлага судлах ололттой байдаг | Х/т-д авах боломжгүй саналыг тусгуулахаар эрмэлзэж цаг алддаг, хуулийн төсөлтэй урьдчилж танилцаагүйгээс цаг их алддаг | Хэлэлцүүлгийн үеэр үндэслэлтэй саналыг шууд тусгах сайн талтай | Шинэ асуудлын талаар ойлгол өгөх | Байхгүй | Санхүүжилт байхгүй байсан | Санал нэг бүрийг тусгах боломжгүй байдаг, мэдээллийн шинжтэй зүйл ярьдаг |
| **Б.Цахим хэлэлцүүлэг** | | | | | | | | | | |
| 11 | Хуулийн үзэл баримтлал, төслийг байрлуулсан Вэб хуудасны нэр, анх тавьсан болон, авсан огноо: | | www.mod.gov.mn | ҮХААЯ-ны цахим хуудсанд 30 хоногийн хугацаатай | www.mof.gov.mn www.parliament.mn www.president.mn www.iltod.gov.mn www.lblip.mn www.parliament.mn | www.mne.gov.mnwww.econet.mnwww.facebook.com | www.moh.mn 2014.1-2014.6; 2013.03.20-2014.10; 2010 онд | Яамны цахим хуудсан дээр 2014 оны 4 сараас тавигдсан | www.mcst.gov.mn10 сард байршуулж 1 сард авсан, зарим нь тавигдаагүй байгаа | www.Moj.gov.mn 2014.05.28, www.burtgel.mn 2014.04.31, www.moj.gov.mn 2014.07.23, www.moj.gov.mn 2014.01.14, www.moj.gov.mn 2014.07.09, |
| 12 | Цахим хэлэлцүүлэгт зориулж тавигдсан мэдээллийг тухайн вэб | | Ойлгомжгүй хариулт | Архивладаггүй | Байхгүй<br><br>Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль нь төслийн | 3 санал | Үгүй | Хадгалагддаг | | УИХ-аар батлагдах хүртэл байрлуулдаг, архивладаг, |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээр нь архивладаг эсэх, тийм бол ямар хугацаанд ашиглах боломжтой: | | | | хугацаанд архивлагдана | | | | | |
| 13 | Цахим хэлэлцүүлгийн үеэр хэдэн хүнээс, хэдэн санал ирсэн: | | 2 | 30 хүнээс 57 санал | Үгүй | Ирээгүй | 3 хүнээс 5 санал | Онцгойлсон санал ирээгүй | | Санал ирээгүй, |
| 14 | Ирүүлсэн саналын товъёог боловсруулсан, тусгайлан авч хэлэлцэж, дүн шинжилгээ хийсэн эсэх: | | Саналын товчоог нэгтгэсэн | Товъёог үүсгэсэн | Үгүй МИДТХ саналын товъёог боловсруулсан | Саналыг товъёог үүсгэсэн | Товъёог үүсгэсэн | Боломжтой гэж үзсэнийг тусгасан | Дүн шинжилгээ ийсэн | |
| 15 | Санал гаргасан этгээдэд өгсөн саналыг нь хуулийн төсөлд тусгасан талаар мэдэгдсэн эсэх; | | Амаар болон утсаар | Цахим шуудангаар болон харилцах утсаар хариу өгсөн, мөн уулзалт зохион байгуулсан | Үгүй МИДТХ хариу өгсөн | Ойлгомжгүй хариулт | Мэдэгдээгүй | Хэлэлцүүлгийн үеэр | Хариу мэдэгдсэн | |
| **В. Бусад асуудал** | | | | | | | | | | |
| 16 | Орон нутагт санал авах ажиллагаа зохион байгуулж байсан уу? | | Орон нутгийн нэгж байгууллагаар дамжуулсан | Орон нутагт зохион байгуулсан | 1 хууль 2-3 аймагт | 1 хууль Зохион байгуулаагүй, 1 хууль зохион байгуулсан | Зохион байгуулсан | Тийм | Зохион явуулсан | Зохион байгуулсан 5 зохион байгуулаагүй 5 |
| 17 | Уг хуулийн төслийг | | үгүй | Эрдэмтэн, судлаачдад | 3 хууль багш нараас санал | Эрдэмтэн, судлаачдад | Оролцуулсан | Багш нараас авсан | Ажлын хэсэгт төлөөллүүд | ХЗС, Эрдэм шинжилгээний |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсронгуй болгоход эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг хэрхэн \хэлэлцүүлэг, ажлын хэсэгт урьсан, төслөө хүргүүлж санал авсан, сайн дураараа саналаа ирүүлсэн гм\ оролцуулсан, түүний үр дүн: | | | хүргүүлсэн | авсан<br>1 хууль олон улсын болон дотоодын зөвлөхүүдээс санал авсан | хүргүүлж санал авсан | | | байсан | байгууллага, багш-7<br>Аваагүй-4 |
| 18 | Нэмэлт саналаа энд бичнэ үү: | | байхгүй | Үзэл баримтлалын дахин дахин хянах, хоёр удаа батлах нь цаг алдах шалтгаан болдог. Нэг төсөлд шаардагдах жишиг зардлыг гаргах | байхгүй | байхгүй | байхгүй | Ойлгомжгүй хариулт | байхгүй | Орон нутагт хэлэлцүүлэх, өдөр тутмын сонинд нийтлүүлж санал авах, хэлэлцүүлгийн зардлыг төсөвт тусгадаг байх |

**ДҮГНЭЛТ**

НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газарт хэрэгжиж буй "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төслийн хүрээнд манай байгууллага "Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийг судалж" байгаатай холбогдуулан хууль санаачлах эрхтэй \хуулийн төсөл боловсруулдаг\ Ерөнхийлөгчийн Тамгын газар ,Улсын Их Хурлын 76 гишүүн, 13 Яамд \нийт 91 этгээд\ руу анкетийн судалгааг УИХ-ын Тамгын газрын даргын гарын үсэг бүхий албан бичиг хүргүүлснээс Улсын Их Хурлын 13 гишүүн, 9 Яамдаас хариу ирсэн юм.

Судалгаанд оролцсон 21 хууль санаачлагч\ хуулийн төсөл боловсруулагч\-даас 78 \69 нь хуулийн төсөл, 9 нь батлагдсан хууль\ хуулийн төслийн талаарх мэдээлэл ирүүлсэн бөгөөд үүнээс 9 хууль батлагдсан, 25 хуулийн төсөл нь боловсруулалтын шатанд байгаа, 42 хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн, хэлэлцүүлэх шатанд байгаа, 2 хуулийн төсөл нь аль шатанд байгаа нь тодорхойгүй байлаа.

Судалгаанд хамрагдсан хуулийн төслөөс 33 төслийг 1-10 удаа, 9 төслийг 10-20 удаа, 4 төслийг 20-оос дээш удаа хэлэлцүүлж, уулзалт зохион байгуулсан бол 12 төслийг олон нийтээр хэлэлцүүлээгүй бөгөөд 7 хуулийг хэлэлцүүлсэн эсэх нь хариултаас тодорхойгүй байна. Уулзалт, хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн хувьд шүүгч, өмгөөлөгч, хуульч, эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүд, ажил мэргэжил, салбарын хүрээнд хэлэлцүүлсэн байдаг бол Яамдын санаачилсан хуулийн төслийг эрх ашиг нь хөндөгдөх болон тухайн хуулийг хэрэгжүүлэх этгээдүүд, ажил мэргэжлийн хүрээнд, төрийн бус байгууллага, тухайн иргэний хөдөлгөөний төлөөлөл болон орон даяар хэлэлцүүлжээ. Судалгаанаас үзвэл Яамдын санаачилсан хуулийн төслүүдийн олонхийг орон даяар хэлэлцүүлсэн байгаа нь харьяа байгууллага, зохион байгуулалтын бүтцийн давуу талыг харуулж бана. Улсын Их Хурлын гишүүд нь орон нутагт ажиллах үеэрээ санаачилж буй хуулийн төслөө хэлэлцүүлж, танилцуулдгаас гадна Н.Энхболд \Хоршооны тухай, МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай CHF Канадын хоршоодын холбоо, УИХ гишүүний зардлаар, 1636 хүн\, Н.Батбаяр \Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төслийг НҮБ-ийн санхүүжилтээр 100 000 хүн\, Ж.Батсуурь \Газрын тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг тойрогт ажиллах явцдаа 3240 хүн\ нар нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан болон, малчдаар хэлэлцүүлсэн байна.

19 хуулийн төслийн хэлэлцүүлэгт 1-100 иргэн, албан байгууллага, 14 хуулийн төсөлд 100-500 иргэн, байгууллага, 6 хуулийн төсөлд 500-1000 иргэн байгууллага, 15 хуулийн төслийн хэлэлцүүлэгт 1000-аас дээш иргэн байгууллага оролцсон байх бөгөөд 8 хуулийн төсөлд хэдэн хүн оролцсон нь тодорхойгүй, 2 хуулийн төсөл хэлэлцүүлгээ хараахан зохион байгуулаагүй байгаа, харин Сангийн яам Улсын төсөвтэй холбоотой 8 хуулийн төслийг нийт хүн амаар хэлэлцүүлсэн гэж хариулжээ.

Давхардсан тоогоор 29 хуулийн төслийг цахим хуудсан дээр байрлуулан, 15 хуулийн төслийг цахим шуудангаар, 11 хуулийн төслийг албан бичгээр хүргүүлэн танилцуулснаас зөвхөн 4 хуулийн төслийг хэлэлцүүлэг болохоос 3-10 хоногийн өмнө хүргүүлсэн талаар дурдаж, бусад хуулийн төслийг хэдий хугацааны өмнө хүргүүлсэн талаар хариулт өгөөгүй байгаа нь оролцогчид саналаа урьчдилан бэлтгэх боломж хангалттай биш байдаг гэсэн дүгнэлтэд хүргэхээр байна.

Хууль санаачлагчид хуулийн төслийн хэлэлцүүлгээ олон төрлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдгаас 9 хууль санаачлагч Төрийн байгууллагуудтай, 7 хууль санаачлагч орон нутгийн ЗДТГ болон орон нутгийн бусад байгууллагуудтай, 6 хууль санаачлагч олон улсын байгууллагатай, 1 хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүний ажлын албаараа, 7 хууль санаачлагч төрийн бус байгууллагатай, 4 хууль санаачлагч Иргэний танхим, Нээлттэй нийгэм форумтай, 1 хууль санаачлагч салбарын байгууллага, 3 хууль санаачлагч төслийн багтай хамтран ажилласан бөгөөд, 1 хууль санаачлагч өөрөө хэлэлцүүлгээ зохион байгулсан байна.

Улсын Их Хурлын гишүүдийн хувьд хэлэлцүүлэг зохион байгуулахад хөрөнгө санхүүгийн асуудал маш хүнд байдаг талаар дурдсан ба судалгаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдээс 6 гишүүн хувиасаа болон гишүүний батлагдсан төсвөөс, 5 гишүүн олон улсын байгууллагын санхүүжилтээр, 1 гишүүн тойрогт ажиллах боломжоо ашигласан бол 2 гишүүн ямар нэгэн зардал гаргалгүйгээр хэлэлцүүлжээ. Яамдын хувьд 5 Яам НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн сан, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, USAID, Германы ОУХАН зэрэг олон улсын байгууллагаас санхүүжсэн байдаг бол Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Хууль зүйн яам төсвөөс санхүүжиж, Батлан хамгаалах яам хөрөнгө төсөвлөөгүй байна.

Судалгаанд хамрагдсан нийт 78 хуулийн төслийн 28 хуулийн төсөлд 2868 иргэн, албан байгууллагаас 4539 санал иржээ. 9 хуулийн төсөлд 10695 санал ирсэн гэж хариулсан боловч хэдэн иргэн, албан байгууллагаас ирсэн нь тодорхойгүй, 3 хуулийн төсөлд 2409 иргэн, албан байгууллага санал өгсөн гэж хариулсан боловч хэдэн санал ирсэн нь мөн тодорхойгүй байсан бөгөөд 34 хуулийн төсөлд хэдэн иргэн, албан байгууллагаас хэдэн санал ирсэн талаар хариулаагүй байлаа.

Олон нийтээс гарсан саналын 0%-50%-ийг 10 хуулийн төсөлд, саналын 50-100%-ийг 16 хуулийн төсөлд тус тус тусгасан гэж хариулсан бол бусад хуулийн төслийн хувьд саналын хэдэн хувийг хуулийн төсөлд тусгасан талаар хариулаагүй болно.

Хууль санаачлагчид хуулийн төсөлд санал гаргасан хүнд тухайн саналыг тусгасан эсэх талаарх хариу өгсөн эсэх гэсэн асуултанд 15 төслийн хувьд хууль санаачлагч хэлэлцүүлгийн үеэр шууд хариу өгсөн, 9 төслийн хувьд хууль санаачлагч цахим шуудангаар хариу өгсөн, 3 төслийн хувьд хууль санаачлагч албан бичгээр хариу тайлбар явуулсан, 3 төслийн хувьд хууль санаачлагч /Л.Эрдэнэчимэг, Н.Батбаяр, С.Бямбацогт гишүүн/ хариу өгөөгүй байна.

Судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдын санаачилсан хуулийн төслүүдийн хувьд 40 хуулийн төслийг цахим хуудсан дээр байршуулсан бол 33 хуулийн төслийг байршуулаагүй байна. Мөн 3 хуулийн төсөл боловсруулагдаж байгаа бөгөөд цахим хуудсанд хараахан байрлуулаагүй байгаа, 1 хууль санаачлагч "хуулийн төслийг УИХ ТГ цахим хуудастай холбоотой асуудлыг хариуцдаг тул хариулах боломжгүй" гэсэн хариу өгсөн бол, 1 Улсын Их Хурлын гишүүн өөрийн твиттер хуудсанд байршуулсан байна. Иргэдийн дунд явуулсан анкетын асуулгаар тэд цахим хуудсаар мэдээлэл авч, санал өгөхийг дэмжсэн \57хувь\ байхад судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдын зүгээс боловсруулсан хуулийн төслийнхөө ердөө 72 хувийг цахим хуудсандаа байршуулсан гэж хариулсан нь хангалтгүй мэт харагдаж байна. Цахим хуудсанд хуулийн төсөл, үзэл баримтлал, бусад хуульд оруулах өөрчлөлт, судалгааны дүнг байршуулах нь олон нийтийг мэдээллээр бүрэн, тэгш хангах хамгийн зардал багатай арга арга болохыг хууль санаачлагчид анхаарах нь зүйтэй юм.

Цахим хэлэлцүүлэгт зориулж тавигдсан мэдээллүүдийг тухайн веб дээр архивлан хадгалдаг уу гэсэн асуултанд 19 хуулийн төслийг архивласан, 50 хуулийн төслийг архивлаагүй, 7 хуулийн төслийг архивласан эсэх талаар хариулаагүй байна. Тухайн хуулийн төсөлд санал өгсөн иргэн, хуулийн этгээд уг санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх, тусгагдаагүй бол яагаад гэсэн хариулт авч байх нь хуулийн төсөл боловсруулах, батлах явцад иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тухайн харилцааг хууль зүйн үүднээс зөв ойлгож, дүгнэх боломж олгохоос гадна тухайн хууль батлагдсаны дараа хуулийг тайлбарлах, хэрэглэх, нэг мөр ойлгох практик болон судалгааны ач холбогдолтой тул хуулийн төсөл, түүнд олон нийтээс өгсөн санал, саналыг тусгасан эсэх, тусгаагүй шалтгаан зэрэг мэдээллийг харьцангуй удаан хугацаагаар архивлан тухайн цахим хуудсанд хадгалах зөвлөмжийг манай багийн зүгээс өгч байна.

Цахим хэлэлцүүлгийн үеэр 16 хуулийн төсөлд иргэд, албан байгууллагуудаас 191 санал ирсэн, 41 хуулийн төсөлд санал ирээгүй бөгөөд үүнд цахим хуудсанд байршуулаагүйгээс уг асуултанд хариулаагүй байж болох талтай байна. 13 хуулийн төсөлд санал өгсөн эсэх нь тодорхойгүй байна. Ирүүлсэн саналд 6 хууль санаачлагч товъёог боловсруулсан, 9 хууль санаачлагч товъёог болосвруулж, дүн шинжилгээ хийгээгүй байна. Санал гаргасан этгээдэд 5 хууль санаачлагч хариу мэдэгдсэн бол 11 хууль санаачлагч хариу мэдэгдээгүй байна. Ирүүлсэн саналд товъёог боловсруулах, санал гаргасан этгээдэд хариу мэдэгдсэн эхэс гэсэн асуултад 7 хууль санаачлагч илэрхий буруу хариулсан байна. Жишээ нь, цахим хэлбэрээр санал ирээгүй гэж хариулсан боловч, саналын товъёог боловсруулж, санал өгсөн этгээдэд хариу мэдэгдсэн гм илтэд буруу хариулсан.

38 хуулийн төслөөр  Орон нутагт санал авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд бусад хуулийн төслөөр орон нутагт санал авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Хэдийгээр хүн амын тал шахам хувь нь Улаанбаатарт амьдардаг тул хэлэлцүүлэг, хуулийн төсөлд санал авах ажиллагааг нийслэлд зохион байгуулснаар хүн амын тэдийчинээ хувийг төлөөлнө гэж тооцож болох боловч ихэнх хуулийн зохицуулалт төв суурин газарт тохиромжтой байдлаар бичигддэг, эсвэл  суурин иргэншилтэй улс орны хуулиудыг жишиг болгон хуулийн төсөл боловсруулдаг гэх шүүмжлэл дагуулсаар байгааг энэхүү судалгаа зарим талаар харуулж  байна. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, нүүдлийн соёл иргэншилтэй манай орны хувьд тухайн хуулийн зохицуулах харилцааны  онцлогоос шалтгаалан ямар хүрээг хармуулан иргэд, олон нийтийн оролцоог хангах вэ, аль хуулийн төслийг заавал хөдөө орон нутгийн иргэдийн оролцоог хангах вэ гэдгийг шийдвэрэх уян хатан зохицуулалт хэрэгтэй байна гэж манай судалгааны баг үзсэн болно.

Хуулийн төслийг боловсронгуй болгоход эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг 49 хуулийн төсөлд оролцуулж, санал авсан ба 24 хуулийн төсөлд эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг оролцуулж тэдний саналыг сонсоогүй байна.

Судалгаанд хамрагдсан хууль санаачлагчдаас хуулийн төслийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад гардаг хүндрэл, бэрхшээл, ололттой талуудыг дурдсахыг хүсэхэд хөрөнгө санхүү дутагдалтай, хэлэлцүүлэгт оролцогчдод хуулийн төслийг олон хоногийн өмнө хүргүүлдэг боловч хуулийн төсөлтэй сайн танилцаагүй байдаг, санал гэхээсээ илүү өөрсдийн асуудлыг ярьдаг, санал авахаар хүргүүлсэн хариуг удаадаг, шинэ нэр томъёо, шинэ зохицуулалтыг хүлээж авахдаа удаан байдаг зэрэг бэрхшээлийг нэрлэсэн байна.  Энэ нь иргэдийн эрх зүйн боловсрол хангалтгүй, хуулийн төсөлд санал өгч тусгуулах нь  өөрт тохиолддог асуудлыг шийдвэрлэх, зохицуулах чухал арга зам гэдгийг бүрэн ухамсарлахгүй байгаа, өөрөөр хэлбэл иргэдийн оролцооны соёл, ардчиллын  ойлголт хангалттай төлөвшөөгүй байгааг харуулж байна. Ихэнх иргэд энэ бол төрийн л ажил гэх хандлагатай  байгаа нь оролцооны ардчиллын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, оролцож байж үр дүнг нь мэдэрдэг практик руу иргэдийг түлхэх явдал чухал болохыг харуулж байна. Нөгөөтэйгүүр иргэдийн оролцоог бүрэн утгаар нь хэрэгжүүлэх нь  хууль санаачлагчид, төр засгийн өндөр албан тушаалтнууд  иргэд, олон нийтийн санаа бодлыг судлахгүйгээр өөрсдийн хүссэн хуулиа баталдаг, олигарх бүлгээ дэмжсэн хууль гаргадаг гэсэн шүүмжлэлээс  салах арга зам юм.

Хууль санаачлагчдаас цахим хэлэлцүүлгээс бусад хэлбэрээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, ялангуяа хөдөө орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулахад зардал, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр үр дүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авахад бэрхшээлтэй байдаг ба тухайн хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор олон улсын эсхүл гадаад улсын хөгжлийн байгууллагын дэмжлэг байхгүй тохиолдолд хэлэлцүүлгийн зардал, хөрөнгийг төсөвт тусгадаг байх шаардлагатай байна, мөн хуулийн төслийг боловсруулж түүнд олон нийтийн саналыг бүх түвшинд тусгаж байхын тулд нэг төсөлд шаардагдах жишиг зардлыг гаргаж хэрэгжилтэд хяналт тавих зэрэг хөрөнгө, санхүүтэй холбоотой саналуудыг өгсөн байлаа.

~~~oOo~~~
~~~

**ХАВСРАЛТ 2**

**Танд энэ өдрийн мэнд хүргэе.**

НҮБХХ-ийн санхүүжилтээр УИХ-ын Тамгын газарт хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд Өмгөөллийн “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практик”-ийг судалж байгаатай холбогдуулан Төрийн бус байгууллагуудын дунд энэхүү товч судалгааг явуулж байна.

1. Танай байгууллага ямар салбарт үйл ажиллагаа явуулдаг вэ?
   ..............................................................................................................................
   .................................................
2. Танай байгууллага үйл ажиллагаа явуулаад хэдэн жил болж байна вэ? ...............................................
3. Танай байгууллагын төлөөлөл төрийн аль нэг байгууллагын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан уу?
   ☐ үгүй ☐ 1 удаа ☐ 2 удаа ☐ 3 болон түүнээс дээш удаа
4. “Ажилласан” бол хуулийн нэрийг бичнэ үү?
   ..............................................................................................................................
   .................................................
5. Танай байгууллага аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу?
   ☐ үгүй ☐ 1 удаа ☐ 2 удаа ☐ 3 болон түүнээс дээш удаа
6. Өгсөн бол хуулийн нэрийг бичнэ үү?
   ..............................................................................................................................
   .................................................
7. Тухайн хуулийн төсөлд санал авч буй тухай мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?
   ☐ хэвлэл, мэдээллээс ☐ утас болон бусад аргаар хүсэлт ирүүлсэн ☐ тухайн байгууллагын цахим хуудаснаас ☐ өөр бусад цахим хуудаснаас
8. Хуулийн төсөлд саналаа ямар хэлбэрээр өгсөн бэ?
   ☐ хэлэлцүүлэгт оролцсон ☐ биечлэн очиж уулзсан ☐ захидлаар ☐ утсаар
   ☐ и-мэйлээр ☐ мессежээр
9. Танай байгууллагын төлөөлөл аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан уу?
   ☐ Үгүй ☐ 1 удаа ☐ 2 удаа ☐ 3 болон түүнээс дээш удаа
10. Оролцсон бол хуулийн нэрийг бичнэ үү?
    ..............................................................................................................................
    .................................................
11. Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна вэ?
    А. Хангалттай Б. Боломжийн В. Хангалтгүй
12. “Хангалтгүй” бол яагаад?

А. Миний саналыг сонсоогүй
Б. Миний саналыг дутуу, хагас сонссон
В. Санал хэлэх боломж олдоогүй
Г. Бусад:.......................................

13. Танай байгууллагын өгсөн санал хуулийн төсөлд хир тусгагдсан бэ?
☐ тусгагдаагүй ☐ зарим нь тусгагдсан ☐ хангалттай тусгагдсан ☐ мэдэхгүй

14. Танай байгууллагын өгсөн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол яагаад тусгаагүй талаар тухайн байгууллага ямар нэг байдлаар хариу өгсөн үү?
☐ Хариу өгсөн ☐ хариу өгөөгүй

15. "Хариу өгсөн" бол ямар хэлбэрээр өгсөн бэ?
...........................................................................................................................
................................................

16. Санал өгсөн иргэн, байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал Та дэмжих үү? Энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ?
...........................................................................................................................
................................................

17. Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах ямар арга хэлбэр илүү тохиромжтой гэж үзэж байна вэ? Та саналаа бичиж үлдээнэ үү.
...........................................................................................................................
................................................

18. Хуулийн төслийг вэбд тавьж олон нийтээс санал авах хугацаа хэд хоног байвал зохимжтой вэ?
☐ 10 хоног ☐ 30 хоног ☐ 60 хоног ☐ . . . . хоног

Нэмэлт санал:
.....................................................................................................................................
..........................
.....................................................................................................................................
....................................................

Дараах хуулийн төслүүдэд саналаа өгч байсан эсэх талаар тохирох хариултыг тэмдэглэнэ үү.

| № | Хуулийн төслийн нэрс | Хуулийн төсөлд санал өгөх ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцсон уу? | Тийм бол оролцсон арга | Таны санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Гэмт хэргийн тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |
| | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |
| | Зөрчлийн тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |
| | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |
| | Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдаагүй\ | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |
| | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |
| | Гэр бүлийн тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |
| | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |
| | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл<br><br>\2012.10.24-нд батлагдсан\ | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |
| | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |
| | Малын индексжүүлсэн даатгалын тухай | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй |
| | | | | Б. Зарим нь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хуулийн төсөл<br><br>\2014.06.13-нд батлагдсан\ | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | В. Захидлаар | Г. Мэдэхгүй |
| | | | Г. Утсаар | |
| | | | Д. И-мэйлээр | |
| | | | Е. Мессежээр | |

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН АНКЕТЫН СУДАЛГАА

НҮБХХ-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газарт хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд манай байгууллага “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийг судалж” байгаатай холбогдуулан цахим шуудангаар уул уурхай, нийгмийн хамгаалал, бизнес, байгаль орчин, авто зам, хүний эрх зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 67 төрийн бус байгууллагатай утсаар холбогдсоноос судалгаанд хамрагдахаар зөвшөөрсөн 30-аад Төрийн бус байгууллагад товч судалгааны анкетыг хүргүүлсэн юм. Товч судалгааны анкетыг хүргүүлсэн Төрийн бус байгууллагуудаас өнөөдрийн буюу 2014 оны 12-р сарын 1-ний өдрийн байдлаар нийтдээ 11 Төрийн бус байгууллагаас хариу ирлээ.

Дээрх 11 ТББ-ууд нь хууль зүйн, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгаалал, авто зам, хүний эрх болон банк, бизнесийн салбарт 1-24 жил үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байсан юм.

Анкет бөглөсөн ТББ-ын 8 байгууллагын төлөөлөл төрийн аль нэг байгууллагын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан байна.

Нийт 9 ТББ-ын төлөөлөл 3 болон түүнээс дээш удаа хуулийн төсөлд санал өгч байсан болон 1 нь үгүй гэж харилан, нөгөө 1 байгууллагын төлөөлөл нь хариулаагүй байна.

Тухайн хуулийн төсөлд санал авч бус тухай мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор 9 байгууллагын төлөөлөл утас болон бусад аргаар хүсэлт ирүүлснээр, 1 байгууллага Иргэний нийгэм форумаас, 1 байгууллага ДЕМО, МБОИЗ, “ТАН” эвсэл, Нээлттэй нийгэм форумаас, дээр дурдсан утас болон бусад аргаар хүсэлт ирүүлснээр мэдээллийг авсан 1 ТББ-ын төлөөлөл мөн өөр бусад цахим хуудаснаас мэдээлэл авч байжээ.

Хуулийн төсөлд ямар хэлбэрээр саналаа өгсөн бэ гэсэн асуултанд 9 ТББ-ын төлөөлөл хэлэлцүүлэгт оролцон саналаа өгч, давхардсан тоогоор 5 нь бичгээр, 2 нь амаар, 3 нь и-мейлээр өгч байсан байна.

Сүүлийн 1 жилийн хугацаанд танай байгууллагын төлөөлөл аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон уу гэсэн асуултанд 9 ТББ-ын төлөөлөл 3 болон түүнээс дээш удаа, 1 нь 2 удаа аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт

оролцож байсан /1 ТББ-ын төлөөлөл хэдэн удаа хэлэлцүүлэгт оролцож байснаа тэмдэглээгүй болно/ гэж хариулсан.

Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна гэсэн асуултанд 6 ТББ-ын төлөөлөл тухайн хэлэлцүүлгийг боломжийн үр дүнтэй болсон гэж үзсэн бол 5 нь уг хэлэлцүүлгийг хангалтгүй болсон гэж үзжээ. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг хангалтгүй гэж үзсэн ТББ-ын төлөөллүүдийн дурдсан шалтгаануудын хувьд 1 ТББ-ын төлөөллийн саналыг сонсоогүй, 4 ТББ-ын төлөөллүүдийн саналыг төвөгшөөн, ойшоодоггүй бөгөөд хэлэлцүүлэг гэж зүгээр л нэр хааж, ээлж өнгөрөөсөн арга хэмжээ болсон гэж хариулсан.

Танай байгууллагын өгсөн санал хуулийн төсөлд хир тусгагдсан бэ гэсэн асуултанд 1 ТББ-ын төлөөллийн хувьд хангалттай, 6 ТББ-ын хувьд зарим нь тусгагдсан гэж үзсэн байдаг бол, 1 ТББ-ын төлөөллийн саналыг тусгаагүй, 3 ТББ-ын төлөөллийн хувьд энэ талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй гэж хариулсан байна.

Тухайн өгсөн санал нь хуулийн төсөлд тусгагдсан эсэх талаар 9 байгууллагад хариу өгөөгүй, 1 ТББ-д и-мейлээр хариу өгсөн бөгөөд 1 ТББ-ын төлөөлөл энэ асуултыг дугуйлаагүй байна.

Санал өгсөн иргэн, байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал дэмжих үү, энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ гэсэн асуултанд 7 төрийн бус байгууллагын төлөөлөл цахим хуудсандаа тавих болон цахим хаягаар илгээх аргыг дэмжсэн бол 2 нь албан бичгээр хариу өгөх нь зүйтэй байна гэж хариулан 2 нь асуултанд хариулаагүй юм.

Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах ямар арга хэлбэр илүү тохиромжтой гэж буй талаар саналыг асуухад 1 ТББ төрөл бүрийн аргаар, 2 ТББ хэвлэл мэдээллийн аргаар, 3 ТББ цахим хуудсаар, 2 ТББ тухайн хуулиар зохицуулагдаж байгаа харилцаанд эрх, ашиг, оролцоо нь хөндөгдөж байгаа байгууллагаас заавал санал авдаг байх, салбар, мэргэжлийн хүмүүсийн дунд хэлэлцүүлэг хийх аргаар иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах, 1 ТББ-ын төлөөлөл хуулийн төслийг маш давчуу хугацаанд боловсруулдаг гэж үзсэн бол өөр 1 ТББ-ын төлөөлөл хуулийн төсөл боловсруулахдаа мэргэжлийн бүлгүүдийн хэлэлцүүлэг, эрдэмтдийн бүлгийн хэлэлцүүлэгт гол ач холбогдлоо өгөх, мөн судалгааг нарийвчлан хийж, үндэслэлийг гаргаж тайлбарласан тайлбараа олон нийтэд хүртээж болох бүх хэлбэрээр хүртээх, тухайн хууль нь ямар харилцааг зохицуулах талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулах замаар зохион байгуулах, 1 ТББ-ын төлөөлөл хуулийн хэлэлцүүлэгт оролцож байсан Иргэний нийгмийн байгууллагуудаар санал авахуулж тусгах зэргээр хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах нь тохиромжтой гэж үзжээ.

Хуулийн төслийг вебд тавьж олон нийтээс санал авах хугацаа хэд хоног байвал зохимжтой талаар асуухад 1 төрийн бус байгууллага 10 хоног, 5 нь 30

хоног, 3 нь 60 хоног, 1 нь 90 хоног цахим хуудсанд тавьж олон нийтээс санал авах нь зохимжтой гэж үзсэн байна. 1 ТББ-ын төлөөлөл дээрх асуултад хариулаагүй байсан юм.

Бидний хийж байгаа судалгааны нэг хэсэг болох сонгогдсон хуулийн төсөл, хуулиудыг боловсруулах явцад хэрхэн олон нийтийн оролцоог хангасанг судлах ажил байлаа. Энэхүү хэсгийн хүрээнд бид сонгогдсон дараах хууль, хуулийн төслүүдэд судалгаанд оролцсон төрийн бус байгууллагууд саналаа өгч, хэлэлцүүлэгт оролцсон эсэх талаар асуулга явуулсан юм:

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд 3 төрийн бус байгууллагын төлөөлөл саналаа өгч байсан ба 1 ТББ-ын төлөөлөл саналаа бичгээр өгөн, түүний өгсөн саналын зарим нь хуулийн төсөлд тусгагдсан байна. 1 ТББ-ын төлөөлөл хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон байсан ба түүний санал хуулийн төсөлд тусгагдсан талаар ямар нэгэн мэдээлэлгүй байгаа бол 1 ТББ-ын төлөөлөл дээрх хуулийн төсөлд саналаа өгч байсан боловч ямар байдлаар гэдгээ дурдаагүй байсан юм.
- Зөрчлийн тухай хуулийн төсөлд 2 ТББ-ийн төлөөлөл саналаа өгч байснаас 1 ТББ-ийн төлөөлөл хэлэлцүүлэгт оролцон амаар саналаа өгсөн ба түүний саналыг одоогоор хэлэлцэгдэж байгаа юм байна. 1 ТББ-ын төлөөлөл дээрх хуулийн төсөлд саналаа өгч байсан боловч ямар байдлаар гэдгээ дурдаагүй байсан юм.
- Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд 3 ТББ-ын төлөөлөл саналаа өгөн, 1 ТББ-ын төлөөлөл хуулийн төслийн ажлын хэсэгт ажилласан ба 2 ТББ-ын төлөөлөл хэлэлцүүлэгт оролцсон боловч 1 ТББ-ын төлөөллийн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар бөглөөгүй байсан бол нөгөө 1 ТББ-ын төлөөллийн саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байгаа.
- Гэр бүлийн тухай хуулийн төсөлд 3 ТББ-ын төлөөлөл саналаа өгснөөс 2 ТББ-ын төлөөлөл хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон боловч 1 ТББ-ын төлөөллийн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар бөглөөгүй байсан бол нөгөө 1 ТББ-ын төлөөллийн саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн мэдээлэлгүй байна
- Тамхины хяналтын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 2 ТББ-ын төлөөлөл саналаа өгснөөс 2 ТББ-ын төлөөлөл хэлэлцүүлэгт оролцон, 1 ТББ-ын төлөөлөл амаар болон бичгээр саналаа өгч, 1 байгууллагын төлөөллын өгсөн зарим саналыг тусган, нөгөө байгууллагын төлөөллийн саналыг хангалттай тусгасан байна
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд судалгаанд оролцсон төрийн бус байгууллагуудаас ямар нэгэн байдлаар санал өгөөгүй байна.

Дээрх судалгаанаас үзэхэд хуулийн төслийг боловсруулж байгаа талаар төрийн бус байгууллагуудад утас болон бусад аргаар хүсэлт ирүүлдэг байна. Үүнээс үзэхэд олон нийт гэхээсээ илүү зөвхөн тухайн хүрээний эсхүл байнга харилцдаг төрийн бус байгууллагуудад хуулийн төсөл боловсруулагдаж байгаа мэдээлэл хүрдэг, нөгөөтэйгүүр тухайн байгууллагууд хэвлэл, мэдээлэл, цахим хаягаар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа талаарх мэдээлллийг авдаггүй болох нь харагдаж байгаа юм. Хуулийн төслийг боловсруулсан байгууллага санал өгсөн төрийн бус байгууллагуудад тэдний саналыг тусгасан эсэх талаар ямар нэгэн хариу ирүүлдэггүй талаар дурджээ. Төрийн бус байгууллагуудын хувьд хуулийн төсөл боловсруулах явцад тухайн салбарын мэргэжилтэн, үйл ажиллагаа явуулж буй олон албан байгууллагуудыг маш дутмаг оролцуулдаг, мөн хуулийн сурталчилгаа муу байдаг талаар нэмэлт саналын хэсэгт бичсэн байсан. Энэ нь хуулийн төслийн сурталчилгаа, олон нийтэд хүрэх асуудал дутмаг, иргэд, байгууллага тэр бүр ямар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа талаар мэдээлэлгүй байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа.

Хуулийн төсөлд өгсөн саналыг тусгасан эсэх талаар төрийн бус байгууллагуудад цахим хэлбэрээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгвөл зохистой байна гэж үзсэн нь өнөө цагийн техник, технологи өндөр хөгжсөн цаг үед иргэн бүр, байгууллага бүр цахим хэлбэрээр хуулийн төсөлтэй танилцаж, санал өгөх нь тэдэнд амар, цаг хэмнэдэг болох нь ажиглагдаж байна. Мөн цахимаар олон нийтээс санал авах хугацааг 30 хоног байх нь зүйтэй байна гэж судалгаанд оролцсон дийлэнх төрийн бус байгууллагууд үзсэн юм. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулиар хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулдаг хугацаа нь бага байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байгаа юм.

~~~oOo~~~
~~~

**ХАВСРАЛТ 3**

**Танд энэ өдрийн мэнд хүргэе.**

НҮБХХ-ийн санхүүжилтээр УИХ-ын Тамгын газарт хэрэгжиж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд Өмгөөллийн “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практик”-ийг_судалж байгаатай холбогдуулан энэхүү товч асуулгад хариулахыг хүсье.

1. Та өөрийн нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн талаар доорх хариултуудаас дугуйлна уу.

| Нас | Хүйс | Боловсрол | Ажил эрхлэлт |
|---|---|---|---|
| а. 18-25 | а. эр | а. бүрэн бус дунд | а. төрийн байгууллагад |
| б. 26-35 | б. эм | б. бүрэн дунд | б. төрийн бус байгууллагад |
| в. 36-50 | | в. тусгай дунд | в. Хувийн хэвшил |
| г. 50-аас дээш | | г. дээд | г. Тэтгэвэрт,оюутан |

2. Та аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу?
   ☐ үгүй ☐ 1 удаа ☐ 2 удаа ☐ 3 болон түүнээс дээш удаа
3. Өгсөн бол хуулийн нэрийг бичнэ үү?
   ..........................................................................................................................
   ..............................................
4. Тухайн хуулийн төсөлд санал авч буй тухай мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?
   ☐ хэвлэл, мэдээллээс ☐ утас болон бусад аргаар хүсэлт ирүүлсэн ☐ тухайн байгууллагын цахим хуудаснаас ☐ өөр бусад цахим хуудаснаас
5. Хуулийн төсөлд саналаа ямар хэлбэрээр өгсөн бэ?
   ☐ хэлэлцүүлэгт оролцсон ☐ биечлэн очиж уулзсан ☐ захидлаар
   ☐ утсаар
   ☐ и-мэйлээр ☐ мессежээр
6. Та аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан уу?
   ☐ үгүй ☐ 1 удаа ☐ 2 удаа ☐ 3 болон түүнээс дээш удаа
7. Оролцсон бол хуулийн нэрийг бичнэ үү?
   ..........................................................................................................................
   ..............................................
8. Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна вэ?
   А. Хангалттай Б. Боломжийн В. Хангалтгүй

**9.** “Хангалтгүй” бол яагаад?

А. Миний саналыг сонсоогүй
Б. Миний саналыг дутуу, хагас сонссон
В. Санал хэлэх боломж олдоогүй
Г. Бусад:......................................

**10.** Таны өгсөн санал хуулийн төсөлд хир тусгагдсан бэ?

☐ тусгагдаагүй ☐ зарим нь тусгагдсан ☐ хангалттай тусгагдсан ☐ мэдэхгүй

**11.** Таны өгсөн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол яагаад тусгаагүй талаар тухайн байгууллага ямар нэг байдлаар хариу өгсөн үү?

☐ хариу өгсөн ☐ хариу өгөөгүй

**12.** “Хариу өгсөн” бол ямар хэлбэрээр өгсөн бэ?

.............................................................................................................................................................

**13.** Санал өгсөн иргэн байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал Та дэмжих үү? Энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ?

.............................................................................................................................................................

**14.** Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах ямар арга хэлбэр илүү тохиромжтой гэж үзэж байна вэ? Та саналаа бичиж үлдээнэ үү.

.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................

**15.** Хуулийн төслийг вэб-д тавьж олон нийтээс санал авах хугацаа хэд хоног байвал зохимжтой вэ?

☐ 10 хоног ☐ 30 хоног ☐ 60 хоног ☐ бусад . . . . хоног

Нэмэлт санал:
..........................................................................................................................
.............................................................................................................................................................

Дараах хуулийн төслүүдэд саналаа өгч байсан эсэх талаар тохирох хариултыг тэмдэглэнэ үү.

| № | Хуулийн төслийн нэрс | Хуулийн төсөлд санал өгөх ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцсон уу? | Тийм бол оролцсон арга | Таны санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Гэмт хэргийн тухай | А. Тийм Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт | А. Тусгагдаагүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | | | оролцсон | Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |
| | | | | Е. Мессежээр | |
| | Зөрчлийн тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | А. Тийм | Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй<br>Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |
| | | | | Е. Мессежээр | |
| | Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдаагүй\ | А. Тийм | Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй<br>Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |
| | | | | Е. Мессежээр | |
| | Гэр бүлийн тухай хуулийн төсөл<br><br>\өргөн баригдсан\ | А. Тийм | Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй<br>Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |
| | | | | Е. Мессежээр | |
| | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл<br><br>\2012.10.24-нд батлагдсан\ | А. Тийм | Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй<br>Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |
| | | | | Е. Мессежээр | |
| | Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл<br><br>\2014.06.13-нд батлагдсан\ | А. Тийм | Б. Үгүй | А. Хэлэлцүүлэгт оролцсон | А. Тусгагдаагүй<br>Б. Зарим нь |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | В. Хангалттай |
| | | | | В. Захидалаар | Г. Мэдэхгүй |
| | | | | Г. Утсаар | |
| | | | | Д. И-мэйлээр | |

## ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХЭРХЭН ХАНГАЖ БУЙ ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮН

Хуулийн төсөл боловсруулахад иргэд хэрхэн оролцож буй талаар Улаанбаатар хотын төвийн дүүргийн 359 иргэдээс урьдчилан бэлтгэсэн асуулгаар асуулга бөглүүлж, анкетийн судалгаа хийж нэгтгэв. Энэхүү судалгааны мэдээлэл цуглуулахад туслалцаа үзүүлсэн ТИС-ийн оюутан Д.Мяасүрэн, О.Мөнхбат нарт

талархал илэрхийлж байна. Ажлын даалгаварт тусгагдаагүй боловч иргэдийн оролцоог өөрсдөөс нь асууж дүгнэх зорилгоор, судалгааны хүрээ өргөн, гүйцэтгэх хугацаа давчуу байсны улмаас орон нутгийг хамруулж чадаагүй бөгөөд зохих хэмжээний төлөөллийг бүрэн хангасан гэх боломжгүй ч тодорхой дүр зураг гаргах боломжтой гэж үзлээ.

1. Та өөрийн нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн талаар доорхи хариултуудаас дугуйлна уу.

| Нас | Саналын тоо | Хүйс | Саналын тоо | Боловсрол | Саналын тоо | Ажил эрхлэлт | Саналын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| А.18-25 | 106 | А. Эр | 130 | А. Бүрэн бус дунд | 9 | А. Төрийн байгууллага | 149 |
| Б.26-25 | 117 | | | Б. Бүрэн дунд | 69 | Б. Төрийн бус байгууллага | 57 |
| В.36-50 | 86 | Б. Эм | 178 | В. Тусгай дунд | 27 | В. Хувийн хэвшил | 62 |
| Г.50-дээш | 31 | | | Г. Дээд | 223 | Г. Тэтгэвэрт оюутан | 62 |
| Хариулаагүй | 19 | 51 | | 31 | | 29 | |

Судалгаанд оролцогч нийт 359 иргэдийн 106 нь буюу 29% нь 18-25 настай, 117 нь буюу 33% нь 26-35 настай, 86 нь буюу 24% нь 36-50 настай, 31 нь буюу 24% нь 50-аас дээш настай бол нийт судалгаанд оролцогчдын 19 нь буюу 5% нь тус асуултанд хариулаагүй байна. Судалгаанд оролцогч 359 иргэний 130 нь буюу 36% нь эр, 178 нь буюу 50% нь эм бол 51 иргэн буюу 14% нь хариулаагүй байна. Судалгаанд оролцогчдын боловсролын байдлыг авч үзвэл 2% нь буюу 9 нь бүрэн бус дунд, 19% нь буюу 69 нь бүрэн дунд, 8% буюу 27 нь тусгай дунд, 62% буюу 223 нь дээд боловсролтой бол 9% буюу 31 иргэн уг асуултад хариулаагүй байна. Мөн судалгаанд оролцогчдын 42% буюу 149 нь төрийн байгууллагад, 16% буюу 57 нь төрийн бус байгууллагад, 17% буюу 62 нь хувийн хэвшилд, 17% буюу 62 нь тэтгэвэрт, эсхүл оюутан байсан бөгөөд энэ асуултанд 8% буюу 29 иргэн хариулаагүй байна.

2. Та аливаа хуулийн төсөлд санал өгч байсан уу?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Үгүй | 244 |
| Б. 1 удаа | 60 |
| В. 2 удаа | 25 |
| Г. 3 болон түүнээс дээш | 22 |
| Д. Хариулаагүй | 8 |

3. Өгсөн бол хуулийн нэрийг бичнэ үү?

| № | Хуулийн нэр | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Нийтийн сонголтын тухай хууль | 1 |
| 2 | Гэр бүлийн хууль | 5 |
| 3 | Хяналтын тухай хууль | 1 |
| 4 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль | 3 |
| 5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль | 25 |

| | | |
|---|---|---|
| 6 | Банкны тухай хууль | 1 |
| 7 | Эрүүгийн хууль | 3 |
| 8 | Төсвийн тухай хууль | 1 |
| 9 | Иргэний хууль | 3 |
| 10 | Зөрчлийн тухай хууль | 1 |
| 11 | Химийн | 1 |
| 12 | Гадаад харилцааны тухай хууль | 1 |
| 13 | Орон сууц хувьчлах хууль | 1 |
| 14 | Дундын өмчлөлийн тухай хууль | 1 |
| 15 | СӨХ-ийн тухай хууль | 1 |
| 16 | Ашигт малтмалын тухай хууль | 1 |
| 17 | Байгаль хамгаалах багц хууль | 3 |
| 18 | Газрын тухай хууль | 3 |
| 19 | Сонгуулын тухай хууль | 3 |
| 20 | Боловсрол шинжлэх ухааны тухай хууль | 1 |
| 21 | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлүүлэх тухай хууль | 6 |
| 22 | Барилгын тухай хууль | 1 |
| 23 | Тамхины эсрэг хяналтын тухай хууль | 17 |
| 24 | Газар чөлөөлөх нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох тухай хууль | 1 |
| 25 | Агаарын тухай хууль | 1 |
| 26 | Хүүхдийн эрхийн тухай | 14 |
| 27 | Иргэдийн оролцоог дэмжих төсөл | 1 |
| 28 | Хилийн боомтын тухай хууль | 1 |
| 29 | Шүүхийн тухай | 1 |
| 30 | Хөгжлийн бэрхшээтэй иргэн ба хууль эрх зүй | 1 |
| 31 | Хөдөлмөрийн тухай | 1 |
| 32 | Боловсролын тухай | 2 |
| 33 | Хариулаагүй | 272 |

4. Тухайн хуулийн төсөлд санал авч буй тухай мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Хэвлэл, мэдээллээс | 159 |
| Б. Утас болон бусад аргаар хүсэлт ирүүлсэн | 32 |
| В. Тухайн байгууллагын цахим хуудаснаас | 40 |
| Г. Өөр бусад цахим хуудаснаас | 32 |
| Д. Хариулаагүй | 96 |

**Тухайн хуулийн төсөлд санал авч буй тухай мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?** Гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогч 359 иргэдийн 44% буюу 159 иргэн хэвлэл мэдээллээс, 9% буюу 32 иргэн утас болон бусад аргаар хүсэлт ирүүлсэн, 11% буюу 40 иргэн тухайн байгууллагын цахим хуудаснаас, 9% буюу 32 иргэн өөр бусад цахим хуудаснаас авдаг гэсэн хариулт өгсөн бол 27% буюу 96 иргэн хариулаагүй байна.

5. Хуулийн төсөлд саналаа ямар хэлбэрээр өгсөн бэ?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Хэлэлцүүлэгт оролцсон | 39 |
| Б. Биечлэн очиж уулзсан | 16 |
| В. Захидлаар | 32 |

| | |
|---|---|
| Г. Утсаар | 8 |
| Д. И-мэйлээр | 26 |
| Е. Мессежээр | 27 |
| Ё. Хариулаагүй | 211 |

Судалгаанд оролцогч 359 иргэний 11% буюу 39 иргэн хэлэлцүүлэгт оролцсон, 4% буюу 16 иргэн биечлэн очиж уулзсан, 9% буюу 32 иргэн захидлаар, 2% буюу 8 иргэн утсаар, 7% буюу 26 иргэн и-мэйлээр, 8% буюу 27 иргэн мессежээр саналаа өгсөн байна.

6. Та аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан уу?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Үгүй | 245 |
| Б. 1 удаа | 31 |
| В. 2 удаа | 9 |
| Г. 3 болон түүнээс дээш | 11 |
| Д. Хариулаагүй | 63 |

Судалгаанд оролцогч 359 иргэдийн 68% буюу 245 нь үгүй, 9% буюу 31 нь 1 удаа, 2% буюу 9 нь 2 удаа, 3% буюу 11 нь 3 болон түүнээс дээш удаа гэж хариулсан бол 18% буюу 63 нь хариулаагүй байна.

7. Оролцсон бол хуулийн нэрийг бичнэ үү?

| № | Хуулийн нэр | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Хяналтыг тухай хууль | 2 |
| 2 | Хүүхдийн эрхийн тухай | 6 |
| 3 | Иргэний оролцооны тухай хуулийн төсөл | 2 |
| 4 | Шилэн данс | 1 |
| 5 | Нийтийн зар мэдээ | 1 |
| 6 | Газрын тухай хууль | 3 |
| 7 | Төсвийн тухай хууль | 2 |
| 8 | Архигүй монгол | 2 |
| 9 | Төмөр замын тээврийн тухай хууль | 1 |
| 10 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль | 3 |
| 11 | Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль | 1 |
| 12 | Иргэдийн өв сангийн тухай хууль | 2 |
| 13 | Тамхины тухай хууль | 10 |
| 14 | Сонгуулийн тухай хууль | 2 |
| 15 | Гэр бүлийн тухай хууль | 3 |
| 16 | Иргэний нийгмийн тухай | 1 |
| 17 | Байгаль хамгаалах тухай хууль | 1 |
| 18 | Иргэний хууль | 2 |
| 19 | Хяналтын тухай хууль | 2 |
| 20 | Гэр бүлийн хүчирхийллийн хуулийн нэмэлт өөрчлөлт | 1 |
| 21 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль | 1 |
| 22 | Хөдөлмөрийн эрх зүй байгууллагын тухай хууль | 1 |
| 23 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа | 1 |
| 24 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хууль эрх зүй | 1 |
| 25 | Хариулаагүй | 308 |

Судалгаанд оролцогч 359 иргэний 51 буюу 14% нь хэлэлцүүлсэн хуулийн төслийг нэрлэсэн бол үлдсэн 308 буюу 86% нь энэ асуултанд хариулаагүй хариулаагүй байна.

8. Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна вэ?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Хангалттай | 12 |
| Б. Боломжийн | 99 |
| В. Хангалтгүй | 54 |
| Г. Хариулаагүй | 194 |

**Та хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэр үр дүнтэй болсон гэж үзэж байна вэ?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогч 359 иргэний 12 буюу 3% нь хангалттай, 99 буюу 28% нь боломжийн, 54 буюу 15% нь хангалтгүй гэж хариулсан бол 194 буюу нийт судалгаанд оролцогчдын 54% нь хариулаагүй байна.

9. Хангалтгүй бол яагаад?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Миний саналыг сонсоогүй | 7 |
| Б. Миний саналыг дутуу хагас сонссон | 1 |
| В. Санал хэлэх боломж олдоогүй | 25 |
| Г. Бусад | 10 |
| Д. Хариулаагүй | 11 |
| Өөрсдийн эрх ашгийг бодсон байдал | |
| Урьдчилан төсөлтэй танилцаагүй | |
| Иргэдийн оролцоо бага танхим дүүргэлт муу цөөхөн хүнтэй хэлэлцүүлэг болдог | |

10. Таны өгсөн санал хуулийн төсөлд хэр тусгагдсан бэ?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Тусгагдаагүй | 34 |
| Б. Зарим нь тусгагдсан | 40 |
| В. Хангалттай тусгагдсан | 7 |
| Г. Мэдэхгүй | 99 |
| Д. Хариулаагүй | 179 |

**Таны өгсөн санал хуулийн төсөлд хэр их тусгагдсан бэ?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогч 359 иргэний 50% буюу 179 иргэн хариулаагүй бөгөөд уг асуулгад хариулсан 180 иргэдийн 19% буюу 34 иргэн санал тусгагдаагүй, 22% буюу 40 иргэн саналын зарим нь тусгагдсан, 4% буюу 7 иргэн хангалттай тусгагдсан, 55% буюу 99 иргэн мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанд хариулсан иргэдийн 26 хувь нь өгсөн саналын зарим нь тусгагдсан буюу хангалттай тусгагдсан гэж үзэж байгааг санал тусгагдаагүй гэсэн 19 хувийн саналтай харьцуулбал иргэдийн санал тусгагддаг гэсэн хариулт давамгайлж, иргэдээс санал авах, хэлэлцүүлэг явуулах ажил зохих хэмжээгээр үр дүнгээ

өгдөг гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Түүнчлэн уг асуулгад хариулсан иргэдийн 55 хувь нь санал тусгагдсан эсэх талаар мэдэхгүй гэж хариулж байгаа нь Хууль, Улсын их хурлын шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд аль алинд нь хуулийн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн санал нь уг төсөлд тусгагдсан эсэх талаар санал гаргагчид мэдээлдэг, эргэх холбоотой байх талаар төрийн байгууллага буюу хуулийн төсөл боловсруулагчид үүрэг хүлээлгэсэн ямар ч зохицуулалт байхгүй байгаагийн үр дагавар гэж дүгнэж байна.

11. Таны өгсөн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол яагаад тусгаагүй талаар тухайн байгууллага хариу өгсөн эсэх?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. Хариу өгсөн | 18 |
| Б. Хариу өгөөгүй | 128 |
| Г. Хариулаагүй | 213 |

**Таны өгсөн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол яагаад тусгаагүй талаар тухайн байгууллага ямар нэг байдлаар хариу өгсөн үү?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогч 359 иргэний 59% буюу 213 иргэн хариулаагүй байна. Уг асуултанд хариулсан 146 иргэний хувьд авч үзвэл 12% буюу 18 иргэн хариу өгсөн, 88% буюу 128 иргэн хариу өгөөгүй гэж хариулж байгаа нь хуулийн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн санал нь уг төсөлд тусгагдсан эсэх талаар санал гаргагчид мэдээлдэг, эргэх холбоотой байх талаар төрийн байгууллага буюу хуулийн төсөл боловсруулагчид үүрэг хүлээлгэсэн ямар ч зохицуулалт байхгүй байгаагийн үр дагавар гэж үүний өмнө дурдсан дүгнэлтийг дахин нотолж байна.

12. Хариу өгсөн бол ямар хэлбэрээр өгсөн бэ?

| № | Хариу өгсөн байдал | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Албан бичгээр | 2 |
| 2 | И-мэйлээр | 5 |
| 3 | Захиа | 1 |
| 4 | Мессеж | 3 |
| 5 | Утсаар | 2 |
| 6 | Хуулийн тухай мэдээлэл өгөх журмаар | 1 |
| 7 | Цахим хуудсаар | 3 |
| 8 | Биечлэн уулзсан | 1 |
| 9 | Хариулаагүй | 341 |

13. Санал өгсөн иргэн байгууллага бүрт хариу бичих нь өндөр зардалтай тул саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх мэдээллийн тухайн байгууллага цахим хуудсандаа тавьдаг байхаар зохицуулбал Та дэмжих үү? Энэ талаар өөр ямар арга, хэлбэрээр хариу өгвөл зохистой гэж бодож байна вэ?

| № | Хариу өгсөн байдал | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Дэмжинэ мэдэхгүй | |

| | | |
|---|---|---|
| 2 | Утсаар | |
| 3 | Дэмжинэ | 91 |
| 4 | Тийм | |
| 5 | Цахим хэлбэрээр санал авхад дэмжинэ | |
| 6 | Цахимаар | |
| 7 | Э-мэйл хаягаар тухайн байгууллагын бүртгэлд өгөх нь зөв | |
| 8 | Дан хуулийн талаар мэдээлэл өгдөг сувагтай бол зүгээр | |
| 9 | Иргэдээс нээлттэй хэлэлцүүлэг авдаг бол дээр | |
| 10 | Цахим хуудсандаа тавьдаг байх | |
| 11 | Цахимаар хариу өгөхөд тийм ч өндөр зардал гарахгүй байх | |
| 12 | Иргэдийн дуу хоолойг сонсож байвал дэмжинэ | |
| 13 | Цахим шуудан | |
| 14 | Бүх хуулийн төсөл хэлэлцүүлэг тусдаа нэгтсэн цахим хуудастай байвал дээр | |
| 15 | Тухай бүрт хариу бичиж иргэдийн нээлттэй оролцоог хангах | |
| 16 | Хууль өөрийн төсөвтэй хэлэлцүүлдэг учир саналыг авсан эсэхэд хариу өгөх | |
| 17 | Хэвлэл мэдээлэл | |
| 18 | Ярилцлага хэлбэрээр | |
| 19 | Дэмжихгүй | |
| 20 | Интернет хэвлэл мэдээллээр дамжуулах нь тохиромжтой | |
| 21 | Мэдээллийн хэрэгсэлээр олон давтамжтай цацах | |
| 22 | Олон нийтэд хүртээмжтэй байдлаар | |
| 23 | Нэгтгэж тавьбал сайн | |
| 24 | Байгууллага цахим хуудсандаа тавьдаг байдлаар | |
| 25 | Хариу хүргүүлэх замаар | |
| 26 | Тухайн иргэдийн цахим шууданд хариу өгвөл дээр | |
| 27 | Ил тод ойлгомжтой байх хэрэгтэй | |
| 28 | Санал өгсөн иргэн бүрт хариу бичгээр өгөхгүй бол Хороо дүүргээр нэгдсэн мэдээлэл авч байвал зүгээр | |
| 29 | Application байвал зүгээр | |
| 30 | Утсанд мессеж ирэх | |
| 31 | Хариулаагүй | 237 |

14. Хууль боловсруулах ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах ямар арга хэлбэр илүү тохиромжтой гэж үзэж байна вэ? Та саналаа бичиж үлдээнэ үү.

| № | Хариу өгсөн байдал | Саналын тоо |
|---|---|---|
| 1 | Хүн бүрт хүртээмжтэй үйлчлэх | 3 |
| 2 | Олон нийтийн оролцоог дэмжихийн тулд гар утасруу нь мессеж хэлбэрээр санал асуулга явуулах | 7 |
| 3 | Олон нийтэд зарлах | 7 |
| 4 | Орон нутагт амьдарч буй иргэдээс хуулийн төслийн талаар санал авч байх хэрэгтэй | 3 |
| 5 | Санал асуулга хэлбэрээр авдаг үр дүнг гаргах | 7 |
| 6 | Хороогоор дамжин санал асуулга авах | 7 |
| 7 | Сайн суртачлах, мэдээллийг хангалттай өгөх | 3 |
| 8 | Цахимаар | 10 |
| 9 | Веб сайтад байрлуулж санал авах эсвэл иргэдийн төлөөлө болгон санал асуулга авах | 3 |
| 10 | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах | 7 |
| 11 | Утсаар | 5 |
| 12 | Е-мэйлээр хандвал зохимжтой | 2 |
| 13 | Цахим ертөнцөөр | 1 |
| 14 | Иргэдэд илүү хүртээмжтэй, олон нийтийн оролцоог хангах зар | 1 |

| | | |
|---|---|---|
| | суртчилгаа, мэдээллээр хангах | |
| 15 | Санал асуулга | 1 |
| 16 | Илүү олон иргэн албан байгууллага олон нийтийн оролцоог оруулах нь зүйтэй | 1 |
| 17 | Ил тод | 1 |
| 18 | Нэг бүрчлэн санал авдаг байх | 1 |
| 19 | Иргэд нэг бүрээс бичгээр санал авдаг байх | 1 |
| 20 | Иргэдээс чөлөөтэй санал асуулга авах | 1 |
| 21 | Мэдээлэл өгөөд бичгээр санал авах нь зөв | 1 |
| 22 | Хууль боловсруулахдаа товч иргэдэд ойлгомжтой хамгийн гол нь хуулийг дээдлэх | 1 |
| 23 | Иргэдээс санал авах, иргэдийн амьдрал ахуй ажил төрлийг сайн судлах | 1 |
| 24 | Мэдээ мэдээллийн нээлттэй хэлэлцүүлэг хийх хэрэгтэй | 1 |
| 25 | Боловсруулах үйл явцад оролцох | 1 |
| 26 | Ил тод дэлгэрэнгүй хангалттай мэдээлэлтэй байх | 2 |
| 27 | Иргэдийн төлөөлөл оролцох | 2 |
| 28 | Олон нийтийг хамарсан шатлалтай санал хураалт | 2 |
| 29 | Тусгай нэг байнгын холбогдох утастай тэр утсаараа санал авдаг байх | 1 |
| 30 | Хэрэгжилтэд анхаарал тавих | 1 |
| 31 | Иргэд мэдээлэл хангалтгүй авдаг учраас оролцоо маш муу байдаг. Мэдээлэл өгөх тогтолцоог сайжруулах хэрэгтэй. | 1 |
| 32 | Орон нутгийн захиргаанаас гадна иргэн бүрт хөрсөн дээр нь буусан бодит үндэслэлтэй уялдуулсан судалгааг гаргасан байх хэрэгтэй. | 1 |
| 33 | И-мэйл хаяг мессежээр | 2 |
| 34 | Хуулийн мэргэжилтэй хүмүүсийг хууль боловсруулах ажиллагаанд түлхүү оролцуулах мөн хороодын ИТ-өөр дамжуулах | 1 |
| 35 | Төлөвлөөгүй ард түмэн алсын хараатай хууль санаачилдаггүй ёс зүй тэгш ёсны соёл төлөвшилтэй хэсэг хүмүүс боловсруулах хэрэгтэй | 1 |
| 36 | Дүүрэг бүр хариуцан ажиллах | 1 |
| 37 | Сайн мэдэхгүй | 2 |
| 38 | Чөлөөт сайтуудад төслийг байрлуулах | 2 |
| 39 | Хуулиа батлахаасаа өмнө боловсруулсан зүйл дээрээ бусдын саналыг авах | 1 |
| 40 | Тухайн хуулийг гардан хэрэгжүүлэх субьектуудын саналыг голчлон авах | 1 |
| 41 | Хэсэг бүрт уулзалт зохион байгуулан иргэдийн саналыг авах. | 1 |
| 42 | Иргэний танхим | 1 |
| 43 | Мэдлэг олгох хичээл заах | 1 |
| 44 | Суртчилгаа сайн хийж иргэдийн идэвхийг сайжруулах | 1 |

## 15. Хуулийн төслийг вэб-д тавьж олон нийтээс санал авах хугацаа хэд хоног байвал зохимжтой вэ?

| Хариулт | Саналын тоо |
|---|---|
| А. 10 хоног | 48 |
| Б. 30 хоног | 156 |
| В. 60 хоног | 70 |
| Г. Бусад .... хоног | 12 |
| Д. Хариулаагүй | 73 |

Нийт судалгаанд оролцогчдын 13% буюу 48 иргэн 10 хоног, 44% буюу 156 иргэн 30 хоног, 20% буюу 70 иргэн 60 хоног, 3% буюу 12 иргэн мэдэхгүй гэж хариулсан бол 20% буюу 73 иргэн хариулт өгөөгүй байна.

Нэмэлт санал:

| № | Санал |
|---|---|
| 1 | Нэмэлт санал байхгүй |
| 2 | Хувь хүний эрх чөлөө буй эдийн засаг байх ёстой |
| 3 | Ямарч хуулийн төсөлд санал өгч байгаагүй хуулийн талаарх асуулга ямар нэгэн мэдээлэл ерөөсөө огт авч байгаагүй |
| 4 | Ямар нэгэн хуулийн төсөлд санал өгч байгаагүй, учир нь боломж байгаагүй |
| 5 | Хуулийн орчин бүрдэхгүй байна |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх тухай хуулийг асууж, санал бодол зөв эсэхийг шалгах |
| 7 | Хуулийн төслийн талаар олон нийтийн санал авдаг утас ажиллуулбал олон нийтийн санал ихийг авах байх |
| 8 | Санал авах хугацааг мэдээгээр дахин сануулж хүртээмжийг ихэсгэх хэрэгтэй |

Дараах хуулийн төслүүдэд саналаа өгч байсан эсэх талаар тохирох хариултыг тэмдэглэнэ үү.

| № | Хуулийн төслийн нэрс | Хуулийн төсөлд санал өгөх ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцсон уу? | Саналын тоо | Тийм бол оролцсон арга | Саналын тоо | Таны санал хуулийн төсөлд тусгагдсан эсэх | Саналын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гэмт хэргийн тухай хуулийн төсөл /өргөн баригдсан/ | А. Тийм | 36 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 7 | А. Тусгагдаагүй | 2 |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 3 | Б. Зарим нь | 14 |
| | | | | В. Захидлаар | 5 | В. Хангалттай | 2 |
| | | Б. Үгүй | 323 | Г. Утсаар | 7 | Г. Мэдэхгүй | 13 |
| | | | | Д. И-мэйлээр | 4 | | |
| | | | | Е. Мессежээр | 4 | | |
| 2 | Зөрчлийн тухай хуулийн төсөл /өргөн баригдсан/ | А. Тийм | 24 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 2 | А. Тусгагдаагүй | 1 |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 2 | Б. Зарим нь | 6 |
| | | Б. Үгүй | 335 | В. Захидлаар | | В. Хангалттай | 8 |
| | | | | Г. Утсаар | 3 | Г. Мэдэхгүй | 2 |
| | | | | Д. И-мэйлээр | | | |
| | | | | Е. Мессежээр | | | |
| 3 | Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл /өргөн баригдаагүй/ | А. Тийм | 40 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 4 | А. Тусгагдаагүй | 7 |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 6 | Б. Зарим нь | 8 |
| | | | | В. Захидлаар | 4 | В. Хангалттай | 5 |
| | | Б. Үгүй | 319 | Г. Утсаар | 7 | Г. Мэдэхгүй | 11 |
| | | | | Д. И-мэйлээр | 5 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Е. Мессежээр | 9 | | |
| 4 | Гэр бүлийн тухай хуулийн төсөл /өргөн баригдсан/ | А. Тийм | 33 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 5 | А. Тусгагдаагүй | |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 3 | Б. Зарим нь | 12 |
| | | Б. Үгүй | 326 | В. Захидлаар | 2 | В. Хангалттай | 3 |
| | | | | Г. Утсаар | 5 | Г. Мэдэхгүй | 4 |
| | | | | Д. И-мэйлээр | 8 | | |
| | | | | Е. Мессежээр | 2 | | |
| 5 | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2012.10.24-нд батлагдсан/ | А. Тийм | 44 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 8 | А. Тусгагдаагүй | 2 |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 4 | Б. Зарим нь | 11 |
| | | Б. Үгүй | 315 | В. Захидлаар | 5 | В. Хангалттай | 14 |
| | | | | Г. Утсаар | 7 | Г. Мэдэхгүй | 8 |
| | | | | Д. И-мэйлээр | 5 | | |
| | | | | Е. Мессежээр | 6 | | |
| 6 | Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл /2014.06.13-нд батлагдсан/ | А. Тийм | 26 | А. Хэлэлцүүлэгт оролцсон | 5 | А. Тусгагдаагүй | |
| | | | | Б. Биечлэн очиж уулзсан | 7 | Б. Зарим нь | 9 |
| | | | | В. Захидлаар | | В. Хангалттай | 2 |
| | | Б. Үгүй | 333 | Г. Утсаар | 1 | Г. Мэдэхгүй | 1 |
| | | | | Д. И-мэйлээр | 1 | | |
| | | | | Е. Мессежээр | 3 | | |

**Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 10% буюу 36 иргэн тийм, 90% буюу 323 иргэн үгүй гэсэн хариулт өгжээ.

**Зөрчлийн тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 7% буюу 24 иргэн тийм, 93% буюу 335 иргэн үгүй гэсэн хариулт өгсөн байна.

**Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 11% буюу 40 иргэн тийм, 89% буюу 319 иргэн үгүй гэсэн хариулт өгсөн байна.

**Гэр бүлийн тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 9% буюу 33 иргэн тийм, 91% буюу 326 иргэн үгүй гэсэн хариулт өгсөн байна.

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 12% буюу 44 иргэн тийм, 88% буюу 315 иргэн үгүй гэж хариулсан байна.

**Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд санал өгсөн үү?** Гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 8% буюу 26 иргэн тийм, 92% буюу 333 иргэн үгүй гэсэн хариулт өгсөн байна.

Та аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу? Гэх асуултанд “Тийм” гэж хариулсан иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг гаргав. Зураг №1




Зураг №1

Та аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу? Гэх асуултанд “Тийм” гэж хариулсан иргэдийн хүйсийн харьцааг харуулав. Зураг №2



Зураг №2

Та аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан уу? Гэх асуултад “Тийм” гэж хариулсан иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг харуулав. Зураг №3




Зураг №3

Та аливаа хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож байсан уу? Гэх асуултад “Тийм” гэж хариулсан иргэдийн хүйсийн харьцааг харуулав. Зураг №4



Зураг №4

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Хуулийн төсөл боловсруулахад иргэд хэрхэн оролцож буй талаар Улаанбаатар хотын төвийн дүүргийн 359 иргэдээс урьдчилан бэлтгэсэн асуулгаар асуулга бөглүүлж, анкетийн судалгаа хийж нэгтгэв. Асуулгын анкетыг Хангарьд ордон, Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын нэг цэгийн үйлчилгээг хүртэж буй иргэд, Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэгчид, МУИС-ийн зарим багш нар, Монголын иргэний агаарын тээврийн ерөнхий газрын ажилтнууд зэрэг төрийн үйлчилгээг хүртэж буй, эсхүл тодорхой ажил эрхэлж буй иргэдээр бөглүүлж авсан болно. Судалгаанд бүх насны ангиллын хүмүүс жигд хамрагдсан байна. Мөн ажил эрхлэлтийн янз бүрийн төлөөллийн хүмүүс уг судалгаанд хамрагдсан болно.

Та аливаа хуулийн төсөлд саналаа өгч байсан уу? Гэсэн асуултанд хариулт өгсөн 359 иргэний 244 буюу 64% нь үгүй, 60 буюу 16% нь 1 удаа, 25 буюу 7% нь 2 удаа, 22 буюу 6% нь 3 болон түүнээс дээш удаа санал өгсөн бол 8 буюу 2% нь хариулаагүй байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 272 хүн саналаа өгсөн хуулийн нэрийг бичээгүй нь тэдгээр хүмүүс хуулийн төсөлд санал өгч байгаагүй гэж үзэж болох талтай. Харин хуулийн төсөлд саналаа өгч байсан хүмүүс нийтдээ 32 хуулийн төслийг нэрлэж, давхардсан тоогоор 108 хүн санал өгсөн гэж хариулж байгаа нь судалгааг цаашид үргэлжлүүлж тэдний санал хуулийн төсөлд хэрхэн туссан талаар дүгнэх боломж байна гэсэн итгэл төрүүлсэн юм.

Хуулийн төслийн талаарх мэдээллийг ихэнх тохиолдолд иргэд хэвлэл мэдээллээс авч байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь тухайн хуулийн төслийг боловсруулж байгаа болон бусад байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авч байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас нь мэдээллийг олон нийтэд хүргэх гол суваг болохыг тодотгож байна. Судалгаанд оролцогчдын 20 хувь нь цахим хуудас, интернетээр мэдээлэл авч буйг хангалттай өндөр гэж үзэхгүй байгаа ч хөдөө орон нутгийн иргэдийн цахимаар мэдэээл хүлээн авах техник, технологи /гар утас, PC, интернет/-ийн нөхцөл бүрдээд байгаа орчин үед хууль тогтоомжийн төслийг олон нийтэд танилцуулж, санал авах “Монголчуултайгаа зөвлөлдөх нь” нэгдсэн цахим хуудас ажиллуулах талаар хуулийн төсөлд бидний өгч буй зөвлөмж үндэслэлтэйг давхар харуулж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон болон ямар нэг хэлбэрээр хуулийн төсөлд саналаа өгсөн хүн судалгаанд оролцогчдын гуравны нэг орчмыг эзэлж байгаа нь хуулийн төсөлд санал өгөх иргэдийн идэвх багагүй болохыг нотолж байна. Хуулийн төсөлд саналаа өгөх хэлбэрийн хувьд хэлэлцүүлэгт оролцох хэлбэрийг дэмжиж

буй иргэдийн эзлэх хувь өндөр байгаа ч и-мэйл, мессэж зэрэг мэдээллийн технологи ашигласан тохиолдол судалгаанд оролцогчдын 15 хувийг эзэлж байгаа нь монголчууд энэхүү хэлбэрийг ашиглах боломж харьцангуй өргөн, цаашид ирээдүйтэй буйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 14 хувь нь хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон гэж хариулж байгаа нь иргэдийн оролцох эрмэлзлэл, идэвх байна гэдгийг нотолсон бөгөөд чамлахаар үзүүлэлт биш юм. Энэ нь нөгөөтэйгүүр хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах нь зохистой хэлбэрийн нэг гэдгийг нотолсоор байна.

Хэлэлцүүлэг хийсэн нийтдээ 24 хуулийн нэр дурдагдсанаас давхардсан тоогоор 52 иргэн хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон гэж хариулж байгаа нь хэлэлцүүлэгт оролцох иргэдийн идэвх сонирхол муу биш болохыг дахин харуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үр дүнг хангалттай буюу боломжийн гэж оролцогчдын 31 хувь нь үзэж, харин 15 хувь нь хангалтгүй гэж үзэж байна.

Хэлэлцүүлгийн үр дүн яагаад хангалтгүй болдог шалтгааныг тодруулахад санал хэлэх боломж олгоогүй, миний саналыг сонсоогүй гэсэн хариулт давамгайлж, хуулийн төсөл боловсруулагчид өөрсдийн эрх ашгийг боддог, хуулийн төсөлтэй урьдчилан танилцах боломжоор хангадаггүй, иргэдийн оролцоо бага, танхим дүүргэлт муу, цөөхөн хүнтэй хэлэлцүүлэг болдог гэсэн шүүмжлэлийг илэрхийлсэн нь ихэнх улс орнуудад оролцоог хангах чиглэлээр тулгардаг бэрхшээл манай орны хувьд ч мөн асуудал хэвээр байгааг нотолж байна.

